

ЭРСЛЭН СЭРЭВ



Сэрээд, ертөнцөө өөрчил

ЛИЗА БИВЭР

Хайрт найз минь,

Бурхан охидоо зорилго, халуун сэтгэл, домогт чанараараа тодроосой гэж хүсэх. Олонх маань сүүдэр дор уджээ. Эдүгээ Бурхан биднийг сэрээд, босоод, дэлхийг өөрчил хэмээн дууднам. Чи хүрээлэн буй дэлхий ертөнцдөө стратегитайгаар, бүтээлчээр нөлөөлөх хувь заяатай.

Эрслэн сэрэв инү чамайг энэ л эгшний төлөө төрснийг чинь мэдэгдсэн, Бурханы амьсгалтай үг болой. Энэ номоор хэлсэн Бурханы үгс нь намайг бүхий л тал, бүхий л төвшинд уриалан дуудаж, хүчжүүлсэн билээ. Мөн Бурханд үйлчлэхээр, хүч чадалтай байхаар шийдсэн, даян дэлхийн үй олон бүсгүйчүүдээс ч ижил гэрчлэл ирдэг.

Хамаг л хайр, дэмжлэгээ шингээсэн энэхүү номоо чамд болоод чиний хамтран зүтгэгч удирдагч нарт илгээж байгаадаа баяртай байна. Энэ номыг болоод онлайн дээрх бусад бүх материалыг таньдаг, мэддэг бүх хүндээ чөлөөтэй дуулгаж, хуваалцаарай. Эрслэн сэрэв ном чамайг харанхуйг хөөж, цөхөрснийг аварч, Бурханы хаанчлалыг газар дээр илчлэхийн төлөө эргэн тойрны чинь хүмүүстэй нэгдүүлэн босгох болтугай.

Хайрт бүсгүй минь, энэ үг миний хайрлах, удирдах, үйлчлэх, өгөх арга замыг мөнхөд өөрчилсөн. Эдгээр хуудаснаас Бурханы зүрхийг эрэлхийлэн хайж буй чамайг ч бас өөрчлөх болтугай хэмээн залбирья. Чамд болоод чиний хариуцдаг хүмүүст хэрхэн нөлөөлсөн тухайгаа ч гэрчлээрэй.

Хүндэтгэсэн,



Лиза Бивэр
LisaBevere@ymail.com



MessengerX.com



MESSENGER
INTERNATIONAL

ЭРСЛЭН СЭРЭВ



Сэрээд, ертөнцөө өөрчил

ЛИЗА БИВЭР

Lioness Arising: Wake Up and Change Your World (Mongolian), by Lisa Bevere

© 2021 Messenger International

MessengerInternational.org

Originally published in English as *Lioness Arising*

ISBN: 978-0307457790

Additional resources in Mongolian are available for free download and video streaming at **MessengerX.com** and on the **MessengerX app**

To contact the author: LisaBevere@ymail.com

This book is a gift from Messenger International and is NOT FOR SALE

Эрслэн сэрэв: Сэрээд, ертөнцөө өөрчил (Монгол) Лиза Бивэр

© 2021 Messenger International

MessengerInternational.org

Номын англи нэр: *Lioness Arising: Wake Up and Change Your World*

ISBN: 978-0307457790

Монгол хэл дээрх бусад хэрэгтэй материалаа **MessengerX.com** болон **MessengerX app**-аас шууд үзэх эсвэл утсандаа татаж авах боломжтой.

Зохиолчтой холбогдох имэйл: LisaBevere@ymail.com

Энэхүү ном нь Мессенжер Интернэйшнэл байгууллагаас Монголчуудад өгч буй бэлэг юм.
ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОНО.

*Дотроо хатан зоригт, эрэлхэг, эршүүд атал
гоо үзэсгэлэнт гал тээж явдаг
эрслэн эгч, дүүсдээ зориулав.*



*Та нар - биширмээр хүмүүс.
Та нар энэ л цагийн төлөө төрсөн хүмүүс.
Хүч, асуулт, үзэл бодлоосоо бүү ай.
Сэр, бос, бүтээгдсэн утга учраа эрэлхэгээр эрэн хай.*


АГУУЛГА

1. Эрслэнг сэрээ	7
2. Үл үзэгдэх хүч	21
3. Аюултай сэргэг	35
4. Айдас, гайхамшгийн нийлбэр	49
5. Үйлчлэхийн тулд хүч орших	65
6. Нэгэн даалгавар дор	75
7. Мэндчилээд халамжлах	93
8. Эрслэн стратегитай	105
9. Эрслэн гэрэлд амьдарч, харанхуйд анчилдаг	121
10. Арслантай хамт алхах	147
11. Шивнээгээс архираа	159
Ярилцах асуулт	173
Зүүвэр	175

ЭРСЛЭНГ СЭРЭЭ

Биднийг чөлөөлөхийн тулд
байгаль сүнстэй хуйвалдах.

РАЛЬФ УАЛЬДО ЭМЕРСОН



1994 он. Амьдралын маань улирлын байдаг л нэгэн шөнө. Гэр орноо эмхлэх гэж бөгтөгнөсөөр, нилээд оройтож орондоо шургалаа. Тэр үед гурван хүүтэй, дээрээс нь давхар биетэй ээж - миний бие орондоо ороо л бол, нам болдог байлаа. Нүдээ аниад л тас. Тэгээд сэрүүлгийнхээ хангинаагаар юмуу хөвгүүдийнхээ шаагианаар эсвэл өрөөг зүсэн тусах өглөөний нарны хожуу туяагаар л сэрнэ. Гэтэл тэр шөнө унтаад, үүрээр голдоо ортол чичирсээр сэрэв.

Тэр үүрээр маш ер бусын, тод зүүд зүүдлэв би. Зүүд гэхээр үнэндээ нойр юмуу сүүдэр маягаар буусан дүр зураг шиг санагдах байх. Гэтэл тэр дүр зураг ондоо байлаа. Би ч зүүдлэхийг үзүүлдэг хүн боловч, тийм бодитой, биетэй зүүдэлж явсангүй. Зүүдний тэр ертөнцөд миний бие тун сэргэг, сэрүүн байх юм. Өмнө маань тэс өөр нэгэн цаг үе, газар үзэгдэх. Би учиргүй гялбаж, цацарсан зүйлгүй атлаа гэрэл гэгээ татуулсан тэнгэрлэг газарт зогсоно.

Тэр жавхлант гэрэл гэгээ газар сайгүй, бүх юмнаас л гийгээд байх шиг. Тэнд манан, сүүдэр байхгүй, зөвхөн жавхлант өнгүүд л үзэгдэнэ. Тэр их солонгорсон амьд өнгө туяаны цоморлигийг дүрслэн өгүүлэхэд газрын үгс

ч дутуудах. Давхарга давхаргаараа, урт өргөөшөө уусан төгөлдөршсөн, зүйл зүйлийн өнгө. Яагаад гэдгийг мэдэхгүй ч, би нил ягаан (Энэ нь бидний мэдэх нил ягаан биш л дээ), цэнхэр (мөн л бидний мэдэх цэнхэрээс өөр) хоёр өнгийг сайн тогтоож авсан юм. Өнцөг, ирмэг, дээд эмжээр гэх зүйлгүй атлаа арын өнгүүд нь хүч зузаалан, гол үзүүлэнгээ тодосгох бөгөөд тэр үзүүлэн нь өргөгдсөн, өө сэвгүй, цөцгийн өнгөт чулуун индэр байх агаад түүн дээр алтан эрслэн тухална.

Эрслэн эрхэмсэг, хүчирхэг, баялаг - муурын язгуурын төгс илэрхийлэл байв. Эрслэн хөдөлсөнгүй. Гэвч түүнийг амьд гэдгийг би мэдэж байлаа. Үнэндээ тэрбээр газар дээр миний үзэж харсан ямар ч амьд амьтнаас илүү амьд санагдав. Эрслэн амгалан толгойгоо өөд өргөн, урд хоёр хөлөө урагш сунган хэвтэнэ. Алтан сортой, алтан нүдэт эрслэн. Өөгүй хүрэн арьс үсэн дороос нь төгс галбиртай булчин шөрмөс нь төвхийнө. Энэ эрхэмсэг эрслэн газар дээрх ямар ч эрслэнгээс хавь илүү бодитой, тод, амьд санагдана. Надад “Энэ тэнгэрийн эрслэн байна” хэмээн бодогдов.

Өөгүй төгс индрийнх нь нүүрэн хэсэг дээр “Тооллого ХХIII” гэсэн бичиг, Ром тоо хоёр үзэгдэнэ.

Эрслэнгийн хажууд би л харин хачин эв хавгүй, өчүүхэн бөгөөд нэвт шувт санагдана. Биеэсээ гарчихсан ч юм шиг бас тулгар биетэй эсэх нь ч мэдэгдэхгүй. Би тэнд зогсоод, өөрийгөө *харах ёстойгоо* - анхааралтай ажаад, огт мэдээгүй явсан зүйлээ олж сурах ёстойгоо мэдээд байлаа. Би тэр дүр төрхийг тогтоох ёстойгоо мэдрээд байлаа. Хэдийгээр би эрслэнтэй хоёулханаа байсан ч, сэрдэж, сүрдсэнгүй. Нүдээ томруулах тусам, сүнс маань улам тэлж, бат холбогдох юм шиг л байдгаараа бүлтийв. Эргэн тойрноо ч чадах чинээгээрээ өөртөө соров. Тэгтэл анхаарал маань шилжиж, эрслэн, бид хоёрын харц мөргөлдөв. Яг тэр үед араас: “*Энэ хүү төрөхөд, чи эрслэнг сэрээнэ*” гэсэн дуу гарахыг дууллаа.

Үүний дараа энэ их сүрхий алтан туяа, эрхэмсэг байдал, гайхамшиг дахин нэг улалзаад л алга болчихов. Нэг мэдэхнээ өглөө болчихсон, би ч сэрчихсэн байж байлаа. Айсандаа гэхээсээ илүү гайхаж цочирдсондоо хамаг мэдэрхүй маань шовойчихсон байв. Сая юу үзчихэв ээ? Цаг хугацаа өнгөрөх тусам, манай дэлхий чинь тэнгэрт буй бүрэн төгс, өнө мөнхийн юмны цаг хугацааны хязгаарлалттай, тусгал маягийн хэлбэр нь гэх юмуу эсвэл бутархай илчлэл нь гэдэгт би итгэх болсон юм.

ЭРСЛЭН МЭТ БОСОХ

Ийнхүү би үүрийн бүрийгээр бие дагжин, зүрх бөмбөрдөн, хараатай чигээрээ хөшин хэвтэв. Өдөр хоногийн эргүүлэг дунд миний огтоос

анзааралгүй өнгөрөөсөн нэгэн зүйлийг Бурхан тэрхүү эрслэнгийн үзэгдлээр ойлгуулах гэсэн мэт. Эдүгээ Бурхан миний анхаарлыг бүрэн олзолжээ. Эдүгээ би Бурханыг мэдэрхүй бүрээрээ сорон сонсож байлаа. Өрөө маань миний дөнгөж сая зочлоод ирсэн өнгөт ертөнцөөс тэс өөр - хоосон, загал харагдах. Дэлхийн өглөөний дуу чимээ ч нөгөө ертөнцийн тув тунгалаг дуу хоолойн дэргэд бөглүү. Би үзэгдлийнхээ үлдцийг сарниахаас айсандаа, хөдлөхөөс ч эмээн, хөшинө. Нүдээ анилаа. Тийм ээ, үнэхээр эрслэн, суурь, бичиг, ар дэвсгэр, дуу хоолой - энэ бүгд бодитой байв.

Цаг өнгөрсөөр, зүрх маань тайтгарч, бие маань ч тайвширч, би нүдээ нээлээ. Суурин дээрх бичгийг мэдэх гэсэн сониуч зандаа хөтлөгдөн, Библиэ татан, орондоо дэлгэлээ. Энэ нь Библийн бүлэг эшлэлийг заасан үг юм болов уу? Тийм бол, Тооллого 23 дээр юу өгүүлдэг юм бол? Тийнхүү хуудсыг нь эргүүлж байгаад, орчуулагч нарын тавьсан гарчгийг үзээд пал хийгээд л явчихав. Тэр хэсэг нь Балаамын үг байв. Балаам бол өөдгүй боловч үнэнийг хэлдэг эш үзүүлэгч байсныг би мэднэ. Тэгээд зүгээр л гүйлгэж уншсаар 19-ээр эшлэлд хүрэв.

Бурхан бол худал хэлдэг хүн биш,
Гэмшин харамсдаг хүмүүн ч бус.
Тэрээр айлдчихаад,
Түүнийгээ хийхгүй гэж үү?
Эсвэл Тэр ярьчихаад,
Түүнийгээ сайн болгохгүй гэж үү?
Харагтун, ерөөхийг би хүлээн авсан.
Тэр ерөөсөн байхад
Би түүнийг нь эргүүлж чадахгүй.
Золгүй явдлыг тэрээр Иаковын дотроос үзээгүй.
Зовлонг бас Израилийн дотроос хараагүй.
Бурхан ЭЗЭН нь түүнтэй хамт бөгөөд
Хааны уухай тэдний дунд байна.
Бурхан тэднийг Египетээс гарган авчирчээ.
Тэдний хувьд Тэрээр зэрлэг үхрийн эвэр мэт юм.
Иаковын эсрэг ямар ч ид шид алга,
Израилийн эсрэг ямар ч мэргэ төлгө байхгүй.
Зохистой цагт Иаков ба Израилийн талаар хэлэгдэнэ.
Бурхан юу хийснийг үз! (Тооллого 23:19-23)

Энд Бурханы итгэмжтэй чанарын талаар л өгүүлээд байна. Бурханы

амлалт баттай, тодорхой. Түүний ерөөл харьшгүй. Бурхан итгэмжтэй учраас, Израиль илбэ шид, хараалын хор, шүлсээс чөлөөтэй, бат ирээдүйтэй байв. Ийнхүү бөөн тайвшралын үгс явж байтал, удаах эшлэл дээр нь:

*Хараач, ард түмэн эрслэн мэт өндийж,
Арслан мэт босож байна.*

Тэр олзоо залгитлаа, алагдагсдын цусыг уутлаа буцаж хэвтэхгүй гэлээ (Тооллого 23:24) гэсэн байлаа.

Би ч чичирсээр, нимгэхээн цаасан дээрх мөнөөх дошгин үгсийг давтан уншив: *ард түмэн эрслэн мэт өндийж, арслан мэт босч байна.* Энэ амьд дүр зургийг би шууд ойлгов. Би толгой дотроо өвсөн дундаас өндийх арслан, эрслэн хоёрыг харлаа. Тэднийг өндийх үед талын уур амьсгал амар амгалан байдлаас эрч хүчтэй байдал руу хувьсав. Арслангийн сүрэг биеийн бэлтгэл байдлаа өөрчлөхийг амьтай болгон мэдэрч, нүд цавчилгүй ширтэнэ. Алтан зогдортон сэрээд, суниан, агаар үнэрлэн, газар орчноо шиншлээд, нүүдлээ хийхэд бэлэн болно. Магад ихэд өлссөн байх. Эсвэл нутаг дэвсгэрт нь дайсан халдахыг мэдрээд, оршихуйгаа мэдүүлэхийг хүсээ байх.

Арслангуудыг өндийхтэй зэрэгцэн миний сүнсэнд хүч чадлын хуй босохыг би мэдрэв. Арслан, эрслэн өндийж, хэвтрээсээ хөдлөхийг сүрдэж, бишрэхгүй өнгөрөх амьд амьтан үгүй. Сэтгэл сормоор гайхамшигт үзэгдэл. Гэхдээ энэ бүхэн надад юуг өгүүлнэ вэ? Энэ зэрлэг, шаргал хүчтэн, бид хоёрын хооронд ямар холбоо оршино вэ?

Энэхүү дүр зураг намайг догдлуулаад зогсохгүй бас үргээв. Дэггүй гүегүүд нь ноололдох зуур нарны илчинд зүүрмэглэн хэвтэх эрслэнгийн дүр зураг сайхан боловч, анчин, алуурчин эрслэнгийн дүр төрх намайг айлгах нь бүү хэл, жигшүүр төрүүлэх. Би *Нэйшинэл Жиографикс, Зэрлэг Хаанчлал* зэрэг нэвтрүүлэг үзсэн бөгөөд тэр том муур гөрөөс, тахийг барьж идэхийг нь харж чадалгүй, нүдээ буруулж билээ.

Энэ мэт бодол толгойд жирэлзэх зуур гэнэт мөнөөх шөнийн үзэгдлийн үгийг санав: “Энэ хүү төрөхөд, чи эрслэнг сэрээнэ.” Энэ юу гэсэн үг вэ? Би аймшиггүй, хүчтэй эрслэн, миний оронд хэвтэж байгаа тулгар биетэй, данхар эмэгтэй хоёрын хооронд ямар ч холбоос харсангүй. Үнэндээ, намайг эрслэн гэвэл - хөх инээд хүрмээр. Би чинь улаан махчин араатан биш, дүпүгээр хооллодог, хагас цагаан хоолтон шүү дээ. Би чинь танихгүй мэдэхгүй зүйлээсээ айж явдаг, уулзсан хүн болгоноосоо шахуу сүрдэж явдаг хүн. Ялангуяа “төмөр хатагтай” нараас бол бүр ухаан алдана.

Тиймээс жирэмслэлт надад бараг л бултах боломж болдог байв. Хүү

маань гэдсэндээ олдохоос хэдэн сарын өмнө би залбирлынхаа халуун дээр Бурханы өмнө бүх тэрслүү байдлаа овоолоод: “Ойлголоо! Би Таных. Амьдралд маань юу хүссэнээ л хий! Би ч юу хүссэнийг тань л хийе. Хүсбэл, эмэгтэйчүүдэд ч номлоё” гэж хэлсэн удаатай. Мэдээж юу ярьж байгаагаа тухайн үедээ мэдээгүй л дээ.

Тэгтэл жирэмсэн болчихсон учраас Бурхан, бид хоёрын хэлэлцээр хүчингүй болсон гэж боджээ. Би тэр захирамж - зөвшөөрлийг нэг ёсондоо Абрахам Исаак хүүгээрээ тахил өргөх хүсэлтэй байгаа эсэхийг л харах гэсэнтэй адил шалгуур л гэж боджээ. Магадгүй, би амлалтаа хэзээ ч биелүүлэхгүй ч, хүсэлтэй байсныхаа төлөө бонус оноо авчих ч юм билүү.

Гэтэл жирэмсний өмнөх хэлэлцээр хүчинтэй хэвээрээ байгааг мөнөөх үзэгдэл батлах шиг.

Тэгээд ч энэ хүү гэдэг нь ямар учиртай юм бол?

Би амаржих хүртлээ охин тээж яваа л гэж бодож байлаа. Хүн болгон л охинтой болно гэсээр. Нэг ч хүн хүүтэй болно гэж хэлж байсангүй. Би л ганцаараа битүүхэн дахин нэг хүү хүсч байв.

Би итгэж ядан толгой сэгсэрлээ. *Хэрэвзээ* энэ бүхэн үнэн байгаад би эрслэн маягийн амьтан болох ёстой юм бол, айсуу энэ хувирлыг өөр хүн харах л учиртай. Энэ үзэгдэлд маань хоёрдагч, лавтай баталгаа шаардлагатай болов.

БАТАЛГААНЫ ЭРЭЛД

Хэдэн долоо хоног өнгөрч, манай хотод миний хүндэт евангелист - найз хүүхэн маань ирэв. Энэ л миний боломж! Түүний өөр нэгэн жирэмсэн найз, бид гурав өдрийн хоолонд орцгоолоо. Найз маань өмнө онцсайн бизнес эрхлэгч байгаад, Есүст итгэхдээ амьдралаа орвонгоор нь өөрчилж, эдүгээ Азийнхаа бүс нутгийг Сайн мэдээгээр довтолгож яваа бүсгүй. *Магадгүй эрслэнгийн дүр зураг түүний тухай ч юм билүү...* . Би энэ санааг өдрийн хоолон дээрээ дурьдаад, найзыгаа хэрхэхийг нь харахаар шийдлээ.

Бид Флоридагийн Өвлийн цэцэрлэгт хүрээлэнд маш сайхан, нарлаг өдөр болзов. Жаал гудмаар алхсаар, болзоот газраа хүрээд, цондгор биеэ амраан суудал дээрээ тухлангаа, охидын шоппинг яриан дундуураа эрслэнгээ яаж аятайхан оруулж ирэх талаараа гайхаж суулаа. Тэгээд хоолоо зооглож байхдаа ам нээв.

Нөгөө тулгар найз маань охин тээж яваагаа хэлтэл, евангелист найз минь намайг ч бас охинтой болбол, сайхан аа гэлээ.

Тэгэхээр нь би “Тэгсэн чинь дахиад хүү байвал, яах уу?” гэж асуулаа.

Гэтэл тэрбээр намайг яаж ингэж бодож чадах байна аа гэх шиг нүдээ

эргэлдүүлээд, Жон, бид хоёрыг гурвын гурван хүүтэй... тиймээс одоо охин л хэрэгтэй хэмээн учирлав. Яг тэр үед нь би эрслэнгийн түүх, хүүгийн тухай мэдэгдлийг хэлэхээр шийдлээ.

Миний яриа аль хэр утгатай санагдсаныг бүү мэд. Үнэндээ ямар ч утгагүйгүй л санагдсан байх. Үнэндээ би өөрөө ч энэ бүхэнд итгэлгүй байсан шүү дээ. Үзэгдэл бодитой гэдгийг мэдээд байгаа хэрнээ, уймарсандаа эрслэнгийн дүр, бид хоёрыг холбоотой гэдэгт эргэлзээд байв. Би тэр үйл явдлыг боловсруулах гэж ихэд мэрийж ярьсан ч, өөрөө ч итгэлгүй хүн чинь яаж ч хүмүүст итгүүлэх билээ? Яриа маань ямар ч утгагүй байгаа нь манай хоёрын атиралдсан царайнаас илт байв. Би мухардалд орсноо ойлгомгогцоо, яриагаа шууд зогсоолоо.

Үүний дараа нэг хэсэг хачин эвгүй нам гүм тогтож, үйлчлэгч найз маань над руу гайхсан янзтай харж сууснаа “Чи хэзээ амаржих билээ?” гэж асуув.

Би ч ганц утгатай зүйл хэлэх болсондоо онгойн: “Арван сарын арванд” хэмээн номхон гэгч нь хариуллаа.

Үйлчлэгч найз маань суудлаа налан, толгойгоо сэгсэрснээ “Үгүй ээ, тэгвэл тэр хүртэл чи эрслэн болж *яагаад* ч амжихгүй” хэмээн итгэлтэй нь аргагүй хэллээ.

Би ч “Яг үнэн!” гэж хашхирмаар байсан ч, жаахан ичсэндээ толгой дохиод л өнгөрөв. Би нэг талаараа тайвширсан ч, нөгөөтэйгүүр доромжлуулчихсан ч юм шиг, ичэх ч шиг, яльгүй дургүй ч хүрэх шиг.

Тэр хүртэл эрслэн болж амжихгүй гэдэг нь юу гэж байгаа юм бол? Дөнгөж хавар болж байна, Арван сар хүртэл бүтэн таван сар байна! Тэгээд ч тэр эрслэн болох өөрчлөлт нь хэдий хугацаанд үргэлжилдэг юм бол? Ер нь би яах гэж энэ үзэгдлийг дэлгэв? Үнэхээр хүү төртөл нь хүлээх ёстой байж.

Найз маань миний гайхшралыг мэдэрсэн болтой “Бурхан чиний дотор маш олон ажил хийх хэрэгтэй байна. ... Чи Арван сар гэхэд чөлөөлөгдөхгүй” гэж хэлэв.

Тийм ээ. Хэдийгээр тэрбээр пал хийтэл хэлсэн нь муухай ч, үнэнийг л хэлсэн юм. Би ч амаа хааж, бодлоо дотогшоогоо урсгаж эхлэхэд, бидний яриа ч төдөлгүй өмнөх жирийн горимдоо шилжлээ. Үйлчлэгч найз маань миний гадаад байдлын талаар л саналаа хэлсэн. Гэтэл би олон талаараа айдас, эргэлзээнд бариулаад байв. Бүр хань нөхөр маань ч хүртэл “Лиза, чи өөр дээрээ өчнөөн айдас, зовлон овоолчихоод, яаж амьдардаг байна аа?” гэж байнга үглэдэг байлаа. Жоны ч зөв байв. Цаг өнгөрөх тусам, энэ байдал маань улам л хэцүүдсээр, улам л хүндэрсээр. Энэ сунжруу сэргээн босгох үйл явц намайг үнэхээрийн туйлдааж байлаа.

ШАЛТАГ БАЙХГҮЙ

Би дөрвөн жил өөртөө шалтаг зохиожээ. Би хорт хавдраас эдгэрсэн хүн. Эмгэнэлт амьдрал туулсан хүн. Одоо сургуулийн өмнөх насны хүүхдүүдээ хүн болгох гэж ядаж яваа, хүүхдээ хардаг, гэрийн эзэгтэй. Бурхан надад үүнээс өндөр хувь зохиол заяана гэж үү? Дотроос маань хүчирхэг атлаа бас ч үгүй зэрлэг нэгэн амьтан сэрэх гэж байж болох уу? Магадгүй эр зориг надад зохих ч юм билүү. Залуу байхдаа тийм ч хөдөлгөөнтэй охин байгаагүй байх аа? Гэхдээ л хүүхэд байхдаа том болоод хөлсний алуурчнаас авахуулаад эмэгтэй сансрын нисгэгч ч болно гэж боддог байсан юм шүү.

Тийм ээ, би пасторын үлгэр жишээ эхнэр, Христэд итгэдэг даруухан эмэгтэйн дүр бүтээх гэж үрлэгдсэн хүч чадлаасаа эргүүлж олохыг хүсч байлаа. Би нэг сайхан зад суниаж аваад, гоо үзэсгэлэнтэйгээр, хүчтэй нь аргагүй өндийж босохыг хүсч байлаа. Дорой, нялцгай гэж үзэгдэхээс залхаж байлаа. Би өнгөрсөн амьдралынхаа шархыг ахин дахин хуулахаас залхаж байлаа. Би хүч үзмээр байна. Хань нөхрийнхөө гал, хүчийг биширч байсан ч, өөрөө нөхрийнхөө араар нуугдаж байгаадаа залхаж байлаа. Шалдар булдар юмсаар тархи толгойгоо цуцааж байгаадаа залхаж байлаа. Дүр эсгэхээс залхаж байлаа. Магадгүй эрслэнгийн үзэгдэл надад хэрэгтэй байж! Сайхан, аюулгүй байхын оронд би тогтуун бөгөөд бага зэрэг зэрлэг харагдахаас буцахгүй.

Тэр өдрийн хоолны дараа би харьж явахдаа, жолоогоо урьд урьдынхаасаа бат атгаж явлаа. “Бор гэртээ Богд” гэдэг шиг ядаж л тоодгор Хонда Сивик дотроо эрслэн шиг ашилж үзмээр байв. Машиныхаа цонхыг нээгээд, хамгийн сүүлийн үеийн магтаалын хөгжмөө ахин цэнэглээд, дэл үсээ агааржуулагчийнхаа бус, байгалийн салхинд намируулав. Одоо бодоход инээд хүрмээр. (Эрслэнд ямар юмных нь дэл, зогдор байх билээ) Жартгар хэлбэртэй Рэй - Бэн шилээрээ хажуугийнхаа толинд арзайж, гялалзах толгойгоо үзэв. ...*Байзаарай, энэ алтан сортой, сагсайсан үсний цаана зэрлэг эрслэн үзэгдэж байна уу даа?*

Арван сар гэхэд бэлэн болохгүй гэлүү? Ха! Би та нарт үзүүлээд өгнө өө! Би бол эрслэн!

Өдрийн хоолон дээрх алдаа, найзын маань эрээ цээргүй үг, хаа хамаагүй элдэв янзын цуврал үйл явдлын нэгдлээр маш сонирхолтой өөрчлөлт хэлбэршиж эхэлжээ. Яг л бээлий шидэгдэж, халз тулаан эхэлсэн мэт.

Арден Кристофер хүүг маань төрөхтэй зэрэгцэн (түүний нэр “галтай, шийдэмгий, тослогдсон нэгэн” гэсэн утгатай) миний дотор нэг юм өөрчлөгдөх нь тэр. Хэдийгээр хүн нэмэхтэй хамт ээжийн ачаа нэмэгддэг ч, би урьдынхаасаа илүү төвлөрөлтэй охин болж хувирав. Бусад ээжүүдийн

л нэгэн адил Бурхантай тогтоосон холбоо маань юу ч үгүй сэмрээд байжээ. Тэр үед би үнэндээ л өдөр тутмын амьдралдаа живээд байлаа. Тиймээс би хэзээ ч дуусашгүй, хамаг хүчийг маань сорж байдаг ажлын жагсаалтаа биелүүлэх гэсээр яваад, өөрийгөө хэн болохыг таг мартаж. Өөртөө эргэлзэхээс өөр юмгүй болжээ. Амьдрал маань өөр дээрээ л төвлөрсөн, тусгаарлагдсан, хөөрхийлөлтэй, үр нөлөөгүй, хэвшсэн, бяцхан амьдрал болжээ. Би нэрээ, хэнтэй гэрлэсэнээ, ямар хүүхдүүдтэй болохоо санаж байсан ч, хийсэн юмс, хүлээсэн хариуцлага маань миний Бурханы охин гэдэг мэдэрхүйг сүүдэрлэжээ.

Намайг чимээгүй байтал, Бурхан чихэнд маань хүчийг шивэгнэж, намайг өөр нэгэн нэрээр дуудав. Бусдын хувьд би хүлээсэн үүргийнхээ дүрслэлээр нэрлэгдэж байлаа. Хүүхдүүдийнхээ хувьд ээж нь, нөхрийнхөө хувьд эхнэр нь, чуулганыхаа хувьд пасторынх нь эхнэр. Гэвч Хамгийн дээд Бурханы хувьд зүгээр л охин үр нь. Бурханых байх гэдэг нь ямар утгатай болох тухай бодтол, өдөр хоногууд маань хүчжин, сэтгэлд минь амралт нэвчин орж ирэв. Зүрх минь тэлжээ.

Арденыг төрсний дараа би эргэлзээ, айдас, аюулгүйн бүс, бүтэлгүйтлийнхээ сүүдэр дороос гарч, бусдад хүрч эхлэв. Тэгээд Арденыг хөхүүлэх хугацаандаа анхныхаа номыг ч бичив (*Out of Control and Loving It!*). Энэ ном надад өөр ертөнцийг нээж өгөв. Гэнэт л би улсынхаа өнцөг булан бүрт байгаа жинхэнэ юмсаар цангасан эмэгтэйчүүдэд номлож эхэллээ. Тэдний шарх, өлсгөлөн, эмэгтэйчүүдийн эрүүл харилцаа холбоог үзэхдээ би улам олон ном бичив.

Цаг хугацаа өнгөрсөөр, бид нарлаг, халуун, чийглэг Флоридагийн гэрээсээ мөн л нарлаг боловч хүйтэн, хуурай Колорагод амьдрахаар нүүлээ. Энэ нүүдэл суудал маань манай гэр бүлийн халуун бүлээрээ ширээ тойрсон цагийг нэмэгдүүлэв. Түүнчлэн олон, олон шилжилтэд дасан зохицох өлчир чанарыг ч суулгав. Удаах арван жилд нь намайг хэд хэдэн удаа (тоотой хэдхэн л удаа шүү) олноос онцгойлж ирээд л “эрслэн” хэмээн нэрлэхийг сонсов. Тэгж дуудуулах бүрийдээ аймхай, бүрэг, гэрийн муужгаа шиг байдлаасаа салж чадсандаа л баясан, мишээгээд өнгөрдөг байлаа. Би мөнөөх эрслэнгийн түүх дуусгавар болж, цаашид надад өөрчлөгдөөд байх юм үлдээгүй гэж боджээ.

Гэтэл үгүй байж.

Энэ бүхэн чиний төлөө биш ээ, Лиза

2007 оны намар нөгөө эрслэн намайг дахин эргэв. Миний бие өөр олон эмэгтэйн хамт үзэсгэлэнт Шинэ Зеландад болсон эмэгтэйчүүдийн

конференц дээр үйлчилж байлаа. Энэ үйл ажиллагаанд маш олон эмэгтэй оролцсон учраас, эмэгтэйчүүдийг бүгдийг нь хамруулахын тулд зохион байгуулагч чуулганы зүгээс үргэлжлүүлэн дахин нэг конференц явуулав.

Эхний конференц нь чуулган дээр болсон бол, хоёр дахь нь Аукланд цэнгэлдэх хүрээлэнд болсон юм. Бид эхний конференцээ дуусгаад, хоёр дахь конференц болох цэнгэлдэх хүрээлэнд очлоо. Ийнхүү конференц маань эхлэв. Үйлчлэгч нар нь чадварлаг, гал халуун, Үгийн итгэмжтэй нярвууд байлаа. Тийм боловч учир битүүлэг нэгэн шалтгаанаар, үдийн завсарлагаанаар миний дотор тавгүйтэж эхлэв. Бэлтгэлийн дарамт биш байлаа - учир нь би эхний конференц дээрээ заасан зүйлээ л давтан заах байлаа. Тэгээд би хичээлээсээ өмнө залбирахаар яарав. Надад эсэргүүцэл тулаад байх шиг санагдана. Энэ байдал тэнд сайн дураараа оролцож буй эмэгтэйчүүд, хамтран зүтгэгч нар, зохион байгуулагч нарын хэнээс нь ч болоогүйг би мэдэж байлаа. Бид бүгд нэгэн зүрхтэй байсан бөгөөд хүндэтгэж, номлож, эмэгтэйчүүдийг урамшуулахад бэлхэн байв. Гэтэл энэ дунд өөр нэгэн зүйл холилдон орж иржээ. Магад Бурхан миний анхаарлыг татах гэсэн байх. Тиймээс би Түүнтэй нэгдэн, зам нийлэх ёстой байлаа. Тэгээд Аукландын далайн эрэг рүү харсан цонхтой зочид буудлынхаа өрөөнд очив.

Өрөөндөө давхиж ороод, Бурханаас чиглүүлэг, ойлголт гуйхаар эрэг рүү гараа сунгаад, Айпод дээр тавьсан “Ялгуусан дуугаар Бурхан руу хашхир” гэдэг дуугаа дагаж дуулав. Зүрхээ цэгцлэхийн тулд би амьдралд маань үйлдсэн олон янзын юмсын төлөө Бурханд талархаж эхэллээ. Би “Nurture” гэдэг номынхоо эцсийн эх бичмэлийг дөнгөж дуусгаад байсан болохоор гар бичмэл, хянан тохиолдуулах ажлаа дуусгасандаа талархав. Миний хувьд ном бичих нь хүнд хөдөлмөр учраас, нэг иймэрхүү маягийн залбирал хэлэв: *Бурхан минь, энэ их ажил дууссанд баярлалаа. Ойрд ёстой юм бичмээргүй байна!*

Гэтэл гэнэт Бурхан сүнсэнд минь өгүүлэхийг мэдрэв. *Хүнд хүчир санагдаж байгаа бол уучлаарай... учир нь Би чамаар удахгүй дахиад бичүүлнэ. Чи надад хэрэгтэй.*

Юу? Би Бурханд хэрэгтэй гэж үү?

Гэтэл Бурхан цааш нь “*Би тэнгэрээс стратегиа илгээх болно. Тэдгээр нь Миний Үг дотор байх болно. Чи эдгээр стратегийг өөр хаанаас ч олохгүй ч, чамд тэдгээрийн хэмжээ нь байх болно. Миний чамд хэлсэн болгоныг чи бичиж тэмдэглэх ёстой. Тийнхүү Миний охид цугларах үедээ эх зургийг бүтнээр нь харах болно. Хэрэв чи эвлүүлдэг тоглоомон дахь өөрийнхөө хэсгийг авчрахгүй бол, зураг чинь бүтэн болохгүй*” гэв.

Тэгтэл мөнөөх эрслэн дахиад л өмнө минь гараад ирэв.

Түүний сүрдэж бишрэм гоо үзэсгэлэн, хүчийг гөлөрч байтал, мөнөөх Хоолой “Хүүг чинь төрөхтэй, чамар эрслэнг сэрээнэ гэж хэлсэн болохоос биш, чамайг эрслэн гэж хэлээгүй бус уу” гэлээ.

Хичнээн хөгийн, хязгаарлагдмал, газрын бодолтой байснаа тэр даруй ухаарав би. Хоолой цааш нь “Есүс бол Иудагийн Арслан бөгөөд сүйт бүсгүй нь эрслэнг сэрээх цаг болжээ. Эрслэнгийн арга зам, чанарыг мэд” гэлээ.

Тэгээд дараа нь мөнөөх стратегийг нь дуулав:

Эрслэнгүүд анд цугаараа гардаг.

Би зог тусав. Бичээс дээр ийм юм заадаг билүү? Энэ бүхэн ямар учиртай вэ? Эмэгтэй хүний дотор хүч, эмэгтэй хүний үр төлөө өсгөж бойжуулах хүчин чадалд үнэ цэнэ байдаг гэдэг үзэлд дасч эхэлж байна. Тэгтэл одоо Бурхан надад тэднийг эрслэн гэж дууд гэх. Энэ бүхнийг яаж эвлүүлэх вэ?

Би Бурхан эмэгтэйчүүдийнхээ дотор ямар нэгэн дошгин, зэрлэг зүйлийг сэрээхийг хүснэ уу хэмээн гайхлаа.

Өмнө минь Тооллого 23 дахин тодроход, би тэндээс Христэд итгэдэг эмэгтэйчүүдийг босгох үүрэг хариуцлагыг олж үзэв. Яг тэр үед би эрслэн Бурханы охидтой юугаараа зэрэгцэж байгааг мэдэхээр, эрслэнг судлахаар шулуудсан юм. Бүтэн хоёр жил эрслэнгийн талаар судалгаа, ажиглалт хийж, бичив. Эхэндээ Бурханы өгсөн алсын харааг дэлгэлгүй, эмэгтэйчүүд, эрслэн хоёрыг зөвхөн уран сайхны талаас нь л холбож байсан бол, цаг хугацаа өнгөрөх явцад энэ алсын хараа нь дан минийх байх ёсгүйг ойлгосон юм. Миний бие Бурханы онцгой соёрхлыг хүртсэн тулдаа эрслэнгийн үзэгдлийг үзээгүй ажээ. Мөн алсын хараа нь хэт хөгжчихсөн тулдаа ч үзсэн юм биш. Бурхан намайг хожмын нэгэн өдөр дуу хоолой болно гэдгийг мэдсэндээ, энэ үзэгдлийг үзүүлжээ.

“Чи эрслэнг сэрээнэ” гэж хэлэх тоолонд, энэ үг эмэгтэйчүүдийг дэлсэж байгааг би хардаг. Тэд заримдаа яг л зүрх сэтгэлээ услуулсан мэт нууцхан нулимсаар хариулдаг бол, заримдаа илчлэлээр амьсгалах шиг санаа алдаад, үзэсгэлэнтэй бөгөөд дошгин байх нь эрүүл гэдгийг ойлгодог. Бурханы охин бүрийн дотор хурганы чанар оршдог шигээ, эрслэнгийн чанар ч амьдарч байдаг учраас, энэ үгд маань манай эмэгтэйчүүд тун өөдрөгөөр хариулдаг. Энэ бол эрслэнгээ сэрээх цаг.

Эрслэнгийн талаар бодохоор, цаанаасаа л инээд хүрэх шиг. Бүр нэг цээж төвхийгөөд явчихдаг. Эрслэн л надад эмэгтэй хүн гэдгээрээ бахархах баярхлыг бусад ямар ч амьтнаас илүүтэй хайрладаг. Эрслэнгийн хүчинд эргэлзэшгүй. Түүнчлэн арслан ч бас эр хүний хийморь сүлдийг хамгаас онож илэрхийлэх байх. Арслан бол ширэнгийн хаан. Тэгвэл түүний хатан хэн гэдгийг тааж ядашгүй.

ХАРААД... СУРАЛЦ

Бурхан эгэл бүтээлээр дамжуулан бидний ойлголтыг сэргээдэг нь байдал зүйл. Есүс цэцэгсээр зүйрлэн Бурхан биднийг яаж хувцаслаж, яаж санаа тавьдгийг заасан байдаг (Матай 6:28; Лук 12:27-г үзнэ үү). Мөн тэнгэр Бурханы алдрыг тунхаглаж, Түүний зөвт байдлыг гайхуулдаг. (Дуулал 19:1, Дуулал 50:6)

Тэнгэрс Түүний зөвт байдлыг тунхагладаг бөгөөд
Бүх хүмүүн Түүний цог жавхланг харсан. (Дуулал 97:6)

Бүтээлийн зэрлэг, дошгин гоо үзэсгэлэн биднийг бүтээсэн Бурханыг маань зэрвэс харуулах шиг. Цонхоо яр. Бурханы энгүй бөгөөд номхрошгүй гоо үзэсгэлэн чиний дотор тэнгэрийн биширхүйг сэрээн сийлэг. Бид бүтээлийн гайхамшигийг үзэх аваас, энэ нь Бурханыг гэх хүсэл тэмүүллийг маань өдөөнө. Сүнс маань харсан зүйлдээ хариу үйлдэх л болно. Бүтээл “Цаана нь бүр их зүйл бий! Нүдэнд харагдаж байгаагаас ч их зүйл. Чихэнд сонсогдож байгаагаас ч их зүйл. Хүний хугацаатай амьдралаас ч их зүйл. Дээр залрах мөнхийн Бурхан бий” хэмээн тунхагладаг.

Есүс Христ дэлхийн сууриас ч өмнө нядлуулах Хурга болж ирсэн боловч, Илчлэл ном Түүнийг Арслан хэмээн илчилдэг:

Ахлагчдын нэг нь надад —Бүү уйл. Харагтун, хуйлмал номыг болон долоон лацыг нь нээхийн тулд *Иудагийн овгийн Арслан* буюу Давидын Үндэс ялсан юм гэлээ (Илчлэл 5:5).

Есүс Христ *Арслан ч, Хурга ч* мөн. Эсрэг тэсрэг хоёр дүрийн нэгдэл гэж байдаг эсэхийг би гайхдаг. Мессеж Библи дээр Иудагийн арслан “долоон лацыг урна” гэдэг. Илчлэл номын бичээч Иохан тэнгэр, газар, доод ертөнцөөр хүртэл хайгаад, долоон лацыг нээж, илчлэлийг хөврөөх зохистой нэг ч амьтныг олж чадаагүйдээ уйлсан. Тэгтэл түүний дэргэд байсан ахлах Иоханыг *нүдээ нээхийг* урамшуулжээ. Учир нь манай Хурга дотор Арслангийн илчлэл орших ажээ. Тэрбээр Ганцаар лацыг задлах ажлыг эхлүүлэх бүрэн эрхтэй болой.

Урж хүүлэх нь түрэмгий үйлдэл. Миний санаанд шууд л хоёр хэсэг болж хүүлэгдсэн сүмийн хөшиг буув (Марк 15:38). Дээрээсээ доош хүртэл цуулагдсан. Бурхан маань бидний дунд хөндөлсөх, тусгаарлах алив

Биднийг чөлөөлөхийн тулд байгаль сүнстэй хуйвалдах.

— Ральф Уальдо Эмерсон

зүйлийг хүү татаж хаядаг. Биширмээр биш гэж үү? Тэнгэрээс гаралтай нууцын ном - Илчлэл ном дээр тэнгэрт хуйлмал номын лацыг тайлах үйлдэл нь газар дээрх юмсыг хөдөлгөөнд оруулдаг.

Одоо ч Бурхан хүн бүрт Өөрийнхөө хувийг задалж, илчлэхийг хүсч байгааг нь би мэдэрч байна. Хүн бүрт илчлэх гээгүй л юм бол, Бурхан яах гэж дэлхийн ер бусын төгсгөлийн түүхийг бичүүлсэн байх билээ? Бид цөхөрч, уйлахын тулд биш, харин зовхио өргөн, нүдээ нээгээд, жинхэнээсээ харахын тулд дахин уригдсан гэдэгт би итгэдэг.

Манай дэлхий тэнгэрийн илчлэл, цэц ухааныг цуурайтуулдаг.

Тэнгэрийн Аав маань бидний зүрхийг нээх гэж л бүтээлээ урласан нь юутай сайхан. Ургамал, амьтан, бүтэц, хөрст дэлхий тэр чигээрээ “Бос, хэн байх ёстой - түүгээрээ бай” хэмээх шиг. Иовын хэлснээр, байгаль бидэнд нэгийг сургах хүчин чадалтай ажээ.

Газрын амьтдаас ч илүүгээр биднийг сургадаг, Тэнгэрийн шувуудаас ч илүү биднийг Тэр мэргэн болгодог” гэдэг хүн нэг ч байдаггүй. (Иов 35:11)

Бидэнд Өөрийнхөө цэц ухааныг хүрэлцүүлэх гэсэн Бурханы хайрын гайхамшиг, цар хүрээнд хүн бидний ухаан хүрэхгүй. Тийм боловч үүнд гайхах ёсгүй. Учир нь Бурхан:

“Учир нь ойн амьтад бүгд,
Мянган толгод дээрх мал сүрэг Минийх.
Би уулын шувуу бүрийг мэдэх бөгөөд
Хээр талд хөдлөх бүхэн Минийх.
Би өлссөн байлаа ч чамд хэлэхгүй байсан.
Учир нь ертөнц хийгээд
Түүнийг дүүргэдэг бүхэн Минийх” (Дуулал 50:10-12) гэдэг.

Бид өөрийгөө газрын бүтээлүүдээс тусгаарладаг ч, Бурхан тэднийг нэр нэрээр нь мэднэ. Бурхан бүтээлүүдээ тоодоггүй гэж бодож байна уу? Бурхан бүтээлээ Өөрийнхөө төлөө загварчилсан. Чихээ нээх аваас - байгаль Бүтээгчээ эцэсгүй илчилж байдаг. Сургаалт үгс дээр “Яв, шоргоолж юу хийдгийг хар, ухаан суу, залхуу минь” (Сургаалт үгс 6:6) гэдэг.

Яг одоо Бурхан биднээс үүнийг л хүсч байгаа. Бурхан биднийг эрслэнгээс суралц гэж байна. Бурхан биднийг “*Охид оо, эрслэнг хар. Анхааралтай аж. Түүгээр өөрийнхөө номхрошгүй мөн чанар, зэрлэг гоо үзэсгэлэн, хорьшгүй хүч тэнхээг сэрээгээд, босоод Миний хүссэн зоригт бүсгүйчүүд бол*” гэж байна.

Эрслэнг сэрээ

Эрслэн хэрхэн эмэгтэйчүүдийн хүч, зоригийг илчлэх билээ? Эмэгтэйчүүд хэрхэн эрслэн мэт босж ирэх билээ? Хүн бүр өөрийнхөөрөө хариулах байх. Гэхдээ эрслэнгийн мөн чанарыг зэрвэс харахуй нь чамд ухаарал хайрлаж юу магад. Бүгдээрээ дараа дараагийн бүлгээрээ Африкийн халуун наран дор тухлаж хэвтээ эрслэнг өндийхөд хүргэдэг дараах хэдэн шалтгааныг үзнэ:

Эрслэн хүчээ авахаар босдог.

Эрслэн бусадтайгаа уулзаж, үйл хөдлөл хийхээр босдог.

Эрслэн анд гарахаар босдог.

Эрслэн бусад эрслэнгээ дагаж босдог.

Эрслэн үр зулзагаа хамгаалахаар босдог.

Эрслэн бардам зантай нь шөргөөлцөгч
дайсантай мөргөлдөхөөр босдог.

Эрслэн хаантайгаа хамт алхахаар босдог.

Эрслэнгийн дүрслэл нь Өндөр Бурханы охин бүр хүчээ хүлээн авч, урмаа хөгжүүлж, амьдралд нь гарч буй өөрчлөлтийг бодитой болгохыг дүрслэн харуулдаг гэмээр. Дотор чинь эрслэн нойрсож байна уу? Номоо уншиж дуусгахдаа чи хариултаа хүлээн авч, хариулт чинь чиний доторх дошгин, үзэсгэлэнтэй, зэрлэг чанарыг сэрээсэн байх болтугай гэж залбиръя.

ҮЛ ҮЗЭГДЭХ ХҮЧ

Дэлхийн эмэгтэйчүүд зүгээр л цэвэр хүн төрөлхтний төлөө эвсэн нэгдэх цаг ирдэг юм бол, тэр нь дэлхийн урьд хожид үзээгүй хүч байх болно.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗУУНЫ

АНГЛИЙН ЯРУУ НАЙРАГЧ, ФИЛОСОФИЧ

МЭТЬЮ АРНОЛД

Биднийг яг одоо сэрээж байгаа юм биш байгаа? Миний бие энэ нэгдмэл хүчийн сүүдрийг үзсэн завшаантай хүн. Бүрэн хэмжээний хөдөлгөөн болтлоо ургах нь баталгаатай энэ үйл явдлын үр жимсийн дээжийг би эх орондоо ч, Европ дорх хязгаар нутагт ч үзсэн. Энэ цугларалт нүд ирмэхийн зуур л дөнгөж нүдээ нээсэн нярай охиноос нас биед хүрсэн бүсгүй болон хувирч байна. Дээрх яруу найрагч, философич хүний үг нь чиний дотор хараахан биелээгүй байгаа зүйлд чинь хандсан үг бус уу? Би дээрх үгийг анх уншуугаа л жинхэнээсээ зог тусан, амьсгаа түгжсэнээ санадаг юм.

Бие маань өөрт буй, огтоос мэдээгүй байсан *хучин чадлаа* олж мэдсэндээ хариу үйлдсэн нь тэр байж. Чиний доторх зэрлэг, ухаалаг, гайхамшигтай нэгэн зүйлийг чинь л сэрээхийг хүсээд байгааг минь чи энэ номын гарчгаас хэдийн мэдсэн байх аа. Сайн сайхны төлөө эмэгтэйчүүд эвсэн нэгдэх талаар эргэцүүлэн бодохыг уриалж байна би. Шаардлагатай бол, дээрх үгийг ахиад унш. Учир нь энэ үгэнд хальт гүйлгээд өнгөрөх бус, хамаг анхаарлаа төвлөрүүлж хармаар үнэт найдвар оршин буй юм.

Өөрөөсөө “Мэтью Арнолдын үг онол, улс төрийн уран илтгэл юмуу найдлага төрүүлсэн таамаглалаас том зүйл байж болох уу? Түүний гэгээрэл цагаа олсон, уриалсан, тэр бүү хэл зөгнөлийн шинжтэй байж болох уу? Тэрбээр өнгөрсөн цагаасаа өнгийгөөд, манай цагийн охидыг эвсэн нэгдэхийг уриалсан уу? Тэрбээр өөрийнх нь цаг үед энэ нэгдэл болох ч үгүй, болох боломж ч үгүйг мэдэж байсан ч, манай цаг үед болохыг мэдэж байв уу? Тэрбээр манай цагийн хэрэгцээ ямар том болохыг ухаарч байв уу? Тэрбээр энэ цагийн чи, бид хоёрыг олж хараа юм болов уу?” гэж асуу.

Эдгээр асуултын жинхэнэ хариулт нь эмэгтэй хүн бүрийн цөмд орших бөгөөд үүнийгээ тэд үгээрээ бус, амьдралынхаа сонголтоор л хамгийн сайн харуулна гэдэгт би итгэдэг. Эмэгтэйчүүд энэ асуудалд аль хэр хүчин чадлаар хариулах нь амьд яваа цагтаа ямар хариу үйлдэл хийхээс нь л мэдэгдэнэ. Цаашилбал, хөвгүүд, охидоо ирээдүйд зөв сонголт хийдэг хүмүүс болгохын төлөө зөв байр суурь руу чиглүүлж буй эсэхээс сонголт нь бүр тодорхой харагдана.

Энэ цагийн эмэгтэйчүүд “бүсгүйчүүдийг ялгаварлан гадуурхахад хүргэж байгаа даян дэлхийн соёл, шашны зөрчилдөөнтэй, боогдмол дүр байдлыг” даван гарах уу? Олон талын дэмжлэггүй байсан ч, хилийн чанадад буй зоригт эгч дүүс маань урагш гарч ирж чадах уу? Барууныхан бид дэмий хоосон юмсаасаа эргээд, жинхэнэ үнэ цэнэ, үнэ хүндэтгэлтэй юмстаа анхаарах уу?

Бид хувь нэмрийг маань үл хэрэгсэж, Бурханаас биш гэж мэдэгдэх зөрчилдөөнтэй дуу чимээ, хэрүүл маргааныг давж гарч чадах уу? Бид цаг үеийнхээ ачаалал, тулгамдлыг ойлгож, зэрэгцэхийн тулд доктрины ялгаа, санаагаа хойш тавьбал, яаж байна? Зүрх, гараа нэгдүүлбэл, эрин цаг төгсөх болов уу? Бид итгэлээр нэгдэх үү? Нэгдмэл итгэл маань зүгээр л нэг эрээвэр хураавар итгэлийн зуурмаг шиг байх ёстой юу?

Нэгдэл маань албадлагын байх уу, амьтай байх уу? Хамтын итгэл маань ажил үйлсээр түрэгдэж, биднийг тов тодорхой, дур булаам, дошгин, бодитой зүйлийн нярвууд болохыг маань илчлэх үү?

Нэгдэл маань бидний найдаж зүрхлэх зүйлсийг ил тодоор дүрслэн харуулж, жинхэнэ итгэлийн маань амьд мэдэгдэл байх уу? Энэ итгэл биеэ хумин, өөртөө л хураагаад байхын оронд өөрийгөө өгөөмрөөр дэлгэн, бусдад өгөх үү? Би үүний л төлөө залбирч байна. Учир нь ингэсэн цагт л дэлхий тэлж, бидний сунгасан гараар хүмүүсийн амьдрал өөрчлөгдөнө.

Тийм ээ, би одоогоор ердөө л жаахан сунгалтыг л хүсч, гуйж байгаа маань үнэн. Гэхдээ сунгахгүй бол, бид тэлэхгүй шүү дээ. Одоо хаана байгаагаа л хараад байж болохгүй. Сунгах гэж байгаа бол, арагшаа, урагшаа, эргэн тойрноо харах хэрэгтэй.

Арагшаа харбал, 1800-гаад онд эмэгтэйчүүд бараг л дуугарах эрхгүй байж. Эргэн тойрноо харбал, дуу хоолой маань яагаад чухал болохыг бид ойлгоно. Урагшаа харбал, бид ирээдүйгээ үг, амьдралаараа босгон байгуулах ёстойгоо ойлгоно.

Хараагаа томруулж, амьдралын олон талбартай харилцах цаг болжээ. Булчингийн бүлд хүчдэл, чангарал, таталдал үүсэх үед хүн суниаж, сунгах үйлдэл хийдэг байна. Суниаж сунгах чадвар нь уян хатан байдлыг нэмэгдүүлэн, гэмтлээс сэргийлнэ.

Өнөөдөр үр хүүхэд маань хэрхэн өсч байгаагаас томчуудын маргаашийн асуудлын шийдэл ихээхэн хамаарна.

— Margaret Muig

Би эрслэнгээр дамжуулан чиний амьдралыг сунгамаар байна. Эрслэн чиний өөрийгөө, бүсгүй хүний чанар, гоо үзэсгэлэн, хүч, зорилго, гэрлэлт, ертөнц, Бурханыг үзэх үзлийг сунгах болтугай. Эрслэн чиний харилцаа холбоог сунгаанд гаргаж, эрчүүдтэй, нөхөдтэйгээ, гэр бүлтэйгээ тогтоох харилцааг чинь хөгжүүлэх болтугай. Эрслэн хүртэл харайхаасаа өмнө биеэ сунгадаг юм шүү.

Өмнө маань амьдралын ч, дэлхийн ч хэрэгцээ хүлээж байна. Энэ том талбарыг үүрэхийн тулд бидэнд аль, алийг нь тээсэн алсын хараа хэрэгтэй.

ХҮЧТЭЙ УЧРААС АМГАЛАН, ЧАДАЛТАЙ УЧРААС ТАЙВАН

Цаашаа явахаасаа өмнө алсын харааны араас төрсөн асуултад хариулмаар байна. Би *“Дээрх эшлэл дээр Бурханы хүмүүс харгислалд залгиулж байхад, эрслэн яахаараа энгүүн тайван байгаа тухай гардаг билээ?”* гэж гайхсан сан. Цаг хугацаа өнгөрч, алсын хараа, бодлуудыг тунгаан хөвөх явцад, миний дотор илчлэл төрснийг (мөн төрсөөр байгааг) мэдэв. Сурсан зарим зүйлээ хэлье.

Бурхан надад эрслэнг үзүүлэхдээ, идэвхигүй байдлаар юмуу айдсаар хариу бариасай гэж хүсээгүй ажээ. Эрслэнгийн дүр төрх нь миний хязгаартай, аймхай үзэл бодлыг илчилсэн бөгөөд үүнтэй маань зөрчилдсөн буюу. Эрслэн нүдийг минь нээж, харааг минь өргөтгөж, үйл хөдлөлийг минь томруулсан юм.

Би аялахдаа, ангайж алмайрмаар хөшөө баримал үздэг. Дани, Ром, Лондон, Парист хүч чадлыг магтан алдаршуулсан, түүхэн эрх чөлөөний эгшин, байлдан дагууллыг алдаршуулан хүндэтгэсэн, аугаа хөшөө дурсгал олон. Би ч өнөөг хүртэл цуурайтсаар буй тэдгээр урлагийн суу бүтээлийн цагийг эзэлсэн гоо үзэсгэлэн, тансаг чанарыг биширч, зураг хөргийг нь ч дарж явсан.

Тэгвэл миний үзсэн эрслэн хөшөө дурсгал биш, харин илчлэл байв.

Илчлэл нь илчилж, гайхшруулах идтэй. Унтлагын хувцастай, бөмбөгнөн зогсох, цүдгэр эмэгтэй би эрслэнгийн өмнө зогсохдоо үнэхээр ч гайхширч, хамаг байдгаа илчлүүлсэн минь үнэн. Эрслэн нэг ч хөдлөөгүй боловч, надаас ч илүү амьд байсан сан. Түүний гоо үзэсгэлэн, хүчийн гэрэлд миний бие алдсан зүйлээ ухаарсан юм. Би айдсаасаа болоод хүч, амь, гоо үзэсгэлэнгээ гээжээ. Би өөрийнхөө жинхэнэ утгаа алдсан учраас, үүнийгээ дагаад Бурханы надад зориулсан боловч, биелээгүй түмэн зүйлийг алджээ.

Би Израильчууд өөрсдийгөө царцаа гэж, Канааны ард түмнийг аваргууд гэж харж байсныг санасан ч, Канааны ард иргэд Израильчуудыг арслан, эрслэнгүүд гэж харж байсныг нь бид Тооллого 23-аас мэднэ.

Эрслэн эгчийг өөртэйгээ жиших юм бол, энэ хоёр үзлийн эсрэг тэсрэг байдал шууд бодитой болж ирнэ. Бид эрслэн эгч шигээ болж чадах уу? Бид хүчтэй учраас амгалан, чадалтай учраас тайван байдаг эмэгтэйчүүд болж чадах болов уу? Бид гоо үзэсгэлэнгээрээ нүүр улайлгүй гангалж чадах болов уу?

Амар амгалантай хосолсон эрслэнгийн дүр төрхийг бид өөрийн болгох ёстой.

Цаг нь болоход, эрслэн боссон. Энэ бол чиний өөрийнхөө хэн болохыг мэдэх цаг. Энэ үед чи өдөөгдөж, сэрж, тав тухаа орхиж, өөрийгөө албадан сэрээх ёстой.

Хүчтэй учраас амгалан, чадалтай учраас тайван байхын эрч хүч нь бурханлаг эмэгтэйн ил тод, үзэсгэлэнтэй дүр төрх болохыг би мэдэж авсан.

Ер нь бол - *хүчтэй учраас амгалан, чадалтай учраас тайван* болоход цаг хугацаа шаардагдана. Дотор чинь хүч амьдарч байгааг ухаарахын цагт чи асна. Бид зөвт байдал дотор амардаг шиг хүчний дотор ч хорогдож сурах хэрэгтэй. Бид тэмцэлдэхээ болихдоо, амралтыг олдог.

Израилийн Ариун Нэгэн, Эзэн БУРХАН айлдахдаа “Гэмшил ба амар тайван дунд Та нар аврагдах болно. *Үнэнч итгэл ба чимээгүй байх нь Та нарын хүч мөн*” гэлээ. (Исаиа 30:15)

Мэдэв үү! Үүнээс тодорхой яаж хэлэх билээ. Тайвшраад, Түүнд найдбал, хүч олгойдно. Өөрийнхөө хүчээр зүтгэхээ болих үед бидний жинхэнэ хүч илчлэгдэнэ. Бурхан чамаас хүчээ харамладаггүй, харин ч харамгүй бэлэглэдэг.

Гэтэл манай эрслэн эгч дүүсээс ялгаатай нь - олон бүсгүй өөрийнхөө хүчээс айж явдаг. Дотор нь ямар нэгэн санаа, асуулт, хүсэл тэмүүлэл төрөхөөс ухаан алдана. Хүчээс айх ёсгүй, хүчийг тас тэврэх ёстой. Номхон

байдлыг ноомой байдалтай эндүүрэв! Номхон байдал нь хяналтан дор хүч, чадлаар хатаагдаж бий болсон чанар болой.

Мосег номхон, даруу гэсэн. Тийм боловч тэрбээр маш хүчирхэг удирдагч, айдас төрүүлэм хүчтэн байв. Мосе “за гэвэл ёогүй” тэр Бурхантай учирсан учраас л тэр байх.

Сайн, мууг мэдрэх болгоомжлол бүхий сэрэмж нь хүн бидний нүцгэн байдлыг сүрдүүлэн, тэнгэрээс хариулт хүсэн гуйх. Бурхангүйгээр сайнаар амьдрах гэж оролдох нь хүмүүнийг хязгаарлана. Өнөөгийн дэлхий хязгааргүй хариулт шаардах, үй түмэн асуудалд ороогдоод байна.

Чичирхийлж байгаа дэлхийгээ тайтгаруулахын тулд Мосетэй адил бидэнд ч бас Бурханы сайн сайхны илчлэл хэрэгтэй байна.

Тиймээс Бурханы хайртай охин минь, чи энэ сайны илчлэлийн нэгээхэн хэсэг байхад зүрхлэн итгэж, бусадтайгаа нийлээд, өөрөөрөө дамжуулан Бурханы сайхныг үзүүлэх үү?

ХАТАН УХААНТАЙ, ЧАДВАРЛАГ

Миний бие “сайныг” зориуд “сайхан”, тэр байтугай “аюулгүйн” талбараар хязгаарласангүй. Тэгээд ч энэ чинь хүч. Түүнчлэн *хатан ухааныг* ч хүч хэмээн дүрслэн тайлбарлаж байхыг би сонссон.

Зохистой чадварлаг эхнэрийг хэн олж чадах вэ?

Тийм эхнэр эрдэнэсээс ч үнэтэй.

Эр нөхөр нь түүнд итгэлээ тавих агаад

Эд олз нь эс хомсдоно. (Сургаалт үгс 31:10-11)

Ганц бие эмэгтэйчүүд өөрийгөө энэ эшлэлд хамаарахгүй гэж үзэхээсээ өмнө Есүс чиний Сүйт хархүү болохыг санаарай. Энэ эшлэлд бид бүгдээрээ багтана.

Хамгийн гол нь бид энэ үүргийг дааж чадах уу? гэдэг л асуудал болоод байна. Бид эргэн тойрныхоо хүмүүсийн амьдралыг баяжуулж чадах уу? Бид нэгэн зэрэг хатан

ухаантай бөгөөд чадварлаг байж чадах уу? Эсвэл хатан ухаантай, чадварлаг гэсэн хоёр хэсэгт хуваагдах уу? Хоёуланг нь бус, аль нэгийг нь илэрхийлэх хангалтгүй. Бидэнд маш чадварлаг бөгөөд хатан ухаантай бүсгүйчүүдийн хүндэтгэл хүлээсэн цуглаан хэрэгтэй. Чадварлаг байхад

Цаасан дээр нүсэр хөтөлбөр гаргах хангалтгүй. Би санаагаа хөрсөн дээр бичих ёстой.

— Эмили Перейри

юу хэрэгтэй вэ? Товчхондоо, юм бүхэн хэрэгтэй. Бид шаардлагатай бүхий л чадлаараа чадварлаг байх хэрэгтэй.

Сүүлийн арван жил би бусдад хүчин чадлыг нь ухааруулахын төлөө амь биеэ зориулж яваа, олон сайхан эмэгтэйтэй уулзлаа. Хэрэгцээгээ ухаарахынхаа хэрээр эмэгтэйчүүд чадварлаг хариутай байхын тулд боловсрол хөөж, тодорхой талын авьяас чадвараа хөгжүүлж байна.

Тэд - ойлгож ухаарсан эсвэл өөрт хамааралтай юмсынхаа хүрээнд асуулт асуух, ухаант бүсгүйчүүд. Тэд тулгал өсөхийн тулд шаардлагатай чанарыг арвижуулахыг сурсан хүмүүс. Эдгээр эмэгтэйчүүд - авьяастай, бэлэгтэй, аймшиггүй атлаа хүндэтгэлтэй, харилцан хамааралтай атлаа өөрийгөө хэн болохыг мэддэг, одоо цагаар амьдардаг атлаа алсыг хардаг, энэрэнгүй атлаа дошгин, ариун боловч гэнэн биш, хүчтэй бөгөөд зөөлөн, энгийн атлаа өндөр стратегитай.

Бидний төлөвлөгөө, хөтөлбөр хөрвүүлэгдэж, газар дэлхий, үүний оршин суугчдад нөлөөлөхгүй юм бол, онолоос цаашгүй болно. Хөтөлбөр маань амилах хэрэгтэй. Дуу хоолой, гар хөлөө өргөсөн цагт л эдгээр нь ажил хэрэг болно.

Манай дэлхий олон хүчинтэй мөргөлджээ. Зуун зууны явцад газар дэлхий маань хар шуурга, цунами, аадар зэрэг байгалийн хүчинд зөндөө л нүдүүлсэн. Газар хөдлөлтийн улмаас дэлхийн гадарга хэд хуваагдаж, суурь нь хүртэл цуурчээ. Зэвсэгт хүчнүүд сайны төлөө ч, дайны төлөө ч үй олон удаа цугласан. Тэд тулааны талбарт мөргөлдөхдөө, ардаа сүйрэл л үлдээх.

Тэгвэл аймшигтай хүчирхэг атлаа айлган сүрдүүлдэггүй, заналхийлдэггүй, устгадаггүй хүчин юу вэ? Энэ хүчний гишүүд нь стратегитай атлаа онцгой үүрэг оройлтой байдаг - зарим нь ил, зарим нь далд - гэхдээ бүгдээрээ үнэ цэнэтэй. Энэ хүч аминч сэдэлгүй, энгийн зорилготой байсан бол, яах уу? Үүнийг юу гэж хэлэх үү?

Аугаа их Александр хаан:

“Би хониор удирдуулсан арслангийн их цэргээс айхгүй. Би арслангаар удирдуулсан хонин их цэргээс айна” гэсэн байдаг.

Биднийг юутай гайхмаар дүрслээ вэ? Бид бол Арслан - удирдагчтай хонь - цэргүүд. Бид Арсланг дагадаг учраас, номхон хонь шиг дайтдаггүй. Бид номхон дагаж, аймшиггүй дайтдаг. Ийнхүү номхон, аймшиггүй хоёр нь өөр хоорондоо зохицон, эвлэлдэнэ. Хүн төрөлхтний хүчний замнал, түүхээс нэгэн үлгэр загвар харагддаг. Эрх хүч хүчээ авна - эрх хүч завхарна - эрх хүч алдагдана - дотроосоо нурна.

Тэгвэл өөр загвар байдаг бол, яах уу? Хэлбэршээгүй атлаа илэрхийлэгдээгүй хүч байвал, яах уу?

Би ойрын хараа тааруу, жижиг үсэг сайн хардаггүй учраас, энэ номоо хэвлэгдэх фонтоос нь хамаагүй том фонтоор бичиж байна. Тийм боловч би холын, том юмсыг маш тод хардаг.

Алсад “үлэмж бэрхшээл, аугаа ялалт” гэсэн зөрчил бүхий, хоёр аж байдал өрнөх нь надад үзэгдэнэ. Хол, ойрын мандал дээр нэгэн зэрэг харанхуйн дараас, жавхлант сэргэлт хоёр үзэгдэнэ. Бурханы бүрэн эрхт гэрэл, төмөр шүүх нь дэлхий дээр газар авсан үзээрийн муухай юмс, завхралыг газар дээр нь илрүүлэн, сөнөөж байна. Бурханы охид ч юу, юугүй дайрахаар мярааж буй эрслэн мэт байна. Энэ бүхэн ирээдүйд бий болохыг би харж байна. Чи ч миний үгд гайхаагүй байх. Би ч бас чамтай адил юмсыг сонины мэдээгээр хардаггүй. Би юмсыг Сүнс доторх нүдээрээ хардаг.

Хараад зогсохгүй... сонсоно. Би холын ч, ойрын ч хашхирааг сонсдог. Би харанхуй шоронд хоригдсон нэгний цөхрөлийн хашхирааг сонссон. Тэд өдөр бүр өөрсдийнх нь дуу хоолойг унтраахаар барахгүй, үр хүүхдийнх нь уйлаан майлааныг ч дарахыг сүрдүүлэн боомилох дарамттай амь тэмцэх. Энэ цөхөрсөн ээж нар үр хүүхдээ л өөрөөсөө сайн явуулахыг хүсэхээс өөр юу ч хүсэхгүй. Нэгэн залуу ээж өөрийг нь “үйлчлүүлэгч нарт үйлчилж” байх хооронд нь орон доороо нуугдаж байдаг, найман настай, өчүүхэн охиныг минь аваад яваач хэмээн биднээс уйлан хайлан гуйсан сан. Золоор Жэймс Робисон, Бетти Робисон хоёрын маань Лайф Аутрийч үйлчлэл охиныг нь аварсан ч, цөхрөлдөө автсан ээж нь айсандаа янхны газраа орхиж явж чадалгүй, үлдэж билээ.

САЛХИН ҮГ

Заримдаа сонссон үгээсээ айх.

Яагаад?

Ямар нэгэн зүйлийг хараагүй юмуу сонсоогүй байх нь амар. Энэ үнэн учраас, ихэнх нь энэ сүрдмээр дүр зураг, чимээнээс сатаарахын тулд нүүрээ буруулаад, нүдээ аньж, чихээ дардаг. Иймээс л аялал жуулчлалтай зэрэгцэн секс наймаа хөгжиж байгаа юм. Тайландад ирсэн гадны жуулчид харсан үзсэн зүйлээрээ зугаацаж цэнгэлдэхийг нь харсан. Миний ярилцсан нэгэн Америк бизнесмэн завхай самуун явдлаа Тайландын эдийн засгийг дэмжсэн гавьяа мэтээр тайлбарлаж байхыг нь ч харсан.

Сонсох чихтэй нь сонсогтун. (Матай 11:15)

Энэ үүрэг Хүний Хүү Есүсийг дээш өргөгдөж, Бурханы Хүүгийнхээ эзлэх ёстой байр суурийг эзэлсэн хойно ч цуцлагдаагүй билээ. Сонсох зүрх зоригтой хүмүүсийн нэн яаралтай хомсдлыг Есүс Илчлэл номд ч дахин хэлдэг.

Чуулгануудад Сүнс юу айлдаж буйг чихтэй нь сонсогтун.
(Илчлэл 2:7)

Бид Түүний асуултад хариулах ёстой. Чих маань онгорхой байна уу?

Үгүй ээ, бид чихээ нээхийг хүсч байна уу гэвэл илүү зөв болох байх. Хайрлагдсан охид минь, бид сонсох төдийгүй, чих тавих энэ үйл явцад бүгдээрээ хамтдаа шүү. Би сэрэхдээ, чамайг нудраад “Саяны чимээг сонсов уу?” гэж асууна.

Харамсалтай нь, бид голдуу тухлаг орондоо эргэлдэн хөрвөөгөөд, сэрээж болзошгүй чимээнээс зугтан, зөөлөн дэрэндээ шигдэх, нойрондоо харам сүйт бүсгүй шиг л байх юм. Сэрүүлгээ хэр чанга орилуулж байж бид өндийгөөд, нойрноосоо бүрэн сэрэх ёстой юм бэ?

Энэ харгис дэлхийн чахраа, чарлаанаас гадна өөр нэгэн дуу биднийг дуудна. Энэ дуу нь чарлаан биш, харин үй түмэн чимээ шуугианыг сэтлэн, бидний чих тавих ёстой дуу юм. Энэ бол Сүнсний тогтуун, намуун дуу хоолой. Бид дуудлага бүрийд нь хариулаад байвал, Түүний дуу улам л чангарсаар байна.

Би “салхин үг” гэдэг үгд хайртай. Бурхан үгээ салхинд дайдаг. Амь, хүчийг шивэгнэгч үгийг тээдэг агаарын урсгал, салхитай Ариун Сүнснийг адилтгах. Бид салхийг үздэггүй ч, нөлөөг нь үздэг. Салхи юмсыг таны амьдралд үлээж оруулна эсвэл таны амьдралаас үлдэн хөөнө. Салхины хүч хөлөг онгоцыг түрсээр, боомт дээр нь авчирна. Салхины хүч усыг эргүүлж, уулсыг довтолно. Урагшлах замд ухраагч “сөрөгч салхи” байна, араас түрэн урагшлуулагч “түрэгч салхи” ч байна. Салхи хурдан, удаан байхаасаа үл хамааран, зогсоо зайгүй дэлхийг ээрэн эргэлдэж байдаг.

Салхи Бурханы шивэгнээг нэг газраас нөгөө рүү зөөвөрлөнө.

Гэтэл биднийг тойрон эсгэрэх үй олон хиймэл дуу чимээ Сүнсний *салхин үгийг* сонсох сонсголыг маань битүүлэх нь олонтаа.

Сонсох чадварыг маань битүүлдэг өөр нэгэн саад нь “мэднэ, мэднэ” гэдэг хандлага юм. Бид аль нэг зүйлийг ахин дахин сонсоод ирэхээрээ, сонсголоо унтраагаад, сонсохоо байчихдаг зантай.

Бид хүний үгд “мэднэ, мэднэ” гэх янзаар хандаад ирэхээрээ, тэс өөрөөр сонсож эхэлдэг. Хэдэн жилийн өмнө би яг ийм хандлагаар Бичээсийг уншдаг байж билээ. Би тухайн Библийн хувилбарыг сайн мэдэж байсандаа,

дараа нь юу гарахыг ч мэддэг болжээ. Чи ч бас ингэж байсан л байх. Үүнээсээ болоод би Бурханы Үгийг хүүхэд шиг бишрэн хүлээж авахаа болив. Тэгээд хайхрамжгүй хандлагатайгаа тэмцэхийн тулд Мессеж Библийг барьж авсан юм.

Яагаад? Би гайхшрахыг хүссэн юм. Тэгээд чамд ч бас тэр гайхамшгийг мэдрүүлэхийн тулд Мессеж Библиэс энд нилээд хэрэглэлээ. Би Библийг өөрийнхөө тайлбараар орлуулах гэсэнгүй ээ. Ердөө л нэмэлт судалгаа, ойлголт өгөх гэсэн л санаатай. Тиймээс чи дуртай Библиэ чөлөөтэй хэрэглээрэй.

Зүгээр л, би чам шиг л үнэхээр сонсохыг хүссэндээ л үүнийг хийлээ. Чих маань онгойсон бол, бид бусдын төлөө дуугүй байж чадахгүй.

Ам хэлгүй, арилж одох хөөрхийсийн төлөө амаа нээ.

Амаа нээж, зөв шударгаар шүү

Ядуус ба зүдрэгсдийг шүүн өмгөөл. (Сургаалт үгс 31:8-9)

Энэ хэсэг дээр Соломоны эх Батшеба хаан - хөвгүүндээ шударга бус явдалд няцарсан хүмүүсийн төлөө хүнгэнэсэн хүчирхэг дуу хоолойгоо өргөхийг үүрэгджээ. Мөн хатан ухаант эмэгтэйн талаарх өгүүлэлд ч энэ тухай дурьдсан байдаг (Сургаалт үгс 31:10-31). Соломоны ээжтэй адил, бид ч бас өөрийнхөө төлөө дуугарч чадахгүй хүмүүсийн төлөө дуугарч байхыг эрчүүддээ уриалах уу? Бид чинь Бурханыхаа өмнө хаад, тахилч нараар томилогдсон бус уу? Тиймээс бусад нь чимээгүй байсан ч, бид ярих л болно.

“Эмээ” хүнийхээ хувьд би хөвгүүд, охиддоо үнэхээрийн том өв үлдээхийг хүснэ. Хүйсийн тэнцвэрт байдал нь дэлхийн ядуурал, тэр бүү хэл алан хядлагын давалгааг зогсоох холбоос болж өгөхийг дэлхийн олон төрлийн судалгаа хэлсээр байна. 2001 онд Дэлхийн банкнаас гаргасан *“Engendering Development: Through Gender Equality in Rights, Resources, and Voice”* гэдэг нөлөө бүхий судалгаагаар дэлхийн ядууралтай тэмцэхэд хүйсийн тэнцвэрт байдал амин чухал гэдэг санааг дэвшүүлсэн байдаг. “Охидын боловсролд хөрөнгө оруулах” нь дэлхийн хөгжилд оруулж болох, хамгийн ашигтай хөрөнгө оруулалт болохыг Дэлхийн банкны ахлах эдийн засагч агсан Лоренс Саммерс бичиж байжээ. Гол асуудал нь улс орнууд энэ хөрөнгө оруулалтыг хийх чадалтай үгүйдээ бус, харин “охидын боловсролд хөрөнгө оруулахгүй байснаараа үзэх хохирлоо дааж чадах уу, үгүй юу”¹ гэдэгт л орших ажээ. Мөн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн нэгэн судалгаа “Эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэх нь эдийн засгийн үр бүтээмжийг өсгөхөд тустай”² гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Өнөөгийн терроризм нь аюулгүй байдлын мэргэжилтнүүдийг өөр өөрийн гэсэн хүйсийн судалгаа хийхийг уриалсан бөгөөд үүнээс дараах дүгнэлт гарчээ:

Исламын алан хядагч нар ийм олноороо байгаа нь Корантай холбоотой гэхээсээ илүү Исламын орнуудын эдийн засаг, нийгэмд хүчтэй эмэгтэй оролцогч нар байхгүйтэй холбоотой. ...Охидыг тодорхой хэмжээгээр зэвсэгт хүчинд бэлтгэх нь ч алан хядагчдын хүчийг сулруулах болно.³

Ийм төрлийн амин чухал, гэгээрүүлсэн, нарийн судалгаанд өндөр үнэ, хүчин зүтгэл ордог. Бурханы хэдийнээ хэлсэн зүйл рүү хүмүүний цэц ухаан эргэж байхыг харах шиг биширмээр зүйл үгүй. Дэлхий дээр асуудал бий болохоос ч өмнө дэлхийд хариулт өгөгдсөн байжээ: тэр хариулт нь эмэгтэй хүн юм.

Хүн ганцаараа байх нь сайн биш. Би түүнд тохирох туслагчийг буй болгоё (Эхлэл 2:18).

Эр хүн ганцаараа байх нь сайн биш байж. Тэгэхээр, яг тэр үе шиг үржлийн тэгшитгэл дээр эмэгтэйчүүдийг нэмэх нь эрчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүд, бид бүгдийн нийтийн дэлхийд ч ач тустай. Тусгаарлагдмал амьдрал нь “сайн биш зүйлийг” урьдаг. Хүмүүс бие биетэйгээ холбоотой байхаар бүтээгдсэн. Тийм боловч, дан эрчүүдийн зузаарал ч сүйрэлд хүргэх боломжтой. Эхлэл номын сургамж, орчин цагийн судалгаа нь эрчүүд ноёлсон соёл нь бүх төвшин дээрээ эрүүл бус болохыг хэлдэг.

Чи зарц байхаар бус, хамтран өвлөгч байхаар бүтээгдсэн. Эмэгтэйчүүд бол Бурханы хариулт. Эмэгтэйчүүдийн дуу хоолой нь хүүхдийн боловсролын тэгш боломжийг нэмэгдүүлж, эдийн засгийг сэргээн, терроризмыг бууруулдаг нь тодорхой.

Тэгвэл эмэгтэйчүүдийн энэ хариулт ямар байдаг вэ?

Би эмэгтэй хүн байхын утга учраа ухаарч, өөрийн болгох үедээ өөрийгөө амьдралын алдаа биш байсныг ойлгосон юм. Охин, гэргий, ээж хүнийхээ хувьд би хариулт байжээ. Би хариулт юм бол, бусад эмэгтэйчүүд ч ялгаагүй л хариулт байх ёстой. Бид Бурханы мэлмийд хоёрдагч иргэд биш. Бурханы хайрт охин чи, хүн төрөлхтний асуудалд амьд шийдэл, амьсгал байх хүчин чадалтай.

Би даян дэлхийгээр аялж, өгөл, балчир эмэгтэйчүүдийн амьдралд энэ энгийн үнэнийг мэдэгдэх үед тэд ямар хариу үзүүлдгийг үгээр

илэрхийлэшгүй. Тэд энэ үгийг зүрх дэлдэн сонсохоос гадна чангаар хэлж, итгэдэг.

“Би бол хариулт.”

Тэр эгшинд тэдний дотор илчлэл суниана. Хараа нь дахин төвлөрч, бүсгүй хүнийхээ чанарыг өөрийг нь бүтэн болгодог Бурханыхаа нүдээр харж эхэлнэ.

Гэхдээ энэ ухаарал нь дөнгөж эхлэл болой.

Эмэгтэйчүүд зүгээр нэг эдийн засгийн зузаатгал биш юм. Шийдэл авчирдаг чадварыг маань дагаад шинэ асуултууд ч үүснэ. Эмэгтэйчүүд бол хүн төрөлхтний анд нөхөр гэсэн шинэ хүний эрхийн түүгээмэл тунхгийг бид бүтээж байна. Бид хүүхэд, эмэгтэйчүүдийг мөлждөг биш, харин соёрхдог дэлхийг бүтээхээр цуглаж байна.

Тэнгэрийн охидын талаар би дараах зүйлсийг мэдэж авсан:

Тэрбээр хайр татмаар, ухаантай, чадвартай.

Түүний амьдрал тасархай биш, харин холбоостой.

Түүнийг Бурхан хайрладаг бол, Сатан үзэн яддаг.

Дэлхий түүнийг ил, далдаар дарладаг.

Тэгэхээр: хэрэв түүнийг дэмжээд өгбөл, хэрэв чи стратегитай байвал, эмэгтэй хүн эцсийн дүнд ямар болж чадах бол?

БОЛОМЖГҮЙ ЗҮЙЛИЙГ СЭРЭЭХ

Би Лайф Аутрийчийн шугамаар бусдын сэтгэлийг доргиох түүхийн эрэлд гаран, Өмнөд Ази, Энэтхэг рүү аялж үзсэн, хувьтай хүн. Камбож, Тайланд, Мумбай руу аялахдаа, үгээгүй ядуурал, бэлгийн мөлжлөгийг гэрчлэн харсан. Түүнчлэн хүмүүсийн өгөөмөр тус дэмжлэг, байгууллагын хамтын ажиллагааны ачаар найдвар, сэргэлтийн амлалт төрөхийг ч үзсэн.

Үйлдэл, хамтын ажиллагаа ус агаар шиг хэрэгтэй байна. Украйнд найзтайгаа өглөөний цай ууж байтал, маш үзэсгэлэнтэй залуу бүсгүй орж ирэв. Украйн ч сайхан хүүхнүүдээрээ алдартай болохоор, энэ ч сонин, содон үзэгдэл биш байв. Гэвч нөгөө бүсгүй жар эргэм насны эрийн хамт явж байлаа. Өндөр өсгийт, бариу өмдтэй тэр охин 18 хэтрэхгүй л насны харагдав. Тэд бидний хажуугийн ширээнд суув. Нөгөө эрийг хоолоо идэх зуур, охин хар кофеогоо оочин, цонх руу хоосон гөлөрнө. Аяганы шүүгээний цаанаас залуу эрчүүд охиныг зааж, хөхрөлдөж, шивнэлдэнэ. Төдөлгүй охиноос хоёр дахин ахимаг насны нэгэн эр ширээнд нь нэгдэв. Би ч уйлмаар болов. Охин өнчин ишиг шиг л ганцаархнаа. Тэрбээр өндөр

хөлсөөр үйлчилдэг, дуудлагын хүүхэн болох нь тодорхой байв. Гэхдээ бид хоёр хүний охин үрийн амьдралаар наймаалцах хоёр панзчны дунд бүлтэртэл гоодсон ч, хайраар ангасан хөөрхий охин суугааг л харж байлаа.

Би хүний наймаанд өртсөн бүсгүйчүүдтэй биечлэн уулзаж явсан. Тийм ээ, тэд бол бидний л эгч дүүс. Тэд дурандаа янхан бололгүй, золиос болж, зарим нь эрэлхгээр тэмцэн босч ирсэн эмэгтэйчүүд.

Лайф Аутрийч байгууллагын ачаар би Энэтхэгийн чийгтэй урт өдөр нэгэн жижиг байранд цугласан хөгшин, залуу хэсэг эмэгтэйчүүдийн зүрх зүсмээр үй олон түүхийг сонсож билээ. Хүн бүр өөр өөрийн гэсэн түүхтэй - зарим нь уйлаад ярьсан бол, зарим нь ямар ч сэтгэл хөдлөлгүй.

Тэд намайг түүхийг нь сонсож яах гэж байгаа юм бол гэж гайхсан л байх. Өрөвдсөндөө юу? Шүүсэндээ юу? Ер нь би тэднийг ойлгох уу даа? Надад хариулт бий гэж үү?

Тэдний дунд байсан Сама гэдэг зоригт бүсгүй (зохиомол нэр) Непалын нэгэн тосгоны, хүсэл мөрөөдлөөр жигүүрлэсэн бяцхан охин байсан тухайгаа дурсан өгүүлэв. Гэвч тэрбээр ээждээ гологджээ. Нэг өдөр ээжтэйгээ маргалдахыг нь харсан хамаатан - ах нь Саматай уулзаад, өөртэй нь хамт Мумбай явж, боломж, боловсрол, мөрөөдлөө хөөхийг ятгажээ.

Итгэмээргүй сайхан амлалт.

Үүр цайхаас өмнө Сама ахтайгаа тосгоноосоо зугтав. Эр зоригийнхоо ачаар Сама урт удаан, хүнд хүчир зам туулсаар, Непалаас Энэтхэг рүү гарч чаджээ. Мумбайд ирээд, ах нь түүнийг нэгэн навсгар дэн буудалд үлдээв. Тэгээд унтаж байх хойгуур нь зарж орхижээ.

Сама бөөн танихгүй хүмүүсийн дунд сэрээд, баахан цочирдож. Ахад нь төлсөн мөнгийг одоо Сама биеэрээ олж төлөх ёстой болжээ.

Самаг нутгийн нэгэн эмсийн хүрээлэнд авчраад, харанхуй өрөөнд хорив. Тэр юу болоод байгааг ойлгож цөхжээ. Ядаж хэл ус ч байхгүй. Хаалга нээгдэж, үйлчлүүлэгч орж ирээд, үйлчилгээгээ авахыг хүсэв. Сама ч байдгаараа эсэргүүцсэн тул түүнийг дөрвөн эмэгтэйгээр бариулж байгаад хүчинджээ.

Сама арван гуравтай байв.

Цаг хугацаа өнгөрсөөр. Сама хэлж сурч, өрөө дарж, энэ хоорондоо шаггүй бизнес - эмэгтэй болжээ. Түүнд хийх ажил, явах газар байхгүй учраас, Сама эмсийн хүрээлэнгийнхээ систем дотор хатагтайн зиндаанд хүрчээ. Тэр өөрөө охидыг худалдан авч, арилждаг хүн болсон байна. Тэрбээр үгээрээ л жаахан охидыг наймаалцдаг болж. Охид Самагийн мэдэл дор хүчиндүүлж, дараа нь Сама тэднийг номхортол нь зодохыг тушаана.

Би Саматай уулзахдаа ярианд нь итгэж ядав. Сама тэр үед хатагтай биш, дунд эргэм насны, намбалаг эмэгтэй болсон байлаа. Нэг хүн түүнд

Бурханы хайрыг ярьж өгөөд, Сама Христэд итгэжээ. Самад шинээр амьдрах боломж олджээ. Сама эмсийн хүрээлэнг хаяж явах эр зоригтой байж. Эдүгээ Сама нэгэн цагт дарладаг байсан жаахан охидоо аврахын төлөө эцэж цуцалгүй хөдөлмөрлөж байна.

Би Саматай ярилцаж байхдаа, яаж яваад хатагтай болсныг нь ер ойлгохгүй байв. Тэгээд нэгэн цагт айж бүлтгэнэсэн, арван гуравхан настай, жаалхан охин байснаа мартсан эсэхийг нь асуулаа.

“Сама, чи яаж тэр жаахан охидыг хулгайлуулж, хүчиндүүлж, зодуулж байхыг нь харж чадав аа?”

Тэрбээр доошоо харан, толгой сэгсрээд:

“Бидэнд амьд гарах өөр арга байгаагүй” гэж хэлсэн юм.

Ихэнхийнх нь хувьд, амьд гарахаас өөр амьдрал үгүй байжээ.

Би эсэргүүцлийн ууланд авирсан. Би хариугүй нурж унах нь уу гэмээр яйжигар байшингаар дүүрэн, бохир гудмаар явж үзсэн. Тийм байшин дотор амьдарч байгаа хүмүүс найдвараар цалгиагүй нь лавтай. Би эмсийн хүрээлэнгээр орж, согтуурч үзсэн. Баруунд ч зорилгогүй амьдралаасаа болж амьдралаас залхаж, сэтгэл санааны хямралаар өвчилсөн эмэгтэйчүүдийг би үзсэн. Хэн болохоо мартсандаа, өв хөрөнгөө үрэн таран хийж байхыг нь ч үзсэн. Бид хамгийн түрүүнд асуудлыг л хардаг. Тиймээс би хариултыг цөхрөн хайж байв.

“*Half the Sky*” гэдэг сэрээж, сэнхрүүлмээр сайхан номоос эш татмаар байна:

Түүхэн давалгаа эмэгтэйчүүдийг сургуультай амьтан, бэлгийн тоглоомоос бүрэн эрхт эмэгтэй хүн рүү хувиргаж байна.

Эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэгч эдийн засгийн давуу талууд машинд өргөжиж байгаа бөгөөд улс орон бүрийг тэр зүг рүү даллаж байна. Удахгүй бид бэлгийн боолчлол, нэр төрийн аллага, хүчлээр түлэх явдлыг Хятадын хөл боодог заншил шиг л гажуу явдалд тооцдог болно. Хамгийн гол нь энэ өөрчлөлт хэр цаг хугацаа авах, биелэхээс нь өмнө хэдэн охин хулгайд өртөж, эмсийн хүрээлэнд хүргэгдэх, хүмүүс энэ түүхэн хөдөлгөөнд нэгдэх үү, дайсагнах уу гэдэг л асуудал болоод байна.⁴


Энэ бол хүн бүрт тавигдах асуулт.

Яг одоо энэ илчлэлийг танд ч тулгаж байна. Үг маань таны дотор нуугдаатай байгаа үл сэхээрлийг сэрээх болтугай. Та эрслэнгийн чадлаар өндийгөөд, явсан газар бүрийдээ Бурханы гайхамшгийг авчрах болтугай. Тэр цагт бид хамтдаа энэ дэлхийн үзээгүй хүч болно. Эрслэн - эгч дүүс минь, цаашаа умш, сэргээ.

АЮУЛТАЙ СЭРГЭГ

Томоотой эмэгтэйчүүд
түүхийг бүтээдэггүй юм.

Лорел Тэтчер Улрих



Миний бие эрслэнгийн талаар судалгаа хийхдээ, эрслэнгийн төрөл бүрийн биеийн байршил, нас, харилцааны талаар ном, нийтлэл уншиж, DVD, баримтат кино, тэр бүү хэл Ютүб бичлэг хүртэл үзэв. Африкийн Сафарид очиж үзсэн хэдий ч, Америк сэтгэлгээ маань эрслэн гэдэг амьтныг дутуу дулимагхан л ойлгоод байлаа. Одоо ч гэсэн би эрслэнгийн мэргэжилтэн гэхээсээ илүү бишрэгч - сонирхогч гэвэл зохих байх.

Нэгэн баримтат кинон дээр шинээр бий болгосон Африкийн хүрээлэнд хоёр эрслэнг, нэг арслантай хамт суурьшуулж буй үйл явдал гарч билээ. Арслан нь манайхаар бол сүргийнхээ азарга нь бөгөөд хоёр эрслэнгийнхээ тус дэмээр ноёрхлоо үтэр түргэн тогтоов. Тэгээд манай гурав Өмнөд Африкийн хүрээлэнгийн томоохон хэсгийг эзэгнэлээ.

Сүргийн нүүдэл, ахицыг дагахын тулд арсланд нь дохиолол бүхий хүзүүвч зүүжээ. Хоёр жилийн судалгааны дараа арслангаас хүзүүвчийг авсан байна. Дахиж хянах шаардлагагүй болжээ. Дээрээс нь хүзүүвч арслангийн зогдор үсэнд саад болж, сүр сүлдийг нь дараад байж. (Арлангууд газар нутгийнхаа эзэрхлийг үс зогдрынхоо хэмжээ, сүр бараагаар шийдвэрлэдэг юмсанж. Дайсны талын арслан зогдор үсээрээ илүүрхэж байвал, түүний хүзүү хоолойг хазах боломжгүй гэж үзээд, тулааныг эхлүүлэхгүй байх жишээтэй.)

Хүрээлэнгийн ажилтнуудын хоёр жилийн өмнө хүзүүвч зүүсэн арслан нь эдүгээ амархан айж сүрдэх нялх арслан бус, хүчит араатан болжээ. Хоёр эрслэнгийнхээ хүчээр тэрбээр ноёрхлоо бат тогтоогоод, сүргээ халдан довтлогчоос найдвартай хамгаалагч болохоо батлан харуулж чаджээ. Эдүгээ тэрбээр эрх дураараа, зоргоороо, зэрлэгээрээ амьдарч чаддаг, баригдашгүй амьтан болж. Хүрээлэнгийн ажилтнууд хүзүүвчийг нь авахын тулд арсланг унтуулахаас өөр аргагүй. Тэд арслангийн байршлыг тогтоогоод, аюулгүй зайнаас нойрсуулах эмтэй сумаар буудав. Эхний сум арсланг яасан ч үгүй. Арслан цочсон ч янзгүй, хүмүүсийг сүрдмээр шар нүдээрээ цоо харлаа. Дахиад буудав. Арслан гуйвснаа, хэвтээд өглөө. Хүрээлэнгийнхэн түргэн аван, газар унаад өгсөн аварга том арслан руу бут сөөгийг дайран, энхэл донхол дундуур харайлган, замаа индүүдэн давхисаар очив.

Тэгээд Жиипнээсээ харайж буугаад, хүзүүвчийг нь авах гэтэл, хэн гарч ирсэн гээч? Арслангийн тэргүүн эрслэн. Эрслэн зогдор үсгүй. Орчиндоо уусч чаддаг чадвараас нь болоод хүрээлэнгийнхэн эрслэнг яг нүднийх нь өмнө гарч ирэх хүртэл анзаараагүй аж. Тэд эрслэнг анзаараагүй гэдэг нь эрслэн тэднийг анзаараагүй гэсэн үг биш. Арсланд нь аюул тулгарсныг мэдэрмэгцээ эрслэн босоод, далдаас гарч иржээ. Тэгээд айж эмээлгүй хүрээлэнгийнхэнд өөрийгөө үзүүлэв. Эрслэн хүрээлэнгийн ажилтнууд болоод арслангийн голоор орон, арслангийнхаа өмнүүр хойгуур чихээ соотойлгон, үсээ босгон, хөндөлсөн алхахдаа, аягүй байгаагаа тэр эрчүүдэд мэдүүлэн, аятайхан байхгүй бол дэмий шүү гэх шиг архирч байлаа.

Хүрээлэнгийнхэнд унтуулах тарианы үйлчилгээ дуусахаас өмнө амжиж, арслангийн хүзүүвчийг мултлах тун жаахан хугацаа байсан ч, эрслэн саад хийж байлаа. Ганц л нөөц сум үлджээ. *Арсланд хүрэхийн тулд эрслэнг унтуулахаас өөр аргагүй.* Бууч буугаа өргөөд, сайтар онилов. Сум эрслэнг оноход, дошгин эрслэн хүрээлэнгийнхэн рүү эргэсэн ч, сумаа даран газарт унав. Хүрээлэнгийнхэн манарсан арсланд хүрэхэд, уур амьсгал давчидмаар байлаа. Арслан эрслэнтэйгээ адил биеийн тэнхээгүй болсон ч, ухаантай хэвээрээ, хүмүүсийг нэг бүрчлэн дагуулан харж байлаа.

Хүрээлэнгийнхэн шивэгнэлдсээр, арслангийн зогдрын доод хэсэгт хүрээд, ангийн хурц хутгаар хүзүүвчийг нь тасдаад, дараа нь мэдээ алдуулагчтай хоёр сумаа арслангаас сугалж авав. Тэгээд холдоод, анхаарлаа эрслэнд хандууллаа. Тэд хоёр аварга муурны аль нэгийг нь мэдээ орохоос өмнө хурдлах ёстой. Эрслэн хажуулдаж хэвтэх бөгөөд хөхнийх нь эргэн тойрны арьс зузаарсан нь хээлтэй болсныг нь илтгэж байв. Хүрээлэнгийнхэн болгоомжтой нь аргагүй гуяыг нь өргөөд, сумаа бушуухан татав.

Цаана нь арслан архирч, босох гэж оролдсон ч, арай л тогтож чадсангүй. Хүрээлэнгийнхэн араатнууд руу эргэж ч харалгүй, машин руугаа уралдлаа. Жиипний мотор асч, хөдөлсөн хойно л бүгд чангаар амьсгаа авав. Тайлбарлагч урьдын нам дуугаа өндөрсгөөд “Сэрүүн арслангуудын дунд байх шиг аюул үгүй” хэмээн тайлбарлалаа.

МЭДЭЭ АЛДСАН ХРИСТЭД ИТГЭГЧ ХҮМҮҮС

“Сэрүүн”, “аюултай” гэдэг үгс миний анхаарлыг олзлов. Сэрүүн, аюултай арслангууд яадаг юм бол? Бид ч гагцхүү сэрүүн үедээ л олныг маань олзолсон харанхуйлалд аюул занал учруулж чадна.

Бурханы хайртай бүсгүйчүүд минь, яг одоо би та бүхнийг биднийг хориондоо байлгахын төлөө чадах бүхнээ хийсэн дайсны зүрхийг үхүүлж явдаг хүмүүс болохоо ухаараасай хэмээн залбирч байна. Дайсан биднийг бүрэн сэрүүн, хөдөлгөөнтэй үед бидэнд хүрч, олзолж чадахгүйгээ мэднэ. Тиймээс биднээр Бурханы дуудлагыг хийлгэхгүйн тулд мэдээгүйжүүлдэг. Гэвч бид миний зүүдэнд орсон эрслэн шиг сэрээд, өндийгөөд, өөрийгөө хэн болохыг санаад, энэ дэлхийн ёрын муутай гэрлээр мөргөлдөх ёстой юм.

ӨДӨР БҮР МЭДЭЭ АЛДААТАЙ

Өдөр тутмын ажил үүрэгтээ дарагдаад, цаг хугацааны баримжаагаа алдаад, нойрмоглоод, Бурханд хайхрамжгүй болохоос сэрэмжлээрэй. Шөнө дуусч, үүр цайх гэж байна. *Бос, Бурханы үйлст сэргэг бай!* Бурхан биднийг анх итгэхэд эхлүүлсэн авралын ажлаа шувталж байна. Өдрийн энэ чухал цагийг зугаа цэнгэл, хөнгөн амьдралын төлөө үрэн таран хийж, үүгээр түүгээр нойрмоглоон зүүрмэглэж, салан баавгай шиг явж, харагдсан үзэгдсэн бүхэнтэйгээ хагаралдаж, сүйтгээд байх цаг бидэнд байхгүй. Орноосоо босоод, хувцасла! Эцсийн минут хүртэл битгий сунжирч, унжралд. Христээр хувцаслаад, босоод, бэлэн бай! (Ром 13:11-14)

Энэ ятгалга дээрх үгийн сонголтыг нь тэмдэглэнэ үү: өдөр тутмын *ажил үүрэгтээ* автаад, цуцах бий. Эдгээр нь нэг бол чиний үнэт цагийг хулгайлна, үгүй бол чамайг унтуулна. Тиймээс ийм бичээс нь үтэр түргэн босоод, Бурханы ажил үйлст сэрэмжтэй, сэргэг байлгах амин ятгалга болдог. Чи Бурханы ажил үйлст сэргэг байвал, юу хийхээ мэдэх л болно! Цалгардах цаг дууссан. Одоо бол бэлэн байх цаг. Сэрүүлэг хэдийнээ дуугарсан!

Саяхан найзтайгаа утсаар ярьсан яриа маань боссон шиг босоод, бэлтгэлтэй байх хэрэгцээг улам л бататгаж өгөв. Тэрбээр нөхөртэйгээ нэгэн рабби багштай маш сайхан хооллож нөхөрлөсөн тухайгаа өгүүлэв.

Тэр рабби Америкийн Еврейчүүдийн хүнд нөхцлийн төлөөх зовнисон зүрх сэтгэлээ уудалсан юмсанж. Тэрбээр Америк даяарх синагогуудаар аялж, номнохдоо, Америкийн Иүдейчүүдэд “Америкийн Христэд итгэдэг хүмүүс нэгдэн босоод, нөлөөллийнхөө хүчийг ойлгож ухаарахын төлөө залбираарай” хэмээн ухуулдаг ажээ. Бидний хэн, хэнд маань тулгардаг анти - Семитик, анти - Христэч явуулгын өөдөөс Америкийн Христчид, Америкийн Иүдейчүүд нэгдэн зогсохгүй аваас, Америкийн Еврейчүүд тоогоор ч, хүчээр ч мөхөсдөнө гэдэгт тэрбээр зовнижээ.

Гэтэл олонх маань өнөөдөр энэ дэлхий дээр өрнөж байгаа бүхэнд бууж өгсөн эсвэл мэдээ алдсан эсвэл бүр ямар ч ойлголтгүй явна. Магадгүй, төөрөгсдөд хүрэхийн төлөө багахан хүмүүсийг л хөдөлгөдөг, мэдээ алдуулагчтай Сайн мэдээг сонссоор байгаад ийм болчихсон юм биш байгаа? Сүнсний хөдөлгөөний дутагдал, дасгал сургуульгүй байдал маань биднийг нойрмог, унжгар болгов уу? Хуульчлалын дарамт юмуу нүгэлд дасан зохицсон байдал маань бидний хөдөлгөөнийг сааруулж, хариу үйлдлийг маань хойшлуулах юмуу хойрго болгоод байна уу? Бурхан биднийг босгож, аюултай сэргэг болгохын тулд сэгсрэх ажилдаа ороод байж болох уу? Тийм бол, анх удаа биш юм.

Израилийн хүүхдүүд цөлд хугацаа хэтрүүлж тэнэсэн. Тэд зүг чиггүй баахан хонь шиг л яваад л байсан. Заримдаа тэнээд, гомдоллосон. Заримдаа дуулгавартай нь аргагүй өдөр нь үүлэн баганыг дагаж, шөнө нь галан багана дор буудалласан. Заримдаа хоньчин Мосегоо сонссон, заримдаа сонсоогүй. Харин Амлагдсан газартай нь хиллэсэн Моабын талд цуглан буудаллахдаа, тэд бүгдэд ил болжээ. Тэднийг ирээд байгааг хөрш улсууд нь мэдсэн. Чадаж мэдэх юм байхгүй, цөлийн тэнүүлчдийн тэр зогсоол нь хөрш улсуудад нь хүчирхэг дайчдын чуулган шиг л санагджээ.

Дарлалаас өөр мэдэх юмгүй боол явсан Израильчууд эдүгээ Бурханы ургийнхан гэдэг нэрээ буцааж авчээ (*Израиль* гэдэг нь “Бурханы ханхүү” гэсэн утгатай нэр). Цөлд тэнэсэн олон жилийнхээ дараа тэд суурин амьдралд бэлэн болжээ. Гэвч тухайн үед хөрш улсууд, зөнч Балаам, хаадын ойлгочихоод байгаа энэ үнэнийг харин Бурханы хүүхдүүд өөрсдөө ойлгоогүй болтой. Тэд эдүгээ тэнүүлчид бус, харин Бурханы шилмэл мөргөлч, дайчин болоод байснаа мэдсэнгүй.

Харамсалтай нь, өөрийгөө ч хэн болохыг мэдээгүй, эргэн тойрныхоо дайсан үндэстнүүдийг ч хэн болохыг үнэн мөнөөр ухаарч ойлгоогүй явдлаасаа болоод Бурханы хүүхдүүд алсын хараа, зорилгоо гээжээ. Тэд урьдын ариун хориогоо хаяад, шүүхийн алдаа гаргав. Тэд Амлагдсан газарт орохоосоо өмнө мунхагаар ариун бус холбоо сүлбээ тогтоожээ. Тэдний алдаа бидэнд: чи сэрүүн атлаа өөрийгөө хэн болохыг мартбал, ялгаагүй л аюулд орохыг анхааруулах.

Товчхондоо, тэд цөлд завхарцгаажээ. Израилийн эрчүүд зөнч Балаамын зөвлөгөөний дагуу хуаран руу орж ирсэн Моаб хүүхнүүдтэй хууль бус бэлгийн харилцаанд орцгоосон (Тооллого 25:1-2, 31:16, Илчлэл 2:14-ийг үзнэ үү). Моаб эмэгтэйчүүд Израиль эрчүүдийг Моабынхаа бэлгийн мөргөлд уруу татан оролцуулжээ. Тэгээд аймшигтай үр дагавар бий болж, Бурханы хүмүүс хэсэгтээ замаасаа гажив. Дараа нь гамшиг, үнэн тахилч, дайсан - Мидианчууд зэрэг үйл явдал ар араасаа хөвөрч байж л энэ бүх гай эцэслэсэн байна. Бурхан Мосед хүмүүсээ тоолж, дахин хуваах заавар өгөв.

Гэвч Израилийн дайснууд тэднийг ялж чадаагүй юм. Израильчуудыг дуулгавартай байх үед бат ялалт ирж, харин Бурханы заавраас гажих үед нь шүүх бууж байв. Тэд гэмшиж, Бурхан гай гамшигийг зайлуулсан - гэхдээ энэ хооронд хорин дөрвөн мянган Израиль хүн үхсэн.

Бид үүнээс юу сурах вэ? Дайсан биднийг мэдээгүйжүүлж - номхон, дуулгавартай, идэвхигүй байлгаж чадахгүй байвал, аль нэг газарт тухлуулаад, бурханлаг бус, завхарсан хүндэтгэл мөргөл рүү урвуулдаг. Мэдээ алдсан Христэд итгэдэг хүмүүс ямар байдаг вэ? Тэд дараах маягийн юмс ярьдаг:

- “Энэ дэлхий удахгүй сүйрэх нь. Шүүрэлт хурдхан болоосой... энэ бүхнээс хурдхан зайлах юмсан.”
- “Яагаад нөхөртэйгээ хамт сексийн видео хичээл үзэж болохгүй гэж?”
- “Энэ бүхэн ёстой аймаар юм аа. Би нүдээ анилаа (*эвшээнэ*). Нүдээ аниад, жаахан дуг хийлээ.”
- “Бурхан намайг хүн гэдгийг минь мэднэ. Надад нөхрөөсөө авч чадахгүй байгаа бэлгийн хэрэгцээ бий. Ингэж болохгүй гэдгийг би мэднэ л дээ. Гэхдээ би чинь хэдийнээ уучлагдсан... .”
- “Энэ миний дэмжсэн ерөнхийлөгч биш. Би түүний төлөө залбирахгүй.”
- “Секс, хүний наймаа аймшигтай. Гэхдээ гадны улсуудын л асуудал биз дээ?”
- “Гаити, Чилийн газар хөдлөлөөр амиа алдсан хүмүүс үнэхээр өрөвдөлтэй. Алдартай хүмүүс мөнгө босгож, тэдэнд тусалж байгаа нь сайн хэрэг шүү!”

Бид өөрийгөө хэн болохыг мартсан гэхээр заримдаа уйлмаар болох. Бид чинь өөрийнхөө биш, Бурханых болсон шүү дээ. Бид Түүнд болоод Түүний зорилгод зориулагдан тусгаарлагдсан, ариун хүмүүс. Бид чинь Бурхан байдаг гэж үү хэмээн гайхширсан, нүгэлдээ автсан, нутаггүй, эзэнгүй, эцэггүй, уймарч самуурсан хэсэг хүмүүс биш. Бид Христийн нэгдмэл бие бөгөөд иймээс нэр төр, ялалт, тэмдэг, гайхамшгийн хувь тавилантай хүмүүс. Харамсалтай нь, үүнийг зарим бүсгүйчүүд хараахан мэдээгүй явна.

АСУУДАЛ БИШ, ХАРИУЛТ

Би 2005 онд бичсэн “*Fight Like a Girl*” номдоо өгүүлсэн эрч хүчийн талаар өмнө товч дурьдаад өнгөрсөн билээ. Энэ нь “Бурханы охин чи, асуудал биш, харин хариулт” гэдэг санаа юм. Энэ санааг “*Эрслэн сэрэв*” номоо бичиж байхад минь “*Half the Sky*” гэдэг ном ч бататгав: “Эмэгтэйчүүд асуудал биш, харин шийдэл.”¹ Тус номыг эхнэр, нөхөр хоёр, Пулитзерийн шагналт сэтгүүлч - Николас Ди. Кристоф, Шерил Вуданн нар бичсэн болно. Тэд эмэгтэйчүүдийг эрх тэгш үнэ цэнэ, боловсрол, эдийн засгийн боломжоор хангах үйлс рүү дэлхийг сэрээн хандуулах зорилгоор номоо бичжээ. Ном нь ч дэлхийн жүжигчид, идэвхитнүүд, хэвлэл мэдээллийг сэнхрүүлэн сэрээсэн нь талархуштай.

Гэхдээ хүйсийн эрх тэгш бус байдлын талаар хамгийн түрүүнд чуулган дуугардаггүй нь надад гашуудал төрүүлдэг учраас л би уг асуудлыг сөхөж байгаа минь энэ. Яг л аюулт шуурган дунд онгоцны багийнхан нь онгоцоо аврах гэж цөхөж байхад, ганцаараа онгоцны доод, харанхуй хэсэгт унтаж хэвтсэн эртний зарлага Иона шиг л. Уг нь бид л хамгийн түрүүнд онгоцны тавцан дээр гараад, дэлхийн тэнцвэрийг алдагдуулж байгаа шударга бус явдалд Бурханы шийдлийг эрэн хайх ёстой юмсан. Гэхдээ Ионагаас ялгаатай нь бид тус тусын далайн шуурган дундаа ганцаараа усан онгоцынхоо төлөө тэмцээгүй. Байгалийн гай гамшиг ч, эдийн засгийн газар хөдлөлт ч дэлхийг хиаруулж, дэлхий бүхлээрээ чичирхийлж байна. Шударга бус явдал манай дэлхийг сэгсчүүлэн дайвалзуулж байна. Сэрүүлэг хангинаж байгаа энэ үед хүмүүс Христэд итгэдэг хүмүүс рүү хараад: “Яагаад ийм юм болов?” хэмээн асууж байна. Хоригдлууд, шархдагсад, цочирдсон хүмүүс бидэн рүү хараад, оройтоогүй байгаа дээр нь Бурхан руу орилж, Бурханы үйл хэргийн нэгээхэн хэсэг болохын оронд, яагаад унтаад байгаа юм бэ? гэж асууж байна. Гэвч чуулганы дэндүү олон хүн энэ цагийн савалгаанд цохиулан дуниартах юмуу эсвэл нэг их чухал бус юмсын талаар хэрүүл маргаан дэгдээж явна.

Бурхан Нинеvegliйн ард олонд буруу замаар явааг нь хэлүүлэхээр Өөрийнхөө зарлагыг дуулгаваргүй явдлаас нь сэрээсэн. Бурхан хүмүүсийг буруу замаар нь мөхөөхийг хэзээ ч хүсдэггүй боловч, Иона тус эртний хотыг сүйрлээс аврахыг үл хүсчээ. Тиймээс зугтаад, усан онгоцонд нуугдав гэнэ. Тэрбээр Бурханы заасан зүгээс эсрэг зүг рүү аялж явахдаа, нам унтчихжээ. Тиймээс Бурхан хүчит шуурга илгээсэнд, Ионагийн аялж явсан онгоц нь салж унахын даваан дээр иржээ. Иона яах гэж зугтав? Тэрбээр зохисгүй амьтад гэж үзсэн хүмүүсээ аврахыг хүсээгүй аж. Бурхан хотыг ч, Ионаг ч хэлтрүүлсэний дараа Иона Бурханд юу гэж хэлснийг үзнэ үү.

—Өө ЭЗЭН, би нутагтаа байхдаа хэлээгүй бил үү? Таныг нигүүлсэнгүй Бурхан мөн өрөвч, уурлахдаа удаан, хайр энэрлээр бялхам, гай гамшгийг зөөлрүүлэгч Нэгэн гэдгийг би мэднэ. Иймд би Таршиш уруу хурдхан зугтсан юм. (Иона 4:1-2)

Иона тэр хотод Бурханы шүүх, шийтгэлийг хүсч байсан ч, Бурхан тэр хотыг нигүүлсэн, өршөөхийг хүсчээ. Иона пиг хүнтэй тэр хотыг Бурхан сөнөөгөөсэй гэж хүссэн атлаа сүүдэрлэж байсан мод нь үхсэнийх нь төлөө уурлажээ.

Тэгэхэд Бурхан, Ионад —Эрэндийн бутнаас болж уурлах чинь зөв үү? гэж айлдсанд Иона —Үхтэл уурлах минь зөв гэж хэлэв. Тэгэхэд ЭЗЭН —Чи эрэндийн бут өрөвдөж байдаг. Чиний арчлаагүй, ургуулаагүй, шөнөдөө ургаад, шөнөдөө устаж үгүй болсон эд шүү дээ. Тэгвэл Би их хот Нинеveg, баруун зүүн гараа ялгаж мэдэхгүй зуун хорин мянга гаруй хүнийг бас тэр олон амьтдыг өрөвдөн тэдэнд санаа зовохгүй гэж үү? гэж айлдав. (Иона 4:9-11)

Сонсов уу? Үүнтэй адил бид Бурханд юу чухал байдгийг мартаа юу? Бурханд чухал юмсыг мартаад, тав тух, ая байдлаа л боддог болжээ. Өндөр Бурхан тэртээ тэнгэртээ сүйрэл мөхөлд баясаад суугаагүй. Бурхан буруу замаар яваа бүгдийг аврахыг л хүсэх! Бурханы аврахыг хүсч буй хүмүүсийн найдварт садаа хийхгүй байя. Доторх эрслэн - чанарыг чинь сэрээж, чамайг ёрын муугийн гарт сүйрэх гэж байгаа хүмүүсийн шүүгч бус, аврагч болгохыг Бурханд зөвшөөрч хайрла.

Бурханы дуудлагыг дагах цаг болжээ. Бурхан биднээр дэлхийд Сайн мэдээ дайлгасан. Бие биеэ хайрлахыг тушаасан. Бэлбэсэн, өнчин, харийн, ядуу хүмүүсийг халамжлахыг даалгасан. Одоо ч өтөл, бага охидоо дэлхийн асуудалд шийдэл болохыг урамшуулсаар байна. Бурхан биднийг ялгаатай байдлаа хойш тавиад, Түүний ажилд хамтран зүтгэхийг урьж байна.

Зарим маань бие биедээ эелдэг хандах тал дээрээ ажилласаар. Зарим маань алдсан зүйлийнхээ араас уйлаад завгүй. Тэгээд дэндүү олон маань доктрины асуудал зэрэг хөгийн асуудлаар Христийн биеийн нөгөө хэсэгтэйгээ авалцан хашхирна.

Бурханы хайрт охид минь, сэрээх дохионоос болж Иона шиг усанд шидүүлэх юмуу Израильчууд шиг цөлөөр тэнүүлчлэх бий! Тиймээс дэлхий дээрх асуудал, муу муухайд сэрүүн байж, сэргэг хандацгаая. Хүмүүс өндийгөөд, догдолж, ертөнцөө өөрчлөхөд бэлэн байгааг би сүнсэндээ хардаг.

Чиний онцгой илэрхийлэл

Номоо бичиж байхад минь манай хянан тохиолдуулагч нар бүрэн сэргэг эмэгтэйчүүд юуг гүйцэлдүүлж чадахыг уншигч нартаа харуулахын тулд тийм эмэгтэйчүүдийг жишээ болгон бичихийг санал болгож билээ. Тийм боловч би үзсэн харснаараа хашигдмааргүй байна. Бүрэн сэрсэн, аюултай хүний түүх бичигдсээр байна. Христэд итгэдэг эмэгтэйчүүд хувиараа ч, хувьсгалаараа ч ямар сэргэг, аюултай байдгийг дэлхий хараахан хараагүй байна.

Христэд итгэдэг эмэгтэйчүүдийг *сэрээх ажиллагааг* эхлүүлэхийг Бурхан надад хоёр ч удаа үүрэгдсэн. Бид бүгдээрээ *бүрэн сэрэхэд* юу болохыг төсөөлж чадахгүй ч, харанхуйд аюултай, гэрэлд сүр жавхлантай харагдана гэдэгт итгэл дүүрэн байна. Энэ талаар лавшруулан эргэцүүлэх тусмаа, Христэд итгэдэг бүсгүй хүний зэрлэг, дошгин илэрхийлэл хараахан гүйцэт боловсроогүй байгаа гэдэгт би итгэх болсон билээ.

Түүнчлэн, хүмүүс юу хийхээ заалгах дуртай байдгийг би ухаарсан юм. Гэхдээ хэрхэн гэдэг, алхам алхмын Христэд итгэх итгэл нь биднийг Бурханы нууцуудаас хоосолдог. Тэгэхээр, энэ маань хэрхэн гэдэг мессеж биш ажээ. Би *чамайг* сэрээд - эрслэн шиг гунхалзан босоод, өөрийнхөө онцгой илэрхийллийг тултал харуулж амьдраасай л гэж хүснэ. Чиний доторх бүрэн сэргэг эрслэн ямар байхыг гагцхүү Бурхан, та хоёр л тодорхойлно.

Би саяхан ажилтнаасаа дотоод эрслэнгээ сэрэхийг үгээр юмуу дүр зургаар тайлбарлахыг хүссэн юм. Тэгээд *нигүүлсэл, өр зөөлөн, аймшиггүй* гэх зэрэг хариу сонсоод гайхсангүй. Сэрэх хариу үйлдэл нь ийм л олон төрлийн, өргөн хүчин чадалтай ажээ.

Бичээсийг ухаад үзбэл, Бурхан хүмүүстээ юмуу эш үзүүлэгч нартаа юу болохыг нь урьдаас хэлэлгүйгээр, “Яваад, үүнийг, түүнийг хий” гэхийг нь зөндөө үзнэ. Жишээ нь Елиа бэлбэсэн эхнэрт: “Явж, олон сав суулга буюу хоосон сав суулгыг бүх хөршөөсөө зээлж авагтун. Битгий цөөхөн сав аваарай. Чи дотогш орж, өөрийнхөө болон хөвгүүдийнхээ араас хаалгаа хаагаад, эдгээр бүх савандаа юүлж, дүүрснийг нь хажуу тийш тавих ёстой (2Хаад 4:3-4) гэж хэлсэн байдаг.

Жаахан хачин заавар гэмээр. Энэ үйлдэл нь эмэгтэйн хөвгүүдийг боол болгоно гэж сүрдүүлээд байгаа өр хураагч нарын асуудлыг хэрхэн шийдвэрлэх юм бол? Эмэгтэй Бурханы хүн - Елиагийн үгийг биелүүлчихээд, хүрч иртэл Елиа эмэгтэйд: “Явж, тосоо зараад өрөө төлж, үлдсэнээр нь чи болон хөвгүүд чинь амь зууж болно” (2Хаад 4:7) гэжээ.

Бид эхний алхмаа хийлгүйгээр, хоёр, гурав, тэр бүү хэл дөрөвдүгээр

алхмыг мэдэх гэж яарсандаа, хичнээн ер бусын хангамжийг алддаг бол. Тиймээс энэ номыг “үгийг уншаад, залбираад, Бурханы өмнө өрж тавьсан сав суулгыг чинь Бурхан Өөрөөрөө дүүргэхийг үздэг”, тийм л төрлийн ном гэж ойлгоорой. Чамайг сэргээхийн тулд Өөрийнхөө хүссэн хэлбэр, хэмжээ, савалгаатай эрслэнгийн дүр төрхөөр тархийг чинь дүүргэхийг Бурханаас гуй.

Есүсийн арслангийн дүр зураг, өөрийнхөө эрслэнгийн дүр зургаас бүү ай. Энэ чинь Есүсийн хоньчны юмуу хонин сүрэгтэйгээ харилцдаг дүр зурагтай л адилхан болой. Бид жинхэнээсээ хонь уу эвсэл Бурхан биднийг Өөрийг нь хонь шиг дагаж, итгээсэй л гэсэндээ л ийнхүү дүрсэлсэн үү? Үүнтэй адилхан Есүс бидний сүйт хархүү, бид Түүний сүйт бүсгүй. Энэ бол зүйрлэл. Есүс нэгэн зэрэг бидний Хоньчин ч, Хаан ч, Бурхан ч, Хүн ч, Сүйт хархүү ч, Ах ч, Арслан ч, Хурга ч тэгээд Эхлэл бөгөөд Төгсгөл ч мөн. Есүс биднийг сунгахыг хүсдэг байж болзошгүй гэдэгт гайхаж байна уу? Чи үүнд нь өөрийнхөө гэсэн онцгой үзэл бодол, хүч, нөлөөллийнхөө байр сууриас хариулах ёстой.

СЭРЭЭХ ҮҮРЭГ

Коллежид байхад, манай хуурай эгч дүүсийн дотуур байр том “унтлагын тагттай” байлаа. Унтлагын тагт маань барилгын гадаа ч байрладаггүй, гаднаасаа ч орц гарцгүй мөртлөө яагаад тагт гэж нэрлэгдэх болсныг бүү мэд. Унтлагын тагт гэдэг нь зүгээр л хоёр давхарт байрладаг, давхар ороор дүүрэн, урт, харанхуй өрөө л байв. Зарим орыг нь урт ханаа дагуулж байршуулсан бол, заримыг нь харанхуй цонхтойгоо перпендикуляр хэлбэрээр өрсөн байдаг байлаа.

Охид маань тэр өрөөнд нийтээрээ унтдаг байсан тул тэнд сэрүүлэг хэрэглэх хориотой байв. Оронд нь бид миний хамгийн дургүй нэгэн даалгаврыг ээлжлэн гүйцэтгэдэг байлаа. Тэр нь бусдыгаа сэрээх үүрэг байв. Шөнө унтахаасаа өмнө охид маань сэрмээр байгаа цаг дээрээ үнэмлэхээ тавьдаг байв. Тэгэхээр сэрээх хүн нь хэн нь хаана унтаж байгааг мэдэх ёстой гэсэн үг. Сэрээх хүн нь өөрөө сэрүүлэг тавих боломжтой өөр өрөөнд унтана.

Миний ээлж ирэх үед би шүршүүрт орж амжихын тулд хамгийн түрүүнд сэрээх ёстой хүнээсээ гучин минутын өмнө сэрдэг байлаа. Шүршүүрт дараалалгүй орох нь түрүүлж сэрэхийн ганц давуу тал байв.

Сэрээх үйл явц эхэлмэгц, охидыг хоёроос гурван цагийн турш арван таваас гучин минутын зайтай сэрээнэ. Би өөрийгөө бэлтгэж, хажуугаар нь өглөөний цайгаа уунгаа сэм харанхуй өрөө рүү орж гаран, сүлжиж гүйнэ.

Байс хийгээд л өлмий дээрээ гэтсээр ороод, хаалгаа хаагаад, бусад охидыг сэрээчилгүйгээр харанхуй дундуур давхар орнуудаа алдалгүй тоолсоор, гулгана. Тэгээд сэрээх ёстой хүнээ олоод, аяархан сэрээнэ.

Өөр хүний амьдрал надаас шалтгаална гэдэг надад маш том үүрэг хариуцлага өгдөг байв. Тэдэнд хоцорч болохгүй хичээл, өгөх ёстой шалгалт, пялж болохгүй давтлага тэгээд мэдээж болзох ёстой найз хөвгүүд бий.

Шинэков байхдаа нэг удаа алдаа гаргаж байлаа. Хэтэрхий ноомой, чимээгүй байсандаа дээд ангийн эгчээ сэгсрэхээс айчихсан юм л даа. Урдаас нэг юм бувтнаад байхаар нь сэрчихлээ гэж бодтол, өнөөх чинь сэрээгүй, зүүдэндээ ярьж байсан юмсанж. Тэгээд өдрийн хоолон дээр миний алдаанаас болж хохирол хүлээснээ мэдүүлэн, эсэргүүцлээ илэрхийлэв. Зарим алдааг хоёр удаа гаргамааргүй байдаг. Тиймээс зарим охидыг хүчтэйхэн сэгсэрч сэрээх ёстой байдаг бол, заримыг нь зөөлөн товшиход л болдог, зарим нь нэрийг нь шивнэв үү үгүй юу бүлтийгээд босоод суучихдгийг сурч билээ. Зарим нь талархана, зарим нь амандаа үглэж, тээр шаана.

Гэхдээ “За, за, би сэрчихлээ” гэж хэлээд буцаад унтчихдаг нөхөд л хамгийн түвэгтэй. Ийм унтаахай охидыг орноосоо босоод, хоёр хөлөөрөө газар дээр зогсохоос нааш даалгавар минь дуусаагүйг би сурсан.

Өөр нэгэн бэрхшээл нь хүнээ андуурч сэрээх явдал. Хичнээн чимээгүй, болгоомжтой байхыг хичээв ч, заримдаа дээд доод хүнийг нь сэрээчих явдал гарна. Тэгээд гараас минь барьж аваад: “Би сэрчихлээ. Миний үнэмлэхийг авчихаарай!” гэж цочооно.

Хэлэхэд ичмээр боловч, сэрж өгдөггүй унтаахайнуудаас болж би ч амандаа үглэхийг үзүүлдэг байлаа. Заавал хоёр дуудуулна. Ийм ажил хийгээд байхаар дүрмийг нь сурдаг. Охидыг хоёр дуудсан ч, унтаад л байвал, гурав дахиа дуудах албагүй. Гурав дахь дуудлага гэж байхгүй учраас, хоёр дахь удаагаа илүү жинтэй дуудна. Охид сэрээд, хөдөлгөөнд орсон бол, миний даалгавар дуусна. Охид сэрээ бол, одоо би өөрөө хувцаслах ёстой.

Өгөөмөр Бурхан маань хуурай эгч дүүсийн дүрмээр ажилладаггүй нь сайн хэрэг. Тэрбээр эцсийн минут хүртэл баяртайгаар дуудаж сэрээсээр байдаг боловч, дуудлага бүр нь жинтэй байдаг. Эргэн тойрныхоо унтаахай эмэгтэйчүүдийг сэрээх дуудлагаар давхар сэрчихдэг эмэгтэйчүүд одоо ч байдаг нь мэдрэгддэг шүү.

Дошгин ТАЛАА СЭРЭЭХ

Амьдралын энэ улиралд ч би бас л сэрээх ажил хийсээр байгаа нь инээдтэй гэмээр боловч, энэ удаагийн даалгавар маань илүү ноцтой ажээ. Заримдаа

би нөгөө л харанхуй өрөөн дундуур давхар орны хоорондуур гулгасаар, заримыг нь зөөлөн хүрсээр, заримыг нь байн байн нударсаар тэгээд аз нь шовойбол - нэрийг нь шивэгнэх төдийд л бүлтийгээд суучихдаг бүсгүйчүүдээ сэрээсээр яваа санагдах.

Гэхдээ сэрээх ажлыг би ганцаараа хийгээгүйгээ мэднэ. Бурханы охин бүр нойрноос нь сэрээж, сэргээх өөр өөрийн гэсэн арга, юмстай. Би болбоос чиний өмнө нэгэн төрлийн дошгин зарчим, үзэсгэлэнтэй дүр зураг харуулах үүрэг хүлээсэн хүн. Нүд алдмаар гоо үзэсгэлэн, хүчний энэ илчлэл нь чамайг бүрэн сэрээж, цаашид яахаа мэддэг болгохын тулд чиний дотор ямар нэгэн дошгин чанарыг сэрээх хүчтэй байна.

Хөөрхөн эрслэн эгч дүү минь, чи зөвхөн сэрүүн байдлаараа бус мөн Бурханаас хүлээж авсан дошгин талаа илэрхийлэхийн тулд дэлхийд хэрэгтэй. Христэд итгэдэг бүсгүй хүн яаж *дошгин* байх вэ? Орилж чарлаж, маажиж, өшиглөснөөрөө юу? Магадгүй ингэх ёстой цаг байдаг байх. Миний ач нар руу хүн дайрдаг л юм бол, Сицили эмээ би энэ мэтээр тогтохгүй л хариу барина. Хосеа ном дээр Бурхан “ээж - баавгай, эрслэн” зангаа харуулсан байдаг.

Бамбаруушнуудаа булаалгасан баавгай шиг
Би тэдэнтэй тулгарч,
Зүрхнийх нь үнхэлцгийг ярна.
Тэнд Би эрслэн мэт тэднийг залгина.
Зэрлэг араатан тэднийг тасчина. (Хосеа 13:8)

Пээ! Энэ эшлэл дошгин чанарын зэрлэг, харгис талыг яруу тодоор харуулж байгаа ч, энэ нь дан ганц харгислалыг илэрхийлдэг үг биш юм. Өөрөөр хэлбэл, дошгин гэдэг үг нь бас *хури, хүчтэй, хүчирхэг, ширүүн, доргионтой, улангассан, хилэнтэй* гэсэн утга агуулна. Миний дотор хуйларч байгаа мэдрэмжийг дүрслэх илүү дээр багц үгс олдохгүй байх аа. Нэгэн зүйлийн доргио эхлэхтэй зэрэгцэн, чухам шуурга хүчээ авахын адил хамаагүй хүчтэй бас тодорхой зүйл дагалдан бий болжээ. Энэ хүч хувийн үймээн самууныг үүсгэх бус, харин төвлөрлийг авчирдаг. Би илүү төвлөрөлтэй болохоороо, урьд өмнө мэддэггүй байсан зүйлийнхээ талаар илүү сэтгэлтэй болдгоо харсан билээ.

Сэрэлт намайг нэг талаараа барьц алдуулдаг нь үнэн. Ийм нэгэн явдал 2007 оны арван сарын сүүл, 11-ээр сарын эхээр болсон юм. Би тэр олон өрөө дундаас очиж очиж угаалгынхаа өрөөндөө сэтгүүл уншиж суув. Тэгээд хуудсаа эргүүлж байгаад, Тайланд дахь бэлгийн мөлжлөгийн талаар анх олж уншлаа. Нийтлэлээ уншиж дуусгаад, зарим хэсгийг нь дахиж уншаад,

уншсан зүйлдээ итгэж ядав. Хүмүүс яаж ийм харгис байдаг байна аа? Ийм юм болоод байхад би мэдээгүй явжээ? Нулимс урсав (очиж очиж угаалгын өрөөндөө шүү). Тэгээд “*Бурхан минь, Таны охин би энэ асуудалд хүч, дуу хоолойгоо өргөж чадах уу?*” гэж залбирлаа. Энэ залбирал дагуулсан сэрэлтээр нэгэн янзын шилжилт өрнөх шиг болов.

Хэдэн долоо хоногийн дараа Лайф Аутрийчээс залгаж байна. “Лиза, манайхан бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх сан босгох үүднээс Тайланд руу явах баг бүрдүүлж байгаа. Тэгээд хамгийн түрүүнд таны нэр орж ирлээ” гэх нь тэр. Гурван сарын дараа би Лайф Аутрийчийн хүний наймааны эсрэг багийн анхны алтан хараацайнуудын нэг болон Тайланд руу нисч явлаа.

Тэр өдөр залбираагүй бол, яах байсан бол? Зүгээр л уйлаад, толгой сэгсрээд, хуудсаа эргүүлсэн бол, яах байсан бол? Дараагийнх нь хуудсаас л арьс арчилгааны шинэ бүтээгдэхүүн, загварын чиг хандлага, хоолны дэглэм үзээд л таг болох байсан биз. Залбиралгүй, уншаад л өнгөрсөн бол, тэр шөнө тэнгэр өөд дуугаа өргөлгүй орондоо орох байсан байх. Энэ сэдэв дахин анхааралд маань өртөх үед “Тийм ээ, би сонссон. Сэтгүүлээс уншсан. Аймаар” гээд л өнгөрөх байсан байх.

Харин сэрсэн хүн *хариу үйлдэхээс* нааш тайвшрахгүй. Гэхдээ сэрэхийг сэтгэл өвдөхтэй бүү эндүүрээрэй. Аль нэг зүйлд сэтгэл өвдсөн бол, тэрхэн үедээ зовниод өнгөрөхөөс биш, тухайн хуудас дээрээ тогтох хүчийг олохгүй. Сэтгэл өвдсөн хүн заавал сэрсэн байх албагүй. Бүрэн сэрсэн хүн дэлхийн асуудлыг ухаарсан хэрнээ хариу үйлдэлгүй өнгөрөхгүй. Тиймээс л залуу охидыг хулгайлж, дэн буудлаар зарсан тухай уншихаараа би, Бурханаас “Энэ талаар би юу хийж чадах вэ?” гэж залбирдаг юм. Залбирал маань ч боломжийг анивчуулсаар дагуулж ирдэг. Өөр боломжууд байсан болов уу? Магадгүй ээ. Гэхдээ би тэдгээрийг өнгөрөөсөн болтой.

БУРХАН ЧАМАЙГ НОМХРУУЛАХ ГЭЖ АВРААГҮЙ

Бурхан Өөрийгөө орой үгүй, хязгаар үгүй Бурхан хэмээн илчилдэг атлаа биднийг хязгаарлах уу даа. Харин ч эсрэгээрээ. Бурхан зүрхээ бидэнд суулгахыг хүсдэг. Кристин гэдэг найз маань “Бурхан чамайг номхруулах гэж авраагүй!” хэмээн яг голыг нь олж хэлдэг.

Бурхан Христэд итгэдэг царайлсан хүмүүсийг хайгаагүй. Бурхан биднийг Христэд итгэдэг хүмүүс *байгаасай* гэж хүсдэг. *Христэд итгэгч* гэдэг чинь “тослогдсон буюу Христ шиг нэгэн” гэсэн утгатай үг. Есүс “сайн хүн” царайлж яваагүй. Есүс “сайныг үйлдэж”, дарлагдсан хүмүүсийг чөлөөлж амьдарсан. Тэр чамаар юу хийлгэхээр тосолсон?

Над дээр Эзэний Сүнс байна.

Учир нь ядууст сайнмэдээг хүргэхийн тулд

Намайг Эзэн тосолсон юм.

Тэр Намайг илгээсэн нь

Олзлогдогсдод эрх чөлөөг тунхаглах,

Сохруудад хараа оруулах,

Дарамтад байгсдыг чөлөөлөхийн сацуу,

Эзэний тааламжит жилийг тунхаглахын тулд болой гэж уншаад...

(Лук 4:18-19)

Есүсээр эдгээрийг хийлгэхийн тулд Түүнд Бурханы Сүнс тавигдаа бол, тэр л адил Сүнсээр төрсөн бид ч мөн Есүстэй адил хөөрхийст сайн мэдээг номлож, дарлагдаж, зүдрэгсдийг чөлөөлж “Энэ бол Эзэний үйлдэх жил!” гэж зарлах ёстой. Он болгон Бурханы үйл хэргийн жил бөгөөд Бурхан биднийг Түүний төлөө хөдлөөсэй гэж хүсдэг гэдэгт би итгэдэг.

Энэ даалгавраар нэвтрүүлж харбал, Бурхан өдөржин бялуу хийж өнгөрөөдөг, томоотой, баахан гэрийн охидыг хүсдэггүй ажээ. Бялуу хийж, томоотой байх нь буруу биш шүү. Гэхдээ үүнээс хэтрэхгүй байвал, Бурхан биднээр дамжуулж түүхийг бүтээж чадахгүй.

Энэ эшлэл заримд чинь хүнд тусч магадгүй. Надад ч анх уншихад хүндээр тусч байлаа. Энэ нь эрээгээ алдуулах бус, харин статус кво өөрчлөгдөж байж л өөрчлөлт ирдгийг ухааруулах гэсэн анхааруулга болой.

Роза Паркс суудлаа тавьж өгөөд, “өнгөт арьстнуудад” зориулсан автобусны арын хэсэг рүү шилжихээс татгалзсан нь тухайн үеийн Өмнөдийн соёл, автобус - компаний нүдэнд зан авирын доголдол шиг харагджээ.

Нэгэн эмэгтэйн итгэл үнэмшил дээрээ

бат зогсож, суудал дээрээ үлдэх сонголт

нь манай улсын арьс өнгөөр ялгаварлан

гадуурхах үзлийг өөрчилжээ. Тухайн

үедээ тэр бүсгүй түүх бүтээж байгаагаа

ойлгосон гэдэг нь юу л бол. Цаг хугацаа

л сонголтын сэдэл, үр дагаврыг илчлэх

хүчтэй. Магадгүй Роза Бурханаас өгөгдсөн хүний эрх дархыг нь үгүйсгэгч,

тэр бүх хорио цээрээс залхаад байсан байх.

Тэгвэл Дебора, Иаел, Тамар, Эстер, Батшеба, Абигайл, Рахаб тэгээд Мариагийн хувьд? (Библи дээр энэ бүсгүйчүүдээр тогтохгүй олон эмэгтэйн нэрс бий.)

Дебора ард олныг дарангуйлагчийн эсрэг сэнхрүүлж, эрчүүдтэй мөр зэрэгцэн тулалдаж явахдаа намбатай загнасан уу? Тэр үеийн удирдагч

Томоотой эмэгтэйчүүд
түүхийг бүтээдэггүй юм.

— Лорел Тэтчер Улрих

нар үгүй л гэж үзсэн. Түүний эсрэг боссон цэргүүд ялж чадаагүй. Бурханы сонгосон Барак гэдэг удирдагч эр эргэлзсэн тул Дебора Бурханы чиглүүлгийг чадахаараа л гүйцэлдүүлжээ.

Тэгвэл Иаел? Тэр майхны гадсаар дайснаа алах ёстой байсан уу? Зүгээр л унтаж байхад нь эрх баригч нартаа тушаачихад л болох байсан бус уу? Магадгүй, болоогүй л болтой. Бурхан түүний сонголтыг зөвшөөрсөн бөгөөд түүний гавъяаг мөнхөлсөн дуу хүртэл гарчээ.

Мөн Тамар байна. Хоёр ч удаа бэлбэсэрсэн эмэгтэй янхны дүрд хувилаад, бэлбэсэн хадам аав Иудатайгаа харилцаанд оржээ. Түүний үйлдэл олон талаараа хүний санаанд багтамгүй. Бурхан түүнд ийм санаа өгсөн гэж баймгүй. Тамар өөрөө л ингэхийг сонгосон. Гэхдээ тэр бөх зүрхтэй эмэгтэйн хүү нь Христийн алтан ургийн хэлхээнд багтаж, Тамар өөрөө зөвтөд тооцогдсон байдаг.

Эстер зөвхөн хааныхаа тушаалаар л хаан дээрээ бараалхдаг зарлигийг зөрчсөн. Ксеркесийн анхны хатан Вашти дуулгаваргүй байдлаасаа болоод хусагдсан. Эстер үүнийг сайн мэднэ! Гэхдээ Эстерийн ордон доторх дуулгаваргүй үйлдэл нь ард түмнийг нь аварсан буюу.

Батшеба бол завхайрсан эмэгтэй бөгөөд цэц ухаант Соломоны ээж. Рахаб хаандаа худлаа яриад, дайсныхаа туршуулуудыг нуусан янхан эм. Түүний энэ итгэлийн үйлдэл нь Иерихогийн сүйрлээс гэр бүлийг нь авраад зогсохгүй, хөвгүүд нь Давидын болоод Есүсийн ургийн хэлхээнд багтсан. Абигайл нөхрийгөө давсан. Тэгээд гэр бүлээ аварч, Давид хааны сэтгэлийг булаасан.

Мариа хууль бусаар хүүхэд олж, Бурханы Хүүг төрүүлсэн мэт үзэгдэх. Тэрбээр “Хүнтэй гэрлээгүй байж, жирэмслэх чинь муухай. Хүмүүст муу үзэгдэхгүйн тулд гэрлэтэл минь хойшлуулж болохгүй юу?” гэж хэлсэн бол, яах уу?


Энэ эмэгтэйчүүдийн сонголтыг түүх зөвтгөдөг. Тэд сэрүүн, булгилсан зүрхтэй байжээ.

Бүрэн сэрсэн, аюултай сэргэг чамаас ямар хариу үйлдэл гарах вэ? Чи ямар түүх бүтээх вэ? Чи дээрх мэдээ орсон, дошгин эрслэн бүсгүйчүүд шиг гэр бүл, нийгэм, дэлхийгээ хамгаалахаар босох уу? Чи сэрүүн байна уу? Яг одоо зүрхэнд чинь юу булгилж байна?

АЙДАС, ГАЙХАМШГИЙН НИЙЛБЭР

Би аймшигтай болоод гайхамшигтай
бүтээгдсэн ... Таны үйлс гайхалтай

Дуулал 139:14



Эрслэн гэгч хүчирхэг бөгөөд дэгжин амьтан. Орших эс орших, үр төлийнх нь залгамжлал нь тэдний ур чадвар, хүчээс бүрэн хамаарахыг мэддэг болохоороо л эрслэнгүүд зорилгоо тээж, шөрмөстэй хөдөлдөг. Явж байхад нь арьс үс нь амьсгалж байдаг. Эрслэнгүүд хүүхнүүд - бидэн шиг арьс маань унжчихлаа, сүүл маань хэт урт байна, хоорондоо адилхан байна гэж нэгээхэн ч зовнихгүй. Тэд арьсан дотроо итгэл дүүрэн алхална.

Эрслэнгүүд биширмээр амьтад.

Онгон зэрлэг байгалийн сүр сүлд, сор чимэг болохоо өөрсдөө ч мэддэг гэмээр санагдах. Хүүхнүүд, эрслэнгүүд хоорондоо ярилцаж чаддаг байсан бол, бидний өөрийгөө үзэх үзэл, эрслэнгүүдийн өөрийгөө үзэх үзэл шууд л ялгараад ирэх байх. Хүүхнүүд эрслэнгүүд ярилцаж байна гээд төсөөлөөд үзэх үү.

“Эрслэнтэн, та их сүр жавхлантай юм аа.”

“Би мэднэ ээ. Чи миний чадварыг хармаар байна уу?”

“Тэгэлгүй яахав” хэмээн бид хөөрнө.

“Миний сарвууг харж байна уу? Үүнийг хар даа” хэмээн эрслэн биднийг урина.

Эрслэн сарвуугаа эргүүлээд хумсаа гаргахад нь бид сүрдэнэ.

“Энэ сарвуугаараа би үр төл, сүргийг минь хооллох гөрөөсийг унагаж

чадна. Тогтоогоод аваарай.” Эрслэн хумсаа буцаагаад хураахад, сарвуу нь дахин нил ягаан болов. “Энэ сарвуугаараа би үр төлтэйгээ наадаж, тэднийгээ хүч тэнхээнд сургадаг.”

Бид толгой дохиод, өөрийнхөө хумсыг хартал, зарим хэсгээрээ будаг нь хуурчээ.

Гэтэл эрслэн “Миний шүдийг үз!” гэнэ.

Бид түүний том жижиг, хурц шүдийг үзээд, гэдрэг ухрав.

“Энэ шүдээрээ би хамгаалж, алж, иддэг ч, нөгөөтэйгүүр энэ л шүдээрээ бас гүегээ гэмтээлгүйгээр ийш тийш зөөвөрлөдөг.”

Бид ялгааг нь үзээд, дэмий л толгой сэгсэрнэ.

Тэгээд эрслэн “Би аймшигтай бөгөөд гайхамшигтай бүтээгдсэн” хэмээн хамаг гоо сайхнаа гайхуулан дүгнээд, сэтгэл дүүрэн амьсгаа авна.

Үнэхээр ч, эрслэн айдас, гайхамшгийн нийлбэр болохыг бид үг дуугүй хүлээн зөвшөөрнө.

Гэхдээ чи ч бас ялгаагүй.

Би аймшигтай болоод гайхамшигтай бүтээгдсэн тул Танд талархал өргөнө. Таны үйлс гайхалтай бөгөөд Сэтгэл минь ч сайн мэднэ. (Дуулал 139:14)

Чи эрслэнгийн талаар ойлголттой болсон болохоор, би чамайг энэ үгийг итгэл дүүрэн хэлээсэй гэж хүсч байна. Чи ч, чиний эргэн тойрны эрчүүд, эмэгтэйчүүд ч Бурханы хосгүй бүтээл мөн. Гол нь биднийг ээжийнхээ гэдсээс гармагц, гайхамшиг дуусчихсан мэт олонх маань санадаг.

Чи хамгийн сүүлд хэзээ дээрх эрслэн ахайтан шиг итгэл дүүрэн ярьж байгаа эмэгтэйтэй уулзсан бэ?

Тухайлбал, хоёр бүсгүйн харилцан яриа нэг иймэрхүү өнгө аястай л өрнөнө:

“Чи ёстой үзэсгэлэнтэй шүү.”

“Өө баярлалаа. Сүүлд хүүхэд төрүүлэхдээ нэмсэн жингээ хасаад тэр байх.”

Амаржсан (эсвэл амаржиж буй эмэгтэйг харсан) эмэгтэй өөрсдийгөө үнэхээр аймшигтай бөгөөд гайхамшигтай бүтээгдсэнээ ухаарах ёстой. Үүнийг хүн бид мартдаг ч, эрслэн мартдаггүй. Эрслэн хүч чадлаараа гоо үзэсгэлэнгээ гайхуулдгаа мэднэ. Эрслэн гадаад төрхөөрөө төдийгүй, үйл хөдлөл, ур чадвараараа ч гоо үзэсгэлэнтэй болохоо мэднэ. *Эрслэнгийн хүч чадлыг ч, бишрэм чанарыг ч няцаашигүй.* Эрслэн биеийнхээ чадварыг мэддэг бөгөөд үүнийхээ гайхамшгийг ч бүрэн эзэгнэдэг. Эрслэнгийн энэ таалал нь Бүтээгчийг нь алдаршуулдаг. Эрслэн ур чадвартай, хүчирхэг бөгөөд үр төлөө ч ингэж л өсгөнө.

Бид хүч, үйл ажиллагааныхаа гоо үзэсгэлэнг санах ёстой. Би зэгзгэр, нарийхан биетэй байх талаар яриагүй. Би биеэр ч, сүнсээр ч сэргэг, хурц,

төвлөрөлтэй байх, Бурханы аливаа даалгаварт бэлэн байх талаар ярьж байна. Бид жинхэнэ эрслэн мөн л бол, хүчтэй л байх ёстой. Гэтэл хүч чадлын тал дээр ямар амархан андуурагдаж болдгийг саяхан олж мэдэв.

“БАКЪ” БАЙХТАЙ АНДУУРАГДАХ

Долоо хоног үргэлжилсэн андуурал маань үүнээс л эхэлсэн юм. Би Австралид хэд хэдэн цуврал цуглаан хийгээд чамгүй ядрал. Таван цуглаанаа дуусгаад, Бүтэн сайны үдэш жаал амсхийлээ. Тэгээд тэр олон үйл ажиллагааг нойр хоолгүй зүтгэн, гялалзтал зохион байгуулсан удирдлагын багийнхантай уулзах уулзалтанд уригдаж оролцов. Бид дутуу нойр, хэтрүүлсэн хоол, Бурханы сайн сайханд бялуураад яльгүй халчихсан байлаа.

Тэр их амар амгалан дунд нэгэн удирдагч надтай ухаарсан юмсаа хуваалцаж байснаа: “Юу гээч, манайхан намайг “мөрдөн байцаагч” гэдэг. Өнөөдөр Бүтэн сайны өглөөний цуглаан дээр би таныг хэнтэй адилхан болохыг илрүүлсэн” гэлээ.

Би ч: “Хэнтэй?” л гэлээ.

Тэрбээр шууд л: “Терминаторын *жинхэнэ* Сара Коннортай” л гэв.

Би ч юу билээ, хэн билээ гэх шиг нилээд манарлаа.

Тэгээд итгэж ядсандаа: “Сара Коннор чинь шар үстэй биз дээ?” хэмээн хариу довтлов.

“Тийм ээ. Гэхдээ үсэндээ биш л дээ.” Нөгөө эмэгтэй толгой сэгсрээд, гараа агаарт савласнаа: “Нүүрнийх нь хэлбэр, байж байгаа төрх нь... нөгөө, нөгөө бакъ байдал нь” хэмээн эрүүн дээгүүрээ гүйлгэн, аймаар сүртэй ярьлаа.

“*Бакъ*” гэсэн үү?

Ийм албан ёсны үг байхгүй боловч, нөгөө эмэгтэй энэ үгээрээ миний анхаарлыг олзоллоо. Тэр харьцуулалт миний хувьд хүчтэйхэн сунналт шиг л байсан бөгөөд тэр эгшнээс хойш би Сара Коннор болохыг хүсэв! Би ч бакъ гэдэг санаа, дүр төрхөнд дуртайяа толгой дохилоо. Тэгээд энэ санааг баяртай нь аргагүй хүлээж аваад, Америктаа буцаж очоод *Терминатор* гэдэг кинон дээр гардаг тэр бакъ эмэгтэйг харахыг хүсэв.

Гэртээ хариад, медиагийн мастер - Алек хүүгээсээ тусламж хүслээ.

- “Миний хүү, ээждээ Сара Коннорыг олоод өгөөч. Ээж нь үзэх хэрэгтэй байна. Хүмүүс ээжийг нь түүнтэй адилхан гэнэ.”

Алек жаахан гайхсан боловч, майктай, дугуй нүдний шилтэй, винтов буу барьсан зурагт хуудас олж өгөв. Тийм ээ. Яриангүй дошгин, хурц, биширмээр бүсгүй аж. Би Сара Коннорын эхийн сэтгэлийг нь шууд олж

хараагүйгээ хүлээн зөвшөөрнө. (Би өсгөж бойжуулах, ээж байх талаар их ярьдаг учраас, миний хувьд энэ тун чухал байв.) Гэхдээ л эх хүн тулгарсан нөхцөлтэйгээ нягт холбоогүй гэж үү? Хүүгээ алуурчин роботоос хамгаалах гэсэн ганц л зорилгоор амьдарч байгаа, буудахыг мэддэг, бакь эмэгтэйгээс илүү ээж хүн бий гэж үү?

Алек бас видео клипүүдийн цоморлиг олж өгөв. 1980-аад оны тэр монжат намайг бүр алийгаа алдахад хүргэсэн юм. Сара Коннор мотоциклоор давхиж, ганц гараараа винтов буугаа цэнэглэж, галзуугийн эмнэлэгт босгож тавьсан хоёр хүний хэмжээтэй орон дээрээ суниаана. Үүнийг үзээд би шууд л Сара болоодхов!

Тэрхэн эгшинд би өөрөөсөө *Лиза, чи амьдралдаа суниаж үзсэн үү?* гэж асуусан бол, бараг л шууд л суниачихмаар, тийм л эр бяраа амтагдаж байлаа надад.

Гэхдээ би суниагаагүй л дээ. Зүгээр л толгой дотроо галзуурч байсан минь тэр. Мэдээж өөрөө өөртөө Сара шиг л бакь санагдаж байлаа. Би ахлах сургуульд хамгийн бялдар сайтай үедээ ч турник дээгүүр эрүүгээ давуулж зүүгдэх тамирын шалгалтаа ч чүү ай өгдөг *байсныг минь* болгоогоорой. (Тээр доор сүрэг матар байна гэж төсөөлснийхөө ачаар л хэсэгхэн тогтдог байлаа шүү дээ.)

Гэтэл би нэг мөрөө цанаар гулгаж байгаад, нөгөө мөрөө хэлэхэд ч ичмээр, хөгийн шалтгаанаар гэмтээж байснаа мартчихаж.

Тэгээд бодох нь ээ, би амьдралдаа нэг ч суниаж үзээгүй аж! Гэхдээ энэ бүхэн хамаагүй. Тэр үед Сарагийн хийж чадаж байгаа бүхэн миний дотор багтаж байв.

Би түүнтэй адилхан харагдахаас гадна түүн шиг л үйлдмээр байв. Анхны эмэгтэй супер баатар юуны төлөө тэгтэл бэлтгэл хийнэ вэ? Чөлөөлөгдмөгцөө, хүүгээ аварч хамгаалах хүчтэй, бэлтгэлтэй байхын тулд. Гайхмаар! Бэрх улирлыг хүчээ базаахад ашиглаж мэддэг эмэгтэйчүүлд би хайртай. Сара, бид хоёр? Яасан? Миний хувьд - бид хоёр чинь ихрүүд шиг л байлаа.

Ийнхүү мансуурч байхдаа би амьдралдаа ч хийж үзээгүй нэг зүйлээ хийж орхив.

Голдс Жийм рүү залгав.

Тэгээд нэр алдартай нэгэн дасгалжуулагчийг нэр усыг нь цохож байгаад асуулаа. Хүлээн авагч ч намайг Роберт гэдэг мөнөөх дасгалжуулагчтай холбов. Тэгээд тухайн өдөр Робертэд сул цаг байгаа эсэхийг лавлахдаа, дотроо баяртаа багтарч байлаа. Магадгүй хэдхэн удаагийн - гурав юмуу дөрвөн удаагийн хувийн бэлтгэл хийгээд л Сарагийн хэмжээнд хүрчих ухааны юм л бодогдоно. Тийм ээ, үсний маань өнгө өөр байсан ч, бусдаараа бууз хуушуур шиг л болно. Үсээ шар болгохгүй ч гэсэн, гарынхаа баримал

шиг шөрмөслөг шуугаар адилхан болохын тулд би ямар ч бэлтгэлд бэлэн байлаа.

Роберт хэдэн цагийн дараа намайг шалгахаар тохиров.

Шалгалт гэдэг үг надад сэрэмжлүүлэх дохио болох ёстой байсан ч, би анзаарсангүй. Утсаа тавихдаа, эрч хүчиндээ багтарч ядаж байв. Тэгээд Алекаас дасгал хийчихмээр, хэдэн сайхан, эрч хүчтэй, цэвэрхэн дуу бэлтгэж өгөхийг хүслээ. Дараа нь “Би одооноос жийм явна. Надтай явах хүн байна уу?” хэмээн зарлав.

Хоёр хүү маань гайхсан хэдий ч, надтай явья л гэлээ. Ийнхүү бид гурав жиймддэг баатар болов оо. Цоо шинэхэн дуутай АйПододо зүүж аваад л, зааланд ороод явчихав. Магадгүй дараагийн удаа дасгалжуулагчдаа Сара Коннорын ихрийн өрөөсөн гэдгээ батлан харуулахын тулд майк өмсөж ирбэл, зүгээр ч юм уу.

Баярласандаа арай эрт ирээд, ирээдүйн дасгалжуулагчаа холоос харлаа. Дасгалжуулагч маань шинэ шавьдаа дуртай байх байх аа. Зорилгодоо тийм ойрхон хүнийг дасгалжуулна гэдэг чинь дасгалжуулагч хүний аз жаргал биз.

Нэг иймэрхүү л юм бодож байлаа.

Роберт өөр нэг эмэгтэйг дасгалжуулах зуураа, намайг зам дээр биеэ халаа хэмээн дохив. Өгсүүр горим дээр байгаа зам дээр гарах зуураа Роберт миний үеийн нэгэн эмэгтэйг дасгалжуулж байхыг анзаарлаа. Би өөрийгөө тэр эмэгтэйгээс дутах юмгүй л гэж санав!

Тэр эмэгтэй ч янзын хэлбэр галбиртайгаас гадна гялтайсан боронзон арьстай хүүхэн байлаа. Майк, цэрэг өмдтэй тэр хүүхэн яг л амьд Сара Коннор. Тэгэхэд л би анх удаа айдас мэдрэв. Заалны тод гэрэлд гараа хартал, сул махтай, ногоовтор туяатай, гөлийсөн цагаан гар үзэгдэнэ.

Байз! Сүрдэхгүй шүү. Бэлтгэлдээ ороод л юу юугүй шөрмөслөг, бор хүүхэн болчихно. Тэгээд өөрийгөө зоригжуулаад, замын горимоо дахин хэдэн төвшин ахиулчихлаа. Хэдэн удаагийн бэлтгэл, наранд жаахан яваад л би тэр эмэгтэйгээс дутахааргүй болно. Тэгээд ч Сара чинь шоронд байсан юм чинь бас л гөлчгөр цагаан байсан байж таараа.

Би харцаа буруулаад, АйПододо асаагаад, үнэн голоосоо алхаж эхэллээ.

Удсан ч үгүй дасгалжуулагч маань хүрч ирснээ, урам амтагдтал мишээгээд: “Арван таван минут яваад, дараа нь таны зорилгын талаар ярилцъя. Миний өмнөх цаг дуусаагүй байна” хэлж хэллээ.

Арван таван минут аа? Тоглоогүй байгаа? Найман минут л халаахад болно гэж уншиж байсан юм сан. Гэвч эхнийхээ өдөр дасгалжуулагчдаа заагаад яахав гэж бодсондоо, зүгээр л хариу мишээн, толгой дохилоо.

Арван таван минут ч дуусч, би замаасаа бугаад жингээ үзэхээр

эмэгтэйчүүдийн хувцасны өрөө рүү явав. Дасгалжуулагч маань асууж юуны магад. Хувцас сольдог өрөө рүү явахын тулд мөнөөх жинхэнэ бакь эмэгтэйн хажуугаар явах ёстой боллоо. Намайг хажуугаар нь өнгөртөл, нөгөө эмэгтэй дуудаж байна.

Тэгээд: “Та Роберттай ажиллах юм уу?” хэмээн амьсгаадан асуулаа.

Би савтай уснаасаа балгангаа толгой дохив.

- “Тэр намайг алж байна! Би дасгал хийдэг л дээ. Гэхдээ Роберт шал ондоо юм байна” хэмээн нөгөөх чинь явдаг шатаар өгсөнгөө, амьсгаадан ярив.

Би зогслоо. “Гэхдээ та чинь бакь юм байна шүү дээ.”

Эмэгтэй надад хариулах гэж хамаг хүчээ цуглуулах мэт ярвайнгаа, толгой сэгсэрлээ.

Тэгтэл Роберт заалны эсрэг талын жижиг өрөөнөөсөө миний нэрийг дуудан даллав. Би ч түүний зүг анх зааланд орж ирж байснаасаа арай л итгэл муутай алхлаа.

Тэгээд: “Би жингээ үзэх гээд л...” хэмээн бувтналаа.

Роберт миний жинг авч хэлэлцсэнгүй. Тэр миний хүчийг л шалгахыг хүсчээ.

Роберт: “Алчуур авчирсан уу?” гэж асуув.

“Авчраагүй” гэж хариулаад, дасгал хийхдээ бараг хөлөрдөггүй хэмээн тайлбарлалаа. Одоо бодоход, зүгээр л дасгал хийдэггүй гэж хэлсэн бол, үнэнд нийцэх байв.

ЧӨРГӨР - ТАРГАН

За, тэгээд тэр ичмээр үйл явц яг яаж өрнөснийг нарийн санахгүй байгаа ч, ямар ч байсан нэг иймэрхүү юм болсныг багцаалж байна. Би ч тусдаа нэг өрөөнд л бие бялдрын шалгалт авах юм байх гэж санатал, Роберт намайг зааланд дагуулж оров. Тэгээд сэлүүхэн хэсэгт дагуулж аваачаад, арав суниагаатах л гэлээ.

Би ч суниахыг мэднэ л дээ. Гэхдээ ямар хэлбэрээр суниахыг ойлгосонгүй.

Тэгээд: “Охид шиг өвдөглөж суниах уу?” гэж асуулаа.

“Үгүй ээ, жирийн суниалт” хэмээн Роберт цаас, харандаагаа сүртэй гэгч өргөнгөө, түс тас хариуллаа.

Би ч унжирч, гонжролдсоор арав суниахтай аялдлаа.

Роберт надад амсхийх ч чөлөө, хоёр үг солих ч зай өгөлгүй: “За цаашаа! Хорин таван удаа жампинг жакс үсэр” гэлээ.

Сандарлаа. Жампинг жакс ч амархан л даа. Гэхдээ яг яаж хийдэг билээ.

“Гараа толгой дээрээ нийлүүлдэг билүү?” хэмээн асуулаа.

Роберт хариулсангүй.

Тиймээс би санаснаараа л аваад хаячихлаа. Хачин болхи дэвхрэх зуураа жиймийн бусад хүмүүсийг анзаарч амжлаа. Хөвгүүд маань хүртэл над руу харангаа толгой сэгсрэн, инээлдэх нь үзэгдэв.

Роберт: “За, дахиад газар арав хий” гэлээ.

Амьсгаа авах цаг хожингоо би: “Дахиад суниах юмуу эсвэл өөр дасгал хийх юм уу?” гэж асуув.

“Суниа” гэж Роберт хариуллаа.

Би газар тулсан ч, энэ удаа бүр ч хэцүү байв. Гар маань чичирч байна гэж. Даанч өрөвдөлтэй байсан тул би үндсэндээ гэдсээрээ дээшээ доошоо “суниав”.

Роберт дуугарсангүй. “Дахиад хорин таван жампинг жакс!”

Энэ удаа зөв хийе дээ гэж бодсондоо, дахиад л: “Гараа толгой дээрээ нийлүүлдэг билүү?” гэж асуулаа. Надаас үнэхээр хөөрхийлөлтэй дуу гарав.

Роберт: “Хамаагүй ээ... эхэл” хэмээн тушаав.

Тийм байж. Гэхдээ надад хамаатай! Бас бүхэл бүтэн жиймийн нүдэн дээр эв хавгүй дэвхэрч байгаа ээжийнхээ өмнөөс нүүр улайн, хавчигнах хөвгүүдэд маань хамаатай.

Миний зовлон ингэж л эхлэв. Дараа нь бүр ч хүн ихтэй хэсэг рүү шилжиж, дасгалын машин дээр хөлөө өргөх гэж үзэв. Энэ дасгалыг би мэднэ ээ.

Тэгээд байрлалаа эзлээд, тушаалаа хүлээлээ.

“Арван тав өргө.”

Өвдгөө бэлхүүс хүртлээ өргөхдөө, би ч догь харагдаж байгаа даа гэж бодов.

Гэтэл Роберт гараа миний бэлхүүсийн төвшнөөс дээш тогтоогоод: “Үгүй ээ, тэгж биш. Урагш нь тэгш, өндөр өргө” гэж тушаалаа.

Би хөлөө хамаг хүчээрээ өргөсөн ч, Робертын гарт хүрсэнгүй.

“Өшөө өндөр” хэмээн Роберт намайг зоригжууллаа.

Тоглоод байгаа юм уу? Нэгийгээ яая гэж байхад, арван таван удаа ч гэх шиг. Би түүний гарт ганц, хоёр хүрсэн байх аа. За за, нэг ч хүрээгүйгээ хүлээе. Гэхдээ Роберт гараа дээшлүүлээд байх шиг байсан!

Дараа нь гантельтай дасгал хийсэн байх аа. Би ч манарчихсан байлаа. Намайг урт сандал дээр суутал, Роберт хоёр ширхэг гантель авч ирэв. 1.3 кг-ын гантель байсан байх аа. Хөх инээд хүрэв. Одоо чамайг ангайлгаад өгнө дөө.

“Багш аа, би ер нь 5 кг-ын гантель л хэрэглэдэг” хэмээн тайлбарлав.

“Эхлээд үүгээр хийгээд үз” хэмээн Роберт өөдөөс хэллээ.

Би мөнөөх гантелийг нь хөлс дааж, чичирсэн гартаа барьяла.

“Ингээд өргө”.

Би ч ойлгоод, толгой дохилоо.

Тэгээд ядах юмгүй өргөчихөв.

“Тэгж биш ээ. Ингэж өргө” хэмээн Роберт гарыг маань яльгүй засаад: “Яг энэ чигээрээ өргөөд, буулга” гэлээ.

Нэг л биш байлаа. Би тэр гантелийг хэдхэн санжаас дээш өргөж чадсангүй! Магадгүй сунилтаас болсон байх. Тэгээд л гар маань ажиллаж өгөхгүй байгаа байх. Би гараа доошлуулаад дахиад оролдлоо. Дахиад л хэдхэн санжаас дээш өргөж дийлсэнгүй. Би Роберт руу цочирдон хартал, тэрбээр илүү хөнгөн гантель авахаар эргэж харагдлаа. Үнэндээ, заалан дахь хамгийн хөнгөн хэрэгсэл нь тэр байв. Ийм байх ёсгүй дээ.

“Би таван кг-ын гантель өргөдөг юмсан. Заримдаа 6-7 ч өргөнө” хэмээн би ээрэв.

Роберт: “Та буруу өргөөд байна” хэмээн дүгнэлээ.

Роберт намайг тамлаж дуусаад, жижиг өрөөндөө дагуулж орлоо. Цээж нуль хөндүүр, хөл салгалсаар... нөгөө Сара Коннор болдог баатар байхгүй!

Би тамирын нэг ч шалгалтыг нь өгч чадсангүй.

Роберт шууд л хүснэгт бөглөх ажилдаа орлоо. Тэр миний жинг асууж, тоог нь бөглөв. Тэр надаас гэмтэлтэй эсэхийг асуугаад, цаасан дээр бөглөж бичлээ. Би ч түүнд өмнө зүүн өвдөг, мөр хоёр маань асуудалтай байсныг тайлбарлав. Роберт миний гэмтлийг анхааралдаа авлаа. Дараа нь миний гарт Нинтендогийн гар маягийн, гэмгүй царайлсан хэцүү нэртийг бариулав.

Тэгээд: “Хоёр гараараа урдаа атга. Наадах чинь биеэр чинь цахилгаан соронзон гүйдэл явуулж, биеийн чинь өөхний эзэлхүүнийг нарийн тодорхойлно” гэж зааварчиллаа.

Роберт товчыг дараад, ЛЕД дэлгэц дээр тоо гарч ирэхээс өмнө түр хүлээлгэв.

Тэгтэл намайг юу ч ойлгоогүй байж байтал, Роберт миний өөхний хэмжээг заасан тоог үзээд, пүү паа болов.

Би ч: “Би буруу барьчихсан байх” гэлээ.

Бид хоёр дахиж үзтэл, өөхний хэмжээ маань 1 хувиар нэмэгдчихэв.

“Наадах чинь эвдэрчихсэн байх. Эсвэл би юм уугаагүй байх” гэлээ.

Яг энэ үеэр Алек хүү маань өрөөнд сэлгүүцээр орж ирлээ.

Тэгээд “Би үзье” гэв.

Түс. Алекийн өөхний хувь хэмжээ нь 5.2 хувь байв.

“Таных хэд байсын, ээж?”

Би ч түүнд хариулалгүй, өрөөнөөс гарахыг дохилоо.

Роберт толгой сэгсрээд, хоёр өөр зурагтай, хоёр хуудас гаргаж ирэв.

Стэйк махны зураг шиг л харагдав. Нэг нь хар мах, нөгөө нь өөхтэй мах. Би өөхтэй мах нь ажээ.

Таны төрлийн хүмүүсийг “чөргөр - тарган” гэж нэрлэдэг л дээ. Би ч айсандаа өөрийгөө маш идэвхитэй, магадгүй хэтэрхий завгүй хүн хэмээн өмөөрч гарав. Жиймийн хуванцар сандал дээр номхон сууж байгаад, цүндгэр төмсөөрөө дуудуулна гэж ярихгүй шүү!

Роберт мэдэж байна гэсэн шиг толгой дохино. “Та байнгын идэвхитэй хүн учраас, биедээ шаардлагатай эрч хүчийг агуулах хангалттай уураг иддэггүй болтой. Тиймээс бие чинь өөхийг чинь биш, харин булчинг чинь шатаагаад байгаа болтой.”

Миний цочролыг харсан тэрбээр цааш нь: “Яг л стэйк иддэгтэй л адил. Та өөхийг нь салгаад махыг нь иддэг биз дээ. Бие ч бас үүнтэй адил. Махыг чинь буюу булчинг чинь иддэг. Тиймээс та булчингаа, хүчээ алдаад байна. Үүнийг буцааж олох ганц арга нь хүчний дасгалаар булчингаа дахиж олж авах” гэж ярив.

Тэгээд надаас хавьгүй булиа хэдэн эмэгтэйг заагаад, хэдийгээр танаас илүү тарган юм шиг харагдаж байж болох ч, хэрэг дээрээ бага өөхтэй гэдэг доромж үгээрээ шархыг минь урав! Бас миний өөхний дийлэнх хувь нь (бүр нүүр улаймаар) гэдсэндээ юмуу гуядаа биш, гартаа байна гэв!

Гэтэл би гараараа хамгийн их бахархаж явдаг!

Сара Коннор шиг дээшээ суниах төсөөлөл минь пор хийтэл сарнив. Одоо өмнө минь бодит сонголт л байна. Булчингаа шатаасаар, ирээдүйн тамир тэнхээгээ барах уу? “Чөргөр - тарган”, “Хиймэл бакь” гэдэг нэр зүүгээд л явах уу эсвэл жинхэнэ хүчтэй болох уу? Ичгүүртэй хэдий ч, би хүчтэй байхыг сонгож байна! Миний хувьд галбир гэдэг гоё ганган хувцас өмсөхтэй холбоогүй байв. Чөргөр - тарган хүн ч хувцсандаа багтдаг. Гол нь сул талаа олж тодорхойлоод, биеийнхээ эмзэг хэсгийг эрч хүч, тамир тэнхээний эх уурхай болгож хувиргах нь надад чухал.

Би жингээ хасах шаардлагагүй. Би хүчтэй болох ёстой.

Жин гэдэг миний найрлагын оновчтой тусгал биш болохыг би ухаарав. Би ямар найрлагатай вэ? Түлхэлт ирэх үед урдаас нь тулж эсэргүүцэх хүч надад бий юу? Би өгсүүр бус газар, богино зайнд хэд хэд дэвхэрчихнэ. Харин зай маань уртсах юмуу хүч шаардагдах үед би нугарна. Яагаад? Яагаад гэвэл надад нэмэлт хүчийг даах ямар ч тэнхээ байхгүй.

Би хязгаартай хэдэн барьцнаас, тодорхой жаахан жинг л өргөж дийлнэ. Тиймээс л Роберт миний барьцыг өөрчлөх үед би гантелиа өргөж дийлээгүй аж. Ашиглахгүйгээс болоод эзмэг, сул болсон бүл булчинг маань Роберт тусгаарлах үед миний тамир хүрээгүй байна.

Үүнээс хойш миний хандлага өөрчлөгдөв. Үнэндээ яг одоо, энэ үгийг

бичиж байхдаа ч би дасгал хөдөлгөөн хийх хүслээ дарж ядаж байна. Би өөрийгөө ямар булиа болохыг гайхуулах гэж жийм явснаас биш, сул доройгоороо дуудуулах гэж яваагүй. Дасгалжуулагчийн үг надад таалагдаагүй. Гэхдээ үнэнийг мэдэж, сул дорой талаа хөгжүүлэхийн төлөө амьдрах хамгийн сайхан! Улам хүчтэй болохын төлөө сул талаа үнэнээр олж мэдэх хүсэл дотор минь байж л байгаа.

Тэдгээрийг би өөрөө илрүүлж чадахгүй. Үүний учрыг олж, хужрыг тунгаахад дасгалжуулагч шаардлагатай бөгөөд энэ маань өндөр үнэ хөлстэй бас өвчин зовиртай үйл ажиллагаа юм.

ЯЛАГДАШГҮЙ ХҮМҮҮС

Энэ явдлаас хойш хичнээн олон хүн биеэр биш, сүнсээр чөргөр - тарган байдаг бол хэмээн гайхшрав. Гаднаасаа нарийнхан бид амьдралд маань хүндхэн юм дарахад л амь тавихаа дөхнө. Бид тэгш гадаргуу дээр таатай хэмнэлээрээ дажгүй алхдаг. Гэвч амьдрал бидний удирдлагаар хөдөлдөг, гүйлтийн зам биш. Бид Бурхантай хамт алхахдаа, өгсөлт, хурд нь нэмэгдэхийг мэдэрнэ.

Яагаад энэ бүхнийг ярина вэ гэж үү? Яагаад гэвэл Христийн бие эдүгээ зулайнаасаа ул хүртэл бүрэн өөрчлөгдөхийн даваан дээр ирээд байгаа бөгөөд ялалт айсуу. Энэ нь дан миний санаа биш болой. Бурхан:

Эврийг чинь Би төмөр,
Туурайг чинь хүрэл болгох тул
Сион охин оо босож, талхлагтун.
Ийнхүү чи олон ард түмнийг бут цохиж,
Олзыг нь ЭЗЭНд,
Эд баялгийг нь бүх дэлхийн ЭЗЭНд зориулах юм.
(Мика 4:13) гэдэг.

Бурхан үл үзэгдэгч бус, харин ялагдашгүй болгоно хэмээн айлдсаныг тэмдэглээрэй. Чи хэзээ хамгийн сүүлд өөрийгөө ялагдашгүй хэмээн мэдэрсэн? Магадгүй гүйж, тоглох өөдсийн чинээ охин байхдаа л тэр байх. Чи харанхуй дотор нуугдахыг хүсэлгүй, гарц хүссэн л байх. Чи гэрэл, найдвар тээгч байхыг хүссэн л байх. Чи Сионы дийлдэшгүй, эзлэгдэшгүй, ганхашгүй охин байхыг хүсээ л байх. “Эврийг чинь Би төмөр, Туурайг чинь хүрэл болгох тул Сион охин оо босож, талхлагтун” гэдэг үг надад одоо ч сонсогдох.

Бид давтуулж, шинэтгэгдэх үедээ л сүнсний хүчийг олох маань олонтаа.

Энэ хүндийн жингийн бэлтгэл ямархуу байдгийг Мика 4 тайлбарладаг:

Одоо чи хотоос гарч, хээр амьдран,
Вавилон уруу явах ёстой тул
Сион охин оо, дуншиж буй эмэгтэй шиг
Нярайлахаар өвдөж, шанал.
Тэнд чи аврагдана,
ЭЗЭН чамайг дайснуудын чинь гараас чөлөөлнө.
«Сион бузартаж, бидний нүд түүнийг тавлан харах болтугай!» гэх
Олон үндэстэн одоо чиний эсрэг цуглах болно.
Гэвч тэд ЭЗЭНий бодлыг мэддэггүй бөгөөд
Түүний зорилгыг ойлгодоггүй.
Учир нь Тэр тэднийг үтрэмд юүжилсэн тариа мэт цуглуулав.
(10-12-аар эшлэл)

Би энэ хэсэг дээрх амлалтанд хайртай. Чи унаж, дайсандаа юу юугүй алуулах нь уу гэтэл, Бурхан чамайг шижир алт болгон шинэтгэх ажлаа хийж байдаг. Бурхан бэрхшээлээр дамжуулан хүмүүсээ цэвэр, үнэтэй, даацтай болгодог.

Заримдаа хүмүүс юмуу хэвлэл мэдээ Христэд итгэдэг хүмүүсийг ортой л шүүмжилдэг. Үүнийг нь бид даруугаар хүлээж аваад, доторх үнэнийг нь жинлэх хэрэгтэй. Биднийг хатуу, шүүмжлэлтэй, хайрладаггүй гэх үед нь шууд л эсэргүүцэхийн оронд Бурханы Үгийн гэрлээр өөрийгөө тунгааж харах хэрэгтэй. Өөрийгөө шалгаад, шаардлагатай бол, уучлал гуйя.

Гэтэл нөгөөтэйгүүр дайсан - диаволын эрээ цээргүй ял гэж бас байна. Заримдаа тэр Эзэнийг маань бузар булай гэх зэргээр улайм цайм гүтгэн дайрдаг. Заримдаа Бурханы хүүхдүүдийг Эзэнээсээ буруулахгүй бол, ална шүү гэх зэргээр ёрын муугаар дайрдаг. Ийм доромжлолтой тохиролцоо хийлгүй, харин үүнийг Бурханы итгэмжтэй чанар, үнэний зоригтой тунхаглалаар ялах ёстой юм. Энэ дүрслэлийг Илчлэл ном дээр хэлдэг:

Тэд түүнийг Хурганы цус, өөрсдийн гэрчлэлийн үгээр ялжээ.
Тэд үхэн үхтлээ амиа хайрлаагүй юм. (Илчлэл 12:11)

Мика 4:13-ыг уншбал, Бурхан “Гүйцээ! Чи Миний хүмүүсийг устгалаа гэж бодсон ч, устгалгүй, харин ч бэлтгэчихлээ!” хэмээн айлдах шиг. Израильчуудыг замаа алдахад, дайснууд нь тэдний өөдөөс хүчтэй боссон бөгөөд энэ бэрхшээл нь Израильчуудын амьдралыг шинэтгэжээ. Тэгээд дайсан яллаа гэж бодох үед Бурхан хүмүүсээ шинээр байгуулагдсан, ялгуусан ард түмэн болгон гаргаж иржээ.

ЗАВГУЙ ГЭДЭГ УРВАЛТ

Тэгэхээр, энэ бэлтгэлийг хэрхэн эхлэх вэ? Сүнснийхээ хувийн бөгөөд хувьсгалын нөхцөл байдлыг шударгаар оношлон тодорхойлох. *Чөргөр - тарган* гэдэг нэр томъёо нь Дасгалжуулагч - Есүс гэдэг үгийн хажууд хавьгүй зөөлөн мэт. Илчлэл номоос Есүсийн даалгаврыг уншиж байсан уу? Долоон чуулганаас хоёрхон нь л биеийн тамирын хатуу шалгалтаа давсан байдаг. Харин даваагүйчүүдийнх нь хоёр үнэлгээг ингэж хэлжээ:

Би чиний үйлсийг, чи амьд гэдэг нэртэй ч үхдэл гэдгийг мэднэ. Сэргээг байж, үхэх гэж буй үлдсэн юмсаа тэнхрүүл. Учир нь Бурханы минь өмнө чиний үйлс гүйцэлдсэнийг Би эс олов. Тиймээс чи юу хүлээн авсан болон сонссоноо сана. Түүнийгээ сахь, гэмш. Хэрэв чи сэрэхгүй бол Би хулгайч мэт очно. Ямар цагт чам дээр очихыг минь чи мэдэхгүй. (Илчлэл 3:1-3)

Завгүй байдал миний биеийн булчингийн хүчийг нэмэгдүүлэх биш, хасагдуулсан шиг, сүнсний завгүй байдал ч сүнсний тамир тэнхээг байгуулахгүй. Энэ нь биднийг Бурханы ажлаас сатааруулж, хатаадаг. Есүс чуулганы ахиц дэвшлийг мөн ингэж дүгнэжээ:

Би чиний үйлсийг, хүйтэн ч биш, халуун ч биш гэдгийг чинь мэднэ. (Би чамайг дотор гадаргуй мэдээд, надтай адил юм багыг оллоо.) Чамайг хүйтэн юмуу эсвэл халуун байгаасай гэж Би хүсэж байна. Тийнхүү чи халуун ч биш, хүйтэн ч биш, бүлээн тул Би чамайг амнаасаа нулимж гаргана. Яагаад гэвэл чи “Би баян, хөрөнгөжсөн тул дутах зүйл ер байхгүй” гэдэг. Чи хөөрхийлөлтэй, өрөвдмөөр, ядуу, сохор, нүцгэн гэдгээ мэдэхгүй байна. (Илчлэл 3:15-17)

Энэ юу вэ? Бурхан гэр оронтой хүмүүсийг орон гэргүй, мөнгө хөрөнгөтэй хүмүүсийг муудсан, царцуу гэсэн. Аль, аль бүлэг хүмүүс нь өөрсдийгөө нэг янзаар үзэж байсан ч, Есүс тэдний жинхэнэ нөхцлийг илчлэх үед тэд цочирджээ. Сайн Хоньчин минь яахаараа ийм... хатуу байх гэж? Энэ асуултад Есүс Өөрөө хариулсан:

Би хайрладаг хүмүүсээ зэмлэдэг, сахилгажуулдаг. Тиймээс халуун бай, гэмш. (Илчлэл 3:19)

Бурхан бидэнд хайртайдаа л сүнсний маань нөхцөлд санаа тавьдаг.

Биднийг амьдарсан шиг амьдруулахын тулд л дасгалжуулдаг. Энэ өөрчлөлтийг бүрэн гүйцээхийн төлөө Есүс биднийг бодитой үйл хөдлөлд оруулахын тулд цочирдуулж ч чадна. Түүний анхааруулгад ичгүүр, ял, буруутгалаар хандах хэрэггүй. Оронд нь хөл дээрээ зогсоод, эргээд, Бурханы араас хар хурдаараа гүйх ёстой.

АЧААГАА ТЭНЦВЭРЖҮҮЛЭХ

Миний зүүн мөр, өвдөг хоёр асуудалтай байсныг би хэлсэн. Тэгээд бэлтгэлийнхээ явцад шалтгааныг нь олсон юм. Би аялахдаа, цүнхээ голдуу биеийнхээ зүүн хэсгээр үүрдэг ажээ. Тэгээд зүүн мөр, өвдөг хоёр маань амралтаар илааршиж, дасгалаар хүчжив. Цүнх, компьютер хоёроо үүрэхдээ, биеийнхээ хоёр талыг зэрэг ашиглаж сурч, биеэ дахин тэнцвэртэй болгов. Хичнээн олон хүн ачаагаа биеийнхээ нэг талаар л үүрснээрээ гэмтэл авдаг билээ? Энэ нь Христийн биеийн хоёр хэсэг хоёулаа буюу эрчүүд ч, эмэгтэйчүүд ч ачааг хувааж мөрлөх ёстойгоос гадна мөн хувь хүн ч сүнс, оюун, биеэ тэнцвэртэй бэхжүүлэх ёстойг харуулж байна. Хуучин шархаа оролдоод байлгүй, Бурхантай хамт урагшил.

Сүнсний тал дээр авч ярих юм бол, охид, хөвгүүд нь ачаагаа хувааж үүрэх нь юутай үзэсгэлэнтэй болохыг Дуулал 144 дээр Бурхан дүрслэн зураглах.

Хөвгүүдийг маань залууд нь ургаж гүйцсэн ургамал адил,
Охидыг маань ордонд хэлбэртэй урласан булангийн багана мэт
болгооч! (Дуулал 144:12)

Нью Ливинг Транслэйшн Библи дээр “Хөвгүүд маань залуудаа цэцэглэг” гэдэг. Ингээд бодоод үз дээ: хөвгүүд маань удам дамжин хар залуугаасаа цэцэглэх буюу өсч, өнгөжиж, дэлбээлж, Бурханы сайн сайхныг эдлэх. Гэтэл амьдрал дээр ихэвчлэн яадаг билээ? Өсвөр насны юмуу хориодхон настай хөвгүүд ид насан дээрээ бяр тэнхээ, эрч хүчээ үрэн таран хийхийг л бид үздэг.

Охидыг энд багана хэмээн дүрсэлжээ. Багана гэдэг дүрслэл хоёр утгатай байдгийг би сурсан: Нэгдүгээрт - багана, шон, шигүү мөхлөг, тулгуур, гадас зэрэг тулах системийг дүрсэлнэ. Хоёрдугаарт - “удирдагч” гэсэн үндсэн утгатай. Энэ нэр үгийн дор сая дурьдсан бүх үг багтахыг би харсан.

Энэ хэсэг дээр Бурхан барилгын архитектурын зураглалыг дүрсэлжээ. Эмэгтэйчүүд бид гоёлоос том зүйл байхад бэлэн үү? Бид Бурханы гэрийн дээвэр байхад бэлэн үү?

Энэ нь биднийг дахиад хүч чадал, энэ хүч чадлаа хадгалахын төлөө хийх бэлтгэлийн асуудал дээр авчирна.

Уралдааны замд гүйгчид бүгд гүйдэг ч нэг нь л шагнал хүртдэгийг та нар мэдэхгүй гэж үү? Та нар ялахын тулд гүйцгээ. Тэмцээнд өрсөлдөгч бүр бүх талаар биеэ захирах чадварт өөрийгөө дасгалжуулдаг аж. Тэд муудах титэм хүртэхийн төлөө бол, харин бид үл муудах титмийн төлөө юм. Тиймээс би зорилгогүй мэт гүйдэггүй, хий агаар цохих мэт нударгалдаггүй, харин ч бусдад тунхагласан атлаа өөрөө тэнцээгүй байх вий гэсэндээ биеэ залхааж, боолчилдог. (1Коринт 9:24-27)

УРЬДЫН ХЯЗГААРАА АВЧ ХАЯХ

Би хэзээ ч сайн тамирчин байгаагүй. Ахлах сургуульд ялахын тулд биш, харин усанд, лазаниад, найзуудынхаа гэрт хонох дуртайдаа л сэлэлтийн багт хамрагддаг байлаа. Миний хувьд, бариандаа орох нь л дээдийн заяа байв. Гурав, дөрөвдүгээр байр нь наддаа хавасаг. Гол нь баян ходоод л болж болохгүй. Би тэмцээнд дургүй байсан болохоороо, тэмцээний өмнө их сандардаг байлаа. Тиймээс өөрийгөө тайвшруулахын тулд өөртөө: *“Ганцхан минут л хүчтэй сэлчих. Тэгээд л дуусчихна. Тэгээд л найзуудтайгаа зугаацна”* гэж хэлнэ.

Харамсалтай нь, би өөрийгөө багтаа хэрэгтэй гэдгээ ойлгоогүй явж. Ганцхан өөрийгөө л бодож явж - өөрийнхөө айдас, хүсэл тэмүүлэлгүй байдлаа л аргалдаг байж. Багаа бодохгүй учраас, нэг их хүчлэхгүй. Би хэзээ ч ялахыг хүсээгүй учраас, хэзээ ч ялаагүй юм. Би багийнхаа хэсэг бололгүй, зүгээр л алба мэт ханддаг байжээ. Эргээд бодоход, би ялагдахаасаа бус, ялахаасаа илүүтэй айдаг байсан гэлтэй. Цойлоод ирсэн бол, улам л цойлох байсан байх. Гэвч би үнэ өртгийг нь төлөх хүсэлгүй байсан юм. Би байдгаараа хичээгээд, чадахгүй бол, шархлах байх гэхээс айсандаа, 70-80 хувиас хэтрэхгүй л зориулагддаг байсан юм болов уу. Яагаад тэгдэг байснаа мэдэхгүй. Гэхдээ өнөөдөр би хайхрамжгүй байдлыг - нэн ялангуяа сүнсний хайхрамжгүй байдлыг хэрхэвч хүлээн зөвшөөрөхгүй. Миний амьдрал дан ганц надад хамаатай, минийх биш гэдгийг ухаарсан болохоороо, би урьдын хязгаараа зад татдаг болсон.

Эрслэн - чи ч бас ингэх ёстой. Хүчээ хөгжүүлэхэд, эхлээд бүтэлгүйтэж болно. Гэхдээ энэ чинь сурах үйл явцсын нэгээхэн хэсэг. Анхнаасаа л төгс гүйцэтгэдэг хүнийг би л лав мэдэхгүй.

2Петр 3:1 дээр:

Тэдгээрийн дотор би сануулгаар та нарын чин сэтгэлийн бодол санааг сэргээж байгаа нь... Харин өнөөгийн тэнгэр ба газар нь Түүний үгээр байгаа бөгөөд галд зориулагдан, сүсэг бишрэлгүй хүмүүсийн шүүлт ба сүйрлийн өдөрт хадгалагдаж байна. (Оюун санаагаа жигд анхаарал дор байлга. ... Бурхан дахин үгээ айлтгаж, дохио өгөх бэлтгэл байдлаа авчээ) гэдэг.

Анхаарлаа төвлөрүүлэх нь *чиний* үүрэг болохыг тэмдэглээрэй. Өдөр бүр анхааралтай бөгөөд төвлөрөлтэй байх уу эсвэл хайхрамжгүй, анхааралгүй байх уу гэдэг сонголтын хүч нь чамд бий. Бурхан бэлтгэл байдалд байгаа учраас, өнөөдөр сэрэмжтэй байх ёстой. Бурхан энэ дэлхийн болохгүй байгаа юмсыг зөв болгох бэлтгэл байдалд байна. Бурхан бат ялалт байгуулахад бэлэн болжээ. Өндөр Бурхан дохих үед чи эрслэн шиг хүчтэй хөдөлж, харайхад бэлэн үү?

Ариун Сүнс чиний хүчийг Бурханы Үгийн гэрлээр шинжилж, чамайг ялагч болгож авахын тулд бэрхшээлээр дамжуулан дасгалжуулахыг нь зөвшөөр. Бурханы Үгийн жин, Ариун Сүнсний бэлтгэл сургууль, давталтаар амьдралынхаа гэмтэлтэй юмуу сул талаа сэргээж, хөгжүүл. Хувцсандаа багтаж байна уу гэдэг төвлөрлөө сүнс дотор би хэн бэ гэдэг төвлөрөл болго. Гэхдээ хамгийн чухал нь хүчээсээ бүү ай. Эрслэн шиг л хүчээрээ Бурханыг алдаршуул. Дэлхий юу болоод байна аа гэх эргэлзээ, айдаст автах үед бүхнийг бүтээгч, тэнгэр, газрын Бурхан чамайг амьдралаараа аймшигтай гайхамшиг бүтээн туурвихыг уриалан дуудаж байдгийг санаарай.


Үүнд итгэж байна уу? Чи бусдыг юугаараа хөглөдөг вэ? Чи зүрхээрээ “чагнадаг” уу? Чи стратеги бүтээхийг мэдэх үү? Чи ур чадвартай, бүтээлч хүн үү? Чи ээж хүн үү эсвэл багш хүн үү? Чи семинар юмуу гэр бүл дотроо найр наадам зохион байгуулж чадах уу? Чи тамтаггүй замбараагүй гэрийг эмх цэгцэнд нь оруулж янзалж чадах уу? Эсвэл чи дээр нь бичигдэх зохиолоо хүлээж байгаа цэвэр хуудас юм уу?

Бид бүгд хүч чадлаа бусдад түгээдэг байр сууриа эзлэхээс нааш сэтгэл ханахгүй. Эрслэн - эгч дүү минь, бид чиний аймшиггүй хүчээр дутаж байна. Энэ үнэхээр гайхамшигтай.

ҮЙЛЧЛЭХИЙН ТУЛД ХҮЧ ОРШИХ

Бид бүгд хөршөө босгон байгуулах,
сайн сайхны төлөө түүнд таацуулья.

Ром 15:2



Онгон зэрлэг байгальд гарахаас нааш бидний тэр бүр анзаардаггүй нэгэн чанар эрслэнгийн ертөнцөд байдаг юм билээ. Би өөрөө Өмнөд Африкийн бүс нутгийн араатан муурнуудын талаарх танилцуулга, нүүдэл суудлын талаарх баримтат киноноос үүнийг мэдэж авсан юм. Киноны эхэнд тайлбарлагч хүрээлэнд амьдардаг эрслэнгийн хоёр сүргийг танилцуулав. Эхний сүрэг нь хоёр залуу эрслэн, нэг залуу арслангаас бүрэлдэж байлаа.

Гурван арслан хүрээлэнгийн хилийг тогтоож, томоохон газар үргэлжилсэн, тогтой төмөр хашаатай залгаа, жижиг мухар газар амьдарна. Хамгаалагч хашааны нэгээхэн хэсгийг хумьж нээсэн нь арслангуудад өргөн уудам боловч, урьд хэзээ ч гишгэж үзээгүй, танил бус нутаг дэвсгэрийг нээж өгчээ. Гэнэтийн эрх чөлөөндөө цочирдсон гурван арслан хэрхэхээ мэдэхгүй, баахан самгардах шиг.

Үүнийг таамаглаж байсан хүрээлэнгийн ажилчид залуу арслангуудыг шинэ нутаг руу нь нэвтрүүлэх стратеги боловсруулсан байж. Тэд арслангуудыг өлсгөлөндөө дийлдэхдээ, дасал болсон нөхцлөө ардаа орхиод, шинэ хоолны эрэлд шинэ гэртээ нэвтрэг гээд хэдэн өдөр хоолгүй орхив.

Хүрээлэнгийн ажилчид том машиныхаа ачаан дээрээс томуу гөрөөс буулгаад мөнөөх мухар газрын хашааны гадна, шинэ нутаг дэвсгэр дээр

тавьж орхихийг би шимтэн үзэж суулаа. Арслангууд үйл явдлыг алдалгүй ажиглангаа, гөрөөсний үнэрийг аваад, толгойгоо өргөв.

Залуу арслангууд өлссөн хэдий ч, нөгөөтэйгүүр болгоомжлоод байх шиг. Арслан Африкийн шугуйн аюулгүй газраасаа хөдөлсөнгүй. Арсланг ажиглан байх зуур хоёр эрслэн онгорхой хашаа руу ойртонгоо, нааш цааш сүлжилдэн алхална. Яг л өмнө тогтой хашаа байсан хэсгийн хэмжээг тооцоолох шиг. Тэр хоёр нэг агаар, нэг газар шиншлээд, хашаанаасаа холдон ухарснаа төдөлгүй буцаж ирээд, хэсэг байс хийснээ, хашааг онгойлгов. Яг л болсон явдлыг ойлгох гэсэн мэт. Яагаад энэ хэсэг гэнэт онгойчихов? Арай урхи занга биш байгаа гэх шиг л.

Эцэстээ нэг эрслэн нь хашааны наана гарахаар шийдэв. Өлөн ходоод нь болгоомжлолыг нь дийлсэн болтой. Тэрбээр хилийн шугамаар зоригтой даваад, гөрөөсөнд ойртож очлоо. Замынхаа дунд хашааны нөгөө талд үлдсэн эрслэн рүүгээ хүрээд ир гэх шиг эргэж харна. Нөгөө эрслэн нь хашааны наана хэсэг байзнаж байснаа, төдөлгүй тэргүүлэгч эрслэнгээ гүйцэж ирэв. Ийнхүү тэр хоёр найдвартай байдлыг баталгаажуулахын тулд гөрөөсийг эргүүлж тойруулан шиншлэв. Тэгээд амтлах маягаар амсаж үзлээ. Хоол нь шинэхэн, сайхан мах байсан ч, хоёр эрслэн дайрч орохоосоо өмнө маш сонирхолтой үйлдэл хийв. Эрслэн гөрөөсийн хоолой, хөлөөс нь зуураад, ангийн махаа арслантай хамт зооглох гэсэн шиг хуучин буурь руугаа зөөх нь тэр. Энэ үйлдэл нь намайг ангайлгав. Зориг зүрхгүй арсландаа санаа тавьж байгаа байдал нь ёстой ангаймаар. Тэд арслангүйгээр найрлахгүй л гэнэ.

Эмэгтэйчүүдийн ийм үйлдэл тун үзэсгэлэнтэй.

ЭРГЭЛЗСЭН НЭГЭНДЭЭ ТУСЛАХ

Эрслэнгийн хүндэтгэлтэй үйлдлээс бид нэгийг сурч, үйлдэл, харилцан үйлдэл, хариу үйлдэлдээ тусгах уу? Бурхан охидынхоо өмнө дэлгэж байгаа шинэ газар нутгийн сайн сайхныг бусаддаа авчрахын төлөө цаг, эрч хүчээ зориулдаг эмэгтэйчүүд байх уу бид?

Тийм ээ, эргэн эргэн харах, бусдыгаа хүлээхэд явдал чинь саарах хэдий ч, зөвхөн эхэндээ л тийм байдгийг мэдээрэй. Сайн сайхан, өгөөмөр байдал, цэц ухаанаа зориудаар сунгах явдал нь эцсийн дүндээ заавал ялалтанд хүргэнэ. Бурхан хүмүүсээ шинэ амьдрал, эрх чөлөөгөөр үлээхийг хүмүүс маань баяр хөөр, хүсэн хүлээлтээр тосч авдаг. Зарим нь юу болохыг хүлээн, эргэлзэх. Зарим нь ч эсэргүүцэх.

Бурханы охид бүгдээрээ босоод, өмнө маань Бурханы байршуулсан эрх чөлөө, зорилго руу нэвтрэхийн төлөө би найдан залбирна. Хүчтэй,

зоригтой, үнэний суурьтай хэд нь эргэж хараад, босгон дээр гацан зогсох бусдыгаа урамшуулна.

Ром 15 дээр үүнийг тун сайхан илэрхийлсэн байдаг:

Хүчтэй бид өөрсдөдөө таацуулалгүй, хүчгүйнхээ сул дорой байдлыг үүрэх ёстой. Бид бүгд хөршөө босгон байгуулах, сайн сайхны төлөө түүнд таацуулья (*Хүч нь статусын бус, үйлчлэлийн төлөө болой*) (Ром 15:1-2).

Хүчтэй, чадвартай нь урагш алхаад, эргэлзэгч нэгэндээ зааварчлах, шийдвэртээ гацсан, түгдэрсэн, дайвсан, сульдсан нэгэндээ гараа сунгах боломжтой. Энэ эрч хүч бусдад түгэн дэлгэрч байхад би дуртай. Өтөл, балчир эмэгтэйчүүд дотроо том байхад би дуртай. Тэд урагш давшиж, эргэн тойрноо эзлэхийг хүсдэг. Зарим нь Бурханы даллан дуудах тэр онгон зэрлэг нутагт хөл тавихыг хүсэв ч, босгон дээр нь эргэлзэн зогсох.

Саяхан цуглааны дараа нэгэн хөөрхөн охин надтай уулзаад, чин сэтгэлээсээ ярилцлаа. Тэрбээр надтай богинохон уулзахдаа, дотроо байгаа Бурханаас заяасан, том мөрөөдлөө бүгдийг нь хуваалцаж амжаагүй учраас, гэртээ хариад, сэтгэлдээ байгаа бүхнийг нарийн, дэлгэрэнгүй бичсэн и-мэйл илгээсэн юм. Дараа нь үүнээсээ ихэд зовсон боловч, үнэндээ зовох хэрэггүй билээ. Би түүний захидлыг уншиж байхдаа, айдсыг нь ойлгов. Түүний үгс миний доторхыг цуурайтуулж байлаа. Учир нь би ч бас шилжилтийнхээ улиралд яг тийм мэдрэмжийг үзсэн бөгөөд үүнийгээ ч нөгөө охинд ярьж билээ.

Заримдаа өөр хүмүүс биднээс түрүүлж гүүрээр даваад, гүүрний нөгөө талд аюулгүй хүрсэн гэдгийг мэдэх хангалтгүй мэт. Заримдаа түрүүлж гарсан эгч дүүс нь эргэлзэн зогсох хэд рүүгээ эргээд харах хэрэгтэй байдаг мэт. Эргэж харах нь “Эгч дүүс минь ээ, би хүрчихлээ... энд аюулгүйгээр барахгүй маш сайхан байна!” гэсэн дохио болдог мэт.

ШАШНЫ ДАРАМТЫГ АВЧ ХАЯХ

Зарим маань алмайрсандаа яахаа мэдэхгүй хөшчихдөг мэт. Хэдийгээр олон эмэгтэйчүүд өөрт нь зориулсан Бурханы эрх чөлөөг олж байгаа ч, зарим нь шашны дарамт дор гацсаар. Эмэгтэйчүүд маань өнгөрөгч арванаас л эхлэн холимог хүмүүст хандаж үгээ хэлдэг болсон. Гэхдээ л энэ эрх чөлөөг хүлээн зөвшөөрч чадахгүй эмэгтэйчүүд ч, чуулган ч олноороо байсаар. Би ч бас тэдний нэг байв.

Би Бурханы охидын өмнө айдасгүй ярьж чаддаг хэрнээ дунд нь хэдэн залуу ороод ирэхэд л хар хөлс цутгачихдаг хүн байв. Нэгэн өглөө намайг урьсан пастор, миний аймшиггүй дайчин найз бүсгүй хоёр надад: “Лиза, боль! Чи эмэгтэйчүүдийн өмнө байдаг шигээ л эрчүүдийн өмнө бай” гэж хэлэх хүртэл би алдаа хийхээс айж, сандарсандаа өөрийгөө дэгээдэж унагах шахдаг хүн байлаа.

Би ч өөдөөс нь “Би өөрөө ч мэдэхгүй байна” гэж хариулав.

“Тэгвэл, хурдхан шиг олж мэдэж чадах нь уу? Чи ийм шийдвэргүй байж болохгүй.”

Тэдний үг надад хурц тусав. Эрүүл чуулганд аль, аль хүйсийн дуу хоолой хэрэгтэй. Миний шийдвэргүй байдал үнэндээ энэ итгэл үнэмшлийг няцааж байв! Би чангахан дуугарч чадахгүй байв. Үнэндээ би эрчүүдийн өмнө Бичээсийн төлөө бус, харин эмэгтэй хүн байгаадаа гэмшиж байлаа. Тэгээд эргэлзээ намайг чичлэх үед би өөдөөс нь чиглэн сэлүүрдэж гарав.

Мэдээж би эмэгтэйчүүдэд заах илүү дуртай. Гэхдээ эрчүүдэд үйлчилж байгаадаа гэмшихээ больсон. Би нэг зүйлийг мэднэ: эрчүүд чамайг номло гэсэн бол, өөрт байгаагаа бүгдийг нь шавх гэсэн үг. Тэднийг урамшуулаад, өргөөд, засаад өгбөл, чи тэдний жинхэнэ нөхөр болно, тэд ч чамайг уухайлна. Харамсалтай нь, амьдрал дээр эсрэгээрээ өрнөх нь даанч олон.

Тэд, үүрэхэд бэрх хүнд ачаа баглаж, хүмүүсийн мөрөн дээр тавьдаг атлаа өөрсдөө үүнд хуруугаа ч хүргэхийг хүсдэггүй. (Матай 23:4)

Есүсийн үеийн шашны удирдагч нар ард түмнийг шашны хууль дор хүчин зүтгүүлэх дуртай байжээ. Яагаад тэр вэ? Миний бодлоор, өөрсдийнх нь бүтээсэн хууль дор хүмүүс зүдрэхийг харахдаа, өөрөө өөртөө ноён шиг санагддаг байсан байх. Тэгээд өөрийгөө Бурханд илүү ойр мэт санаж, бах тав нь ханадаг байсан байх.

Дээрх эшлэл нь тун чухал болой. Бурханы хууль нь ачаа дарамт биш, баяр хөөр байх ёстой байж. Хоол хүнс тамир тэнхээ өгдөг бол, ажил хөдөлмөр ядраадаг. Бид Бурханы үйлс, сайн сайхны найр наадамд хүн болгоныг урьдаг хүмүүс байхаар дуудагдсан. Бид Бурханы яндашгүй сайн сайхныг хүмүүст хүртээх ёстой хүмүүс. Үүний тулд заримдаа Бурханы хөвгүүд, охид бид өөр дээр маань овоолсон шашны жинг авч хаях хэрэгтэй болно.

Магадгүй чи “Ганц бие эрэгтэй юмуу эмэгтэй хүн ч үйлчилж болно гэсэн үг үү?” гэж асууж байгаа байх. Болно оо! Христийн бие дотор үйлчлэхийн тулд гэрлэсэн байх ёстой гэдэг далбагар богцоо авч хая. Паул ганц бие байсан. Эмэгтэй хүн томчуудад биш, хүүхдүүдэд үйлчлэхэд л тохирно гэдэг тээшийг суллая. (Бид хүүхдүүдтэй маань хэн ажиллаж

байгаад анхаарах ёстой биш үү?) Мөнчлөн Бурханы амлалтыг ярих байр сууринд очихоосоо өмнө эхлээд төгс байх ёстой гэдэг авдрыг гаргаж хаях уу? Төгс хүн гэж үгүй бөгөөд ийм хатуу шаардлага энэ дэлхийг улам л эздүүлнэ. Өнгөлгөөгөө хаяцгаая. Алдаагаа хүлээн зөвшөөрөөд, түүнээсээ сураад, Есүсийг өргөмжлөөд цаашаа явцгаая.

Харин ч эрх чөлөөгөө ашиглан, хүмүүс дээр буруу зөрүү өрсөн шашны хэрэгтэй, хэрэггүй ачааг авч хаях уу? Бурхан биднийг шинэ зүйлд - шинэ нутаг, атар газрыг эзэмшүүлэхээр дуудах үед бид хөлөө олохгүй, бүдэрч унах шахдаг. Өнгөрөгч арван жилд чуулган маш ахицтай ажилласан бөгөөд энэ нь сайн хэрэг боловч, бүгдээрээ яг жигд хурдаар хөдлөхгүй байна. Тийм боловч, Бурхан ажилласаар, өмнө хаалттай байсан хаалгыг нээсээр, хүмүүсээ айдсыг ялан дийлэгч нар болгохын тулд зүрхэнд нь өлсөө цангааг бий болгосоор байна.

Саяхан нэг и-мэйл хүлээж авлаа. Гурав дөрвөн жилийн өмнө намайг “ариусгагдан, тослогдсон эмэгтэйчүүд Бурханы гэрт дуу хоолойгоо өргөх ёстой” гэж заахыг маань сонссон нэгэн бүсгүй илгээж. Энэ үг түүний мэддэг юмсаас тэс өөр байсан учраас, эхэндээ цочирджээ. Миний үг үнэхээр түүнийг эргэлзүүлж, зовниожээ. Цаг хугацаа өнгөрсөөр, тэр ч сурсаар, залбирсаар, Бурхан ч түүнд миний сургаалыг батлан, өмнө нь мөнөөх хаалгыг нээж өгчээ. Тэр үед нөгөө бүсгүй миний үг үнэндээ Бурханаас эхтэй байсныг сонсохдоо, мэдэрсэн зөрчлөө ухаарсан байна. Бурхан түүнтэй энэ талаар ярих үед дотоод тав тух нь эвдэгджээ. Олон жилийн өмнө хэлсэн үг маань тэр эмэгтэйн дотор үр мэт ажиллаж, эдүгээ л ургац болон халиурчээ.

Бид үнэнийг хайр дотор өгүүлж, бусдыг аялалдаа урих арга байдлаар амьдрах үүрэгтэй. Сул дорой, өлсгөлөн нэгнээ хаяж явж болохгүй.

Езекиел 19:2 дээр “Эх чинь арслангуудын дунд ямар эрслэн байсан гээч!” гэдэг.

Би үүнийг уншихдаа “Энэ юу гэсэн үг юм бол?” хэмээн бодож билээ. Тэгээд Езекиел 19-ийн агуулгыг үзлээ. Тэнд хоёр гүегээ чадалтай, хүчирхэг арслангууд болгохын төлөө өсгөн бойжуулж буй эрслэнгийн элэг эмтрэм дүрслэл гардаг. Тэгээд бодлоо: *Би арслангуудын дундах эрслэн болмоор байна!* Хүчит хөвгүүд, охидыг өсгөх, хүчирхэг амьдралтай эмэгтэй байхыг хүсэхгүй хэн байх билээ. Би олон эмэгтэйчүүдийн амьдралд хүрэлцэх эрх хүртсэн завшаантай эмэгтэй. Гэхдээ бас эрчүүдийн амьдралд ч хүрэлцэх зэмсэг байхыг хүснэ. Би айсан, сульдсан, зөрчилдсөн *бүгдийн* амьдралд хүрэхийг хүснэ. Гэхдээ юу гээч? Үүнийг чи ч хүсч байгаа. Бурхан охидынхоо зүрхэнд бусдыг өргөх хүсэл сүлжиж нэхсэн буй.

НАЙДВАРГУЙД НАЙДВАР

Заримдаа дороо эргэлдэж байгаа нэгэндээ гараа сунгах нь найдвар хайрлах шиг л энгийн зүйл байдаг. Лайф Аутрийчийн шугамаар Камбож руу хийсэн аяллаараа би шөнийн гудмаар явж, биеэ үнэлдэг охидтой ярилцсан юм. Тийм охид дээр явж очих болгонд тэд миний яриаг үл тоосон, биеэ барьсан байдалтай байв. Ганц охинтой ч, бүлэг охидтой ч ярилцсан ялгаагүй, яг л ийм маягаар надтай харилцана. Тэд миний асуултад ганц үгээр хариулчихаад, хоорондоо жиг жуг хийнэ. Дунд эргэм насны, цагаан арьстай Америк эгч тэдэнтэй яриад байгаагийн учрыг гайхсан нь тодорхой. Гэхдээ яриа маань өрнөсөөр, яваандаа би тэдний мөрөөдлийг асуув.

“Та нар юу хийж амьдрах мөрөөдөлтэй вэ? Өөр хүн больё, өөр юм хийе гэвэл, юу хийх вэ?”

Илүү том зүйлийг мөрөөдөж, найдах урилгыг маань сонсоод, тэдний нүүр гийгээд л явчихав. Хар дарсан амьдрал дунд нь мөрөөдөхийг уриалан дуудсан хүн гараад ирлээ гэж үү? Тэд гэнэт л надад хурдан, хурдан хариулж эхлэв. Орчуулагч маань ч гүйцэх гэж бажгадав.

“Би үсчин болмоор байна!”

“Би ресторан нээмээр байна!”

“Би зах дээр гоё гоё юм зардаг барааны лангуутай болмоор байна.”

“Би хүмүүст ад үзэгдэхээргүй ажил хиймээр байна.”

“Би их мөнгө олоод, ар гэртээ явуулмаар байна.”

Охид зогсоо зайгүй шулганалдав. Тэд хэдэн минут тачаангуй төрхөө тайлж хаяад, яг л өсвөр насны гэнэн цайлган охидоороо байлаа.

Төмөр торных нь хаалга нээгддэгсэн бол, тэд хэн болцгоохоо сайн мэднэ! Боломж олдох бүрийд бид тэднийг шоронгоос нь гаргах санал тавьдаг бөгөөд тусламжийг маань цөөхөн хэд нь л хүлээж авна. Гагцхүү ичгүүрээ таягдаж хаяж чадсан нь л ийнхүү урагшилна. Олонх нь ял, ичгүүрийнхээ хоригдол хэвээр үлдэнэ.

Ийм цөхөрсөн нөхцөлд мөрөөдөх, дотоод хүслээ мэдэх нь хангалтгүй. Ийм аймшигтай урхинд орж, ялагдалд автсан хүн ихэвчлэн хаалгыг нь том дэлгээд өгсөн ч, торныхоо буланд шигдсээр үлддэг. Бид охидод янхны ажлаас чөлөөлөгдөх арга зам гаргаж туслахаас гадна байгаа газарт нь сайн сайхныг хүргэж өгсөн билээ. Бид тэднийг Есүстэй танилцуулсан. Есүс тэдний талд бөгөөд Есүс л итгэл найдваргүй хүмүүсийн цорын ганц найдвар болохыг хэлсэн.

Есүсийг амьдрал, зүрхэндээ урих эсэх нь тэдний л шийдвэр. Чи, бид хоёр бусадтайгаа хөл нийлүүлэн, урамшуулж болох ч, эцсийн шийдвэрийг тэд өөрсдөө л гаргана.

ЭРСЛЭНГИЙН ҮНЭН

Энэ бүлгийн эхэнд ярьсан нөгөө баримтат киноны эрслэнг санаж байна уу? Тэд яагаад идшээ арслан дээрээ аваачих болов? Аваачилгүй, өөрсдөө идэх боломж байсан уу? Байсан. Хамгийн боломжийн арга нь өөрсдөө эхэлж идчихээд, үлдэгдлийг нь өөрөө ирээд идбэл идэг гээд арсландаа үлдээх. Эсвэл өөрсдийнхөө хувийг идчихээд, үлдэгдлийг нь арсландаа авчраад өгдөг ч юм уу. Бүтэн гөрөөс зөөж байснаас гуравны нэгийг нь зөөбөл, биед ч амар. Гэтэл тэд бидний санаснаас тэс өөр - ширэнгийн хуулиар үйлдэх ажээ. Хүчтэй нь амьд үлддэг хатуу ширүүн хуулиар оршин тогтнодог ан амьтдын хаанчлалд хоёр эрслэн яагаад тийм өгөөмөр загнах болов? Тэгээд өлөн арсланг хооллоно гэдэг чинь өөртөө бага хоолтой л үлдэнэ гэсэн үг.

Магадгүй эрслэнгүүд бидний умартсан нэгэн зүйлийг мэдэж байсан байх. Хоёр эрслэн өөрсдийнх нь бөгөөд үр төлийнх нь ирээдүй одоохондоо гэнэн, залуу байгаа тэр арслангаас л бүрэн хамаарахыг совингоороо мэдэж байсан байх. Тиймээс хоёр эрслэн арсланг хожим хүчирхэгжихийн цагтаа тэдний тусыг маргахааргүй үйлдэл хийжээ. Тэд өнөөдөр шугуйд бүгэж байгаа арсланг харалгүй, харин хожим бий болох араатны хаан - арсланг харжээ. Хожим тэрбээр эрийн цээнд хүрээд, айж эмээхийг мэдэхгүй зоригтон болно. Тэр цагтаа зүрх муутай, залуу байхад нь хооллож ундаалж байсан хоёр эрслэнг санана. Тэр цагтаа хоёр эрслэнтэй амьдралаа холбоход найдвартай гэдгийг мэднэ. Ухаант эрслэнгүүд бардам зангаа хойш тавиад, арслангийн тааллыг олохыг урьтал болгожээ.

Бидэнд ийм ухаан байдаг билүү?

Эсвэл *би* ийм ухаантай байж болох уу? гэвэл илүү зөв болох байх.

Эсвэл бид арай бардам авиртай байна уу? Хандлага маань “Чи өөрөө л айгаад ирэхгүй байгаа биз дээ? Энд ч хоолтой, ундтай сайхан л байна. Бурхан охидоо идэх уухаар элбэг дэлбэг жаргааж байна. Ирмээргүй байгаа бол, наанаа наад янзаараа л байж байхаас” гэж байна уу?

Бид үнэнд суралцах хэрэгтэй: *одоо багыг хүртэнэ гэдэг нь ирээдүйд багыг хүртсээр байна гэсэн үг биш*. Хүндэтгэл хэзээд хаана ч хүчинтэй.

Хүч нь статусын төлөө бус, үйлчлэлийн төлөө өгөгддөг (Ром 15:2) Энэ зарчмыг хүн бүр анхаардаг сан бол, энэ дэлхий хичнээн олон зовлонгоос сэргийлэх бол. Сул дорой, аймхай, хүлцэнгүйн төлөө үйлчлэх нь бидний хүч гэдгийг бид мэддэгсэн бол? Ямар сайхан байх бол! Хүн бүр л амьдралынхаа төгсгөлд Есүсээс “Сайн байна, Миний итгэмжтэй, сайн зарц” гэдэг үгийг сонсохыг хүснэ.

САЙН ҮЙЛЧЛЭЛИЙН ТӨЛӨӨ БОС

Үйлчлэл гэдэг үг олон янзын хэрэгжилттэй. Нэр үг ч, үйл үг ч болно. Үйлийн хэлбэр нь “засах, шалгах, тохируулах, оношлох” гэсэн утгатай. Есүс тахилаараа бидний төлөө “үйлчилж”, биднийг ариун Бурханы өмнө зогсох эрхтэй болгосон. Бид ч энэхүү амиа зориулсан үйлчлэлийн тусгал болсон амьдралаар амьдардаг. Биднийг бүрэн бүтэн болгохын төлөө Есүс сэг болсон. *Үйлчлэл* гэдэг нэр үг нь “ёслол, зан үйл, ариусгах ёслол” гэсэн утгатай. Заримдаа чуулганы зорилго ану Бурханд бөгөөд бие биедээ үйлчлэхийг сурах явдал гэдгийг бид умартаа юу даа хэмээн эмээх. Христэд итгэгчид бид шал буруу санаагаар цуглах нь олонтаа. Өөрөөр хэлбэл Бурхан бидний төлөө юу, юу хийж чадахыг сонсох гэж л ирдэг. Бүгдээрээ дөрвөн хананы маань дотор ч, ариун сүмийн гадна ч хөл нь хөшсөн хүмүүст гараа сунгахаар нэгдэцгээе.

Хэнийг ч ардаа үлдээхгүйн төлөө өмнө маань нээгдэх эрх чөлөө, таалал, шинэ боломжийн амлалтаар Бурханы юмс дотор урагш хөдөлцгөөе. Би дараах даалгаварт хайртай:

Биднийг Христийн зарц нар бөгөөд Бурханы нууцын нярвууд гэж тооц. Мөн итгэмжит байхыг нярвудаас шаарддаг. (1Коринт 4:1-2)

Бид хамгаалалтын алба бус, хөтөч байх ёстой хүмүүс. Бид бусдыг хаанчлалд урих ёстой болохоос, Бурханы нууцын гадна байлгах ёсгүй. Бид оновчтой мэдлэгтэй, найдвартай хөтөч байх үүрэгтэй. Бусдыгаа ардаа үлдээлгүй, авч орохын тулд Бурханы бидэнд нээж өгч буй хаалган дээр түр зогсоод, арагш харж сурцгаая.

Өндөр Бурханы охин - чиний сунгасан гар өгөөмөр бөгөөд хүндэтгэлтэй байх ёстой. Бурханы амь чөлөөлдөг бол, хууль дарамталдаг. Чи “нүдийг нүдээр” гэдэг зарчмаас Христэд итгэх итгэл рүү чөлөөлөгдсөн. Тийм боловч, Христийн биеэр дүүрэн нүдгүй, өм цөм шүдтэй хүмүүс байх.

Өөрийгөө хүчтэй, жавхлантай, аймшиггүй, дошгин, хамгаалагч, тайван, зовнилгүй нэгэн гэдгийг бүү март. Бурхан язгууртан хүүхдүүдээ арслан, эрслэнтэй ахин дахин зүйрлэдэг.

Тэрээр мярааж хэвтэх нь арслан мэт, эрслэн мэт. Түүнийг босгож хэн зүрхлэх вэ? Чамайг ерөөх бүхэн ерөөгдөж, чамайг хараах бүхэн хараагдах болтугай гэв. (Тооллого 24:9)

Өөрийнхөө зэрлэг, дошгин мөн чанарыг умартбал, чиний нөмөр, хөтөлгөө дорх хүмүүс эрсдэлд орно. Христийн бие “Бурхан бидний өмнө уудам ертөнцийг дэлгэж өгсөн” гэдэг үнэнийг ухамсарласан, хүндэтгэлтэй, хүчирхэг хамгаалагч нараас тогтох.

Эрслэн эгч дүүс минь ээ:

... бид та нарт ам нээсэн. Зүрх маань ч нээгдсэн.

Та нарыг бид хашаагүй харин та нар дотроо хашигдсан аж.

Хариуд нь “Та нар ч нээлттэй бай” гэж би хүүхдүүдэд хэлдэгчлэн та нарт хэлж байна. (2Коринт 6:11-13)

Сонсож байна уу? Биднийг Бурханы онгон зэрлэг, цэлгэр уудам орон зай руу урьжээ. Энэ бол яг одоо байгаа газартаа том амьдрах уриалга юм. Тэнгэрийн хүч газар дээр буухыг харах гэж тэнгэрт очтолоо хүлээх хэрэггүй. Бурхан чамайг хаашаалаагүй.

Гэхдээ өлөн ходоодондоо дийлдэхээс нааш хоёр эрслэн аюулгүй байдлаа орхиж, хашаанаасаа гараагүй. Үүнтэй адил - алсын хараагүй, хүсэл тэмүүлэлгүй байдал маань биднийг зэрлэг байгальд хөл тавихаас хязгаарлан, хорьдог. Зүрх үхэж, өөрийгөө, ертөнцийг, Бурханыг харж сурсан үзлийнхээ хоригдол болсоор. “Хаалганы цаадах” ертөнцийг харанхуй, аймшигтай гэж төсөөлөөд байх юм бол, тэгж л санагдана.


Нүдээ нээгээд, өөрийгөө хэн болохыг сана - чи бол явсан газартаа харанхуйг үргээх хүчтэй, гэрлийн шижир туяаг атгагч. *Учир нь та нарын дотор байгаа Тэр бол дэлхийд байгчаас аугаа* (1Иохан 4:4). Дэлхийд байгчаас дутахгүй юмуу адилхан биш шүү. Чиний дотор байгаа Тэр болбоос энэ дэлхий дээр чамтай сөргөлдөх ямар ч хүчээс *хол илүү!* Өндөр Бурхан Өөрөө чамайг дуудсан шүү. Бурхан л чамайг үхлээс амь руу, элдвийн хориг цаазтай энэ дэлхийгээс өнө мөнхлөл рүү шилжүүлж авахын тулд Хүүгээ илгээн, загалмай дээр хадуулсан. Чамайг анхны амьсгалаа авахаас өмнө Бурхан чамайг хорионоос суллах арга замыг гаргажээ. Бурхан чамайг Өөрийнхөө хаанчлалын уудам эрх чөлөөнд нэвтрүүлэхийн тулд Өөрийгөө хязгаарлаж, өчүүхэн бидний торон доторх, өдийхөн амьдралаар амьдарч үзэхийг сонгожээ.

Тэр одоо ч биднийг “Наагуураа даваад, наашаа хүрээд ир!” хэмээн дуудсаар.

НЭГЭН ДААЛГАВАР ДОР

Эмэгтэй хүнийг чөлөөлөх бүрийд
эрэгтэй хүн чөлөөлөгдөж байдаг.

МАРГАРЕТ Мийд



Арслангийн ертөнцөд хүйсийн самуурал гэж юм байхгүй. Арслангууд нь эрслэн болох гэж оролдохгүй, эрслэнгүүд нь арслан болох гэж оролдохгүй. Арслан ч, эрслэн ч нэг нэгнээ дууриах юмуу нөгөөгийнхөө дүрд орох гэж оролдохгүй. Аль, аль нь өөртөө сэтгэл хангалуун, онцгой хүйсээрээ бахдана. Эр, охин гэдэг хүйсээс гадна сүрэг дотор толгойлогч арслан, эрслэн гэж байдаг ч, энэ статус нь голдуу хоолон дээр л үүрэгтэй.

Муурын бүл дундаас арслангууд нь хүйсээрээ шууд ялгаран харагддаг. Арслан гэдэг үгээр зөвхөн арсланг л нэрлэнэ. Товчхондоо, арслангийн хүйсийг тодорхойлох нэгээс олон хүчин зүйл байдаг байх нь.

Арслан хүзүү толгойгоо ороосон их дэл үстэй. Энэ нь толгойлогч арслангийн сүрэгтээ гүйцэтгэдэг онцгой, тусгай дүрийг нь тодруулдаг бөгөөд арсланг Африкийн талд аймшигтай сүртэй харагдуулна. Эрслэнгийн дэлгүй, мулзан төрх нь түүнийг ангаа гэтэн барихад нь нүдэнд үл анзаарагдам болгож, байгальтай уусгадаг. Хүнд дэлгүй учраас, эрслэн маань хурдан хөдөлж, холоос дайрах боломжтой байдаг ажээ.

Эрүүл арслан, эрслэнгүүд бие биедээ хэрэгтэй гэдгээ мэддэг. Тэдэнд тусдаа гарах, бие даах гэсэн ойлголт байхгүй. Амьтны ертөнцөд нэг хүч нь нөгөөгөөсөө дутахгүй чухал байдаг. Арслан аюулгүй байдлаа хариуцдаг,

эрслэн хангамжаа хариуцдаг. Энэ амин чухал тэнцвэр нь “эрүүл, хүчтэй альфа арслан хүчирхэг эрслэнгүүдийн тусламжаас татгалзахгүй” гэсэн утгатай. Арслангийн ертөнцөд арслан нь өөрийгөө эрслэнгүүдээр хүрээлүүлж, тэдний ертөнцөд нэвтрэхийн тулд өөр хоорондоо хүчээ үздэг. Яагаад? Тухайн газар нутгийг арслангууд биш, холбоотон - эрслэнгүүд л эзэрхдэг ажээ. Сүргийг тэргүүн - арслангийн эвсэл нь 2-3 жил тутамд өөрчлөгддөг бол, эрслэнгүүд насаараа эзэгнэнэ.

Альфа арслан (зүгээр л амьд байхын тулд бус, харин) цэцэглэн хөгжихийн тулд эрслэнгүүдийн нүдэн дээр өөрийгөө хүч чадлаараа зарлан тунхаглах ёстойгоо мэднэ. Мөн газар нутгаа өвлүүлэн эзэгнүүлэх үр төлөө үлдээхийн тулд хүчирхэг, чадварлаг эрслэнгүүдийн тусгүйгээр явахгүйгээ ч мэднэ. Арслан үлбэгэр, сулбагар амьтдаар өөрийгөө хүрээлүүлэхгүй, аяндаа хүрч ирээд захирагдана гэж ч хоосон найдахгүй. Арслан өндөр мэргэшсэн, холбоотон - эрслэнгүүдийг л онилно.

Арслан зориудаар хамгийн л чадварлаг, сурамгай анчдыг нь, үр төлөө асран бойжуулах чадвартайг нь, хил хязгаараа сахин хамгаалж, өргөжүүлэн тэлэх хүчтэйг нь сонгож, тэдний хүчийг дуртайяа хүлээж авна. Арслан хожим сүргийг нь сайн ханган тэжээх чадвартай, үр төлөө сургах ирээдүйтэй эрслэнг л хайна. (Арслан өөрөө өсгөж бойжуулна гэж юу байхав.) Дээрээс нь хүчтэй, эрүүл эрслэн олон хээлтэж, төллөдөг бөгөөд энэ нь арслангийн хувьд хүчирхэг угсаа бүтээх боломж юм.

Үр төлөө тэжээж, өсгөж чадахгүй гэхээс айдаг эрслэн олон удаа төллөдөггүй. Ийм эрслэн дорой бус, хүчирхэг альфа арсланд татагдана. Толгойлогч арслан юмуу арслангууд (голдуу нэг бүлийнхэн) эрслэнгийн сүрэгтээ авчирдаг хангамж, хүч, халамжийг эдлэх эрхээ олж авах ёстой. Энэ завшааныг голдуу арслангийн бүл хооронд өрнөдөг, нээлттэй тэмцэлдээнээр олж авна.

Хүчтэй нь үлдэж, дорой нь зугтахад тэмцэлдээн дуусна. Заримдаа альфа арслан өрсөлдөгчөө ална. Бүл чадалгүй арслан амьд үлдлээ ч, сүргийнхээ нутаг дэвсгэрээс албадан цөлөгдөх бөгөөд энэ нь тэр газарт ан хийх эрхээ хасуулж байгаа хэрэг юм. Тэрбээр нэг бол нүүж, өөр газрын эрслэнгийн сүргийн эрэлд гарна эсвэл өөрөө амьтны идэш болж дуусна.

Энэ явдлыг эрслэнгүүд хажуугаас харсаар. Тэд сүргийг нь довтолгоо, халдлагаас хамгаалдаг хүчтэй хамгаалагчийг, үр төлдөө хүчтэй эцгийг л хүснэ. Тиймээс ч арслангуудыг тулалдуулж, ялагчийг тодруулж, ялалтын үр өгөөжийг нь хүртэнэ. Нутаг дэвсгэрээ байлдан дагуулсан арслан зэрлэг байгалийн хатуу ширүүнд амьд гарах илүү даацтай бөгөөд хүчирхэг удмаа батлан харуулна.

Ялагч тодроход, эрслэнгүүд түүнд бүрэн үнэнчээр зүтгэнэ. Сүргийн бусад арслангууд зайгаа тавьж өгнө. Альфа арслан бусад арслангаас

татгалзаж болох ч, эрслэнгүүдээсээ нүүр буруулна гэж зангүй. Дан ганц үржлийн төлөө биш л дээ. Эрслэнгүүд хүнс тэжээлээр хангаж, сүргийн харилцааг бүтээдэг. Эрслэнгийн сүрэг нь хүчирхэг бөгөөд биширмээр байх тусам, араатны хаан арслан маань тэр хэмжээгээрээ аюулгүй бөгөөд жавхлантай оршино.

Сүргээ хамгаалахын төлөө бүхнийг хийдэг арслантай гэдгээ мэддэг эрслэнгийн сүрэг хэзээ ч арслантайгаа дайсагнахгүй. Арслангийн хүч эрслэнгүүдийг ч, үр төлийг нь ч аюулгүй байлгана. Хүчиндээ итгэлгүй нэгэн л дарангуйлах гэж оролддог.

Байр сууриа эзэлсэн, хүчит арслан бяр чадлаа батлан харуулах гэж эрслэнгүүдийг дарангуйлахгүй. Юугаа ч батлах билээ? Угаасаа хэдийнээ ялчихсан шүү дээ. Түүнийг хэн давах билээ? Үүнтэй ижил манай Хаан - Иудагийн Арслан маань дардаггүй, өргөдөг юм.

НЭГЭН ДААЛГАВАР ДОР

Эрслэн арслангийнхаа бат хамгаалалт дор амарч, арслан ч эрслэнгийнхээ хангамж, сайн сайхан дээр найрлана. Арслан эрслэнгээ хамгаалж, эрслэн нь эргээд түүнд өв хайрлана.

Захирагдахуй гэдэг үгийг хэсэг бодож үзнэ үү. Санаанд чинь юу бууж байна? Эхнэрүүд нөхөртөө захирагдах талаар өгүүлэх Ефес 5:22 л бууж байгаа байх. Христэд итгэдэг олон хүн энэ эшлэлийг тасдаж аваад, туйлширсан, баригдмал хэлбэрээр тодорхойлдог нь сонирхолтой. Бид *захирагдахуй* гэдэг үгийг Бурханы санаанаас хазайлгаж тодорхойлдог. Христэд итгэдэг олон эмэгтэй өөрийгөө эрчүүдэд үйлчлэхийн төлөө л төрсөн гэж үздэг. Чуулган дотор номлох, бодол санаагаа хүндэтгэлтэйгээр дуулгах юмуу удирдлагын үүрэг оройллыг дааж авах нь *үйлчлэл* гэдгийг тэд ухаардаггүй.

Захирагдахуй гэдэг нь дан ганц гэр бүлийн хосод хандсан үг бус. Энэ үг нь Христэд итгэдэг бүх хүнд зориулсан Бурханы төлөвлөгөөтэй хайрцаглагдаж, зэрэгцдэг гэсэн нэгэн тодорхойлолтыг би сонсож билээ. Тухайлбал *сабмиссион* (захирагдахуй) гэдэг англи үгийн *саб* гэдэг удиртгал нь “дор” гэсэн утгатай бол, *миссион* гэдэг нь даалгавар гэсэн үг болно. Нийлүүлбэл, захирагдахуй гэдэг нь “нэгэн даалгавар юмуу үүрэг дор” гэсэн утгатай болно. Жишээ нь Жон, бид хоёр нэгэн даалгавар дор яваа улс. Чуулганы талбар дор авч ярьбал, бид пасторуудад тусалж, хувь хүмүүсийг хүчитгэх даалгавартай.

Бодоод үз. Бид чинь бүгдээрээ эвлэрлийн үйлчлэгч нар - төөрөгсдийн төлөөх элчин сайдууд биш гэж үү? Дараах хоёр эшлэл Бурханы эрэгтэй, эмэгтэй элчин сайд болсон бидний даалгаврыг олзлон хэлжээ.

Учир нь Бурхан дэлхийг Христ дотор Өөртэйгөө эвлэрүүлж, тэдний гэм бурууг эс тооцсон ба эвлэрлийн үгийг бидэнд даалгасан билээ. Иймээс бид Христийн төлөөх элчин сайд юм. Бурхан биднээр дамжуулан ятгаж байгаачлан Христийн төлөө та нараас бид гуйя. Бурхантай эвлэрцгээ. (2Коринт 5:19-20)

Товчдоо: Биднийг бие биеэ хайрлаж, өөр хоорондоо гар нийлэн ажиллахыг үзсэн хүмүүс манай Есүсийг жинхэнэ гэдгийг мэдэх болно. Энэ бол эрчүүд, эмэгтэйчүүд, гэрлэсэн, гэрлээгүй, удирдагч, ажилтан - бүх хүний нэгдмэл зорилго байх ёстой. Нүглийн хүч дуусгавар болсон. Бурханы өршөөл бүх хүнд нээлттэй. Есүсийн тахил биднийг бүгдийг маань ялгүй болгосон байхад, яллаад байх шаардлага байхгүй. Бурхан биднийг эр, эм гэлтгүй бүгдээрээ Өөрийнх нь *үйлсийг* хүмүүст мэдүүлээсэй гэж хүсэх! Гэтэл оронд нь бид бие биедээ хийж чаддаг, чаддаггүй юмсыг нь чөлөө завгүй сургасаар.

Бурхан биднийг эрчүүд, эмэгтэйчүүдэд (ямарваа) зөрчлөө таягдаж хаяад, Бурханы үйлс рүү нэвтэрч орохыг нь үнэмшүүлдэг, урамшуулдаг сэнхрүүлэгч нөлөө байхын төлөө гар нийлж ажиллаасай гэж хүсдэг. Бид хүний харилцааны бүх талбарын зөрчлийг шийдвэрлэдэг байгаасай. Эдгээр нь дан хүйсийн асуудал бус, харин яс үндэс, нийгэм, эдийн засаг, гэр бүл, чуулган, зах зээлийн эрч хүч зэрэг асуудал болой. Бурхан бүгдэд эвлэрлийг хүсэх!

Тиймээс хэн нэг нь Христ дотор байвал тэрээр шинэ бүтээл мөн. Харагтун, хуучин нь өнгөрч, шинэ болсон байна! Энэ бүхэн Бурханаас ирдэг бөгөөд Тэрээр биднийг Христээр дамжуулан Өөртэйгөө эвлэрүүлэв. Ийнхүү эвлэрлийн үйлчлэлийг бидэнд өгчээ. (2Коринт 5:17-18)

“Хэн нэгэн” гэдэг нь *бүгд* л гэсэн үг. Христтэй холбогдсон эрэгтэй, эмэгтэй, хүүхэд - ер нь хэн ч бай дахин бүтээгддэг. Хуучин амьдрал нь ор мөргүй болно. Дээрх эшлэл дээрх *шинэ болох* гэдэг үг нь “мөөг ургах” гэсэн утгатай юм. Мөөг нэг ургахаараа, хувхай хоосон байсан газар яах ийхийн зуургүй өсч, үржиж, ярайдаг учраас, энэ тун сонирхолтой үгийн сонголт гэмээр. Христ доторх шинэ амьдрал маань зүгээр нэг үзэл баримтлалын холио солио биш юм. Энэ бол хэнд ч нээлттэй, дотроо үржил тээсэн амьдрал юм.

Арслан, эрслэнгийн харилцаа хэдийн тогтжээ. Эрслэнгүүд нь арслантайгаа нэг л даалгавартай гэдгээ ойлгоно. Ямар даалгавар? Өвтэй, хүчтэй арслангийн угсааг бий болгох. Үүнд хүрэхийн тулд тэд үр төлөө

бойжуулж, хамгаалж, өсгөнө. Энэ даалгаварт арслан ч, эрслэн ч өөр өөрийн үүрэгтэй бөгөөд нэг нь нөгөөгийнхөө даалгаврыг дээрэмдэхгүй.

Гэтэл амьдралын жирийн тогтолцоо байх ёстой юмсыг хоёр туйл руу хадууруулж байхыг би харсан. Нэг туйл дээр нь эмэгтэй хүнийг захирагдахуй нэрийн дор дарладаг. Гэтэл нөгөө туйл дээр нь эмэгтэйчүүд бүсгүй хүний чанараа бурханчлан тахидаг. Энэ талаар жаахан хожуу ярина. Эхлээд захирагдах гэдэг ойлголтыг хэрхэн сэглэдэг талаар ярилцъя.

Жиргээг мушгих

Та нар Жиргээг мэдэж байгаа. Амьдралын асуудал, санаа руу өнгийх цонх болдог, товч мэдээлэл юм. Нэг удаа би *Fight Like A Girl* ном дээрх ойлголтоо постолсон юм л даа. “Эрчүүд дан ганц хүйсийнхээ улмаас л удирдлагад тэнцдэг юм биш, эмэгтэйчүүд дан ганц хүйсийнхээ улмаас л удирдлагад тэнцдэггүй юм биш. Хэн хэн нь чанарынхаа улмаас л тэнцдэг.”¹ гэсэн удирдлагын талаарх эшлэлээ биччихэв. Би үүнийг дан ганц чуулганы удирдлагад юмуу гэр бүлтэй холбож хэлээгүй шүү. Ердөө л эрэгтэй байна уу, эмэгтэй байна уу - ямар ч удирдагч хүнийг удирдлагад тэнцүүлдэг ганц хүчин зүйл нь чанар болохыг л хэлсэн болно.

Тэгээд Жиргээ, Фэйсбүүк дээрээ тавьчихаад, маргааш болтол таг мартав. Өөрийгөө ч зөрчилтэй үг хэлчихлээ гэж бодсонгүй. Харин ч цаанаасаа ундарч гарсан үг л гэж бодов. Энэ үг юу дагуулахыг гадарласан ч үгүй.

Гэтэл зуугаас илүү хариу хүлээж авснаа харахдаа, хүмүүсийн мэдрэлийг хөдөлгөснөө ойлгов. Өдөр тутмын ажилдаа автаж явах хойгуур маань Фэйсбүүк дээр хэлэлцүүлэг өрнөжээ, хө. Христэд итгэдэг хэсэг эмэгтэйчүүд хилэгнэсэн байв.

Нэг эмэгтэй “Өөрийгөө илүү чанар чансаатай гэж үзсэн эмэгтэй хүн нөхрөө захирч болно гэдэг чинь юу гэсэн үг вэ!” гэж бичсэн байна.

Тэгэхээр, би ийм зүйл хэллүү?

Зарим нь намайг гагцхүү эр хүн л чуулганы удирдагч байж болно гэсэн бичээсийг эс хэрэгслээ хэмээн яллажээ. Би чуулганы удирдлагын талаар өгүүллүү? Тэгтэл бас удирдлагын талаар ерөнхий хэлэлцүүлэг өрнүүлсэн байлаа. Зарим эмэгтэйчүүд “эмэгтэй хүн хэзээ ч удирдагч байж болохгүйг” Фэйсбүүкийн хэрэглэгч нарт тайлбарлажээ.

Гэтэл тэр хүнээс нэгэн охин “Та тэргүүн пасторын гэргийг удирдагч биш гэх гээ юу?” хэмээн чин сэтгэлээсээ асуусан байв. Эмэгтэй хариуд нь “Үгүй ээ, удирдагч биш! Зүгээр л нөхрөө дэмжих хүндэтгэл хүлээж яваа хүн” гэж бичсэн байв.

Сүүлдээ миний ч тархи эргэчихэв. Санал бодлууд хөврөх явцад харилцан яриа нь захирагдах тухай хэлэлцүүлэг болон хувирчээ. Зарим нь намайг удирдагч гэж байхад, нөгөө хэсэг нь зүгээр л эмэгтэй хүн учраас, удирдагч биш гэсэн байв. Намайг нөхөртөө захирагддаг учраас, түүний сүүдэр дорх удирдагч гэх тайлбараар хаацалсан байлаа.

Тэгвэл түр зогсоод, хамтдаа учирлан эргэцүүлэе. Хүйсийн сэдвийг сөхөх тоолонд яагаад энэ яриа эмэгтэйчүүд эрчүүдэд захирагдах тухай яриа болж нарийсна вэ? Би хүмүүсийг удирдаж байгаа бол, Бурхан намайг томилсон учраас л тэр. Товчхондоо, удирдагч хүнийг хүмүүс дагадаг. Лицензтэй байна уу, лицензгүй байна уу - зарим маань удирдагч мөнөөс мөн. Тиймээс үлгэр жишээгээрээ удирдахад маань Бурхан бидэнд туслах болтугай. Энэ эргэлзээг тайлахын тулд Паулын Тимотод даалгасан удирдлагын үүргийг харцгаая.

Тиймээс харгалзагч нь өө сэвгүй, нэг эхнэрийн нөхөр, биеэ барьдаг, хэрсүү, хүндэтгэгдсэн, зочломтгой ба заах чадвартай, дарсанд үл шимтэгч, зодоонч биш, харин дөлгөөн, хэрүүлч бус, мөнгөнд шуналгүй, өөрийн гэрийг сайн захирдаг, бүхий л хүндлэл дор хүүхдүүдээ захирдаг байх ёстой. (Хэрэв хэн нэгэн өөрийн гэрийг захирч мэдэхгүй бол хэрхэн Бурханы чуулганыг халамжлах билээ?) Шинэ итгэгч байж болохгүй. Эс бөгөөс биеэ тоон диаволын шүүлтэд унах вий. Тэрээр буруутгалд хийгээд диаволын урхинд орчихгүйн тулд гадна байгсдын зүгээс сайн гэрчлэлтэй байх ёстой. Үүнчлэн үйлчлэгчид хүндтэй, хоёрдмол үгтэй бус, дарсанд шунадаггүй, эдийн шуналгүй, итгэлийн нууцыг цэвэр мөс чанараар сахидаг байх ёстой. Эхлээд тэд шалгагдаг. Тэгээд гэм зэмгүй аваас үйлчлэг. (1Тимот 3:2-10)

Дээрх эшлэл дээр Паул эрэгтэй удирдагч хүний тэнцлийн чанарыг жагсаажээ. Тэгээд араас нь ингэж хэлсэн байна:

Түүнчлэн эмэгтэйчүүд (*ялгаагүй чанартай буюу*) хүндтэй, гүтгэгч бус, тэвчээртэй, бүгдэд итгэмжтэй байх ёстой. Үйлчлэгчид нь нэг эхнэрийн нөхөр, хүүхдүүдээ болон гэр бүлээ сайн захирдаг байг. Учир нь онц үйлчилсэн нь сайн байр суурь ба Христ Есүс дэх итгэлдээ үлэмж зоригийг олж авдаг. (1Тимот 3:11-13)

Эмэгтэйчүүд эмэгтэй гэдэг шалтгаанаар удирдлагад тэнцэхгүй байсан юм бол, Паул яахаараа удирдлагын тэнцлийн чанарыг жагсаах билээ? Жон, бид хоёр ч үйлчлэлийнхээ албанд хүн авахдаа, эр, эмийг нь харахаасаа илүү

чанарын шаардлагын жагсаалтаа л мөрддөг. Паул удирдагч хүн эрэгтэй л биш бол, найдалтгүй гэж хэлээгүй. Паул чанар дээр нь л төвлөрсөн байна. Паул эмэгтэйчүүдийг тусгайлаагүй, харин яг ижил жишиг, үлгэр загварыг мөрдөнө гэсэн. Тэгвэл, нэг нөхрийн юмуу эхнэрийн хань байх ёстой гэсэн үүргийн хувьд яах билээ? гэж асууж болох. Тэгэхээр, тухайн үед эмэгтэй хүн нэгэн зэрэг олон нөхөрт гардаггүй байсан болохоор, энэ үүрэг нь зөвхөн эрчүүдэд хамаатай болно.

1Тимот 3:11-13 дээр Паул Тимотод удирдлага дахь эмэгтэйчүүдийн чанарын талаар зааварчлаад, дараа нь чуулган дахь үйлчлэгч, дикон эмэгтэйчүүдийн талаар нарийлан ярьсан. Яаж мэдэж байгаа юм гэж үү? 1-2-аар эшлэлийг уншаад, эрчүүдэд зориулж нарийн ширийн заавар өгөхөөсөө өмнө юу хэлснийг үзье.

Хэрэв *хэн нэгэн* нь харгалзагч болохыг эрмэлзвэл, тэр сайн ажил хүсэж байна. (Хэн хүн чуулган дотор удирдлагад ажиллахыг хүсбэл, сайн байна! Гэвчиг нөхцөл буй.) (1Тимот 3:1-2)

“Хэн хүн” гэдэг үгийг харж байна уу? Ийнхүү Ийнглиш Стандарт Вержн дээр “хэн хүн” гэж хэлсэн бол, Нью Ливинг Транслэйшн дээр “алив хүн” гэдэг.

Эмэгтэй хүн чуулганд л биш бол, хаа ч хамаагүй удирдаж болох хэрэг үү? Бурхан Нүглээс өмнө ч, Нүглийн дараа ч эмэгтэйчүүдийг ямар ч асуудалгүй босгож ирээд байхад, Авралын дараах хүн - бид эмэгтэйчүүдийг эрхтэй, хүчтэй болчих бий гэхээс юунд эмээнэ?

Нэг удаа эмэгтэйчүүд - биднийг Фэйсбүүк дээр гал авалцтал үзэлцэж байтал, нэг залуу дундуур орж ирээд “Бүсгүйчүүд ээ, та нар яагаад өөрсдийнхөө өөдөөс далайна вэ? Бидэнд та нарын хувь нэмэр хэрэгтэй байтал, та нар бие биеэ хориод байна!” гэж хэлж билээ. Тэр хүн яг л онож хэлсэн юм. Бид л бие биеэ хорьж, доош хийдэг. Христийн төлөө бие биеэ дэмжээд, өргөөд өгөхийн оронд нэг нэгнээ ямар ч үр дүнгүй эмэгтэй, ямар ч үр дүнгүй Христчин болгох гээд л дарамтлаад л байдаг.

Олон нийтийн сүлжээнд гарсан энэ гэнэтийн тохиолдол надад хүйсийн асуудлыг гэр бүл дотор төдийгүй, чуулган дотор ч авч үзэх хэрэгтэйг ойлгуулж билээ. Энэ дэлхий Бурханы хөвгүүд, охидын амьдрал, удирдлагын тал бүр дээр тогтоож өгсөн, Бурханы жинхэнэ зүрх, эх санааг харах хэрэгтэй.

СЕКСИСТ ХАНДЛАГА

Америк чуулганд сексист хандлагын талаар яриад байх шаардлага байхгүй болсон гэдэгт итгэмээр л байна. Тийм ээ, би улсаа л нэр цохон дуудаж байна. Дэлхий даяар аялж, дэлхийн үзэл бодлыг нутагшуулахын зэрэгцээ би, эмэгтэйчүүдийн оролцоог хориглодог манай уламжлалт арга барил бөмбөрцгийн бусад хэсэгт ажилладаггүйг хардаг. Эмэгтэйчүүдийн хувь нэмэр байгаагүй бол, зарим улс үндэстэнд чуулган орших ч үндэс байхгүй.

Бурханы бүтээл бүр сайн. Тэдгээрийг талархалтайгаар хүлээн авсан бол гологдох зүйл үгүй. Учир нь энэ нь Бурханы үгээр ба залбирлаар ариусгагддаг. (1Тимот 4:4-5)

Бурханы бүтээсэн юмс нь талархалтайгаар, тааламжтайгаар хүлээж авмаар, сайн юмс байдаг байхад, Бурханы бүтээсэн хүмүүсийг ингэж хүлээж авах ёсгүй гэж үү? Эрчүүд, эмэгтэйчүүд - ялгаагүй сайн болой.

Алив зүйл нь Бурханаар бүтээгдсэн бол, бид үүнийг үл тоох юмуу орхигдуулж болохгүй нь байна. *Үл тоох* гэдэг нь дооглох, шоглох, дээрээс доош харах, элэглэх гэсэн утгатай. Эдгээр үйлдэл нь тухайн юмыг, хүнийг юмуу тэдний үүрэг, хувь нэмрийг үнэгүйдүүлдэг.

Хаях гэдэг үг нь утга тодорхой боловч, хамгийн оновчтой утгыг нь түүж үзье. Орхих, чулуудах, шидэхээс гадна *хаях* нь асуудлыг самууруулах, үймүүлэх, ээдрээтүүлэх, ярвигтуулах гэсэн утга агуулна. Түүн дээр “байхгүй” гэсэн утга бүхий *гадагш* гэдэг үгийг нэмчихбэл, *гологдлын* дүр зураг тодорч байна. Чуулган дотор эмэгтэйчүүдэд ихэвчлэн ингэж л хандаж хэвшсэн гэж айж байна. Тэднийг уриалгахнаар хүлээж авалгүй, хажуу хаяанд орхиж, дуу хоолой, үнэ цэнэ, хувь нэмрийг нь үгүй хийх. Энэ явдлыг ч *аль, аль* хүйс маань “захирагдахуй” гэдэг ойлголт дор хүлээн зөвшөөрдөг.

Эцэст нь эрчүүд ч, эмэгтэйчүүд ч үнэ цэнийн өндөр алдагдал хүлээнэ. Мэдээж чуулганд эмэгтэйчүүдээс илүү эрчүүд л өндөр байр суурь хүлээдэг ч, заримдаа тэд эмэгтэй хүний ухаанаар дутсандаа, гар мухардана. Гэхдээ бид эрчүүдийнхээ төлөө Бурхандаа талархдаг билүү? Тэднийг Бурханы хардагчлан - сайн хэмээн хардаг уу?

Эсвэл үйлдлийг нь шоглоод байна уу? Хамтдаа инээлдэх талаар яриагүй шүү. Хүн төрөлхтний хошин занд инээхгүй байхын аргагүй. Бидний хошин чанар үнэндээ Бурханы л цаглашгүй хошин занг илэрхийлэх. Тийм боловч би энд хүйсийг доог тохуу болгож, доош хийх тухай ярьж байна. Хүн өөрөө ч мэдэлгүй ийм зан гаргадаг. Зугаа цэнгээний үйлдвэрлэл

алхам тутам эрчүүдийг доош хийж, эмэгтэйчүүдийг сексийн бараа таваар болгодог.

Үнэгүйдсэн эмэгтэй эрчүүдийг эсэргүүцэх үед сексист хандлага нутагшина. Тэгэхээр, ийм болсон хүн хаачих билээ? Харамсалтай нь, үүний хариуд зарим эмэгтэйчүүд тэрслэн босоод, нөгөө туйл руу хадуурах нь ч бий.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ БУРХАНЧЛАХ

Би энэ номоо бичиж байхдаа, Амазон дээр миний өмнө бичсэн нэг номтой зэрэгцсэн хоёр өөр номын гарчгийг анзаарав. Аль, аль нь “эмэгтэйчүүдийг бурханчлах” үзэл суртлыг дэмждэг зохиолчдын бүтээл байлаа. Энэ нь эмэгтэй дарь эх, охин тэнгэрийг юмуу эмэгтэй хүнийг бурханчлах итгэл үнэмшил л дээ. Бурхан надад *Чиний номын баруун, зүүнд байгаа хоёр номыг аваад, эмэгтэйчүүд хэрхэн дуу хоолойгоо алдсаныг мэд хэмээн шивнэхийг нь дуулав.*

Би хуудсыг нь эргүүлэн, удиртгал, асуултыг нь уншихдаа элэг эмтрэм, уй зовлонгийн хашхирааг олж сонссон юм. Хоёр зохиолч маань хоёулаа маш хүчирхэг, нөлөө бүхий эмэгтэйчүүд боловч, чуулганаас гүн шарх, гомдол авсан хүмүүс байв. Тэдний бөхөж унтарсан гялалзсан чанарын хойноос дотор минь цурхиран уйлах шиг.

Яагаад тэд заавал Бурханы өргөөний гадаа эмэгтэй бурхдыг залах болов?

Тэд үзүүрлэсэн асуултаараа статус квог халз тулаанд дууджээ. Тэд чуулганы удирдагч нарыг айлган сүрдүүлтлээ оюун ухаанаа билүүджээ. Чуулган дотор “захирагдахуйн” нэрээр дуу хоолойг нь тэгтэл боож, авралынх нь эрх чөлөөг тэгтэл боомилсон гэж үү?

Тэд асуултаараа эрчүүдийг ч, эмэгтэйчүүдийг ч чичрүүлсэн гэдэг нь эргэлзээгүй.

Магадгүй чи тэдний дайтай гомдож, эрэлд гарч үзээгүй байж болох ч, миний хувьд үзсэн. Гэхдээ би ганцаараа үзээгүй. Би “Өндөр Бурханы охин би ямар учраас үнэ цэнэтэйг минь хэлээд өгөөч” гэсэн асуулт бүхий захидал, и-мэйл, зурвасаар бөмбөгдүүлдэг.

Би та бүхэнд Сью Монк Киддсын *The Dance of the Dissident Daughter* гэдэг номын нэгээхэн хэсгээс толилуулмаар байна. Тэрбээр Евангелийн чуулганы бүсгүйд тохиолдох л үйл явдлыг дэлгэн харуулжээ:

“Эмэгтэй хүн удаалж бүтээгдсэн атлаа түрүүлж нүгэл үйлдсэн” хэмээн тэр эр хэлэв. Тэгснээ Евагийн талаар, Ева эрэгтэй хүний

тусын тулд бүтээгдсэн, Ева Бурханыг дагалгүй, хориотой жимсийг Адамд барьсан болохоороо үнэ цэнэгүй хэмээн ярьж гарлаа. ... Зүрх лүг хийгээд л явчихав. Тэр мэдрэмжийг үгээр илэрхийлж болдог бол, би: “Бурхан минь, Та яах нь энэ вэ? Даанч дээ” л гэх байсан байх.”²

Зохиолч цааш нь Бурханыг чуулганы үзлээр нэвтрүүлж харах гэж яаж зүдэрсэн тухайгаа өгүүлжээ. Түүнтэй би ч санал нийлнэ. Бурхан эр байна уу, эм байна уу - хэнийг ч ийм болхи дүгнэхгүй.

Ева болоод түүний охид амархан мэхлэгддэг учраас, тэднийг удирдлагад гаргаж болохгүй гэж байгаа бол, бид ч Адамын болоод түүний хөвгүүдийн хамар дээр хаалгаа тас хийлгэх ёстой болно. Адам чинь *мэдсээр байж*, Бурханы даалгасан үгээс урвасан шүү дээ.

Адам, Ева хоёрын эндлийг дур хүсэлдээ хөтлөгдсөн гэмт хэрэг, санаатай аллага хоёрын ялгаатай зүйрлэж болох байх. Ева сонор сэрэмжээ буулгасан бол, Адам жингийн тэнцлийг маш сайн мэдэж байсан.

Хуульгүйгээр нүгэл үйлдсэн бүх хүн мөн хуульгүйгээр мөхөх болно. Хуулийн дор нүгэл үйлдсэн бүх хүн хуулиар шийтгэгдэх болно. (Ром 2:12)

Бид ямар гээчийн шашинлаг ертөнцийг бүтээсэн болоод, оюунлаг эмэгтэй судлаач нар чуулган дотроос үнэнийг олж чадахаа больчихов оо? Бид суурин дээрээ гарч зогсоод, хариултыг олохгүй бол, охид маань ийм асуулт асуух үед яах болж байна?

Бид энэ чигээрээ замнаад байвал, Бурхан эрчүүдийг маань өршөөг! Эмэгтэйчүүд таг чиг байгаа цагт эрчүүд эрүүл, хүчтэй өсөхгүй. Бурханы охидын асуулт эрчүүдийг сунгаж, илүү эрх чөлөөтэй болгодог учраас, бидний дуу хоолой тэдний хүчинд нэмэр л болох. Эмэгтэйчүүдийн үзэл бодол эмэгтэйчүүдийг дэлбээлүүлэх уур амьсгалыг бүтээж, эрчүүдийг давтаж, шинэтгэнэ.

Би эмэгтэйчүүдийг бурханчлах философитой зохиолч нарын эссег уншиж байхдаа нэг бус удаа цочирдож билээ. Тэдний зүрхэн дэхь хөндий хариулт нь миний зүрхийг эмтлэх.

Эмэгтэйчүүдийн нулимсан далай биднийг зааглах шиг. Алсын эрэг дээр зогсохыг нь хараад гуниг төрөв. Тэд өөрсдийгөө тэрслэгч, охин тэнгэр гэх боловч, би тэднийг Өндөр Бурханы найзууд, охид гэнэ. Миний хувьд - тэдний өгч байгаа хариултаас нь бус, хангинах гомдлоос нь хавьгүй их үнэнийг сонссон тул тэдний буруутгал чихэнд минь шуугина.

Нэг хуудсаар дүүрэн гунигтай түүх. Тухайлбал, тэнд Америк эхчүүд

охин төрүүлэхдээ, эр нөхрийнхөө өмнө гэмшихийг нь байнга хардгийг нэгэн эх баригч эмч гэрчилжээ. Дөрвөн хүүтэй эх хүн - миний хувьд энэ байж болошгүй явдал. Би эмэгтэй хүнийг хайрладаг нөхөртөйдээ азтай. Нөхөр маань хөвгүүддээ ухаангүй ч, охин үртэй болохыг мөн ч их хүлээсэн дээ. Иймэрхүү түүхийг нөхөртөө хэлэхээр, нөхөр маань итгэж яддаг. Бидэнд охин заяасан бол, бид түүнийг хүсэн хүлээсэн хонгор охин минь хэмээн өргөнө!

Шашны дөрвөн хананаас хариулт, үнэ цэнэ, эрх чөлөө олоогүй тэдгээр эмэгтэйчүүд “эцгийн эрхт дарангуйллаас” ангид гэж үзсэн газартаа тахилын ширээ босгожээ. Тэгээд тэр ой мод, далайн эрэг дээрээ охин тэнгэрийн хавьгүй энэрэнгүй, зөөлөн гэх “диваажингаа” байгуулсан байна.

Анхаар! Би тэдний замыг хэнд ч зөвлөхгүй. Би тэдний охин тэнгэрийг ч, шашны ууртай бурхныг ч сонгохгүй. Би Бүтээгч, Өндөр Бурханаа л сонгоно.

ТЭНГЭРЛЭГ ЗОРИЛГЫН ЭРЭЛД

Ийм нэгэн эмэгтэйчүүдийг бурханчлах хөдөлгөөний удирдагч Марианне Виллиамсон *A Woman's Worth* номдоо ингэж бичжээ:

Би “Яваад Мариатай ярилц” гэж хэлэхдээ, “Яваад - чуулганд очоод, лаа асаагаад, модон сандал дээр суугаад, Мариа дарь эхийн өмнө нухацтай яриа өрнүүл” гэж хэлж байгаа хэрэг. Тухайлбал, “Мариа, би гэргий юмуу найз охин, ээж, охин хүнийхээ хувьд хэн болохоо мэдмээр байна. Би эмэгтэй хүнийхээ хувьд тултал амьдармаар байна. Би таны зиндааны ариусал, гэгээрэлтэй болмоор байна. Бүсгүй хүний минь амин чанар гадаад үзэмжээс минь гэрэлтээсэй гэж хүсч байна.”³

Эмэгтэй хүнийхээ хувьд тултал амьдрахын төлөө залбирахад буруу юм байхгүй. Гол нь хэнд хандаж залбирах нь л чухал. Виллиамсон дараа нь Католик шашинд таагүй хүмүүсийг харж үзсэн маягийн үг хэлжээ:

Та Мариа дарь эхэд итгэдэггүй бол, ЗҮГЭЭР ээ. Грек охин тэнгэр юмуу Энэтхэгийн охин бурхдын аль нэгийг эсвэл өөр нэг охин тэнгэрийн билэгдлийг сонгоод, түүнтэйгээ холбоо харилцаа тогтоо.⁴

Холбоо харилцаа тогтоох ий? Яг энэ үгийнхээ араас мань зохиолч уур хилэнгийнхээ урхаг шалтгааныг дэлгэжээ:

Эмэгтэй хүний чанар дэлхийд үнэлэгдэх нь бага ажээ. Та нарыг хүйсийн дорой хэсэгт тооцож, бэлгийн эд таваар шиг л үзнэ. Хүүхэд төрүүлэхээс бусад тал дээр та нарыг дурын сонголт болгоно. Залуу халуун нас чинь үнэ цэнийг чинь өсгөж, насыг чинь дагаж үнэ цэнэ чинь тодорхойлогдоно. Өөрийгөө хэн болохыг эсвэл амьдралаа дэлхийгээс хайгаад олохгүй учраас, тэндээс бүү хай. Дэлхий чамайг ад үзнэ. Бурхан чамайг эрхлүүлнэ.⁵

Ядаж л ийм үгээр дуусгасанд нь талархъя. Гэхдээ зохиолч яахын аргагүй дотроо шаналж байна. Тэрбээр жинхэнэ охин тэнгэрийн холбоо харилцаагаар цангажээ. Тэрбээр ямар нэгэн мөнхийн гоо үзэсгэлэнт, хүчирхэг охин тэнгэрийн таалалд багтсанаараа, хүн - бидний харилцаанд ус агаар шиг дутагтаж байгаа тэр нэгэн зүйлийг олж авна хэмээн найдсандаа, Грек охин бурхдыг хүртэл шүтээд үз гэж хэлэхдээ хүртэл тулжээ. Хайгаад буй үнэнээ олоосой л гэж залбиръя.

Католик шашинтай явсан хүнийхээ хувьд би түүний санааг ойлгож байна аа. Би Мариа дарь эхийг шүт гэж огт хэлэхгүй ч, Протестантууд Мариаг бурхдын тооноос хасахдаа (тэр угаасаа бурхан шүтээн биш), эмэгтэйчүүдийн хувьд үлгэр жишээ байх эрхийг нь давхар хасчээ.

Мариа бурхан биш боловч, бурханлаг эмэгтэй байсан. Тэрбээр асаасан лаа хүлээж авдаг баримал биш, харин үлгэр жишээгээрээ зам гэрэлтүүлж өгдөг эмэгтэй байсан юм. Тэрбээр ирээдүйд Бурхантай гар нийлэн, Есүсийг илчлэх охидын хар зураг байжээ.

Есүс гэсэн үү гэж үү? Сонирхолтой санаа байна. *A Woman's Worth* гэдэг номыг эргүүлж тойруулаад, Мариагийн хүү - Есүс гэдэг нэрийг нэгээхэн ч олж харсангүй. Есүс үгүйгээр Мариа яаж үнэ цэнэтэй байх билээ? Тэгэхээр, жинхэнэ урилга нь юу байна?

Хамаг учир нь үнэндээ Мариа, Афина юмуу Афродитадаа биш. Хамаг учир нь үнэндээ бидний өөрсдийн маань бүтээсэн нэргүй сүнсэнд л орших!

Эмэгтэйчүүдийг бурханчилдаг зохиолч нар Бурхан, охин тэнгэр, шашин, эрчүүдийн талаар ярьсан атлаа үзэсгэлэнт Аврагч, Бурханы Хүү - Есүс Христийн талаар барагтай дурьдахгүй. Тэд хатад, идтэн шидтэн эмс, эх хүний талаар өгүүлэх атлаа үхлээс амилсан Хүүгийн талаар ярихгүй. Яахаараа эхчүүд хүүгийн илчлэлээс зайлсхийх гэж? Тэд Есүсийг тойроод л, тэр бүү хэл Түүний үгийг зээлдэн үгийн тойрон бүжиг хийгээд байх атлаа Түүний нэрийг дурьдахгүй.

Гэхдээ энэ ч бас сюрприз биш ажээ. Өөрсдийгөө бурхдын зиндаанд өргөмжилсөн улсад Аврагч ямар хэрэгтэй гэж?

Охин тэнгэрийн байр суурь нь зүгээр ч нэг нэгэн төрлийн хүч биш, харин мөргөл хүндэтгэлийг шаардана. Гэтэл бид эрэгтэй, эмэгтэй хүнийг юмуу бүтээлийг шүтэж болохгүй. Бид чинь зөвхөн Бурханыг л шүтэх ёстой. Чуулган үнэнийг буюу анхны санааг номлодог бол, эмэгтэй хүнийг үнэд хүргэх гэж охин бурхдыг бүтээх хэрэгцээ арилна.

Тэнгэр, газрын Бурхан - Өндөр Бурхан авралын төлөвлөгөөндөө эмэгтэй хүний үнэ цэнийг ил тод зарласан. Бурхан эр хүний үргүйгээр Хүүгээ төрүүлж авсан. Бурхан Мариаг гэдсэн дэхь ариун хүүхэдтэй нь хамгаалахыг Иосефт үүрэгдсэн. Бурханы Сүнс бүлтгэнэсэн, жоохон Еврей охины онгон умайд амийг мэндлүүлжээ. Тэр шившлэг хийж, өөрийгөө дарь эхээр зарлаагүй. Мариа Бурханы үгэнд орсон ч, өөрийгөө чадах эсэхэд эргэлзэж байв! Бид ч бас Мариагийн үгийг цуурайтуулж, өөрийн болгох болтугай. *Тэнгэрийн Аав минь, амлалтынхаа дагуу бидний дотор үйлдэх болтугай. Бид Таныг үйлдэнэ гэснээ үйлдэнэ гэдэгт итгэж байна. Даян дэлхийн дарлагдагсдыг өргөж, амьдралаар минь дамжуулж Хүүгээ илчлэх болтугай.*

Дотоод охин тэнгэрээ биелэл болгох гэж байна гэж өөрийгөө эрчүүдийн дээр өргөмжлөх нь бидний тэнгэрийн зорилгын хайгуул биш ээ. Эмэгтэйчүүд ноёлсон газар эрчүүд жинхэнэ хүч, эрх чөлөөг олохгүй. Эмэгтэйчүүд ч хүч тэнхээгээ илүүдэл доктринд даруулахдаа, үр нөлөөтэй байж чадахгүй. Аль, аль хүйс нь холбоотнууд, хамгаалагч нар болохоос биш, атаатнууд, бурхад биш.

Хүндэтгүүлж мөргүүлэх хүсэл нь хүн бүрт ирдэг шалгалт юм. Люсифер үүн дээр л унасан. Эрх хүчний төлөөх хүсэл нь бурханлаг бус зүйл биш бөгөөд эрчүүд, эмэгтэйчүүд бүгдээрээ их бага хэмжээний итгэл, эрх хүч, нөлөөллийн мэдэлтэй байдаг.

Хүн хэзээ ч төгс эрх хүчийг эзэгнэхээр бүтээгдээгүй. Энэ нь тэнгэрэлч нарт ч ахадсан үүрэг бөгөөд Бурханы Өөрийнх нь Хүү - Есүс Христ ч Бурхантай эгнэх хэмээн зүрхлээгүй. Филиппойчуудад илгээсэн Паулын захидал бидэнд харийн эрх хүчний байр суурийг дагахгүй байхыг үүрэгдсэн буй:

Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой бай. Хэдийгээр Тэрээр Бурханы дүр байсан ч, Бурхантай тэгш байхыг булаах гэсэнгүй, харин Өөрийгөө юу ч үгүй болгон Боолын дүрийг авч, хүнтэй адил болжээ. Хүн төрхийг олсон Тэрээр Өөрийгөө мөхөс болгож, Үхэлд, загалмайн үхэлд хүртэл дуулгавартай байв.

Тиймээс ч Бурхан үлэмжийн дээдээр Түүнийг өргөмжилсөн бөгөөд Алив нэрээс дээд нэрийг Түүнд соёрхов. Энэ нь Есүсийн нэрд Тэнгэр, газар дээр, газрын доорх бүгд өвдөг сөгдөж, Бурхан Эцэгийн алдрын төлөө Есүс Христ бол Эзэн гэж Хэл бүхэн хүлээн зөвшөөрөхийн учир ажээ. (2:5-11)

Манай дэлхийд үйлчлэгч нар хэрэгтэй байна. Бүгдийг өргөхийн тулд бөхийсэн миний Есүс бидний зарим шиг маань шаардагч байна гэхээр санаанд буушгүй. Харамсалтай нь бид Хаанаа буруугаар таниулдаг. Эс бөгөөс яахаараа энх тайвны төлөөх дэлхийн удирдагч нар “Христэд итгэдэг хүмүүсээс болоогүй бол, би Христэд итгэх байсан” хэмээн өөрсдийгөө зөвтгөх билээ. Ямар сайндаа л Махатма Ганди гуай: “Би Христэд дуртай. Гэхдээ танай Христэд итгэдэг хүмүүст дургүй. Танай Христэд итгэгч нар Христтэйгээ огт адилгүй”⁶ гэж хэлж байхав.

Чамайг үнэний зоригт эрэлчин болоод босоод ирээч гэх хашхираа, гачигдлыг сонсохгүй байна уу? Бидний нэг л их хувхай хоосон “ариуслын” гадна байгаа төөрөгсөд, шаналагсдыг зориудаар хайрлах үүрэг бидэнд бий.

Чуулган чамд боломж олгохгүй байвал, тэр хайрыг хурдны зам дээр бариад оч, замын хажуу дээр бариад зогс. Дөрвөн хананы маань гадна чамайг тэврээ дэлгээд угтах шархтай, эвдэрхий хүмүүс дүүрэн бий. Нийгэмдээ хүр, орон гэргүй хүмүүст хүрч, мэргэжил нэгтнүүддээ хүр, сургуулийнхаа системд хүр. ... Цэлийсэн, том амьдрал бүтээ.

Хүмүүсийн нүдийг олзлом өндөр хөшөө босго.

Тэгэхээр, одоо хэрхэх билээ? Бурханы шийдвэрлэхсэн зүйлийг асуудал болгож өлгөсөөр байх уу? Нэг бол тас захирагдахуй, нөгөө бол эмэгтэйчүүдийг бурханчлан тахиx хоёр туйлаас сэргийлэхийн тулд сэтгэлгээгээ тэнцэтгэж болохгүй юу? Эрчүүдээ хүндэтгэж болохгүй юу? Зарц боол шиг ч биш, хилэнтэй охин тэнгэр шиг ч биш, харин арслан, эрслэн хоёрын үлгэр жишээг даган, эрчүүдтэйгээ хамтран босъё л доо.

Хүчтэй эмэгтэйн үнэ цэнэ

Жиргээ, Фэйсбүүк дээр нийтлэх юмуу эмэгтэйчүүдийн өмнө зогсох эсвэл биеэрээ юмуу зурагтаар ярихдаа би боломж л олдбол, эмэгтэй хүний үнэ цэнийг тасралтгүй тунхагладаг. Эмэгтэйчүүд дуу хоолойгоороо чуулган дотор ч, чуулганы гадна ч, орон нутагтаа ч, дэлхийн хэмжээнд ч хувь нэмрээ оруулахыг зориуд сануулдаг. Тэд энэ эрх үүргээ баяртайгаар хүлээн аваад зогсохгүй, амьдрал болгоосой хэмээн залбирна.

Намайг номлосны дараа “Та наадахаа эрчүүдэд хэлээд өгөөч?” гэсэн

хүсэлт байнга гарч ирдэг. Ил чангаар номлосон үгийн маань хариуд ийм эрэмгий хүсэлт тавьж байгааг нь хүн сонсоод мэдчих бий гэсэн шиг энэ хүсэлтээ шивэгнэж хэлэхийг нь яана.

Эмэгтэйчүүдийг л урамшуулбал боллоо гэж бодох үе надад байлаа. Пөн хийсэн халуун дулаан, аюулгүй уур амьсгал дунд эмэгтэйчүүдэд хандаж заах нь чухал аа. Гэвч Бурханы охидын аялал үргэлжлэх явцад, дан эмэгтэйчүүдийг л ийм маягаар урамшуулаад байх нь хангалтгүй болохыг би сурсан. Яг л зоосны нэг талыг нь үнэлэхтэй адил.

Сүүлийн хэдэн жил миний ертөнц өргөжиж, дуу хоолойг маань Бүтэн сайны цуглаанд урьдаг болов. Тэдэн дунд мэдээж эрчүүд бий. Эрэгтэй, эмэгтэй нийлсэн хүмүүст дуу хоолойгоо хүргэх үедээ би эмэгтэйчүүд хичнээн гайхамшигтай болохыг тэдэнд мэдүүлдэг.

Үүнийг маань ч эрчүүд эсэргүүцэж байхыг би хараагүй. Эрчүүд ч ялгаагүй гайхамшигтай болохыг би тэдэнд зориуд хэлнэ! Эрчүүд уйлахыг би зөндөө харсан. Эхнэр, нөхрүүд барилдаанаа зогсоогоод тэврэлдэхийг нь харсан. Эрх хүчний төлөөх хөөрхийлэлтэй тэмцлийнхээ төлөө бие биеэсээ уучлал гуйхыг харах хичнээн сайхан гээч.

Хайрт эрслэн - бүсгүйчүүд минь, эрчүүд бидний асуудал биш ээ. Энэ бол хавьгүй гүн асуудал. Сатан л бидний аль, аль хүйсийн нэр төрийг гутааж явдаг, мэхлэгч, дайсан мөн. Эрчүүд хэдийгээр асуудал биш боловч, хариултын нэгээхэн хэсэг байх ёстой. Эрчүүд маань эмэгтэйчүүдтэйгээ эгнээд, нэр төр, эрх хүчийг сэргээх ачааг үүрэлцэх үед маш эрч хүчтэй нэгэн зүйл өрнөдөг.

Заримдаа дуу хоолойгоо өргөх байр сууриа эзлэхэд л тэмцлийнхээ тэн хагаст хүрчихнэ. Эргэн тойрон дахь эрчүүд чинь чамайг сонсох чадвартай бас эрчүүд, эмэгтэйчүүдийг хамтдаа босох урамшууллын үгийг чинь хүлээж авах чадвартай байх хэрэгтэй. Өөрчлөлт хийх шаардлага байгаа бол, хэн, хэн маань адилхан хөдлөх ёстой. Бурханы байр суурийг цуурайтуулах ёстой.

Үүний тулд 1Коринт 11-ийг нарийн харцгаая. Энэ хэсгийг тус тусад нь задлаад, ерөнхий утгыг нь гаргая.

Тиймээс тэнгэрэлч нарын улмаас эм хүн толгой дээрээ эрх мэдлийн тэмдэг байлгах ёстой. (Дашрамд хэлэхэд, эрчүүд, эмэгтэйчүүдийн ялгааг ухаж хэтэрхий бүү умш) (и10)

Паул бүх дагалдагчийг хүйсийн ялгааны талаар хэтэрхий их ухаж унших юмуу том асуудал бүү болго гэжээ. Ялгаа байх ч, эдгээр нь хэзээ ч биднийг салган бутаргахын төлөө бус, эвлэн нэгдүүлэхийн төлөө л байна.

Гэвч Эзэн дотор эр хүнгүйгээр эм хүн гэж үгүй бөгөөд эм хүнгүйгээр эр хүн гэж үгүй юм. (Эрэгтэй хүн, эмэгтэй хүний хэн нь ч ганцаар явж, тэргүүлж болохгүй) (и11)

Паул энэ мэдэгдлээрээ хүйсийн харилцан хамаарлыг илтгэж байна. Харилцан хамаарал оршиж байгаа бол, эрэгтэйд ч, эмэгтэйд ч тэргүүнчлэл өгөгдөөгүй ажээ.

Эрэгтэй хүн Бурханы гоо үзэсгэлэнг цацруулсан тусгал болон түрүүлж бүтээгдсэн нь үнэн бүлгээ. Гэвчиг эмэгтэй хүний биеийн титэм болсон толгой нь гоо үзэсгэлэнгээрээ “тэргүүн” болсон нөхрийнхөө толгойноос давдаг нь яриангүй. (и11)

Эрэгтэй хүн Бурханы тусгал болон түрүүлж бүтээгдсэн - энэ үнэн. Гэтэл араас нь “гэвчиг” гэдэг үг орж ирж байна. Эмэгтэй хүн гоо үзэсгэлэнгээрээ нөхрөө давдаг гэжээ. Энэ нь тусгайлан нөхөр, эхнэрийн харилцаанд хандсан яриа болохыг тэмдэглээрэй.

Учир нь эм хүн эр хүнээс буй болсончлон эр хүн эм хүнээр буй болсон. (и12)

Анхны эмэгтэй Ева нь Адам гэдэг эрэгтэйгээс бий болсон нь мөн л үнэн. Гэхдээ Паул дахиад л “гэвч” гэдэг утгаар жингийн нөгөө талыг тэнцэтгээд (түүнээс хойш) эрэгтэй хүн эмэгтэй хүнээр буй болдог болсон гэжээ.

Харин бүгд Бурханаас болой. (Амьдрал дээр бүх юм Бурханаас гардаг учраас, “хэн нь тэргүүлэхээ” үздэг уламжлалт уралдаанаа зогсооцгооё. (и12)

Ийнхүү жин маань төгс тэнцвэржсэн болохоор, Паул хүйсийн мэтгэлцээний дүүжин даажингаас давуулан, тэнгэрийн үзэл бодлыг зааж өгчээ: бүх юм Бурханаас гардаг учраас, хэн нь илүүрхэх маргаанаа зогсоо! Энэ хариулт маш олон зөрчлийг шийдвэрлэх учиртай. Бурхан ганцаараа л Нэгдүгээрх нь! Зөвхөн Тэр л ариун, зөвт, хайр, үнэн, зам маань, амь маань, эхлэл бөгөөд эцэс маань болой.

Бурхан урсгал чиглэлийн хуульд ганхана гэж байхгүй. Бурханыг бидний “болно, болохгүй” гэдэг хууль журам хөндөхгүй. Бурханыг ажилдаа орох үед хүмүүс үйл хөдлөлийг нь ойлгож хүлээж аваад, дор нь хөл нийлүүлэх үед Бурхан ерөөлөө тушаадаг юм.

Харагтун, ах дүүс хамтдаа нэгдмэлээр амьдрах нь Хичнээн сайхан, хичнээн тааламжтай вэ! ...Сионы уулс дээр буудаг Хермоны шүүдэр адил юм. Учир нь тэнд ЭЗЭН ерөөлийг, Мөнх амийг тушаасан билээ. (Дуулал 133:1, 3)

Түүхнээ чуулган иймэрхүү асуудал дээр хуваагдаж байсан ч, ядаж би хойч үедээ ийм өв үлдээмээргүй байна. Гэхдээ миний бодол, мэдрэмж Бурханы хэрхэн үйлдэх хэмжээний дэргэд хумсын чинээ л юм. Юмс өөрчлөгдөх болно оо.

“Бурхан айлдахдаа
«Эцсийн өдрүүдэд Би Сүнсээ
Бүх махбод дээр цутгана.
Хөвгүүд, охид чинь эш үзүүлж,
Залуус чинь үзэгдэл үзэн,
Хөгшчүүл чинь зүүд зүүдлэх болно.
Эр, эм гэлгүй боолуудынхаа дээр
Тэр өдрүүдэд Би Сүнсээ цутгана.
Тэд эш үзүүлэх болно.
Би дээр тэнгэрт совин ёр
Доор газарт тэмдгүүдийг өгнө.
Энэ нь цус, гал,
суунаглах утаа билээ.
(Үйлс 2:17-19)

Эцсийн өдрүүдэд Бурхан Үгээ буулгана. Цус, гал, савсах утаа униарын дүрслэл нь эртний Еврейчүүдийн тахилын ёслолыг санагдуулах.

Тэнд л хүмүүс Өндөр Бурханд тааламжтай тахилыг өргөхөөр хуран цугладаг байв. Тахил өргөгдөж, галаар тэнгэрлэг талбар өөд орчино.

Шинэ гэрээний алсын хараанд хуц, үхэр, бухыг тахилын ширээ дээр өргөх тухай ярьдаггүй. Харин Өндөр Бурханы эш үзүүлэгч - зарц нар болсон өгөл, шингэн хөвгүүд, охидын дуу хоолой өргөгдөж байх нь л харагдана. Гал маань мөргөлийн тахилын ширээн дээр шатахгүй. Бид Сүнсээр асаагдаж, хөдөлдөг учраас, тэр гал дотор минь бий.

Өнгөрсөн он жилүүдэд би хүйсийн талаар шууд ярихаас айдаг байлаа. Харин одоо шаардлагатай бол, дугтуйгаа задална даа. Нөхөр маань миний хүчээс айдаггүй, харин ч дэмждэг. Хөвгүүд маань ч мөхлүүт, гөлөлзсөн, дарлагдсан эмэгтэйчүүдийн дүр зурагт дургүй. Гэхдээ бусад маань дэмжлэггүй байхад, би дэмжлэг авах нь зөв үү? Энэ дэлхийд газар газрын

дарлагдагсдын төлөө дуугардаг эмэгтэйчүүд хэрэгтэй. Энэ нь энэ дэлхий дээрх бүх бүтээл бие биетэйгээ зэрэгцэн оршихын тулд бүтээгдсэн гэдгийг дуртайяа хүлээн зөвшөөрнө гэсэн үг.

Хүйсийн асуудлаа таягдаж, үр нөлөөг маань мулзлагч туйлшралаас зугтъя. Биднийг Өөрийнхөө дотор хүчтэй, эрчүүдэд хувь нэмэртэй, даян дэлхийн төөрөгсөд, шархтайд авралын дуу хоолой байлгах гэсэн Бурханы жинхэнэ зорилгыг ухаажъя.

МЭНДЧИЛЭЭД ХАЛАМЖЛАХ

Дур булаам уруулыг хүсбэл, эелдэг үг хэл.

Хайраар дүүрэн харцыг хүсбэл,

хүний сайныг нь олж хар.

Гоолиг биеийг хүсбэл,

ядарсан нэгэнтэй хоолоо хуваалц.

Намирсан үсийг хүсбэл,


өдөр бүр нялх хүүхдийн можгор гараар

толгойгоо илбүүлж бай.

Тэгш тайван байдлыг хүсбэл,

ганцаараа биш гэдгээ мэдэж яв.

Сэм Лэвэнсон



Эрслэнгүүд бие биеэ үнэрлэж, үнгэх нь мэндчилгээнийх нь нэгээхэн хэсэг ажээ. Энэ нь эрслэнг зулзага байхаас эхэлнэ. Гүег мэндэлсэн цагаасаа л эрслэнгийн байнгын үнсэлт, үнгэлтэнд орно. Нэг иймэрхүү дүр зураг буух: гүег том арслангуудын ан хийхийг соогтолзон ажиглаж дуусаад, сүрэгтэйгээ нийлнэ. Тэгснээ гэнэт “Ээ, Бурхан минь! Нөгөөх чинь ирж явна! Эгч маань намайг дахиад л долоож, нүүр амыг маань шүлсдэх нь!” гэж бодов. Яг л гэрт нь зочилж ирсэн баахан Итали аниа нартай өрөөнд ороод явчих жаахан охин, хөвгүүн шиг л.

Нүүр тулсан ийм дотно мэндчилгээнд дан зулзаганууд өртөхгүй. Эрслэнгүүд ч бие биесийнхээ нүүрийг долоолно. Ийм мэндчилгээний ёслол нь бие биеэ танихын шинж ажээ. Бидний нүдэнд бүх эрслэн ялгахын аргагүй харагддагтай л адил, тэд ч бие биедээ адилхан харагддаг ажээ. Тухайн эрслэн гадны халдагч бус, сүргийнх нь гишүүн болохыг тэд үнэрээр нь л таних аж. Ер нь үзэмж хуурамч боловч, үнэр үнэнийг илчилдгийг бид мэднэ.

Эрслэн нэг бүр нүднийхээ дээр, хөмсөгтөө тухайн сүргийн үнэрийг хадгалдаг булчирхайтай байдаг байна. Эрслэнгүүд цуглахдаа, хоорондоо хацраа үрэлцэж, толгойгоороо зөөлөн нудралцан, дотно холбоо тогтоодог. Энэ мэндчилгээ нь зүгээр нэг танилцуулах явдал биш ажээ. Хоорондоо танилцана гэдэг нь “Энэ бол би. Харин чи хэн бэ?” гэсэн анхны уулзалт, учраа юм. Гэтэл эрслэнгийн мэндчилгээ нь нэг нэгнээ гэх хайр, холбоо эвслээ батлах тамга, сүргийнхээ доторх дайсныг илчлэх хүчтэй ажээ.

Эрслэнгүүд үнэрлээд, таньдаг. Хүмүүс эхлээд таниад, дараа нь үнэрлэдэг. Жишээлбэл: Манай нөхөр саяхан намайг онгоцны буудал дээрээс угтаж авсан юм. Би машиныг нь таниад, далласан боловч, нөхрийгөө машинаас үсэрч гарч ирээд, хүрч ирэх хүртэл нь түүний үнэрийг мэдрээгүй.

Тэгээд үнэртэй усыг нь танихдаа “Гоё үнэртэж байна” гэж хэлж билээ.

Үйл явдлыг тонгоруулбал, би түүнийг таньж чадахгүй л болов уу: Нэг хүн машинаасаа үсэрч гарч ирээд, над дээр хүрч ирнэ. Би түүнийг ойроос үнэрлээд, үнэрээр нь нөхрийгөө танина гэвэл, жаахан төвөгтэй.

Эрслэнгүүдийн үнэрээр таних төвлөрөл нь хэд хэдэн зорилготой ажээ. Мэндчилээд, үнэрлэснээрээ тэд гадны амьтдыг танина. Үүгээр барахгүй, эрслэнгүүд өөр хоорондоо мэндчилж, бие биеэ үнэрлэхдээ, нэг нэгнээ хүлээн авч, харьяалал хамаарлаа бататгаж буй явдал юмсанж. Бурханы охид бид амьдралдаа байгаа хүмүүсийг ч бас ингэх ёстой ажээ.

ҮР ХҮҮХЭДТЭЙГЭЭ МЭНДЧИЛЖ, ХАЙРЛАН ЭРХЛҮҮЛЭХ

Эрслэн гүегээ угтахдаа “Чи бол биднийх. Чи бидэнд эрхэлж, хүч чадлаа нээж, өсч бойжих эрхтэй. Чи сүрэг дундаа гэдэс цаггалан, аюулгүй байх болно” гэж хэлдэг. Түүнчлэн эрслэн гүег нь хаана байсныг шиншлэх гэж үнэрлэдэг аж. Гүегтээ нүүрээ нааснаараа, зулзага нь хаана, юу хийж явсныг мэдээд “Яахаараа, чамаас хиена чонын мөр үнэртдэг билээ?” гэсэн асуулт тавина.

Өсвөр насны хөвгүүд маань гадуур гарах үед нь би ээжийгээ унтахаас өмнө ирж үнсүүлж байх шаардлага тавьдаг байлаа. Энэ маань давхар, давхар зорилготой. Нэгдүгээрт - хайртай учраас, үнэрлэнэ. Хоёрдугаарт -

ээжийгээ унтахаас өмнө үнэрлүүлэхийн тулд хэт оройтохгүй. Гуравдугаарт - тэднээс юу үнэртэж байгааг нь мэднэ.

Тэгээд нэг иймэрхүү явдал өрнөнө. Хүү маань гэртээ ирээд, унтлагын өрөөний маань хаалгыг онгойлгоод: “Маам, би гэртээ ирсэн шүү, сайхан амраарай!” гэж хэлнэ.

Намайг хэвтчихсэнийг мэдбэл, бушуухан хаалга хаах гэнэ. Тэр үед нь би: “Миний хүү ирчихсэн үү? Нааш ир, ээж нь үнсье.” гэнэ.

Хүү маань дургүй байвал, сэжиг төрнө.

Хэрэв учиргүй гааны үнэр сэнгэнээд явчихбал, хүү маань таагүй зүйл хийжээ гэдгийг нь би мэднэ. Хүүгээ ойртож ирэхэд нь би хүүгийнхээ нуух гэж оролдож байж мэдэх, хоёрдагч сэжиг бүхий үнэрийг хайгаад л давхичихна. Ээж хүн үр хүүхдийнхээ үнэрийг мэдэлгүй дээ.

Хэрэв манайх өдөр бүр ийм маягаар мэндчилж хэвшээгүй байсан бол, шөнө дөлөөр хөвгүүдээ үнэрлэж шалгах нь хачин санагдаж болох. Манайх чинь өглөө бүр тэврэлдэж, үнсэлддэг улс. Дээрээс нь өдөржин байн байн тэврэлдэнэ. Орой бас сайхан амраарай гээд үнэрлэнэ. За, тэгээд хөвгүүд маань гал зуухаа цэвэрлэхдээ хоорондоо барилдах, ноцолдох юмуу ирэх, явахдаа тэврэлдэх гээд л байнга л биеийн богино холбоо үүсгэнэ. Аль хар нялхаас нь зааж өгсөн энэ мэндчилгээ маань өнөө хэр үргэлжилсээр. Танайх ч бас тэгдэг л байх - бие биеэ сайхан амраарай гээд үнсдэг, сайхан амрав уу гээд тэврэлддэг, мөрийг нь илдэг, толгойг нь илбэдэг, буйдан дээрээ ноололддог.

Том хүү маань өрх тусгаарласан хойноо миний мэдэхгүй олон түүхийг дэлгэсэн юм. Би ч хэзээд нь тийм юм болчихов оо? Би хаагуур нь өнгөрөөчихөв өө? гэхээс өөр үггүй болно.

Хүү маань мушилзаж ирээд л: “Таныг байхгүй хойгуур”, “Найзындаа хонох үедээ” гэж хариулна.

Би гэртээ байсан бол, ганц үнэрлээд л хэрэг явдлыг мэдэх байв! Мэндчилгээ нь үр хүүхэд нь болох, болохгүй юмстай орооцолдсон эсэхийг “мөрдөх” боломжийг ээжүүдэд олгодог. Тэгээд хайр, дасгалжуулалт, сахилга батаар хариу үйлдэхэд маань тусална. Танайхан гэртээ бие биестэйгээ тогтмол тэврэлдэж мэндчилдэггүй бол, одооноос эхлүүлэхийг дэмжиж байна. Хүүхдүүд чинь эхлээд дургүйцэх л байх. Гэхдээ битгий зогсоо. Тэврэлтээрээ чи хүүхэддээ хайртайгаа хэлээд зогсохгүй, түүнд наалдсан гадны үнэрийг тодорхойлж чаддаг болно. Ээжийгээ тэврэх дуртай байсан хүүхэд чинь зайгаа бариад эхэлбэл, шалтгааныг нь олж мэд.

Дураар нь бүү холдуул.

Хүүхэд чинь нас биед хүрч, өсч төлөвшсөн хойно нь ч уулзахдаа тэвэрч, үнэрлэхээ бүү зогсоо. Биеийн холбоо нь түүнд хэзээд энэ гэрийн бүлийн

гишүүн гэдгийг нь мэдүүлнэ. Энэ мэдлэг нь хүүхдийг том хүний амьдралд шилжиж, өөрийн гэсэн гэр бүлээ байгуулахад нь аюулгүй байдлын баталгаа болно.

ӨӨР ХООРОНДОО МЭНДЧИЛЭХ

Эрслэнгүүд өөр хоорондоо мэндчилэхдээ “Бид хамаатнууд. Чамаас эгч дүүсийн маань үнэр үнэртэж байна. Би чиний төлөө байна. Чи ч миний төлөө байгааг би мэднэ” гэдэг.

Бид ч эрслэн - эгч дүүсээсээ өөрцгүй. Хүний халуун дотно мэндчилгээ нь “Бидэнтэй хамт суугаач. Би чамд итгэж байна. Тавтай морил” гэсэн урилга юм. Зайгаа барьсан, албан мэндчилгээ нь “Бид зохих хэм хэмжээндээ л харилцана. Чамайг таньж мэдэх хүртлээ би зайгаа барина” гэсэн үг юм. Ийм маягийн харилцаанд мэндчлэн ёсолж байгаа хүн ч, мэндчилэн ёслуулж байгаа хүн ч биеэ барьдаг. Аа, хэрэв огт мэндчилж дуугарахгүй бол, зочин маань айна.

Өөр хоорондоо мэндчилэх талаар Паул Коринтынхонд юу гэж зааварласныг үзнэ үү:

Ариун үнсэлтээр харилцан мэндчилээрэй.

Ариун хүмүүс бүгд та нартай мэндчилж байна.

Эзэн Есүс Христийн нигүүлсэл, Бурханы хайр, Ариун Сүнсний нөхөрлөл та бүгдтэй хамт байх болтугай. (2Коринт 13:12-14)

Эгч дүүстэйгээ чухам ингэж л мэндчил. Удирдагчтайгаа уулзаж байгаа бол, түүнийг үнэлж хүндэтгэж байгаагаа илтгэсэн байдлаар тэвэрч мэндчил. Шархалсан хүнтэй мэндчилэхдээ, хайр халамжаа шингэтэл нь тэвэр. Заримдаа үг шаардлагагүй байдаг. Заримдаа чимээгүй тэврэлт нь чанга мэндчилгээнээс илүү илааршуулах увидастай байдгийг амьдрал надад зааж өгсөн.

Паул хайр халамжин дорх чуулганууддаа бичсэн захидлаа дуусан дуустал нь маш уран яруу мэндчилгээгээр сүлжсэн байдаг. Мэндчилгээгээ бичиж илгээх нь Паулын хувьд чухал байсан бол, бидний хувьд ч мэндчилж сурах нь яриангүй чухал.

Паул Коринтын чуулгантай хэрхэн мэндчилэхийг үзнэ үү:

Би та нарыг ичээхийн тулд бус, харин *өөрийн хайрт хүүхдүүдийн хувьд та нарт сануулахын тулд* үүнийг бичлээ. Учир нь та нар Христ дор тоо томшгүй сургагчидтай байлаа ч *эцэг болох нь*

олонгүй. Учир нь би Христ Есүс дор сайнмэдээгээр та нарыг төрүүлсэн. (1Коринт 4:14-15)

Паул Коринтчуудад захидал нь юун тухай болох, юун тухай биш болох талаар өгүүлжээ. Паул тэдэнд тулгалт хийж, ичээлгүй, харин тэдний хувьд түүний харилцаа юу болох, түүний хувьд тэд хэн болохыг тодорхойлон хэлжээ. Паул - тэдний аав, тэд түүний хүүхдүүд аж. Дараа нь хэдийгээр итгэгчдийг муу явахыг нь харах хүсэлтэн Коринтод олон байж болох ч, аав хүнийхээ хувьд Паул тэднийг амжилтанд хүргэхийн төлөө л явна гэжээ. Паул өөрийгөө захидлыг хүлээн авагч нарын хувьд хэн болох, тэд түүний хувьд хэн болох, юу хэлж байгаагаа, яагаад хэлж байгаагаа, ямар учраас тэд түүнийг сонсох ёстойг мэндчилгээгээрээ ухуулан ойлгуулжээ. Паул өөр юмсын талаар ярихаасаа өмнө энэ бүгдийг заасан байна.

Нэг нэгнээ тордох

Эрслэнгүүдийн мэндчилгээний үйл явц нь нааштай болбол, шууд нэг нэгнээ тордох үйл ажиллагаандаа орно. Энэ тордолт нь эрслэнгүүдийн болоод арай том гүегүүдийн хооронд хавьгүй бат бөх холбоо үүсгэж, энэ нь эргээд сүргийг илүү нягт холбоотой оршин тогтноодог ажээ.

Эрслэнгүүд нь гол төлөв бие биеийнхээ толгой, хүзүүг буюу өөрөө өөрийнхөө хүрч чадахгүй хэсгийг нь тордоно. Эрслэнгүүд зузаан, хөрслөг хэлээрээ бие биеийнхээ үс ноосыг долоолохдоо, цусан толбо, шороог нь цэвэрлэж өгөхөөс авахуулаад хачиг, шимэгчээс нь салгаж өгдөг ажээ. Шимэгч биеэс чинь цус, шим тэжээлийг сорж байгаа л бол, амиас чинь хулгайлж байна л гэсэн үг. Биеэс цус, бохирдлыг цэвэрлэж өгөх төдийгүй, хачиг, шимэгчийг ч түүгээд өгөх эгч дүүстэй байгаадаа Бурхандаа талархъя!

Тордох нь үнэндээ цэвэрлэх, цэвэршүүлэх, бэлтгэх, шүүрдэх, шүүрдэж авах, эмхэлж цэгцлэх, эмхэлж цэгцэлж авах, засах, засч авах, самнах, толийлгох, дасгалжуулах, заах гэсэн утгатай болно. Тодорхойлолтоос нь үзбэл, би шүдээ тордох, гал тогоогоо тордох, хүүхдүүдээ тооны хичээл дээр нь тордох хэрэгтэй бөгөөд шаардлагатай ажээ.

Тордох үйл явцыг нарийсгаж үзбэл, “цэвэрлэх” буюу “цэвэрлэж авах” хэмээн тодорхойлж болно. Есүс Петргэй яг иймэрхүү тордох яриа өрнүүлсэн байдаг. Есүс Петрийн хөлийг угаахыг хүссэн ч, Петр татгалзсан. Тиймээс Есүс Петрт Түүгээр хөлөө угаалгахгүй бол, хийж буй үйл хэргийнх нь хэсэг болж чадахгүйг нь хэлсэн. Тэгтэл Петр хүсэлтийг нь туйлшрааж, нэг мөсөн толгойноосоо ул хүртлээ угаалгах хүсэлт тавьжээ.

Гэтэл гайхамшигт Есүс маань гол зарчим дээрээ л тогтов:

Усанд орсон нэгэн хөлнөөсөө бусдыг угаах хэрэггүй. Тэгээд ч бүхэлдээ цэвэр байна. Та нар цэвэр байна. Гэхдээ бүгдээрээ биш шүү гэлээ. (Иохан 13:10)

Бид Есүст харьяалагддаг учраас, цэвэрхэн. Гэвчиг өдрийн туршид хөл маань бохирдох юмуу заримдаа очсон газар, хийсэн юмс, өмссөн гутлаас маань шалтгаалаад хөл маань шивэртэх боломжтой. Амьдрал хэмээх аяллын замд бид - за, ямар ч байсан миний л хувьд бохир заваан юман дээр бишгүй л гишгэдэг. Өдөр жаргахад, бид өдрийн турш бохирдсон хөлөө угааж цэвэрлэх хэрэгтэй.

Тиймээс л Есүс цааш нь ингэж хэлжээ:

Тэгвэл Би, Эзэн бөгөөд Багш атлаа та нарын хөлийг угаасан юм чинь та нар ч мөн нэг нэгнийхээ хөлийг угаах учиртай. Миний та нарт үйлдсэн лугаа адил та нарыг үйлд хэмээн Би ийм дуурайл өгөв. Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Боол нь эзнээсээ илүү агуу биш, мөн элч нь илгээгчээсээ агуу биш юм. Үүнийг мэдэж, үйлдвээс та нар ерөөлтэй. (Иохан 13:14-17)

Есүс дагалдагч нарынхаа хөлийг угаагаад, бидэнд ч өөр хоорондоо ийнхүү үйлдэхийг үүрэгдсэн. Энэ нь мэдээж нөхөр маань орой бүр бяцхан педикюр хийж өгөх ёстой гэсэн үгчилсэн заавар биш л дээ (Гэхдээ хань минь, би ч дуртайяа хийлгэмээр л байна шүү). Магадгүй хөл угаах нь биднийг бие биеэ замын хир буртгаас сэргээж, шинэчилж байхыг билэгдсэн юм болов уу.

Би ганц хоёр удаа - ялангуяа чуулганд ажилладаг эмэгтэйчүүдэд шилэн трико өмсөхийг шаарддаг байсан, дээр үед хөл угаах эвгүй үйл ажиллагаанд оролцож билээ. Гэтэл Есүсийн үед хөл угаах нь өнөөдөр бидний гар барих юмуу тэвэрч угтдагтай л адил гэртээ айлчилсан зочноо угтах соёлынх нь нэгээхэн хэсэг байжээ.

Би хөл угаах ёслолыг сэргээх санал дэвшүүлээгүй шүү. Тэд чинь онгорхой углааш, шороон замтай үед амьдарч байсан бол, бид чинь битүү гутал, засмал замтай эрин үед амьдарч байна. Би ердөө л найз нөхдийнхөө юмуу Бурханы хүндэтгэлийн өргөөнд орохдоо, эхлээд өдрийнхөө шороог гөвөх цаг гаргаад, дараа нь хайртай дотны хүмүүстэйгээ харилцах тухай л хэлж байна.

Эрслэнтэй адил бид ч бие биеийнхээ амьдралыг шороо, хачиг, шимэгчээс нь цэвэрлэхтэй адил үйлдэл хийх хэрэгтэй.

Нүдэндээ өөрийгөө цэвэр гэх
Буртгаасаа угаагдаагүй хүмүүс ч бас байх.
Ихэмсэг нүдтэй, дээгүүр харцтай хүмүүс ч бий.
Газар дээрх ядуусыг,
Хүмүүсийн дундах үгээгүйчүүдийг залгих
Илд мэт шүдтэй, хутга шиг араатай хүмүүс ч бас бий.
Шуналын туламд “Өг, Өг” гэгцгээдэг
Хоёр охин,
Ханаж цаддаггүй гурав дахь
“Хангалттай” гэж хэлдэггүй дөрөв дэх нь бас буй.
(Сургаалт үгс 30:12-15)

Шимэгч *“надад өг, дахиад өг”* гэсээр амийг маань хулгайлж, шим шүүсийг маань сорж байдаг. Шунал, дур тачаал нь цус сорогчтой л адил. Бие биеэ торддог хүмүүсийн дунд байвал, бид нэг нэгэндээ амьдралаа цэвэр авч явахад нь тусална.

Саяхан би нэгэн залуугийн амьдралд үгээ хэлэх ёстой үгүйгээ шийдэх ёстой болсон юм. Тэрбээр ирээдүйтэй удирдагч байсан бөгөөд, би ч түүнийг хүндэтгэнэ. Би түүний амьдралд зориулсан Бурханы дуудлагад жаахан харам байсандаа, үгээрээ засмаар гэх үү дээ санагдаад байлаа. Гэхдээ үүний тулд эхлээд хоорондын харилцаагаа тодорхойлох, тэр миний үгийг дуулах эсэхийг нь мэдэх хэрэгтэй байв. Тиймээс түүнээс: “Чуулган дотор би чиний хувьд хэн бэ?” гэж асуулаа.

Залуу ч шууд л: “Би таныг удирдагчаа гэж хардаг” л гэж байна.

Энэ хариултаас нь би түүнд үг хэлж, тэр ч миний хэлэх үгийг дуулах юм байна гэдгийг мэдэв. Хэрэв залуу өөрөөр хариулсан бол, би зөвлөгөөгөө хойш тавих байлаа.

Ийм маягийн хөлийн угаал нь хэн, хэндээ ашиг тустай. Бид хүмүүст үг хэлээд зогсохгүй мөн бусдыг ч амьдралд маань хувь нэмрээ оруулахыг урьдаг. Надад том эгч шиг минь л хүндтэй нэгэн найз байдаг юм. Тэрбээр Бурханы охидыг нэгтгэн цуглуулж чаддаг, ер бусын пастор хүн. Бид хоёр сайн, муугаа мэддэг болтлоо л урт удаан үерхсэн хоёр.

Саяхан түүнийг зориуд урьж авчирч байгаад, амьдралаа цэвэрлүүлэх шаардлагатай болсон мэт санагдлаа. Би кофе оочингоо найздаа: “Миний амьдралд үгээ хэл. Намайг тэнэг, утгагүй юм хэлэх юмуу хийж байгааг минь сонсох юмуу харж байгаа бол, хэл. Надад миний сүнсний амьдрал болж бүтчихсэн юмуу зөв зүйтэй санагдахгүй байна. Гэхдээ би зүй ёсны хүнээр л амьдралдаа чиглүүлэг, цэц ухаан хэлүүлмээр байна” гэлээ.

Найз минь ч амьдралын маань бүрхэг талыг цэвэрлэх урилгыг маань дуртайяа хүлээж авлаа. Гэхдээ үүний тулд би түүнтэй харилцаа тогтоох

ёстой. Түүнтэй байнгын харилцаатай байж, ном, подкастыг нь сонсож, зааврыг нь хүлээж авах ёстой. (Найз маань хэдийнээ тодорхой хэлчихсэн зүйлээ надад зориулж давтаад байх шаардлагагүй) Найзад маань намайг захиргаадах хүсэл байхгүй. Намайг нүүр амаа завааруулахаас сэргийлэхэд л болно! Бие биеэ тордох үйл ажиллагаанд оролцож байгаа хүн “би заваарчихбал, бусад маань ч заваартана” гэдгийг мэдэх хэрэгтэй.

Чамайг хүндэтгэлийн өргөөнд явж ороход, хэн ч мэндчилэхгүй, харилцахгүй байвал, би чамд харилцаа холбоотой чуулганд явахыг зөвлөнө. Харилцаа холбоогүй нөхөрлөл, чуулган чамайг Бурханы зорилгын дагуу тордохгүй. Арчилгаа тордолгоо хэрэгтэй хүн андашгүй байдаг. Надад ийм арчилгаа тордолгоо хэрэгтэй байсан болохоор, би амьдралдаа пастор найзыгаа урьсан. Надад ганцаардсан, үл ойлгогдсон мэдрэмж төрж байв. Энэ нь тийм ч аятайхан гоёл биш учраас, эдгээрийг амьдралаас маань зайлуулж, намайг самнаад өгөх хүнийг хүсч байлаа.

Арчилгаа тордолгооны энэ үйл явц нь бидний хувьд харилцаа холбооны гол цэг байж болох. Хүн бид асар их үнэ төлөөсөөр сургамж авдгийг аварга шар найзууд маань сайн мэддэг гэлтэй: өөрөө өөрийгөө тордох нь аюултай.

АРИУН ЦЭВЭР БУС, АРИУН ЧАНАР

Хөл угаалыг Петр эсэргүүцээд, нэг мөсөн биеэ цэвэрлүүлчихье гэдэг сайн дурын санал тавьсныг санаж байгаа байх. Гэтэл Есүс түүнд ингэж түргэдэхгүй байхыг мэдүүлсэн:

Есүс —Усанд орсон нэгэн хөлнөөсөө бусдыг угаах хэрэггүй. Тэгээд ч бүхэлдээ цэвэр байна. Та нар цэвэр байна. Гэхдээ бүгдээрээ биш шүү гэлээ. (Ариун цэвэрт бус, ариун чанарт анхаарч байгааг минь мэд) (Иохан 13:10)

Есүс бидний ариун цэвэрт бус, ариун чанарт л анхаарах. Эцсийн эцэст бид үүндээ л хариуцлагатай. Бид бие дээрээ төвлөрөх үед шунал, тачаал жолоогоо алддаг. Зарим итгэгчид бусдыг цэвэр бус хэмээн яллах атлаа өөрсдөө ариун царайлахдаа л анхаарна. Есүс яг л энэ тухай хэлсэн:

Хоёр нүүрт фарисайчууд, хуулийн багш та нар золгүй еэ! Та нар аяга тавагнаыхаа гадна талыг нь цэвэрлэдэг ч дотор нь дээрэм тонуул, хувийн сонирхол дүүрэн аж. (Матай 23:25)

Бид үүний цаад том зураглалыг харах ёстой: ариун байдал нь ариун цэврийн бус, зүрхний үйл ажиллагаа юм. Өдөр тутмын амьдралын өрнөл бидний гар, хөлийг завааруулж болох ч, гагцхүү Бурханы цэвэр болгодог зүйлийг бохирдуулж чадахгүй. Тэр л биднийг ариун болгодог, цорын ганц Эзэн - Бурхан болой!

Бид сайныг үйлдэхээсээ илүү муугаас зайлах дээр анхаараад ирэх үед самуурал бий болдог. Тэр үед л чөлөөтэй амьдрал маань гадны халдагч, араатны цохилтод өртөнө. Есүс муугаас зугтаад явах бус, харин сайныг үйлдэх тухай ярьсан. Нүглийн эсрэг зүйл нь чанар болой.

Ёрын мууг сайнаар л ялна. Ёрын мууг дүрэм журмаар оруулах юм уу зайлж зугтсанаар шийдэхгүй. Тийм ээ, бид хил хязгаартай байж, цэц ухаанаа хэрэглэх ёстой. Тийм ээ, бид ёрын мууд оролцож, ёрын муутай хутгалдаж болохгүй. Тийм боловч, бид хэрэгцээгүй юмсыг хусаад байгаа юм биш биз? Өөрийгөө цэвэрлэх гэж оролдох юмуу бусдаар буруу газраа цэвэрлүүлэхээ больцгооё.

Шунал, тачаалын биеэ хэрхэн цэвэрлэх Есүсийн зөвлөгөөг үз:

Харин та нар *доторхыг нь* өглөг мэтээр өг, тэгвэл харагтун, бүх юмс та нарын хувьд цэвэр байх болно. (Лук 11:41)

Бурхан биднийг дотроо цэвэр байхад л анхаардаг. Бурхан намайг “цэмцгэр байшингаасаа гараад, бусдад туслахын төлөө хуруу, хумсаа жаахан заваартуулахаас айхгүй байхад” Түүний бие болсон чуулганыг ятга гэдэг.

Чухам энэ сургамжийг л Фарисай Симон авах ёстой байжээ.

Төгс тордолгоо

Есүс Фарисай Симоны гэрт оройн зоогт уригджээ. Хотын янхан орж ирээд, амар тайвныг нь алдагдуулах хүртэл тэр уулзалт их л “цэмцгэр” өрнөж байв. Эмэгтэй Есүсийг тэнд байгааг дуулаад, хүрч иржээ. Зүгээр ч ирээгүй, маш үнэтэй анхилуун тос авчраад, Есүсийн өмнө өвдөглөж байгаад, хөл дээр нь цутгаж тослов! Хөөрхий Симон. Тэр зүгээр Есүстэй, найз нөхөдтэйгээ сайхан найрлахыг хүстэл, ийм юм болчихсон. Симон үүнийг үзээд, дотроо “Энэ хэрэв эш үзүүлэгч мөн юм бол Түүнд гар хүрч буй энэ эмэгтэй хэн болохыг, түүнийг нүгэлтэн гэдгийг нь мэдэх учиртайсан” хэмээн боджээ (Лук 7:39).

Есүс Симоноос асуув. Өрөө цуцлуулсан хоёр хүний хэн нь илүү талархах талаар: Бага өртэй байсан нь уу, их өртэй байсан нь уу? Симон

их өртэй нь л илүү талархана хэмээн зөв хариулжээ.

Тэгтэл Есүс өрөөнд байсан тэмээнээс том тэмдэгтэй асуудлыг сөхөв (янханы талаар өгүүллрүүн):

Есүс түүнд —Чи зөв шүүлээ гээд, тэр эмэгтэй уруу эргэж, Симонд —Чи энэ эмэгтэйг харж байна уу? Намайг гэрт чинь орж ирэхэд чи Надад хөл угаах ус ч өгөөгүй, харин энэ эмэгтэй хөлийг минь нулимсаараа норгоод үсээрээ арчлаа. Чи Намайг үнсээгүй. Харин энэ эмэгтэй Намайг орж ирснээс хойш хөлийг минь үнсээр байна. Чи толгойг минь ч тосоор тослоогүй, тэр харин үнэт тосоор хөлийг минь тослов. Тиймээс Би чамд хэлье. Түүний олон нүгэл уучлагдсан. Учир нь тэр их хайрласан. Харин багахан уучлагдсан нь бага хайрладаг (Лук 7:43-47).

Эдгээр эшлэл нь шашны мэргэжилтнүүдийн өмнө *тэр эмэгтэйн талаар* Есүсийн хэлсэн үгийн тэмдэглэгээ юм. Гэхдээ *тэр эмэгтэйд* хандаж Есүсийн хэлсэн үг үүнээс илүү чухал болой.

... эмэгтэйд — *Нүгэл чинь уучлагдлаа* гэв. Түүний хамт тухлан сууж байсан хүмүүс хоорондоо —Нүглүүдийг хүртэл уучилдаг энэ хэн гээч вэ? гэлцлээ. Есүс тэр эмэгтэйд хандаж —Итгэл чинь чамайг аварлаа. Амар тайван яв даа гэж айлдав. (Лук 7:48-50)

Есүс тэр найранд уригдаагүй цорын ганц хүнийг ийнхүү сулласан нь илэрхий байна. Яагаад? Яагаад гэвэл тэр эмэгтэй Симоноос ялгаатай нь Есүстэй мэндчилээд, хөлийг нь угаасан. Симон өөрийгөө хэт өндөрт тавьсан учраас, Есүсийн өмнө бөхийх даруу зангүй байсан бол, эмэгтэй өөр байв.

Нүглээ уучлуулах боломж Симонд байсан уу? Мэдээж байсан. Тэнд байсан бүх хүнд байсан. Есүс сургаалт үлгэрээрээ дамжуулан чадах чинээгээрээ л заадаг байсан ч, яг тэр үед Симон Есүсээр зүрхээ арчилж тордуулах шаардлагаа ухаараагүй болтой.

Зүрхээ тордуулах шаардлагагүй гэж төсөөлж байгаа л бол, бид бусдыг шүүмжилж эхэлнэ. Бусдыг шүүхдээ өөрт хэрэгтэй зүйлээ няцаана. Симонд ийм л зүйл тохиолджээ. Тэрбээр хөлөө угаалгах шаардлагатай байсан. Түүнд амар мэндийн мэндчилгээ хэрэгтэй байсан. Түүнд тос тосолгооны эдгэрэл хэрэгтэй байсан. Гэвч тэрбээр өөрийгөө энэ хэрэгцээнээс дээгүүр тавьсан учраас, зочиддоо эдгээр мэндчилгээ, тордолгооны алийг ч санал болгоогүй.

ХҮНДЭТГЭЛИЙН БАЙР СУУРЬ

Би үүнийг бичиж байхдаа, Есүс манай цагийн хуульчлагч удирдагч нарт: “Та нар энэ эмэгтэйг уучлал хүртэхээсээ өнгөрсөн, нүгэлтэй амьтан гэж үзэж байгаа учраас л үл тоох ажээ. Та нар түүнийг миний Сайн мэдээний даалгаварт нэг их байр суурь эзлэхгүй гэж бодож байж болох ч, би түүний жишээг тодосгож, үүгээрээ эмэгтэйчүүдийг зөвтгөнө. Та нар Еваг Адамаас том нүгэл үйлдсэн гэж үзсэндээ, түүний охидыг Миний ширээнээс хүртэх эрхгүй гэж бодож байж болох ч, уучлуулсан хүмүүс хавьгүй их талархдгийг бүү март. Охид маань Миний хөлийг угааж, тосолноороо ч хамаагүй, хүндэтгэлийн байр сууринд очих л болно” гэсэн утгатай үг хэлж байхдаа, тэр эмэгтэй рүү харж хэлсэн болов уу хэмээн өөрийн эрхгүй гайхаж билээ.

Эрслэн минь, сүр жавхлант Эзэнээ дахин бахдан баярлуулах зүйл хийх цаг нь боллоо. Үүний тулд би бусдынхаа ч хөлийг угаахад, өөрийнхийгөө ч угаалгахад бэлэн. Есүс биднийг хараад гайхширч чадахын тулд чадах бүхнээ хийж, хүрэх газраа хүрэхэд бүгд бэлэн байцгаая. Симон тэр эмэгтэйг Есүст хаа хамаагүй халдаж байна гэж үзсэн ч, Есүс эмэгтэйн үйлдлийг хайрласан. Оролдлого чинь анхандаа эв хавгүй байвал, бүү санаа зов. Зүгээр л эхэл. Би Есүсээр “Намайг гэх хайр чинь Миний бахыг хангав” гэж хэлүүлмээр байна.

Эзэнийхээ төлөө гайхамшигтай онцгой сайхан зүйл хийцгээе. Энэрэл, тордолгоо харамгүй үзүүлж, бусдыг хүлээн авахдаа бид Эзэнээ ханамгүй ихээр биширдэг. Тэрбээр эргэн ирээд, биднийг амилуулах цагийн төлөө бие биеэ тосолъё. Нулимсаараа ч хамаагүй бие биеийнхээ хөлийг угаая. Чуулганыхаа хөлөөс хог шороог нь угаах хэмжээнд чийгшүүлтэл нь уйлцгаая. Өөрсдийнхөө нүглийн төлөө, даян дэлхийн эмэгтэйчүүд, хүүхдүүдэд тулгарах шударга бус явдлын төлөө уйлцгаая. Хэрэв хүртсэн нигүүлсэл чинь чамайг нулимсаа урсгатал чинь бөхийлгөхгүй байвал, олзонд орсон охидын зовлонгийн харгислалыг хөдлөх хөшүүргээ болго. Нулимс чинь бусдын хөлийг угааж, Эзэнийг маань өргөнө.

Эрслэнгийн мэндчилгээ, тордолгоо нь бидний хувьд бие биеэ хэрхэн хүлээн авч, бие биедээ харьяалагдахын билэгдэл болно. Хэрхэн мэндчилж буй маань бие биеэ хэрхэн үздэгийг маань тодорхойлно (удирдагч, найз, дагалдагч зэргээр). Бусад хүн чамайг хэрхэн үзэж байгаа нь хэрхэн тордохыг нь тодорхойлно. Бид бие биеэ тордохдоо, бие биеэ үнэ цэнэтэй болгодгийг эрслэнгийн жишээ харуулж байна. Энэ утгаараа, бид нэр хүнд, даруу байдал, хүндэтгэл харуулж байгаа юм. Мэндчилгээ маань “Би чамайг танина. Би чамайг үнэлнэ. Би чиний төлөө байна. Одоо би, тэр

газраас наалдсан шавар шавхайг чинь цэвэрлээд өгье” гэсэн үг юм.

Би саяхан эрслэн эгч дүүстэйгээ хоёр өдрийг хамтдаа өнгөрөөгөөд ирлээ. Бид уулзалдахаараа тэврэлддэг. Бид бие биеийнхээ оршихуйд тайтгарч, амардаг. Бидний зургаан хүүхэн зочид буудлын хоёр өрөөнд байрлав. Хамтдаа унтаад, хамтдаа сэрнэ. Өдөржин латге ууж, хоол иднэ. Унтлагын хувцастайгаа уулзаж, орой нь бие биеэ тордоно. Бид өөр хоорондоо сэтгэлээ нээж, чөлөөтэй байсан. Нөхөрлөлийн энэ дотно холбоонд зүрх нь шархалсан ээжүүд, төвхнөж амжаагүй аялагч нар, ядарч туйлдсан дайчид, догдолсон алсын хараатай эмэгтэйчүүд бий.

Бид зургаа эхний шөнөө бие биетэйгээ мэндчилсэн. (Санасан шүү, хайртай шүү гээд л) Маргааш нь сэрээд тордох ажлаа эхэлсэн. (За, чи минь ямаршуу байна даа гээд л) Бид нэг нэгнийхээ сул бөгөөд давуу талыг мэднэ. Заримдаа энэ нь нэг л ижил зүйл байдгийг бид мэднэ. Бид бие биеэсээ хэцүү асуулт асууна. Хамтдаа хөхрөлдөж, уйлж, айдас, нүгэл, сул талаа илчилнэ. Тэгээд эцэст нь бие биеийнхээ, үр хүүхдийнхээ, ирээдүйнхээ төлөө залбираад дуусгана. Үүний төгсгөлд ядардаг боловч, хачиггүй, шавар шороогүй, цэвэрхэн хөлтэй болно.


Эдгээр эрслэн эгч дүүс маань надад хайртай, миний төлөө байдгийг мэддэг учраас, би тэднээр тордуулах дуртай. Тэд миний хувьд хэн болохыг би мэднэ. Би ч тэдний хувьд хэн болохыг тэд мэднэ. Заримдаа бид санал зөрнө. Гэхдээ бид салахгүй.

Чиний амьдралд мэндчилж угтах ёстой эмэгтэйчүүд байна уу? Зөөлөн тордолгоо хэрэгтэй байгаа эмэгтэйчүүд байна уу? Тордох ажилдаа урьж оролцуулмаар байгаа хүн байна уу?

ЭРСЛЭН СТРАТЕГИТАЙ

Шүүх газар сууж буй хүнд
 Шударга сүнс болж,
 Тулаанд дааман хаалга тийш ухрагчдад
 Хүч чадал нь болно.

Исаиа 28:6



Эрслэнгүүд саваннагийн хамгийн хүчирхэг амьтад биш чиг, сул талаа стратегийн ухаан, бор зүрхээрээ нөхчихдөг амьтад. Эрслэн эгч дүүс маань холбоотнууд – стратегийн баг шиг ажилладаг. Тэд бол эгч дүүс, эх, охид, хамаатан садны сүрэг юм. Тэд хол, ойрын холбоотой учраас, нэг нэгнийхээ давуу бөгөөд сул талыг нь нөхдөг байна. Ан ав хийх, алга болсон үр төлөө хайх, залуусаа сургах тал дээр сүргийн эрслэн бүр үүргээ биелүүлж, хувь нэмрээ оруулна.

Тухайлбал ангийн үйл ажиллагаанаас эхэлье л дээ. Эрслэнгийн анд гурван хүчин зүйл чухал: цаг хугацаа, өнгөлөн далдалгаа, ойрын дайралт. Эрслэнгийн хувьд цаг гэдэг амин чухал бус, харин бүх зүйл юм. Бид цаг хугацааг өөрийнхөө талд ажиллуулж чаддаг эрслэнгийн ур чадварт суралцах ёстой: Эрслэн хэзээд нь авлахаа мэдэхийн тулд цаг хугацаа, гэрлийг ашиглана. Эрслэн байгаль орчин хамгийн таатай цагт буюу үүрийн бүрэнхийгээр авладаг байна. Нар мандаж, жаргахыг хэн ч түргэлүүлж чадахгүй учраас, эрслэн зорилгоо тээн, тэвчээртэй хүлээнэ. Гэрлийн бууралт нь эрслэнгийн өнгөлөн далдалгааг дэмжиж, ойртох боломжийг нь ч нэмэгдүүлнэ. Шөнө Африкийн талын дийлэнх араатан амьтдын хараа буурдаг бол, эрслэнгийн хараа бүрэн ажилладаг байна. (Энэ талаар дараа дэлгэрэнгүй ярина.)

Гэрэл түүний талд байгаа цагт эрслэн цаг хугацаа, байршил дээр ч ажиллаж чадна.

Эрслэн ихэвчлэн тал газар нуугдана. Барих гэж байгаа ангаа салхин доор нь сахиж суух эрслэн өдрийн гэрэлд анхаарал үл татах. Эрслэн шилдэг байршлаа олоод авбал, тэр чигээрээ тогтоно.

Эрслэн - ан амьтдын сүрэгт хөнгөн тусдаг амьтан биш. Түүний оршихуй талаар нэг тарж, хавийн амьтныг цочоож, үргээнэ. Айсан амьтад араас нь эрслэн хөөж яваа эсэхийг мэдэхээр эргэж харна. Гэвч эрслэн огт хөдлөхгүй. Цаг нь болоогүй ажээ. Эрслэн алтан сорт өвсөн дундаа хөдлөлгүй хэвтэнэ. Эрслэн хүлээх зуураа дуг хийж болох ч, нам унтахгүй. Эрслэн хөдлөх зөв цагаа хүлээн, хүчээ хуримтлуулна.

Үргэсэн сүрэг тайвширч, эрслэнг ч мартагнах. Тэгээд дахиад л толгойгоо өвсөнд зооно. Тэвчээрийн урлагийг эзэмшсэн эрслэн талтайгаа уусч, идэш нь ч эрслэнгийн оршихуйд дасан, тайвширна.

Үүрийн бүрий болмогц, эрслэн идэш рүүгээ сэм сэм гэтэн мөлхсөөр. Аварга том савар нь чимээ гаргахгүй шахам. Эрслэн идэшдээ хүрэх орон зайгаа баримжаалахын тулд байн байн тооцоотой амралт авна. Амжилттай дайралт хийхэд ойрын зайнаас огцом довтлох нь чухал. Эрслэнд зээрийн хурд байхгүй шүү дээ.

Тэгтэл гэнэт эрслэн ширэлдээ өвсөн дундаас сүр сар хийтэл үсэрснэ. Айж цочсон зээр амь мөлтөс үргэн зайлахад, бөгсөн бие нь эрслэнгийн хурц савраас зүүний зайтай л мултрав. Эрслэнгийн хөөлт эхлэв. Айж балмагдсан зээр урхинд ороод явчихсанаа ч мэдэхгүй. Өөр нэг эрслэн урдаас нь дайрахад, зээр түүнээс мултран зайлахдаа бас нэгэн эрслэнгийн саварт орно. Эрслэнгүүд идшээ үтэр түргэн цааш нь харуулна.

Эхний эрслэн бүтэлгүйтсэн үү? Бүтэлгүйтсэн ч байж болох, бүтэлгүйтээгүй ч байж болох. Гэхдээ нэг зүйл тодорхой - тэрбээр маш нарийн гүйцэтгэлтэй, стратегийн төлөвлөгөөний нэгээхэн хэсэг байв. Эрслэнгүүд бол сүрэглэж ан хийдэг, цорын ганц аварга муужгаа билээ. Бар, ирвэс, хар ирвэс, цоохор ирвэс нар ганц, ганцаараа анд гардаг бол, эрслэнгүүд хамтарч хийнэ. Эрслэнгүүд бол нарийн ур чадвартай анчид. Эрслэн болгон байршлаа эзлээд, сүргийнхээ эгч дүүс дундаа авлах ур чадвараа хөгжүүлдэг ажээ. Арслангууд баригдсан бүхнээ унагаж авахын тулд сүрэг рүү ухас хийн халддагаараа алдартай. Арслан чинь алчуурчин араатан шүү дээ. Гэтэл эрслэнгүүд яардаггүй... тэд тооцоотой тоглодог. Тэдний ан хийж байгаа нь онц сонирхолтой кино шиг л. Тиймээс л эрслэнг *домогт (эр зоригт) анчинд* тооцдог.

Домогт

Би энэ үгд хайртай. Аягүй баатарлаг үг. Хэлээд үз л дээ.

Би энэ үгийг яриандаа тогтмол хэрэглэдэг болоод удаж байна. Хэлэх тоолонд л сонсогчийг ангайлгана. *Домог* гэдэг үгийг хичнээн хэлсэн ч, бусад үг шиг утга нь шимэгдэж алга болохгүй, сүртэй хэвээрээ л дуулдана. Эрслэнтэй адил энэ үг ч бас эгшиг авиандаа нууцлаг чанарыг агуулна.

Надтай хамт аялдаг залуу бүсгүйчүүд энэ үгийн зохицолдоог олж мэдэхээр олон янзын зүйрлэл дээр хэрэглэж үзжээ. Тэд аяллын *домог*, ачааны *домог*, тээшний *домог*, залбирал, номлолын *домгийн* талаар ярьдаг. Домог гэдэг үг бидний хувьд цоо шинэ, зэвүүн үг болох болтугай.

Домог нь бас өөр нэгэн утга агуулдаг бөгөөд эмэгтэйчүүд маань үүнийг судалж, илэрхийлэхийг би үнэн голоосоо уриалж байна. Би *ан хийх* гэдэг үгийг *домогт* (зоригт) гэдэг үгтэй хоршуулахдаа (эрслэн бол домогт анчдын шилдэг жишээ шүү) бас *дошгин*, *стратегитай*, *санаачилгатай*, *эцэг эх байх*, *хэлбэр*, *харилцаа* зэрэг үгстэй хоршуулж үзмээр байлаа.

Ер нь бол хязгааргүй хувилбар үүсгэж болно. Гэхдээ эрслэн маань том *дуугардаг* амьтан биш, харин *өөрөө* том буюу домогт амьтан болой.

Домогт чанар хэлбэр дүртэй байсан бол, яг л муурын дүртэй байх байх. Би хэдий нохойнд хайртай ч, өөрийнхөө Йоркийг домогт буюу зоригт амьтан гэж хэлж ёстой чадахгүй. Домогт гэдэг чанар нь өнгөтэй байсан бол, алтлаг л өнгөтэй байх байх. Бүтцийн хувьд? Халиурсан үс. Домогт нь зорилготой амьдрахыг хэлэх бөгөөд үүнийг хөгжүүлэх боломжтой ч юм, ёстой ч юм. Чамд энэ чанар байгаа л бол, чиний өмч. Эрслэн домогт чанараараа л хүчтэй болдог. Эрслэн энэ хүчээсээ айхгүй. Харин ч эсрэгээрээ итгэлтэй байдаг.

Миний компьютерийн *Encarta Thesaurus* (тайлбар толь) *домогт* буюу *зоригт гэдгийг чадвар, ур, өрсөлдөх чадвар, сэргэлэн, ур ухаан, ашиг өгөөжтэй* гэж тодорхойлсон байх юм. Дээрээс нь би дараах давхар иртэй тодорхойлолтод дуртай: “1. Гоц чадвар, ур, хүч. 2. гоц эрэлхэг чанар, эр зориг.”¹

Эрслэнтэй адил чамд домогт (зоригт) чанар бий. Амьдралд чинь биеллээ олохоор хүлээж буй гоц чадвар, хүч, эр зориг бий. Магадгүй боловсрох цагаа далдуур хүлээж байж болох ч, байгаа гэдэг нь эргэлзээгүй. Бурхан бидний дотор авьяас, ур чадварууд нуусан л байгаа. Бид харин тэдгээрийг олборлож, илрүүлэх ёстой. Домогт чанар нь *Би бүгдийг мэдэхгүй, бүгдийг хийхгүй ч, сайн хийх ёстойгоо л мэднэ* гэдэг. Чиний домогт чанар тоглоом, спортын дундуур эсвэл шинэ зүйл оролдож байхад чинь гэнэт сэргэж мэдэх. Үсэрч гарч ирээд, тоглохыг хүсдэг, тийм чанар чиний дотор бий юу?

Аймшиггүй амьдарч байгаа эрслэнг үзээд баярлан хөөрч байгаа тал чинь чиний домогт чанар байж болох. Эрслэнгүүд ан хийсэн ч, хамгаалсан ч, хээрийн сургууль хийсэн ч, сайн хийнэ гэдгээ мэднэ.

Тэгэхээр, эрслэнгүүд яагаад домогт анчдын шилдэг жишээ байдаг байх нь уу? Тэд өрсөлдөхгүйгээр, суудлаа булаалдалгүйгээр, зүгээр л *хамтдаа* ан хийдэг. Ямар ч эмэгтэй илүү юмуу дутуу хувь нэмэртэй байна гэж байхгүй. Зүгээр *өөрөөрөө* л бай! Өөр хүний авъяас билгийг хуулбарлах нь хэнд ч ашиггүй - ялангуяа чамд. Харьцуулж, хуулбарлаж, өрсөлдсөнөөр хувь хүний онцлог чанар бий болохгүй. Эрслэн болгон өөрийнхөө ур чадварыг л хурцалдаг. Бид ч түүний үлгэр жишээг л дагах ёстой.

бид олуулаа Христэд нэг бие бөгөөд хүн бүр нэг нэгэндээ (онцсайнаар хэлбэршиж, гайхамшигтайгаар ажилладаг) эрхтэн юм. Бидэнд өгөгдсөн нигүүлслээр бэлгүүд маань ялгаатай. Эш үзүүллэг нь итгэлийнхээ хэрээр (Ром 12:5-6).

Би өндөр ур чадвартай илтгэгч нараас бүрдсэн конференцэд оролцдог. Тэднийг дууриах заримдаа айж сүрдмээр байдаг. Алдаж онож байж л би өөрийгөө тултал хөгжүүлж, өөрийнхөө л шилдэг хувилбар байх ёстой гэдгийг сурсан билээ *Lioness Arising: Wake Up and Change Your World-*. Хүн чамайг ямар нэгэн дүрд оруулж жүжиглүүлэх гэж амьдралдаа урьдаггүйг санаарай. Тэд чамайг л урьдаг.

Дээрх эшлэл дээрх “онцсайнаар хэлбэршиж, гайхамшигтайгаар ажилладаг” гэдэг үгийг уншихдаа, нөгөө *домогт* гэдэг үгийг бас чи айдас, гайхамшигийг хослуулан байж бүтээгдсэн гэдгээ санаарай. Бурхан чам руу айдсын сүнсийг бус, хайр, хүч, саруул ухааны сүнсийг амьсгалж оруулсан (2Тимот 1:7-г үзнэ үү). Чи аймхай, хулчгар болж бус, айдас төрүүлмээр сүртэй бүтээгдсэн. Бурханы хайртай охин чи, даян дэлхий дээрх аймшгийн улиралд Бурханы гайхамшигийг илэрхийлэхээр илгээгдсэн. Чи гайхамшигтай үйл ажиллагааны нэгээхэн хэсэг бөгөөд энэ ч бас домогт чанарын нэгээхэн илэрхийлэл гэдэгт би итгэдэг.

Бурхан биднийг бүгдийг маань эрслэнгүүд шиг дор дороо байршлаа эзэлж, хүчээ тултал гаргахыг л хүснэ.

Эрслэнгийн ан хийх чадварыг Африкийн соёл тэр чигээрээ магтан дуулдаг. Цуутай анчдыг “эрслэнгийн хөвгүүн” хэмээн алдаршуулна. Эрслэн л эр, охин - бүх үр төлөө анчид болгон, өсгөн хүмүүжүүлдэг шүү дээ. Энэ динамикийг Бичээс ч тодосгох:

“Эх чинь арслангуудын дунд
Ямар эрслэн байсан гээч!

Гүегүүдээ өсгөхдөө тэрээр залуу арслангуудын дунд хэвтэж,
Гүегүүдээсээ нэгийг өсгөсөнд тэр нь арслан болж, олзоо тасчихыг
сурчээ (Езекиел 19:2-3).

Гэхдээ эрслэн дан ганц үр төлөө хүмүүжүүлэхгүй ээ. Үүнийг бусад амьтан ч чадна. Эрслэн сүргээ бүхлээр нь халамжилж, өтөлсөн, шархадсандаа ч анхаарна. Тэд бол сүргийг эрүүл нэгтгэл шиг барьцалдуулж байдаг “наалдан пад” гэлтэй.

Арслан - өөрийнхөө оршихуйг чангаар зарлахаас үл эмээх, эрхэмсэг дүр. Тэгвэл эрслэнгийн хувьд эсрэгээрээ - байгаа үгүйгээ үл мэдүүлэх нь түүний жинхэнэ хүч болдог ажээ. Ан хийх юмуу үр төлөө хооллохдоо өөрийгөө чангаар зарлан тунхаглах нь эрслэнгийн зорилго биш - өнгөлөн далдалгаа нь эрслэнгийн давуу тал аж. Гэхдээ үр төлд нь аюул занал тулгарбал, өөр хэрэг шүү.

Эрслэнгийн өмнөөс чи ан агнах уу?
Идэр залуу арслангуудын идэх хүслийг
Үүр нүхнүүдэд тэд хярж,
Хоргодох газруудад хүлээн хэвтэх үед нь хангаж чадах уу?
(Иов 38:39-40).

Энэхүү бичээс нь Бурхан - Иов хоёрын харилцан ярианы сонсгол ажээ. Энэ харилцан яриа бидэнд эрслэнд ан хийж, мөрдөж мөргиж, өлөн ходоодтой үр төлөө хооллохыг нь Бурхан Өөрөө зааж сургадгийг хэлж байна. Гайхамшигтай биш гэж үү? Аугаа Бурхан маань л эрслэнгийн ахуй орчинд ур чадварыг нь хурцлах хэрэгцээт эд юмсыг байршуулж, шинэ санаа өгдөг бус уу? Бурханы амьсгалтай бүтээлүүд нь эрслэнд ан хийж, бойжуулах ухааныг зааж өгдөгтэй адил, бүтээлийн гайхамшиг нь бидний ч Бурханыг хайж, бие биеэ хайрлах хүслийг бадраадаг бус уу?

Галзуу хөөцөлдөөн

Би ан хийх ойлголтыг өргөжүүлмээр байна. Ан хийх нь зүгээр нэг *алж идэх* явдал биш ажээ. *Ан хийх* нь хөөх, мөрдөх, хайгуул хийх, тэр бүү хэл аврах ажиллагаа байдаг ажээ. Үйл үг нь хөөх, мөрдөх, мөшгих, мөрөөр нь шиншлэх, дагах, отож хэвтэх гэсэн утга агуулна. Эдгээр үйл үгээр нь бидний Бурханы араас мөрдөж мөшгих байдлыг дүрсэлдэг нь нэн сонирхолтой.

Бурхан ЭЗЭН минь,
Таны дотор би хоргодсон билээ.
Намайг мөшгөж буй бүгдээс
Намайг авран чөлөөлөөч. (Дуулал 7:11)

Энэ ан тун сонирхолтой ажээ. Би “Бурхантай галзуу юм шиг хөөцөлдөх” гэдэг ойлголтод дуртай. Энэ нь нойрмоглон хийх, өглөөний чимээгүй цагаас төрөх алсын хашхирааны дүрслэл болой. Эдгээр нь яаравчлал, хурд, зорилготой хөөцөлдөөнийг илэрхийлсэн үг байна. Энэ бичээсийг өөр нэгэн өнцгөөс харж болно. Энэ нь нэг бол ямар нэгэн галзуу, аюултай юмнаас зугтах гэсэн утга илэрхийлж болно эсвэл Бурханы араас галзуу юм шиг хөөх гэсэн утга илэрхийлж болно. Аль нь ч байж болно. Аль, аль нь гоё догдуулмаар хэдий ч, би хувьдаа Бурханыг галзуу юм шиг хөөх гэдэг санаанд нь илүү дуртай. Түүнчлэн Бурхан миний араас галзуу юм шиг хөөх гэдэг санаа ч гоё. Заримдаа би манай гэрийн цонхны араамаар жаазлагдсан уулсын барааг ширтээд: “Бурхан минь, та Хэн юм бэ? Би Таны бат хүчний гэрлээр өөрийгөө мэдмээр байна!” гэж шивэгнэдэг юм.

Мэдээж Бурханыг “агнаж унагана” гэж юу байхав. Түүнийг догонцуулах ч боломжгүй. Инээдтэй хэрэг. Гэхдээ Түүний барааг зэрвэс үзээд өнгөрдөг. Түүний дотроос хайгаад байгаа зүйлээ хальт хардаг. Бушуухан Бурхантай хөөцөлдөж, Түүнийг “агнах” цаг болсныг дотор минь мэдрээд байна.

Эрслэн гэвчээр заан хүлээдэг шиг, цаг тогтоосон хүлээлт нь Бурхантай хөөцөлдөх үйл явцсын салшгүй хэсэг юм. Магтаалч:

ЭЗЭН, Өглөөд Та дуу хоолойг минь сонсоно.
Өглөөгүүр би Таны өмнө бараалхан, хүсэн хүлээх болно
(Дуулал 5:3) гэдэг.

Ан хийх нь мөн “харах, хайх, эрэл хайгуул болох” гэсэн утгатай. Эдгээр нь бидний дамжуулгыг цуурайтуулна. Эцэст нь бас *ан хийх* нь хайгуул, даалгавар, мөрдлөгө, судалгааг илтгэдэг.

Өндөр Бурханы охид - бид хариулт, цэц ухаан, хүчийг авладаг. Бид Бурханд баригдах гэж Түүнтэй хөөцөлддөг бөгөөд баригдаа бол, Түүний гэрэл, амьдралыг бусдад тусган харуулна.

Сайн сайхан хийгээд хайр энэрэл тань
Насан туршид минь намайг лавтай яа дагана.
ЭЗЭНий өргөөнд би мөнхөд оршин сууна. (Дуулал 23:6)

Цэц ухаан, зөвлөгөө нь Бурханы араас гүйдэг төдийгүй, Бурханыг араасаа гүйлгүүлдэг эмэгтэйчүүдээс олдоно. Эдгээр бүрэн сэргэг эмэгтэй болгон бусдад Бурханы хайр, халамжийн тасархайг түгээдэг. Бурханы үзэсгэлэн, хайр эмэгтэйчүүдийн дундаас харагдах төдийгүй, түгээгддэг. Бурханы хайртай охин чи, шийдлийн илчлэл, үнэний хайгуулын багийн нэгээхэн хэсэг шүү. Бидний арслан - Есүсийн илчлэлээр дамжиж байж л Бурхантай тогтоох тэнгэрлэг холбооны төлөөх даалгавар маань бодитой болно. Зөвхөн эмэгтэй хүн л тавьж чаддаг асуулт гэж бий. Бурхан зөвхөн эмэгтэй хүнд л илчлэлийг нь даалгасан хариулт бий. Үүний биеллийг харахын төлөө бид эвсэн нэгддэг.

Эрслэн эгч дүүс маань анд гарахаасаа өмнө цугладаг ажээ. Тэд хамтдаа амарч, өлсөж, суниаж, босно. Тэд хамтдаа ан хийх байршлаа эзэлж, эцэст нь хамтдаа найрлана. Ийм маягаар амьдарна. Байршил нь өөрчлөгдөж болох ч, эрслэнгүүд эцэстээ хамтдаа л байна!

Соёлын алдарт антропологист Маргарет Мийд улс үндэстэн бүрийн соёлыг ухаж судласан олон жилийнхээ хөдөлмөрийн дараа “Эгч дүүсийн харилцаа нь гэр бүл доторх хамгийн өрсөлдөөнтэй харилцаа мөн боловч, насанд хүрсэн хойноо тэд хамгийн хүчтэй холбоотнууд болдог”² гэж хэлсэн байдаг.

Энэ үгийг уншихаар *Ийм л зүйл болж байна даа! Бид өсч байна!* гэж бодогдох.

Би энэ бүхнийг бичин, *Nurture* гэдэг номынхоо судалгааг хийж байхдаа, стратегитай амьдарч байгаа эгч дүүсийн жишээ Библи дээр хомс байдгийг анзаарч билээ. Үнэндээ, найз бөгөөд журмын нөхөд шиг эмэгтэйчүүдийн үлгэр жишээг хаанаас олох билээ хэмээн гайхшрахдаа, зүрх үхэх шиг болж билээ. Үнэхээр олмоор байв. Бурханы Сүнс л биднийг энэ үйл явц дундуур хөтлөхөөс нааш бид эрслэн мэт босч чадахгүйг харж байна уу?

Ийнхүү Бичээсээс жишээ хайж байхдаа би, Бурханы Сүнсний *Охидын талаарх тэр бүлэг одоо л бичигдэж байна. Охидод маань амьдралаа сайн бичиглэхийг хэл!*³ гэх шивнээг сонсож билээ.

Хувь нэмэр хичнээн чухал болохыг мэдэхгүй өнгөрөх эрсдэлд би чамайг оруулж зүрхлэхгүй. Юу гэсэн үг болохыг ойлгож байна уу? Бид хувиараа ч, хувьсгалаараа ч үг, үйлдэл, сонголт бүр маань үнэлэгдэх, сайн амьдрал бичихээр цугласан, хоорондоо холбоо хамаарал бүхий эгч дүүсийн буюу Бурханы охидын түүхийг бичилцэж байна. Энэ цугларлыг даган, Бурханы эрслэнгүүд дошгин хүч, нигүүлсэл, ур чадвараар босохыг би харж байна.

ШУДАРГА ЁСНЫ ЗАМААР

Бидний хувьд, Бурханы бөгөөд Түүний хариултын араас төдийгүй, шударга ёсны араас явахын төлөө хамтдаа босох цаг болжээ. Шударга ёс хуулийн хэргэм зэрэг шаардахгүй. Шударга ёс нь амьдралын хэв маяг болох ёстой. Манай улс шударга бус явдлыг үл тэвчих, тэнгэрийн улс болохоор байгуулагдсан. Манай хуулийн систем шүүхийг маань үнэний төлөөх ариун дархан газар болгохоор байгуулсан. Гэтэл сүүлийн үеийн шийдвэрүүд зальжин хуульчдын уран сайхан тоглоомын талбай болчихсон юмуу хэмээн гайхшрахад л хүргэж байна.

Шүүх газар сууж буй хүнд
Шударга сүнс болж,
Тулаанд дааман хаалга тийш ухрагчдад
Хүч чадал нь болно. (Исаиа 28:6)

Энэ бичээс ер бусын үйл явдлыг дүрслэн харуулах. Шударга ёс нь дүрэм журмыг гүйцэтгэхээс хавьгүй том зүйл юм. Үүнд сэтгэлгээ, эрч хүч шаардлагатай. Шүүгч, хуульч хоёрын хэн, хэнээр нь улс үндэстэн, иргэдийн үйлдлийг шударга бусаас шударга ёс руу замчлах шийдвэр гаргуулах цэц ухааны ойлголт бидэнд хэрэгтэй. Жинхэнэ шударга ёсны сахилга нь хүчтэй бөгөөд онцсайн хамгаалагч нарыг дуудна.

Шударга ёс гэдэг үгээр Америк улсыг томъёолдог үе байлаа. Намайг жаахан байхад, супер баатрууд “Үнэн, шударга ёс, Америк ёс” гэдэг уриатай байлаа.

Учир нь шүүх дахин зөв шударга болж,
Зүрх шулуун бүхэн түүнийг дагана. (Дуулал 94:15)

Бидэнд шударга ёсны сэргэлт хэрэгтэй болжээ. Манай шүүхийн систем шударга шүүхийн мэдрэмжээ алдсан байх хэмээн би айж байна. Чанартай зүрх шударга ёсыг мөшгидөг. Зүрх чинь зөв бол, чи шударга бусыг тэвчихгүй. Энэ зөвхөн шүүхийн системээр хязгаарлагдахгүй, энэ маань амьдралын алхам бүрт хэрэгжих ёстой. Энэ дэлхийн бурууг зөв болгоод өгөх байх хэмээн засгийн газар, чуулган, хүнийг царайчилсаар суух хооронд маань эмэгтэйчүүд, хүүхдүүд үрэгдсээр байна. Хүүхдүүдийг хор хохирлоос авран хамгаалахад шударга ёс хэрэгтэй гэдэгтэй бид бүгдээрээ санал нийлнэ.

Зоригт эрслэнгүүд нийлж байгаад сүргийнхээ үр төлийг хамгаалдаг. Үр төлд нь аюул занал тулгарбал, эрслэн стратегитай дайчин болж хувирна. Нэг

удаа баримтат киноноос арслангийн сүрэг дунд нэвтэрсэн аварга могойн тухай үзэв. Үхлийн хортой аварга могой тэг дунд нь байхад ч эрслэнгүүд үймж сандралдсангүй, тогтуун байх. Эрслэнгүүд эмх журмаа алдалгүй, үр төлөө зугуухан боловч маш хурдан аюулгүй газар руу зөөвөрлөв. Эрслэн бүр ойр байгаа гүегийг хүзүүдэн хазаад, хорт могойноос холдууллаа. Нэг эрслэн үр төлөө сахих зуур эгч дүүс нь могойн хөдөлгөөнийг ажиглан хянаж байгаа бусадтайгаа эргэж нийлэв.

Нялх нойтноо холдуулаагүй байж, могойтой ноцолдож болохгүйг мэдэх эрслэнгийн цэц ухаан намайг ангайлгав. Тэгсэн бол, үр төл нь саад болохоос гадна эрсдэлд орно. Үр төлөө аюулгүй газарт аваачсан бол, эдүгээ аварга могойтой тулалдаж болно. Эрслэнгийн зөн совинтой хандлагыг өндөр тактик, стратеги гэхээс өөр юу гэх билээ.

Эрслэнгүүд *үр төлөө* бүгдийг нь амиа тавин хамгаална. Эрслэн өөрийнхөө үр төлийг хамгаалдагтай л адил өөр эрслэнгийн үр төлийг хамгаална. Эрслэнгүүд хамтдаа анчлаад зогсохгүй, бүгд нэг, нэгнийхээ үр төлд өрлөг эх нь болно. Үүнтэй адилхан, бид даян дэлхийн хүүхдүүдийг хүний, өөрийн гэж ялгалгүй, аюул заналаас авран зайлуулах ёстой юм. Энэ нь бид гэрт ч, гадаа ч тулалдана гэсэн үг. Хол, ойрын хөршийнхөө төлөө босцгооё.

Эрслэнгүүд нэг нэгнийхээ үр төлийг хамгаална гэдгээ анхнаасаа л мэддэг учраас, авран хамгаалах зүрх сэтгэл нь сүрхий гавьяа биш ажээ. Бурханы үнэртэй байгалийн хангамжийн дагуу, эрслэнгүүд цаанаасаа л нөхөн үржихүйн циклээ хөрвүүлэх чадвартай байдаг аж. Үүнийхээ ачаар тэд нэгэн зэрэг хээлтэж, төллөдөг ажээ.

Тэгэхээр, үндсэндээ тэд сүргээрээ хээлтдэг ажээ. Үр төл нь ойрхон төрсөн бөгөөд ижил хоол тэжээл авч, адилхан бэлтгэл сургуулиар бойжих нь ирээдүйд амьд үлдэх боломжийг нь нэмэгдүүлэхийг эрслэнгүүд мэднэ. Үүгээр түүгээр бөмбөрөлдөх бондгор, алтлаг зулзаганууд эхийн сүүгээр гачигдахгүй. Сүргийн нягт холбоотон - эрслэнгүүд нэг нэгнийхээ үр төлийг алаг шоо үзэлгүй, өсгөөд л өгнө. Сүрэг дотор бойжихын нэгэн давуу тал нь ах эгч, дүүс нь бүгд ойролцоо хэмжээ, туршлагатай болдог. Тэд адилхан сургалт, хоол тэжээл, амралт, тоглоом наадгайгаар дамждаг бөгөөд энэ бүгд нь эцэстээ үр төл байхад нь төдийгүй, ирээдүйн сүрэгт нь ашиг тусаа өгөх, өндөр үр чадвар болж тогтоно.

Эрслэнгүүд зөвийг үлгэрлэн харуулах маягаар үр төлөө сургана. Зэрлэг байгальд алдаа гаргах орон зай байхгүй. Ур чадварт суралцахгүй бол, үр төл нь аюулд орж, сүргийн ирээдүй бүрхэг болно.

Эрслэнгүүд тоглох зуураа агнахыг сурдаг. Тэд гүег байхдаа л арга барилд суралцана. Ээж эрслэн хажууд нь хэвтэж, гүег нь цовхчиж тоглоно.

Ээжүүд нь ч оролцоно. Эрслэнгүүд гүегтэйгээ төдийгүй, хоорондоо ч ноцолдож тоглоно. Тэд энэ тэрүүгээр өнхөрч, оролдож, цовхчиж байгаа гүегтээ хүч чадлыг нь мэдрүүлэхийг хүсдэг. Гүег нь хэтэрхий хол явчихбал, ээж - эрслэн ганц архираад л дураараа этгээдийг эргүүлж авчирна.

Энэ бүх ноцолдоон наадгайн цаг нь сүргийн гишүүн бүрт хүчийг нь мэдрүүлэх зорилготой. Бурхан биднийг хөхрөлдөж, зугаацаж байхад дуртай. Бид тоглохдоо өөрийгөө дахин бүтээдэг юм.

Учир нь Та миний тусламж бөгөөд
Таны жигүүрийн дор
Би баясгалантайгаар дуулна. (Дуулал 63:7)

Эрслэнгүүд үр төлөө тэрхэн өсгөж, сургахын тулд нэгэн зэрэг шахуу хээлтэж, төллөдгийг анх олж мэдэхэд минь Бурханы Сүнс *Лиза, хүүхэд бүр амьдрах тэгш эрхтэй. Хүүхэд бүрт хамгаалалт, тэжээл, сургалт, хангамж хэрэгтэй* гэж хэлж билээ. Газрын хүүхдүүдийн сайн сайхан нь бидний хариуцлага. Бид тэдний төлөө шударга ёсыг стратегитай тогтоох ёстой.

Дошгин хариу үйлдэл

Ээж хүн хүний хүүхдийг хичнээн удаа аврах ёстой вэ?

Эх хүн хөхүүл хүүхдээ мартаж
Хэвлийнхээ хөвгүүнийг энэрэхгүй байх уу?
Хэдийгээр тэд мартаж болох ч
Би чамайг мартаггүй. (Исаиа 49:15)

Эх хүн үрээ мартана гэдэг санаанд буумгүй ч, амьд Бурхан үүнийг “байж болох” гэжээ. Тэгэхээр, энэ эшлэлд эмэгтэй хүн хүүхдээ өсгөж бойжуулахгүй байх юмуу санаандгүйгээр шархлуулах нь байж боломгүй явдал гэдгийг илэрхийлж байна. Харамсалтай нь, бид санаанд оромгүй зүйлс бодит байдал болдог цаг үед аж төрж байна. Хар тамхи, архи, мөнгөний төлөө үр хүүхдээ аюулд өртүүлдэг эхчүүдийн тухай байнга мэдээллэж байна.

Саяхан хэвлэл мэдээгээр гэр бүлийн хоёр хос хоёр жаахан охиныг хулгайлсан тухай гарч байна. Нэг зоригт охин нь арван найман жил хорионд байхдаа, хоёр охин төрүүлж, өсгөжээ. Нөгөө жаахан охин нь гэрээсээ хулгайлагдаад, есөн сар хорионд байжээ. Охидын хэн, хэн нь араатнуудад хүчиндүүлж, харгислуулжээ. Аль, аль тохиолдол дээр нь хүүхэдгүй эхнэрийг

нь нөхрийнх нь үйлдсэн гэмт хэргийн хам хэрэгтнээр ялласан байна.

Алек хүү маань энэ хэрэгт эмэгтэйчүүд оролцсоныг сонсоод, цочирдож билээ.

Тэрбээр эмэгтэй хүн хүүхдүүдийг авардаггүй энэ дэлхийг ойлгож ядан, “Яахаараа эхнэрүүд нь охидыг авардаггүй билээ?” гэж асууж билээ.

Тэр хоёр эмэгтэйн хэн, хэн нь эрүүл байгаагүй гэхээс өөр хэлэх хариу надад олдоогүй юм даа. Тэдэнд сонголт байсан - тэд дуугараагүй. Яагаад ч юм тэдний дотор эхийн сэтгэл сэрээгүй ажээ.

Бид эрчүүд л эмэгтэйчүүдийг дарладаг гэж боддог ч, дандаа тийм байна гэж байхгүй. Тэр хоёр эмэгтэй юу болж байгааг мэдсэн ч, юу ч хийгээгүй. Үнэндээ тэд охидыг хүчирхийлэх боломжоор нь хангаж өгчээ.

Хүчирхийлэгч хоёр эрийн хэн, хэн нь эхнэрүүд, охидыг дарангуйлалдаа байлгахын тулд захирагдах ойлголтын талаар эрүүл бус үзэл ашиглаж, бичээсийг гуйвуулсан нь сонирхолтой. Нөхөртөө таалагдах гэсэн тэр хоёр хүүхний үйлдэл улс үндэстнийг маань цочоов.

Тэгвэл эрслэн аюул заналхийлэл, үр төл хоёрын дундуур харайж ордог. Тэр байтугай сүргийнх нь арслан үр төлд нь аюул занал учруулах гэвэл, эрслэнгүүд түүний өөдөөс хамсан босдог тухай уншиж байлаа.

Бурханы Үгийг эрүүл саруулаар ангилан, үүний дагуу амьдардаг, эрүүл саруул эмэгтэйчүүдийн хувьд өнөөдрийнх шиг ийм амин чухал цаг байгаагүй байх аа. Бид хүйс, захирагдахуй, гэр бүлийн болзолгүй дуулгавартай байдал зэрэг асуудалд цэц ухаантай, бодлоготой хандах хэрэгтэй. Бурхан эдгээр зарчмаар хэнийг ч эрсдэлд оруулахыг хүсэхгүй. Эдгээр нь эрүүл энхийн бөгөөд сайны төлөө оршдог.

Эмзэг, нялхсыг хамгаалах нь бидний үүрэг хариуцлага. Эрслэнтэй адил бид ч ямагт хүүхдүүдийг аюулаас зайлуулах ёстой. “Эх хүн хүний, өөрийн бүх хүүхдийг аврах ёстой” гэдэг зарим эмэгтэйчүүдийн умартсан үнэнийг эрслэн Бурханаас хүртсэн зөв совингоороо мэднэ.

Хүүхэд төрүүлснээрээ л ээж болчихдоггүй ажээ. Инээд алдсан, таван настай, хөөрхөн нялх амьтанг эх нь сексийн наймаанд зарсан тухай мэдээ хэдэн сарын өмнө манай улсыг цочроов. Тэд нялх охины цогцсыг Хойд Каролинагийн эзгүй ой модон дундаас олжээ. Тэгэхээр, энэ ном хэвлэгдэх үед мэдээгээр юу эс гарахыг ёстой бүү мэд.

Гэвч олонх маань “эх хүний сэтгэлгүй” ийм явдалд эгдүүцэн цочирдож байгаад Бурхандаа талархах минь. Замаа алдсан хүмүүс хүн байхаа умартах, цөвүүн цаг ирэх талаар Бичээс зөгнөсөн байдаг (Ром 1:26). Хүн байх гэдэг нь бурхантай адил байж, түүний зүрх, ухааны хувийг тээнэ гэсэн үг. Өөрийнх нь дүр төрхөөр бүтээгдсэн хүний амь амьдралыг үнэгүйдүүлж, хүүхдүүдийг бэлгийн эд сонирхол болгох явдалд Бурхан

хилэгнэдэг. Бурханы хандлагыг мэдсэн бид ч ийм явдалд уур хилэн, хайраар хандах ёстой. Зарим маань хүсээгүй, эрсдэлтэй хүүхдүүдийг үрчилж авах маягаар орон гэрээ нээх ёстой. Бид буруу болгоныг засч залруулах ёстой хэмээн төр засгаа царайчлалгүй, өгөөмөр байх ёстой. Хөршөө жинхэнээсээ хайрлацгаая.

Дарлал, шударга бусын өмнө бид чимээгүй байх юм бол, нэг л өдөр дийлдэх эрсдэлтэй. Чуулган өндийж босоод, хүний наймаа, бэлгийн боолчлолын ёс бус явдлыг цэгцлэхийг нь би хармаар байна. Би энэ талаар байнга тээж, байнга ярьж явдаг хүн. Саяхан онгоцонд дэргэд минь суусан нэгэн залуу бүсгүйтэй даян дэлхийн эмэгтэйчүүд эвсэн нэгдэж, эдгээр асуудалтай халз тулахыг нь харах хүсэл тэмүүллээ хуваалцаж билээ. Гэтэл тэр над руу хараад: “Та ямар эрхээрээ ингэж ярьдаг билээ?” хэмээн тулгав.

Түүний асуултын хүч намайг дэлсээд л авлаа. Би зог тусаад, хэсэг чимээгүй болсноо, өөдөөс нь “Тэгвэл би ямар эрхээрээ дуугүй байх ёстой юм?” хэмээн мөргөлдлөө.

Бүсгүй дуугаа хурааснаа, ердөө л надад ямар нэгэн боловсролын юмуу мэргэжлийн чанар чансаа байгаа эсэхийг л мэдэх гэсэн санаагаа учирлан тайлбарлав. Би бүсгүй рүү эгц харж байгаад, сүүлд шалгахад л лав шударга бусын өөдөөс дуугарч болохгүй гэсэн хуулийн заалт байгаагүй бөгөөд энэ тал дээр “мэргэжлийн” хариулт гэж байдаггүйг тайлбарлаж өгсөн юм. Ийм гэмт хэргийн харгислал олон хүнээс хариу шаардана.

Хүүхдийн ариун нандин байдлыг тонож, томчуудын тачаал, завхралын боол болгох нь ой гутмаар шударга бус явдал. Үй олон хүүхэд амаа үдүүлчихээд байхад, *хүн - бид* яаж дуугүй байж зүрхлэх билээ?

Яаж үүний төлөө уйлахгүй өнгөрөх билээ? “Сайн хүмүүс юу ч хийхгүй байхад л, муу ёр ялна” гэдэг үгийг хичнээн удаа сонсож байж, итгэх төдийгүй, үйлдэх юм бэ? Би гадны улсууд руу аялж, үгээгүй ядуу газраар алхаж явахдаа, эхчүүдийнх нь нүдийг хараад, юу бодож байдаг бол доо хэмээн гайхдаг юм. Тэд *Миний үр чинийхээс дутуу гэж үү?* гэж асууж байдаг болов уу?

Тэдэнд ийм бодол зөвшөөрөхийг маань Бурхан бидэнд бүү зөвшөөрөг. Зүүн Өмнөд Азид хоёр ч ээж надад хүүхдээ өгөхийг хүсч билээ. Нэг ээж бүр хүүхдээ надад тэврүүлсэн. Хүүхдийг нь тэвэрч байтал, ээж нь над руу хараад, миний мэдэхгүй хэлээр шулганан, дохиж зангаад байв. Бас нэг удаа нэг эмэгтэйн хүүхдийг нь өхөөрдтөл, ээж нь орчуулагчаар охиныг нь авах хүсэлтэй байгаа эсэхийг минь асуулгаж билээ. Тэдний цөхрөлийг харж байна уу? Тэд тэс өөр хэл устай, хар элгийн хүнд үр хүүхдээ өгөхөд ч бэлэн байна. Магадгүй тэд мөнгө горьдсон байх. Гэхдээ мөнгөнөөс илүүтэй үр хүүхэддээ ирээдүйтэй амьдралыг хүссэн байх. Бидний хувьд

- үр хүүхдээ зарна гэдэг ой тоймд буумгүй зүйл. Гэхдээ санаж сарвайх үрдээ өгөх юу ч үгүй болбол, чи яах вэ?

Бид үр хүүхдээ өөрт байгаа боломж, бололцоогоо ийм эмэгтэйчүүдийн хүүхдүүдтэй хуваалцах ухамсар, сэтгэлтэй болгож өсгөх үү? Хүүхдийг нь гэртээ авчрахаасаа илүү үүнийг л хийхийг Бурхан биднээс хүсдэг гэж би итгэдэг.

ХҮҮХДҮҮДИЙГ АВРАХ

Тийм ээ, ядууралд цөлмүүлсэн улсын төлөө элэг эмтэрч болох ч, манай улсад ч шат шатандаа анхаарах ёстой тэмцэл зөндөө байна. Тухайлбал, энэ номыг бичиж байхад, маш сонирхолтой нэгэн явдал өрнөв. Америкийн боловсролын системд стратеги бүхий домогт зоригийг хэрэгжүүлэх нь юу болохыг би зэрвэс харсан юм. Би зочны зүгээс оролцсон болохоороо л зэрвэс харсан гэж байгаа юм. Гэтэл боловсролын систем, үйл ажиллагааны манаанд амь амьдралаа зориулж байгаа хүмүүс бий. Хязгаартай төсвөөр эрх тэгш боловсрол олгохын төлөө эцэж цуцахаа мэдэхгүй хөдөлмөрлөдөг багш, боловсролын ажилтнуудын төлөө Бурхандаа талархах минь. Тиймээс л тэдэнд туслах ёстой цаг гэж бий.

Нэгэн хагас, бүтэн сайны орой манай отгон хүү Арден унших гэрийн даалгавраа хийж байлаа. Сагсан бөмбөгийн шалгалтандаа тамирдсан хүү маань надаас: “Ээж ээ, та надад уншаад өг” гэж гуйлаа. Өөрөө унших гэхээр, нүд нь анилдаад байж. Манай хэд том өрөөндөө хөл бөмбөг үзээд шуугиантай байсан болохоор, бид хоёр унтлагын өрөө рүү явлаа.

Би унших зуураа тэр номын агуулгад сэрдхийв. Тэнд өсвөр насны хүүхдийн өөрийгөө егүүтгэх, танхайрах, хань ижил, хүүхдээ хүчирхийлэх, тамлан дарлах, насанд хүрээгүйчүүдийн архидан согтуурал, архидалт, үр хүүхдээ хаях, дэлгүүрээс хулгай хийх зэрэг эсэн бусын юм гарч байлаа. Үүнээс дор юм гэж хаа байхав гэж бодож байтал, нүүр улаймаар сексийн явдал гарч ирэв.

Хүү маань “Маам, би энэ номыг уншмааргүй байна” гэж хэлээд, эргэлээ. Тэгээд үүнээс ч эвгүй үзэгдэлтэй олон хэсэг байсан тухай хэлэв. Гол нь есдүгээр ангийн хүүхдийн уран зохиолын хичээл дээр ийм ном уншуулж байгаа нь ноцтой асуудал байлаа. Би ч маргааш өглөө нь сургууль руу нь утасдаад, Арденд өөр ном унших даалгавар өгөх хүсэлт тавихаар шийдэв. Маргааш өглөө нь багштай нь ярьтал, багш нь ч Арденд өөр ном унших даалгавар өгөх тал дээр зөвшөөрлөө. Утсаа таслахдаа, санасандаа хүрсэндээ баяртай байсан ч, энэ талаар ямар нэг юм хийх ёстой гэсэн бодол өдөржин эргэлдэв. Сургуулийн бодлогын дагуу, ээдрээтэй агуулгатай тэр номыг эцэг,

эхийн зөвшөөрлөөр уншуулах ёстой байжээ. Золоор, би хүүдээ уншиж өгөх явцдаа л агуулгыг нь олж мэдэв. Түүнээс биш, юу ч мэдэлгүй өнгөрөх байж.

Тиймэрхүү агуулгаас ганцхан өөрийнхөө хүүхдийг хамгаалаад өнгөрөх нь зөв үү? Тэр ном сургуулийн хөвгүүдэд порнограф, секс, эцэг эх, архи, хулгай, хүчирхийлэл, амиа хорлох талаар ямар ойлголт суулгах вэ? Үүнийг ойлгосон хэрнээ дуугүй өнгөрөх гэж үү? Бусад хүүхдүүд, ээж, аавуудыг хамгаалах үүрэггүй гэж үү?

Тиймээс би тэр номын агуулгын талаар эцэг, эхчүүдэд сэрэмжлүүлэг болгон, энэ талаар ганцхан би л зовниогүй болохоо сургуульд мэдүүлэх үүднээс блог бичив. Хорин дөрвөн цагаас бага хугацаанд таван зуугаас олон хүн (олонх нь боловсролын ажилтнууд) тухайн номыг эсэргүүцснээ илэрхийлсэн хариу өгөв. Зарим ээж нар яг иймэрхүү юмсаас болж хүүхдээ сургуулиас нь гаргаж, гэрээр сургах болсон тухайгаа хэлжээ.

Би энэ түүхийг бичсэн зохиолчийн эрхийг хөндөөгүй. Харин арван дөрвөн настай хүүхдэд уншихад зохистой эсэхэд л зовнисон. Тэр ном порног суртчилжээ. Секс наймаа порногоос л эхтэй. Эрүүл бус дүр зураг нь залуу хүүхдийн эмэгтэй хүний талаарх үзэл бодлыг хэрхэн сэглэхийг хэн мэдлээ. Порно, гар хангалга хоёр нь арван дөрвөн настай хүүхдэд байх л зүйл мэт хэлжээ. Порно нь золиосны хүнээ (эр, эм хамаагүй) урхидан, захиргаадагч сэтгэлгээг бүтээх хүчтэй. Энэ зөрчил нь ирээдүйн сексийн харилцааг нь эмэгтэйчүүдийг жигших, сэтгэл санааны болоод сексийн төсөөлөл, сексийн донтолт зэрэг нөгөө л сексийн наймааны зам болж өгдөг юмсаар бузарлах боломжтой.

Манай улсын боловсролын систем залуу охид, хөвгүүдийг хатжуулж, чанаржуулах гэсэндээ л зөвшөөрсөн байх л даа. Уг нь тэд энэ зорилгод хүрэхийн тулд үр дүнтэй бодлого баримталдаг ч, тэр ном яагаад ч юм амжаад орчихжээ. Би сургуулийн захиралтай нь уулзах цаг аваад, зарим бодлого нь зөрчигдөөд байгааг мэдүүлэв. Сексийн наймааны асуудалтай улаан нүүрээрээ тулж явсан хүнийхээ хувьд, эмэгтэй хүнийг сексийн эд бараа шиг танилцуулж байгаад сэрдхийж байгаагаа хэлэв.

Тэр номыг долоо хоногийн дотор л сургалтын хөтөлбөрөөс хасав. Сонголтын явцад гаргасан алдаагаа илрүүлж, дахиж ийм алдааг давтахгүйн төлөө өөрчлөлт хийсэндээ, тэд ч баяртай байлаа.

Улсын сургуулиуд хүүхдийг соён гэгээрүүлэхийн төлөө ажиллаж амьдарч яваа хүмүүсээр дүүрэн. Тэд ч бидэнтэй л адил алдаа гаргаж, алдаж шүүдэг. Тиймээс дайрч довтлохын оронд боловсролын үйл ажиллагаанд нь эвсэн нэгдэж, ганцхан өөрийнхөө хүүхдийг хамгаалахын оронд бүх хүүхдийн сайн сайхны төлөө урамшуулбал зөв бус уу?

Намайг зовнилоо илэрхийлэх үед л сургуулийн удирдлага тус номыг 9-ээр ангийнханы уран зохиолын хичээлийн хөтөлбөрт багтсаныг мэдэв.

Золоор хүү маань яг анхных нь жилийн уншигч нарын нэг болж таарчээ. Дохиолол дуугарсан учраас, сургууль ч дэмжиж, олон хүүхэд тиймэрхүү хүчирхийллээр дүүрэн, асуудалтай материал унших зөрчлөөс аврагдав.

Энэ үйл явц дунд би Христчин гэдгээ зарласангүй. Би сургуулийн удирдлага, багш нар руу дайрч давшлаагүй. Би тэдэнтэй өөрсдийнх нь баримталдаг бодлогын дагуу л харилцсан. Асуудлыг авч хэлэлцэхээс гадна би учир шалтгаантай шийдэл санал болгов. Энэ асуудлыг цэгцлэх ажлыг хариуцан гүйцэтгэхэд бэлэн байгаагаа ч мэдүүлэв. Та нар ч бас ингэж чадна.

АНЧЛАХ ЦАГ

Бурхан чи, бид хоёрыг хамт ан хийхийг урьж байна. Түүнийг эрэн хайж, дагаж мөшгихдөө, бид хэрэгтэй цэц ухаан, хариултаа олно. Салалт, сэтгэл санааны хуваагдлаар сэглэгдсэн дэлхий дээр бидэнд нэг нэгнийхээ үр хүүхдийг хамгаалж, сургахын тулд тэнгэрээс амьсгалагдсан нөхөрлөл, стратегийн харилцаа хэрэгтэй. Дэлхий дээрх эрсдэлд орсон хүүхдүүдийг, төөрөгсдийг аврах ажиллагаанд тэнгэрээс амьсгалагдсан стратеги, хариулт шаардлагатайг ухаар. Арал шиг оршдог хүн байхгүй. Бид бүгдээрээ салшгүй. Энэ эрч хүчийн улмаас, чиний үйлдэл надад нөлөөлөх хүчтэй, миний үйлдэл чамд нөлөөлөх хүчтэй. Хамтын ажиллагаатай хүчин зүтгэлээр л бид гэртээ ч, чуулгандаа ч, нийгэмдээ ч түрлэгийг эргүүлж чадна. Бид нийгмийн сүлжээ гэдэг маш том давуу талтай эрин цагт аж төрж байна. Энэ харилцааг сайнаар хэрэглэх эсэх маань биднээс л хамаарна.

Би эрслэнгийн талаарх судалгаагаа эхлүүлэхдээ, муурын төрөл дундаас ганцхан арслангийн бүл л сүргээрээ амьдардаг болохыг мэдэж авсан юм. Нэг арслан нь доройтлоо ч, нөгөө нь хүчтэй байна. Нэг нь бүтэлгүйтлээ ч, нөгөө нь амжилтанд хүрэх бөгөөд энэ бүх хүч нь нэг хүчирхэг арслангийн нөмөр нөөлөг дор бүрэлдэнэ.

Энэ бол ганц баатарлаг муужгааны түүх биш. Хүчирхэг хар ирвэс, ирвэс, цоохор ирвэст ийм дэмжих систем байхгүй. Эдгээр ээж - муужгаанууд хоол хүнсний эрэлд анд гарахдаа, зулзагаа үүрэндээ орхиод явахаас өөр аргагүй байдаг бөгөөд эргэж ирэхдээ үүрээ сүйтгүүлсэн байх нь олонтаа. Нэг баримтат кинон дээр цоохор ирвэс - ээж үүрэндээ эргэж ирээд, хөөрхөн зулзага нь байхгүй болсныг үзээд, орь дуу тавин уйлж байсан юмдаг. Цоохор ирвэс зулзагаа ямар нэгэн гайхамшгаар амьд үлдсэн байх бий хэмээн найдсандаа шөнөжин өрөвдөлтэй нь аргагүй гасалж билээ.

Чи, бид хоёр тусдаа хүмүүс биш ээ. Садан төрөл биш атлаа яс

махны минь тасархай - үр хүүхдийг минь өөрийн юм шиг харж ханддаг хүмүүс байгаа гэдгийг мэдэх нь надад ямар том тайтгарал болдгийг яаж илэрхийлэхээ ч мэдэхгүй байна. Залбирлаараа гэр бүлийг маань Бурханы сэнтийн өмнө өргөж хамгаалдаг хүмүүсээр бид ерөөгдсөн билээ. Тэр бүү хэл, уулзаж учирч яваагүй ч, бидний төлөө залбирч байсныг нь бүр хожим олж мэдэж байх жишээний. Хэзээ ч уулзаж яваагүй “хоригдлууд” Сайн мэдээ сонсож, аврагдахын төлөө олон хүн өгөөмрөөр өргөдөг. Бусдын гэр бүлийг халамжилдаг хүн бүрийг тэнгэр өгөөмрөөр шагнах болтугай.

АМЬСГАЛЫГ НЬ БОО

Эрслэн анчлахдаа ер нь бол идшээ хазаж, урдаггүй. Эрслэн зүгээр л амьсгалыг нь бооно. Үүнтэй адил, бид ч бас дайсныхаа амьсгалыг бооё. Үүний нэг арга нь өөрийнхөө амьсгалыг өгөхгүй байх явдал юм. Гэтэл бид дайсанд дэндүү их боломж олгодог. Бид бие биеийнхээ эсрэг ярихаа болиход л дайсны хүчийг тасална. Бие биеэ муучлахын оронд үгээрээ босгон байгуулж, зэмлэж, засч, урамшуулья.

Ан хийхэд маань надад миний хүчийг ойлгодог, сул талыг маань нөхдөг *эмэгтэйчүүд* хэрэгтэй байдаг шиг, чамд ч бас хэрэгтэй. Ингэхийн тулд би зориуд миний сул тал дээр хүчтэй байдаг эмэгтэйчүүдээр өөрийгөө хүрээлүүлэх сонголт хийдэг. Мөн тэдний сул талыг ч өөрийнхөө хүчээр нөхөхийн төлөө үнэн голоосоо залбирч явдаг. Гишүүн бүр хувь нэмрээ оруулдаг харилцаа л тэнцвэртэй бөгөөд эрүүл байна.

Ганцхан өөрийнхөө үр төлийг л бөөцийлөөд байлгүй, дэлхий дээрх бүх хүүхэд бидний үүрэг болохыг ойлгож, сэрэмжлэх тал дээрээ өсцгөөе. Бид хүүхэд нэг бүрийг гай тогторын замаас зайлуулах болтугай. Дошин дээрээ л том байхад боллоо гэдэг төсөөлөл бидэнд бүү байг. Ийм бодол хол аваачихгүй. Ганц гараараа дэлхийг байлдан дагуулна гэдэг бодол бидэнд бүү байг.

Христийн сайнмэдээнд л зохистой амьдар. Тэгвэл би ирээд, та нарыг харлаа ч эсвэл байхгүй байлаа ч та нарыг сайнмэдээний итгэлийн төлөө нэг сэтгэлээр хамтдаа зүтгэж, нэг сүнс дотор баг зогсоцгоож мөн эсэргүүцэгчдийн юунаас ч айж сүрдэхгүй байгааг чинь би сонсоно. Энэ нь тэдэнд сүйрлийн тэмдэг, харин та нарт Бурханаас ирдэг авралын тэмдэг юм. (Филиппой 1:27-28)

Бид хамтдаа байвал, стратегитай байна.

ЭРСЛЭН ГЭРЭЛД АМЬДАРЧ, ХАРАНХУЙД АНЧИЛДАГ

Буруут нь мөшгөөгүй байхад ч зугтдаг бол
Зөвт нь арслан мэт зоригтой.

СУРГААЛТ ҮГС 28:1

Эрслэнгүүд сайн хийдэг юмаа хэрхэн хийхээ мэддэг бөгөөд өөрийнхөө хүчин чадлыг мэдэхээс (энэ бол домогт эр зориг) гадна тэдний амьдрал харьцангуй энгийн байдаг. Ядрахаараа амарна, өлсөхөөрөө анчилна. Бусад үед нь голдуу алжаалаа тайлна.

Эрслэнг онцын ажилгүй, сэлгүүцэж эсвэл нойрмоглож, зүүрмэглэж хэвтэхийг нь чи хараа л байх. Заримдаа нарны элчийг нөөцлөх нарны хавтан шиг алтан нарны гэрэл дор дээшээ харж хэвтэнэ. Ноолох гүегүүд нь хүртэл амарч буй эрслэн ахайтны амар амгаланг эвдэхгүй. Харин дүрсгүй гүег хэрээс хэтэрсэн тохиолдолд ойрхон байгаа ээж нь зөөлхөн шиг дэлсээд авна. Гэхдээ өдрийн дунджаар хорин цаг шахуу унтаж амардаг эрслэнгүүд тэр бүр стресстээд байхгүй.

Эрслэн амарч дуусаад, сайтар суниагаад, сүргийнхээ тоглолтод нэгдэхдээ, хоёрдагч бэлтгэл байдалдаа буюу өндөржүүлсэн бэлэн байдалд шилжинэ. Гэхдээ өндөржүүлсэн бэлэн байдал дунд ч тэд өндөр төвлөрөхөөс биш, хэзээ ч стресстэхгүй.

Энэ тогтуун атлаа төвлөрөлтэй бэлтгэл байдал нь охид бидний эрслэнгээс сурах ёстой өөр нэгэн амин чухал бүтэц болно. Дараах эшлэл бидэнд тодорхой ухаарал хайрлаж байна.

Буруут нь мөшгөөгүй байхад ч зугтдаг бол

Зөвт нь арслан мэт зоригтой

(Арслангууд мэт амгалан, итгэлтэй, зоригтой). (Сургаалт үгс 28:1)

Харж байна уу - амгалан, итгэлтэй, зоригтой. Хүмүүс ер нь амгалан, итгэлтэй байдлыг эр зоригтой хослуулдаггүй боловч, Бурхан хослуулдаг. Үүнийг эрслэнгээс харж болно. Эрслэнгийн бэлтгэл байдал нь “Би бол би. Би хүчирхэг бөгөөд өндөр ур чадвартай, зугаатай атлаа алж ч чадах, амгалан, төвлөрөлтэй, халамжтай амьтан” гэдгийг л хэлээд байдаг.

Эмэгтэйчүүдтэй л адил эрслэн ч эсрэг тэсрэгийн цуглуулга ажээ. Энэ эшлэл арслангийн тухай өгүүлэх боловч, зарчим нь ялгаагүй бүх хүйст хамаатай. Эр, охин ялгаагүй арслангийн бүл тэр чигээрээ ийм л хандлагатай. Бид ч ийм байвал, яасан юм?

Анчлаагүй үедээ эрслэн сүүдэрт хэрэгтэй, хэрэггүй хөдөлгөөн хийгээд байх шалтгаан байхгүй. Эрслэн гэрэлд л амьдарна. Эрслэн эгч дүүсээ цуглуулаад, Африкийн цэлийсэн талд амьдардаг. Тэд сүүдэргүй тэр газарт амарч, тоглож, гоёж гоодож, сургаж, тэр бүү хэл хээлтэнэ. Эрслэн *яахаараа* ичэж, нуугдах ёстой билээ?

Тэдний ертөнцөд арслангийн бүлийг халз тулаанд дуудчих зүрхтэн, хүчтэн байхгүй. Тэд хэний ч өмнө ухрахгүй (замд таарсан зааны сүрэгт зам тавьж өгөхөөс бусад тохиолдолд). Эрслэнгүүд анд гараагүй үедээ зүсээ нуугаад байх ямар ч шаардлага байхгүй. Арслангийн бүл ямар ч яриагүй нутгийнхаа хаад, хатад нь бөгөөд сүргийнхээ хоол тэжээлийн сүлжээний толгойлогч нар ч мөн.

Халуун өдөр эрслэн сүүдэрт тухалдаг ч, хөнжил дор нуугдахгүй. Эрслэн ирвэс, цоохор ирвэс шиг ганцаараа амьдарч, ганцаараа анчилдаггүй бөгөөд тэдэн шиг модон дээр авирч, бут сөөгний араар нуугдаж чадах ч, ингэх шаардлага эрслэнд байхгүй. Манай эрслэн өдрийн гэрэл гэгээд эгч дүүс, ээж, саднууд, үр төл, зулзагуудтайгаа задгай амарна.

Үүнийг бичиж байхдаа, би яг ингэж амьдармаар байна. Би өдрийн наранд эгч дүүс, охид, саднууд, ээжүүдтэйгээ айдасгүй амраад, үр төлөө харж баясан, эргэн тойронд маань биднийг ялах юу ч байхгүй гэдэг бат мэдлэгтэй сэтгэл хангалуун баймаар байна.

Жон, бид хоёр сафарид хоёр охин, гүегээ дагуулсан эрслэн - ээжийг дагахдаа, энэ эрч хүчийг харсан юм. Сүрэг намрын өндөр өвсөн дундуур зорилгогүй туучих шиг л харагдав. Гэдэс нь цаггалан бөгөөд нүүрэн дээр нь цус наалдсан байхыг би харлаа. Тэд саяхан ан хийж, найрласандаа, нойрмоглон харагдана. Тэртээ алсад хэдэн мод харагдсан тул би сүргийг тийшээ л явах байх гэж бодтол, явсангүй! Тэд шууд л манай машинаас гурав ч хүрэхгүй метрийн зайтай, замын хажуу дээр тэрийснээ, нүүр амаа

долоолоод, алтан нарны өөдөөс шаргал нүдээ анивчсанаа, тавхан минутын дотор унтаад өгөв.

Хажууд нь том жийптэй, буу агссан (мэдээж зөвхөн хүрээлэнгийн ажилчид л буутай байлаа), баахан жуулчид байсаар байтал, эрслэн биднийг хүн ч гэж тоосонгүй. Эрслэнгийн сүрэгт үдээс өмнөх унтлагын цаг нь л чухал.

ГЭРЭЛД АМЬДРАХ

Тэр даруй миний толгойд гэрэлд амьдрах гэдэг нь ямар утгатай болох талаар үй түмэн төсөөлөл, санаа харвав. Нэгнийх нь хувьд, нээлттэй амьдрахыг хэлэх байх. Цонх, хаалга чинь нарны гэрэл, гэр бүл, найз нөхдөө оруулахад бэлэн, байнга дэлгээтэй. Манай гэрийн гал тогоо байнга дэлгээтэй байдаг. Яагаад гэвэл эрчүүд олонтой манай гэрт хэн нэгнийх нь ам заавал хөдөлж байдаг. Гэтэл гэрлээр дүүрэн, нээлттэй зүрх шиг эрүүл мэндэд чухал зүйл үгүй.

Хариуд нь “Та нар ч нээлттэй бай” гэж би хүүхдүүдэд хэлдэгчлэн та нарт хэлж байна. (2Коринт 6:13)

Ийм энгийн, эрх чөлөө хайрласан атлаа заримдаа айдас төрүүлмээр үүрэг байх уу? Амьдралаа нээх хүч нь бидэнд л байх нь. Эхлээд бид нээгдэнэ, дараа нь нээлттэй амьдарна, эцэст нь амьдрал маань өргөжин тэлнэ. Амьдралаа нээж, нээлттэй чигээрээ амьдрах нь давхар үйл ажиллагаа юм. Чи амьдралаа нээсэн ч, нээлттэй чигээрээ амьдрахгүй байж болно. Зарим хүн амьдралын тодорхой талбар, харилцаан дээр өөрийгөө маш их илчилдэг. Гэхдээ тэд нээлттэй чигээрээ амьдраад байвал, өмнө далдалж байсан олон зүйл нь илчлэгдэнэ. Зарим хүн зарим талаа нуун далдлахын тулд зарим талаа илчилдэг.

Гэхдээ Паулын үг толгойд ахин дахин тоглогдох тусам, энэ үүрэг улам л хараад ханашгүй санагдах. Бидний амьдрал - амьд Бурханд ил барих бэлэг мэт. Паулын үг нь дээрээс илчлэгдэж, илгээгдсэн бүхнийг хүлээн авахад нээлттэй амьдралыг дүрсэлжээ. Бүх талаараа сунаж тэлэхэд бэлэн, нээлттэй амьдрал.

Би та нарыг өөрийнхөө ертөнцийн тал бүртэй харилцахдаа, амьдралаа өсч, бэхжиж, өргөжин тэлж байгаа хөдөлгөөнтэй байдлаар төсөөлж байгаасай хэмээн хүснэ.

Урьд нь харанхуй байсан та нар өдгөө Эзэн дотор гэрэл тул гэрлийн хүүхдүүд ёсоор яв. Бүх сайн, зөвт байдал ба үнэнд

гэрлийн үр жимс байна. Ингэхдээ Эзэнд таалагдах юмыг ол.
(Ефес 5:8-10)

Үүнийг сонсож байна уу? Эрслэнтэй адил чи ч бас гэрэлд гарчээ. Чамд айдсын сүүдэр байхгүй. Чиний амьдрал дээгүүр шившигийн сүүдэр бүрхэхгүй. Би энэ уриалга дуудлагад хайртай. Зам нь ч амархан - зүгээр дагаад явахад л болно!

Маш олон хүн дуудлагаа мэдэхийг хүсдэг. Бурханы энгийн байлгадаг зүйлийг төвөгтэй болгохгүй байя. Бурхан биднийг сайныг, зөвийг, үнэнийг үйлдэхэд дуудсан. Нарны гэрэлд өгөгдсөн эдгээр үйлдлийн жагсаалт нь биднийг шившиглэхгүй. Гэрлийн хүүхдүүд бид гэрлийн үйлдэлд дуудагдсан. Бид сүүдэрлэг газар үйлдэгддэг олон үйлдлээс цэвэршсэн. Бид Бурханд юу таатай болохыг ойлгоод, үүнийгээ зүгээр л хийдэг.

Бурханы жавхлантай гэрэл харанхуйг нураасан эгшнээс эхлээд Христ доторх бидний амьдрал цаг үргэлж өргөжиж, цаг үргэлж тэлсээр байна. Тэр цагаас эхлэн цацах болсон сум бүрийг нарны хурц туяа, дулаантай адилтгаж болно.

Цаг агаар сайхан дулаахан байхад би цонхоо дэлгээд, агаар оруулах дуртай. Нэвт салхилах сэвүүн салхи орон гэрээс минь бүгчим агаарыг туугаад, цэнгэг агаараар нэвт шувт хуйлран сэлгэнэ. Онгон байгалийн амтат үнэрийг цацахад, гэр маань байгалийн анхилуун үнэрээр торлогдон амилж, хөдөлгөөнд орж, цээж дүүрэн амьсгалмаар болдог. Шинээр тайрсан өвс, дөнгөж дэлбээлсэн цэцэгс, нарс модны давирхайг чийглэсэн бороо тэргүүтэй, гайхамшигт байгалийн тансаг үнэр хүний ахуй амьдралын ханан дотор хан хийнэ.

Онгон байгалийн эрч хүчийг дотроо оруулах нь эрслэн дээр хамаг анхаарлаа хандуулахын нэгэн шалтгаан билээ. Учир нь эрслэн маань амархан - хэцүү, амралт - эр зориг, зэрлэг - аюулгүйн уулга алдмаар тэнцвэрийг өөрийн биеэр ер бусаар дүрслэн харуулдаг гэлтэй.

Зүдэж зүтгэгсэд хийгээд хүнд ачаа үүрсэн бүгд ээ, Над дээр ир. Би та нарыг амраа. Буулгыг минь өөрсөд дээрээ ав. Надаас сур. Би дөлгөөн, зүрхэндээ даруу. Та нар сэтгэлдээ амралтыг олох болно. Буулга минь аятай, ачаа минь хөнгөн гэв. (Матай 28:28-30)

Шашин дотор өсч бойжсон охид бид Бурхантай вальс эргэж сурах хэрэгтэй. Жон, бид хоёрын хувьд мартагдсан дууль болсон хэмнэл манай дөрвөн хөвгүүнд цаанаасаа л байдаг. Тэд цаанаасаа л хөгжимд чөлөөтэй, эвсэлтэй хөдөлнө. Гэтэл бид хоёр чинь чуулганы гадна зохиогдсон хөгжимд

л хөдөлж сурсан хүмүүс. Энэ маань бид хоёрыг хөдөлгөхөөсөө илүү хөшүүн болгодог. Нигүүлслийн, хүчлэгдээгүй хэмнэл нь сүнсэн дотор минь хийж байгаа Бурханы ер бусын ажилд хариу хандах төрөлхийн ундарга юм.

Бурханы хайртай охин минь, чи Бурханы төлөө ажиллахдаа ядарч байна уу? Бурхантай яаж гар, хөл нийлж амьдрахаа мэдэхгүй байна уу? Заримдаа бид үүнийгээ санах хэрэгтэй. Би ч санах хэрэгтэйгээ мэднэ. Жил хүрэхгүй хугацааны өмнө би яг тасарч унахын даваан дээр ирээд байлаа. Чи ч бас стрессээс болоод хэзээ юугүй шургачиж унах нь уу гэмээр, тийм эгзэгтэй газар байсан байх аа? Яахав, чи байгаагүй байж болох ч, би байсан. Би гурван сарын дараа болох уулзалтандаа зовниж байлаа.

Тэгээд зөрчлөө найзтайгаа хуваалцаад, түүнээс зовнилоо шийдвэрлэх зөвлөгөө авлаа. Найз маань намайг урамшуулаад, өөрийнхөө хувийг авчирбал, алдарт Эзэн маань ургацыг халиуртал үржүүлнэ гэсэн юм. Би амьсгал аван уужраад, Эзэн маань хэний ч тоохгүй шахам, өчүүхэн зүйлийг үржүүлэн дэлгэрүүлснийг саналаа.

Эрх чөлөөтэй бөгөөд хөнгөн амьдарч сурцгаая. Хүмүүс Уналтын дараа ажил, зүтгэл дээр төвлөрсөн бол, Авран сэргэлтийн дараах бид амралтын бэлтгэл байдал авах ёстой.

Мөн дотор нь зогсдог энэхүү нигүүлсэл уруу бид Түүгээр дамжин итгэлээр орох боломжтой болсон бөгөөд бид Бурханы алдрын найдварт баярладаг. (Ром 5:2)

Би энэ нээлттэй урилгад дуртай. Бид хэтэрхий удаан хугацаанд өөрсдөө ч хаалга, цонхоо битүү байлгалаа, хүмүүс ч бидний хаалга, цонхыг битүү байлгалаа. Бурханы хайрт охин минь, амьдралынхаа орцыг нээж, хаах хүч нь ганцхан чамд л байдгийг санаарай. Хил хязгаар чухал хэдий ч, Бурханыг урихад ямар ч аюул үгүй. Бурханд амьдралынхаа үүдийг дэлгээтэй байлгabal, чи Бурханы нигүүлсэл, алдар орших, найдвартай газарт хүрнэ.

Нуугдмал юм байгаа бол зөвхөн илчлэгдэхийн тулд юм. Нууц юм байгаа бол зөвхөн илрүүлэгдэхийн тулд юм. (Матай 4:22)

Энэ тал дээр чи “дотор нь байгаа хүн” шүү. Чамаас далдлагдсан Бурханы сайны нууц гэж байхгүй. Бурхан чамайг мөнхийн хайраараа хайрласан бөгөөд дүүрэн хайр энэрлээрээ чамайг урьдаг. Бурхан нууцаа илчилдэг шиг, чи ч бас нууцаа илчлэх аюулгүй. Чиний дээгүүр савсах далд нүгэл, шившиг, дүрэм гэж байхгүйг мэдэх шиг эрх чөлөө үгүй. Бурхан чиний далдын хар нууц, зөрчлийг мэддэг хэрнээ л чамд хайртайгаа ил тод мэдэгдсээр байдаг.

Хариуд нь ч чамаас хайр хүснэ. Бурхан Аав бол хайр, Түүний цорын ганц Хүү Есүс биднийг Аавтайгаа эвлэрүүлэх гэж алуулсан болохоор, үүнийг ярихгүй байхын аргагүй. Сайн мэдээ нууц биш. Бурханы хайрын мессеж нь биднийг гайхшруулдаг тэр нууц болой.

Бид чинь хэн болоод, Тэнгэрийн Аавынхаа санаа сэтгэлийг татаж, Түүнээс ийм ер бусын бэлэг хүлээж авна вэ? Тэрбээр бидэнд хайрынхаа төлөвлөгөөг илчлээд, өөрсдөө ч чөлөөтэй хүлээн авч, бусадтай ч чөлөөтэй хуваалцахыг хүссэн. Хүн бүр Бурханы хайрыг сонсох эрхтэй.

Биднийг цэлгэр гэрэлд урьсан Бурханы урилгыг уншиж байхдаа чи, амьдралд чинь цоожтой тал байсаар байгааг ухаарсан байж магадгүй. Айдас, хар ичгүүрийн, хашаатай газар байж болох. Магадгүй нээхээс айж байгаа хаалга юмуу цонх байж болох. Би ойлгож байна аа.

Гэр бүлүүд хамтдаа аялахдаа, голдуу холбоотой хоёр өрөө захиалдаг. Өрөөнүүд нь тус тусдаа боловч, давхар хаалгаар холбогдоно. Чөлөөтэй нэвтэрч болох ч, хоёр хаалга хоёулаа нээгдэхээс нааш наашаа цаашаа нэвтэрч болохгүй. Жон, бид хоёр ер нь хаалгаа шууд нээдэг боловч, хөвгүүд маань ачаа тээшээ суллаж, хувцсаа сольсон хойноо л хаалгаа нээнэ. Хоёр хаалга хоёулаа нээгдсэн бол, бид хөвгүүдийнхээ өрөө рүү, хөвгүүд маань манай өрөө рүү нэвтрэх боломжтой болно. Тэгээд бүгдээрээ бие биеийнхээ өрөөнд чөлөөтэй орж гарна.

Бурханы хайртай охин минь, хаалгаа нээ. Нөгөө талд нь гэр бүлийнхэн чинь бөөнөөрөө хүлээж буй, цэлийсэн сайхан өрөө бий. Юунаас ч битгий ай. Бурхан чамд хаалга хаагаагүй. Эсвэл нээлттэй байсан хаалгаа нүүрэн дээр чинь тас хаахгүй. Түүний хаалга нээлттэй. Зүгээр л өөрийнхөө талын хаалгыг нээ.

Би чамайг өвчин эмгэгтэй талаа Бурханд нээж өгөхийг уриалж байна. Сүүдрийнхээ шавхруу, толбо бүрийг Бурханы амь, гэрлээр үлдэн хөө.

Сэтгэлийн дайсан биднийг сүүдэрт л байлгахыг хүснэ. Харанхуй нь бүхнийг ээдрээтэй болгож, гэрэл дор тодорхой, энгийн харагддаг зүйлийг эргэлзээтэй болгодог. Бурхан маань биднийг гэрэлд амьдруулахыг хүсэхээр барахгүй, гэрэл мэт амьдруулахыг хүсдэг. Чи яг одооноос нуруу тэнэгэр амьдарч чадна. Залбирлын хүч, сайхан нь үүнд л оршино.

Би чамд зориулж, хаалгаа тайлж, нээхэд чинь тус болох үгийг бичлээ. Гэхдээ зүрхээ л дагаж залбираарай:

Тэнгэрийн Аав минь ээ,

Би Тан дээр Есүсийн нэрээр ирж байна. Нуугдсанд минь уучлаарай. Би гэрэлд гармаар байна. Би хаалттай хаалга бүрийг

дэлгэж, Таны хайрын гэрэл, сайн сайхан руу нэвтэрч орно. Би уучлагдах эрхээ хүлээн авч, үнэн дотор алхахыг сонгоно. Яагаад гэвэл энэ л намайг эрх чөлөө дотор байгуулна. Би Таных. Би Таны хайранд даатгуулж, Таны замыг дагана. Өмнөх замыг маань гэрэлтүүлээч. Амень.

ШӨНИЙН ХАРАА

Тэгэхээр, гэрлийн охин минь, би чамтай эрслэнгийн талаар сурсан өөр нэгэн чанарыг хуваалцах гэж тэсч ядаж байна. Эрслэн гэрэлд амьдарч, харанхуйд анчилдгийг бид мэддэг болсон. Гэхдээ тэд харанхуйд хэрхэн анчилдаг юм бол? Нарийн мэдрэмж, үнэр, сонсголдоо байна уу? Үгүй юм.

Үнэндээ, эрслэн эгч дүүс маань *харанхуйд хардаг байх нь*.

Хэрхэн?

Эрслэн болоод муурын бүлийн бусад гишүүд гэрлийг хүлээн авч, хугалж, тусгах онцгой чадвартай байдаг ажээ. Орчин тойрондоо байгаа ямар ч гэрлийг хараа болгон хөрвүүлж чаддаг ажээ. Тас харанхуйд эрслэн чи, бид хоёр шиг л сохор байна. Харин тэр харанхуйд өчүүхэн гэрэл ёлтойх төдийд л эрслэн хүлээж аваад, шөнийн дуран болгочихдог байх нь. Сарны туяа, алс ёлтогнох гэрэл ч эрслэнгийн шөнийн хараа болж чадна.

Нүдэнд нь гэрэл нэвтрүүлдэг хүүхэн хараа нь хүн биднийхээс тэс өөр. Энэ нь эрслэнд бусдын харж чадахгүй юмс дээр хараагаа төвлөрүүлэх чадвар өгдөг. Тодруулбал, тэдний дуран болж өгдөг хараа нь гадаад орчноос биш, өөрсдийнх нь нүднээс гардаг ажээ. Тиймээс л муурын нүд заримдаа харанхуйд гэрэлтээд байдаг юмсанж. Тэд олдсон гэрэл бүрээ нөөцөлж, тусгадаг байна.

Тэгвэл бид яаж хоцрох билээ? Дэлхийн харанхуйлал ихсэх тусам, бидэнд гадаад орчноос олодох гэрэл улам л багасна. Энэ бол бидний дотоод гэрлээ хөгжүүлж, тэр гэрэл дээрээ төвлөрөх цаг.

Хэрэв би “Харанхуй үнэхээр намайг нөмөрнө.

Намайг хүрээлэгч гэрэл нь шөнө” гэвэл

Харанхуй ч Танд харанхуй биш бөгөөд

Шөнө ч өдөр мэт гэрэлтэнэ.

Гэрэл харанхуй адил юм. (Дуулал 139:11-12)

Эрслэнгийн шөнөөр харах энэ чадварыг эзэмших ёстой цаг гэж байдаг бол, тэр цаг нь өнөөдөр юм. Дийлэнх маань өдөр хардаг бол, би та нарт харанхуйд ч харах чадвараа хөгжүүлэхийг уриалж байна. Эрслэнгүүд

нүдэн доторх гэрлээрээ хардаг. Дотроосоо гэрэлтэх юм бол, бид гадаад харанхуйд захирагдахгүй. Энэ маань бидэнд Бурханы дайтай илүү өргөн, илүү холын, сайжруулсан хараа өгнө.

Бурхан гэрэл. Түүнд харанхуй байхгүй. Дотор маань энэ тунхагийг намируулах орон зай байна уу? Гэрэл байгаа газар хараа байна. Хараа байгаа газар найдвар, харааны эдгэрэл байна. Хараа байгаа газарт илчлэл байна.

Миний захидлаар хүлээж авсан хамгийн анхны эшлэл маань Ефес 1-ээр бүлгээс үүсэлтэй:

Бидний Эзэн Есүс Христийн Бурхан, алдрын Эцэг нь та нарт мэргэн ухаан хийгээд илчлэлийн сүнсийг өгч, Өөрийгөө бүрэн мэдүүлж зурхний чинь мэлмийг гийгүүлээсэй! (17-18)

Энэ эшлэл миний өдөр тутмын залбирал болсон. Би шөнө бүр нүдээ аниад, зүүдэндээ Бурханыг урихдаа, үүнийг шивнэж хэлдэг. Харин өдрийн цагаар Бичээсийг уншихаасаа өмнө хэлсэн амлалтыг нь амьсгалж хэлнэ. Би тэнгэрийг газар дээр бий болгохын хүчин чадалд нүд тайлагдахын ер бусын гайхамшигт олзлуулдаг байлаа.

Чи юутай зууралдана - түүн шигээ л болно. Чи харж байгаа зүйлдээ л хариу илэрхийлнэ. Бид Бурханы хязгаар үгүй гайхамшигийг харах нүдгүй болсон хэмээн эмээх. *Бурхан минь, харах нүд өгөөч.*

Энэ хүсэлт эш үзүүлэлд хүүхэд мэт, цайлганаар хандах ёстойг маань илэрхийлнэ. Энэ хүсэлт Елигийн Самуелд хэлсэн заавраас цуурайтаж байна.

Яв, хэвтэж амар. Хэрэв Тэр чамайг дуудвал чи “ЭЗЭН минь, айлдаж хайрла. Боол тань сонсож байна” гэж хариул. (1Самуел 3:9)

Бурхан бяцхан Самуелыг амарч байхад нь дуудан сэрээжээ. Бид ч түүний “Эзэн минь, айлдаж хайрла. Боол тань сонсож байна” гэсэн хариут тусгах ёстой.

Самуел Бурханыг уриад, үгийг нь дуулах хүртлээ өөрийг нь нэрээр нь дуудсан Бурханыг мэдэхээс биш, Бурханы нэрээр ярьж үзээгүй байв.

Хэд маань биднийг нэрээр маань дууддаг Бурханыг мэддэг билээ? Би үүнийг үл тоосондоо хэлж байгаа юм биш, харин энэ бол дөнгөж эхлэл болохыг л хэлж байна. Бүгдээрээ цаашаа *илүү шунацгаая*. Бурханы зөвлөгөөнд шунаж, Түүнтэй ажиллахад шунаж, Түүний үгийг дуулцгаая.

—Харагтун! Би Израильд нэгэн зүйлийг үйлдэх ба үүнийг сонссон бүхний хоёр чих нь хангинах болно. (1Самуел 3:11)

Бурхан одоо ч бидэнд “Охид оо, анхааралтай сонс. Би дэлхий дээр хамаг бүхнийг доргиож, даян дэлхийн анхаарлыг татах нэгэн зүйлийг үйлдэнэ” хэмээн айлдаж байгаа гэдэгт эргэлзэх юм алга.

Самуелын өдрүүдэд Эзэн барагтай юм айлддаггүй, Бурханы хүмүүсийн мөргөлийн өргөл, хүндэтгэл ч үнэ хүндэтгэлгүй болоод байв. Бэлгийн гэм нүгэл эрээ цээрээ алдаад байв... сүм дотор шүү! Удирдагч нь өөрөө хөвгүүдийнхөө зөрчлөөс ашиг хүртэж байсандаа, хөвгүүдээ байр сууриас нь буулгасангүй.

Хариуд нь Бурхан Елигийн гэрээс нүүр буруулж, итгэл даах, ариун хөвгүүнийг гаргаж иржээ. Манай цаг ч үүнээс нэг их ялгарах юмгүй байгаа бөгөөд Бурханы хүүхдүүд амьд бөгөөд сэрүүн байна.

Балчир хөвгүүн Самуел улам өсөж торнин, ЭЗЭНий бас хүмүүсийн тааллыг олов. (1Самуел 2:26)

Би *яг ийм амьд*, Бурханаар ерөөгдсөн, хүмүүсийн тааллыг олсон залуусыг хардаг. Тэдний амьдралаас тэнгэрийн мутар харагддаг бөгөөд Бурхан тэднийг бидэнтэй мөр зэрэгцүүлж, хамтран ажиллуулахыг хүсдэг.

Үүний тулд Бурханы хийж буй юмсыг харах эш үзүүлийн сэргэг нүдтэй байж, үгийг нь сонсох чихтэй байж, Бурханы Үгийг хүний зүрхэн дэхь бул чулуунуудыг бутлан зайлуултал нь амьд бөгөөд хүчтэй тунхаглах ёстой.

Энэ ухаарлаар, би одоо бичих хуудсаа эш үзүүлийн өнцгөөс бичмээр байна. Би чамайг аль алийг нь хүсэн хүлээж, Бурханы амьсгалах гайхамшгийг дотроо хүлээж авахад бэлэн байгаасай гэж хүсч байна. Зарим бичээс, дүр дүрс, хэсгийг унших үед дотор чинь Бурханы бэлэг доргиж, бадарч болзошгүй шүү.

Ариун Сүнс чиний амьдралын хэвлийг сунгаж, сонсох, харах, ойлгох хүчин чадлыг чинь өсгөнө.

Намайг нэг удаа номлосны дараа Бурханы хүчирхэг тосолгоотой, нэгэн сайхан охин хүрч ирээд, “Таныг номлох тоолонд, хэвлий дэхь үр минь догдлох юм” гэж хэлж билээ.

Тэр бүсгүй бие давхар байсангүй. Тэрбээр дотор нь Бурханы хөдөлгөж байгаа нэгэн зүйлийг тийнхүү дүрсэлжээ.

Бурхан учир зүйн таамаглалаас бий болсон ургаа таамаг биш. Бурхан гэрэл шиг л шууд мэдэгддэг, нотолгоотой. Бурхан - харанхуйд учир зүйн гэрлээр хайдаг зүйл биш. Бурхан бол гэрэл..

— Абрахам Иошуа Хешел

Чи ч бас ийм сэгсрээг мэдэрч байсан л байх. Гэхдээ хариуд нь магадгүй одоо хүртэл *Би зөнч, эш үзүүлэгч биш! Би чинь хүүхдээ хардаг ээж, өсвөр насны охин, бизнес эмэгтэй юмуу эмээ* хэмээн маргаж байж болох. Эш үзүүлэгч гэдэг үг чамд ясандаа галтай Иеремиаг юмуу загасны гэдсэнд буй Ионаг л санагдуулдаг байх.

Тэгэхээр, мэдээж чи тэднээс өөр амьдралтай гэдэг нь тодорхой. Чи эш үзүүлэгч биш байж болох. Гэхдээ энэ нь чи эш үзүүлэгчийн бэлэггүй гэсэн үг биш.

Эш үзүүлэгчийн бэлэгтэй байна гэдэг нь урьдчилж мэдэх стратегийн хүчин чадал бүхий алсын хараатай ч, холын хараатай ч байх явдал юм. Тэр байтугай, бидний залбирал ч эш үзүүллийн чанартай байдаг. Бид Бурхан сонсож байгаа учраас хариулж, бидний урьд өмнө үзэж хараагүй аугаа зүйлсийг үйлдэнэ гэдгийг нь мэдсэндээ л залбирдаг. Бид хүсэн хүлээлтээр алсыг харж, залбирдаг.

Есүсийг газар дээр амьдарч байхад, Фарисайчууд нүдгүй байсан. Есүсийн амьдрал, үг тэдний таг сохор байдалтай байнга мөргөлдөж, хилэнг нь бадраадаг байв. Иохан 5 дээр ч Есүс тэднийг дахиад л уурлуулсан. Энэ удаа тэд Есүсийг Шаббат өдөр буюу хагас сайн өдөр хүн эдгээлээ гэж уурласан. Есүс тэдний Шаббатын хуулийг нь зөрчихсөн гэнэ. Гэхдээ Есүсийн үйлдэл хүмүүстээ Шаббатыг хүндэтгэж, санаж, сахихыг заасан Бурханы тушаал дотроо л байсныг санах хэрэгтэй.

Доголон хүнийг эдгээхээс илүү ариун зүйл байх уу? Гэтэл тэр хүмүүс юу ч хийхгүй байх нь илүү ариун бөгөөд эдгээх ёстой юм бол, өөр өдөр эдгээх ёстой гэж үзжээ. Дүрэм, журамдаа сохорсон тэд бүдэрчээ.

—Эцэг минь одоо болтол ажилласаар байна. Би ч ажиллаж байна гэж айлдав. Үүнээс болж иудейчүүд Түүнийг алахыг улам санаархах болжээ. Учир нь Есүс Амралтын өдрийг зөрчсөн төдийгүй мөн Бурханыг Эцэгээ хэмээн Өөрийгөө Бурхантай адилтгасан юм. Есүс тэдэнд —Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Эцэгээс хийж харуулсныг нь л Хүү хийхээс Хүү юуг ч Өөрөөсөө хийдэггүй. Учир нь Эцэг юу хийнэ, Хүү нь бас эдгээрийг түүнчлэн хийдэг. *Эцэг Хүүгээ хайрладаг бөгөөд Тэр хийж байгаа бүхнээ Түүнд үзүүлдэг. Та нарыг гайхуулахын тулд тэдгээрээс ч агуу ажлуудыг Тэр Түүнд үзүүлнэ.* (Иохан 5:17-20)

Шаббатын гол утга учир нь ажил хийх, хийхгүйдээ биш, харин Бурханы дотор амрах явдал юм. Есүсийн шууд үг бидэнд асуулт төрүүлж байна.

Нэгдүгээрт - Чи Бурханы охин мөн үү?

Чи Бурханы хийж байгаа үйлсийг харж байна уу?

Чи тэр үйлс дотор баймаар байна уу?

Чи гэрэл тээгч баймаар байна уу эсвэл харанхуй руу заагч баймаар байна уу?

Чи Христэд итгэх итгэлийн амьдралыг бие дааж байгуулах гэж байна уу?

Чи цөхөрсөн, төөрсөн, үхэж байгаа, шархтай дэлхийд Бурханы гайхамшгийг хүргэмээр байна уу?

Есүс хэзээ ч хачин байгаагүй. Харин очсон газар бүрийдээ Бурханы гайхамшгийг хүргэж байсан. Бурханы Хүү Есүс хүртэл дураараа юу ч хийж чадаагүй бол, бид Ариун Сүнсний гэгээрэлгүйгээр юу хийж чадахав. Бид Есүс шиг л явах ёстой. Бурхан бидэнд тусална гэж амласан. Үүнийг Үйлс 2 дээр тодосгосон.

“Бурхан айлдахдаа
«Эцсийн өдрүүдэд Би Сүнсээ
Бүх махбод дээр цутгана.
Хөвгүүд, охид чинь эш үзүүлж,
Залуус чинь үзэгдэл үзэн,
Хөгшчүүл чинь зүүд зүүдлэх болно.
Эр, эм гэлгүй боолуудынхаа дээр
Тэр өдрүүдэд Би Сүнсээ цутгана.
Тэд эш үзүүлэх болно.
Би дээр тэнгэрт совин ёр
Доор газарт тэмдгүүдийг өгнө.
Энэ нь цус, гал,
суунаглах утаа билээ.
Эзэний агуу, цог жавхлант
өдөр ирэхийн өмнө
Нар харанхуйлж,
сар цус мэт болно.
Эзэний нэрийг дууддаг бүхэн
аврагдах болно» хэмээв”
гэснээр болжээ. (Үйлс 2:17-21)

Сүүлчийн өдрүүдэд Салхин Үгсийг бидэнд амлажээ. Бурхан яах гэж биднийг сонгосон юм бол хэмээн эхэндээ үнэхээр гайхмаар байдаг шүү. Даян дэлхийгээр аялж, эргэн тойрноо харж явахад, “Би л Бурхан байсан бол, өнөөдрийнх шиг ийм хүмүүс дээр Сүнсээ яасан ч цутгахгүй. Ийм аймаар бохир, заваан биш, хамаагүй сайхан, цэвэрхэн, аюулгүй үеийг

сонгох байсан” гэж бодогдох.

Христэд итгэдэг хүмүүсийг хядаж эхлэхийн яг өмнөх үеийг буюу МЭ 50 оныг л шилж сонгох байсан. Гэхдээ тэгсэн бол, бид яах байсан бол? Эсвэл чи магадгүй “Надад Сүнсний цутгал хэрэггүй, би хүсэхгүй байна” гэж бодож байгаа байх. Гэхдээ миний юу хэлэх, чиний юу хүсэх тийм чухал уу? “Сүүлчийн өдрүүдэд” Бурхан “Би Сүнсээ бүх төрлийн хүн дээр цутгана” гэж хэлсэн.

Эцсийн дүнд бидэнд хүмүүс нь ч байна, Бурханы Үг ч байна. Үүнийг хэлсэн болохоор, энэ юу гэсэн үг вэ? Сүнсний цутгал гэж юу вэ? Тэгэхээр, Сүнсний цутгалыг илүү ухах үзье.

Хоёр мянган жилийн тэртээ Ариун Сүнс Есүсийг илчилж, хол, ойрын итгэгчдийн зүрхийг шинэчлэхээр дэлхий дээр цутгагдсан. Тиймээс бидэнд Есүсийн бие болох чуулганы дотор ажиллаж буй Ариун Сүнс байгаа байх нь. Гэхдээ миний хувьд, өнөөдөр бидэнд байгаа зүйлийг Ариун Сүнсний цутгал гэхэд хэцүү л байна.

Тэгвэл цутгал ямар байх бол?

Үүнийг олж мэдэхийн тулд бид эхлээд сүнс гэдэг үгийн утгыг мэдэх хэрэгтэй. Сүнс гэдэг нь дөрвөн онцгой утгатай. Эхнийх нь “хүч”. Энэ тодорхойлолт дор *урам, зан чанар, хүсэл, хүч, сэтгэлийн хүч хат, ёс суртахууны эд эс, цэц ухаан, шийдэмгий зан, билэг танхай, зүрх, араншин* гэдэг үгс багтана. Урам зориг болоод биеийн хүч болон цутгагдсан Сүнсний жишээ болбоос:

ЭЗЭНий Сүнс түүний дээр хүчтэйгээр бууж ирсэнд тэрээр гартаа барьсан юу ч үгүй атлаа ишгийг тасчих мэт арсланг хүү татав.
Харин тэр үйлдсэн хэргээ эцэг эхдээ ярьсангүй. (Шүүгчид 14:6)

Тэгэхээр, энэ тагтаа шиг бууж ирсэн Сүнсний дүр зурагтай адилгүй, ноцтой жишээ байна.

Сүнсний цэц ухаан, ёс суртахууны хүч хатын жишээ болбоос:

ЭЗЭНий Сүнс, Мэргэн ухааны ба ухаарлын сүнс, Зөвлөгөөний ба хүч чадлын сүнс, Мэдлэгийн хийгээд ЭЗЭНээс эмээхүйн сүнс Түүн дээр оршино. (Исаиа 11:2)

Мөн:

Бурхан, миний дотор цэвэр зүрхийг бүтээж, Миний дотор зөв сүнснийг шинэчлэн авчраач. (Дуулал 51:10)

Бас Ариун Сүнс чадвар бөгөөд ур чадвар болон цутгагдсан жишээ ч байна:

Би түүнийг мэргэн ухаан, ойлголт, мэдлэг, бүх талын ур чадварт Бурханы Сүнсээр дүүргэсэн нь... (Гэтлэл 31:3)

Эцэст нь Сүнсийг зүрх хэмээн танилцуулжээ:

Би тэдэнд ганц зүрхийг өгч, тэдний дотор шинэ сүнсийг тавина. Махбодоос нь чулуун зүрхийг авч, тэдэнд махан зүрхийг Би өгөх нь... (Езекиел 11:19)

Тэгтэл бас *сүнсний* хоёр дахь тодорхойлолт байх бөгөөд энэ нь сэтгэл гэдэг үгийн дор оршино. Энэ сэдвийн дор *дотоод хүн, амин хүч, амин үндэс* гэдэг үгс багтана.

Хүмүүний сүнс өвчнөө тэсвэрлэх авч Хэн цөхөрсөн сүнсийг тэнхрүүлэх вэ? (Сургаалт үгс 18:14)

Зүрх хөгжилтэй бол царай тунгалаг. *Зүрх шаналахад сүнс зовууртай.* (Сургаалт үгс 15:13)

Сүнсний гурав дахь тодорхойлолт нь “хий үзэгдэл, хий юм, сүнс - үзэгдэл, цус сорогч” гэх зэрэг утга илэрхийлнэ. (Энэ талаар лавшруулж судлах хэрэгцээ байхгүй гэдэгт би итгэл төгс байна.)

Тэгээд эцэст нь сүнсийг “ерөнхий мэдрэмж, хандлага, ааш байдал, чиг хандлага, уур амьсгал” гэх утгаар тодорхойлно. Жишээ нь: Эндэхийн уур амьсгал, сүнсний байдал нааштай сайхан, таатай байна гэж ярьдаг даа. Энд сүнс сүлдний юмуу тагтааны талаар яриагүй, харин уур амьсгал, хүлээлтийн талаар ярьж байгаа нь тэр. Сүнс цутгахын өмнө, дээд өрөөнд бүх хүн нэг газарт, нэг хэмнэлээр хөдөлж, Бурханы хийх үйлсийг урин залахад, тэнд хүндэтгэсэн уур амьсгал, хандлагын тогтоц, сүнсний байдал ноёлсон байх.

Эзэн бол Сүнс. Эзэний Сүнс хаана байна, тэнд эрх чөлөө байдаг. (2Коринт 3:17)

Тэгэхээр, энд Сүнс Бурханаас хүлээн авах эрх чөлөөний уур амьсгалыг бүрэлдүүлж байна.

Намайг *сүнсийг* хэлний бэлэг мэтээр тодорхойлоогүй байгааг чи анзаарсан байх. Хэл нь Ариун Сүнсний оршихуйн нэг үндсэн илэрхийлэл, нотолгоо боловч, Ариун Сүнсний бүрэн илэрхийлэл *биш* юм.

Ариун Сүнс дээрх олон аргаар илэрхийлэгдэх нь Библиэр нэг бий. Сүнс Самсоныг Филистинчүүдийн сүмийг буулгасан, ер бусын хүчээр хүчжүүлсэн. Елиа хааныхаа сүйх тэргийг ч гүйцэж түрүүлэх хурдтай байсан. Бурханы урам зориг Гидеон дээр буух үед тэрбээр зэвсэггүй атлаа дайсны цэргүүдийг бут цохисон. Бурханы Сүнсээр говийн ганц бүсгүй Дебора Израилийн дайсны өөдөөс хүчийг босгож ирж чадсан. Сүнсний хүчээр Есүс явсан газар бүрийдээ, уулзсан хүн бүрийдээ Бурханы зан чанарыг харуулсан.

Тэгээд бас бид байна. Өнөөдөр хүмүүс айсандаа зүрх үхэж, бүтэлгүйтэхийг Библи хэлдэг. Энэ сульдаагч айдсыг хэрхэн ялах вэ? Магадгүй Бурханы урам зоригийн цутгал л шийдэл авчрах байх.

Бид эш үзүүлэл сэргэх улиралд аж төрж байгаа учраас, зарим хүн магадгүй агаар мандал дээр байгаа зүйлийг хараад байгаа атлаа дотроо ургуулан бодсон, дарлагдсан мэдрэмжээ л ахин дахин давтан, үглэсээр байж болох. Зарим чинь амьдралдаа жаахан хачин юмуу эсвэл бүр шал буруу гэмээр эш үзүүллийн хөдөлгөөнтэй тулгарч байсан ч байж болох.

Тэгэхээр, шууд л хэлье. Бурхан зүгээр нэг эш үзүүлэгч гэдэг зэрэг зиндаа, албан тушаалтай бүлэг хүмүүсийг хүсдэггүй. Бурхан хүмүүсийн зүрхийг хүсдэг. Бид төрсөн он цагийнхаа чанарын нөлөөгөөр л эш үзүүллийн чанартай болдог. Семинарт суусан учраас бус, харин Самуелтай адил Бурхантай уулзаж учирсан учраас тэр. Асуудал нь семинартаа байгаа юм биш. Зүгээр л эш үзүүлэл нь семинараас хавьгүй том зүйл юм.

Бурхан хэзээ ч тусдаа, тусгай, хязгаарлагдмал байдлыг хүсдэггүй. Бурхан бүтээл, эш үзүүллийн хараа, сонсгол нь бидний харах нүд, сонсох чих, ярих ам, ойлгох зүрхийг нээгээсэй л гэж хүсдэг.

Эш үзүүллийг хэт хялбаршуулах эрсдлээ үүрээд, өөрийнхөө хамгийн хайртай эш үзүүлэгч Исаиаг судлаж байхдаа сурсан хэдэн удирдамжийг хэлээд тавьчих уу. Энэ эш үзүүлэл бүхий амьтай бичээсээс бид дараах зүйлсийг сурна:

Тийнхүү Тэрээр бидэнд замаа зааж, бид жимээр нь алхах юм.
(Исаиа 2:3)

Гоё байгаа биз: Биднийг бүтээгдсэн арга замаар маань амьдруулахын тулд Бурхан бидэнд ажилладаг арга замаа мэдүүлжээ. Бид Бурхантайгаа хөрвөж амьдрахын тулд бүтээгджээ. Бурхан бидэнд арга зам, үйлсээ мэдүүлэхийг хүсдэг. Энэ ойлголтыг барин, Ром 9-ээр бүлэг дээр Паулын

давтсан Исаиа 49-ээр бүлгээс алсын хараа бүхий, зарим нэг үндсэн удирдамжийг олж мэдсэнээ толилуулъя.

1. Өөдөө хар.
2. Эргэн тойрноо хар.
3. Сайтар хар.
4. Урагшаа хар.
5. Үнэнийг ярь.

Нэгдүгээрт - *өөдөө хар*. Тэнгэр өөд яаж харахаа мэдэхгүй байвал, тэнгэрийн үзлийг олж авахын тулд Илчлэл номыг үзэхэд л болно. Энэ ном - дэлхийн төгсгөлийн талаарх аймшгийн зөгнөлт зохиол биш шүү. Энэ бол болсон, болж байгаа, болох юмсын илчлэлийн цомог. Бурхан цаг хугацаанаас ангид, цагийг эзэлсэн Нэгэн бөгөөд тэр л байр сууриасаа айлдах нь олонтаа. Би коллежид байхдаа, Илчлэл номыг бүтэн семестр уншсан бөгөөд энэ номыг цаг хугацааны болзлоор тайлах гэж оролдож байгаа хүмүүсийг хараад одоо ч гайхдаг юм. Тэр байтугай энэ бүхнийг бичиж буулгасан Иохан ч өөрөө ойлгосон нь юу л бол. Заримдаа юмыг нэг бүрчлэн мэдэхгүй, зүгээр л тайзны ард бидний төсөөлөлд ч багтахгүй, нүсэр кино өрнөж байгаа гэдэгт итгэхэд л болно.

Бид өөдөө харах хэрэгтэй. Есүс Бурханы дүрээ тайлаад, Хүний Хүүгийнхээ дүрээр Галил нуурын эргээр алхалж, номнож, нөхөрлөж байсан тухай бид номносоор байна. Тэгвэл Есүс Иоханд Өөрийнхөө ямар дүрийг илчилсэн бэ? Чаддаг юм бол, төсөөлөөд үз:

Урт дээл өмсөж, цээжээрээ алтан бүс бүсэлсэн Хүний Хүү лугаа адил Нэгэн дэнгүүдийн дунд байлаа. Түүний толгой ба үс нь цагаан ноос буюу цас адил цагаан агаад нүд нь галын дөл адил, хөл нь зууханд улайсгаж өнгөлсөн хүрэл адил, дуу хоолой нь их усны шуугиан мэт байлаа. Тэр баруун мутартаа долоон од барьж, хоёр талдаа иртэй хурц илд амнаас нь цухуйх бөгөөд нүүр нь хурцаар гэрэлтэх нар мэт байв. Би Түүнийг хармагц хөлд нь, үхсэн мэт уналаа. Баруун мутраа над дээр Тэр тавиад —Бүү ай. Эхэн ба эцэс нь Би бөгөөд амьд Нэгэн мөн. Би үхсэн байсан. Гэвч харагтун! Би үеийн үед амьд бөгөөд Надад үхлийн ба Үхэгсдийн орны түлхүүр бий. Тиймээс чи юу харснаа, юу байгааг болон эдгээрийн дараа юу тохиолдохыг бичигтүн. (Илчлэл 1:13-19)

Бүгдээрээ бодитой хандацгаая л даа. Иохан магадгүй 12 дундаасаа хамгийн тогтвортой нь байсан байх. Магадгүй бүр Есүсийн хамгийн эрх танхи дагалдагч ч байсан байж болох. Яагаад гэвэл Сүүлчийн зоог дээр Есүст наалдаж суусан гэдэг. Иохан Есүсийг Бурханы Хүүгийнхээ дүрээр

суугааг нь хараад, хөлд нь үхэнгээ алдан унасан! Хурга тэвэрсэн, загас шарсан Есүсээс арай л өөр байна уу, үгүй юу. Өндөр Бурханы Хүүг од атгасан, хуяглагдсан, сүр жавхлантай дайчин хаан хэмээн дүрсэлжээ. Есүсийн энэ дошгин илчлэлийг номлоод эхэлбэл, яах уу? Илчлэл номын эхлэлийг хар л даа.

Удахгүй болох ёстой юмсыг боолууддаа үзүүлэхийн тулд Бурханаас Түүнд өгсөн, Есүс Христийн илчлэл. Тэнгэрэлчээ Тэрээр илгээж, боол Иохандаа үүнийг мэдүүлсэнд тэрбээр Бурханы үг болон Есүс Христийн гэрчлэлийг мөн үзсэн бүхнээ гэрчилсэн болой. Энэхүү эш үзүүллэгийн үгсийг уншигч ба сонсогч мөн үүнд бичигдсэнийг сахигчид нь ерөөлтэй еэ! Учир нь цаг ойрхон байна. (Илчлэл 1:1-3)

Илчлэл ном нь нэн тэргүүнд Есүсийг илчилсэн ном болой. Энэ илчлэлийг уншдаг, сонсдог, сахидаг хүн дээр ерөөл дуудагдсан учраас, бид энд анхаарахын дээдээр анхаарах ёстой гэж бодном. Энэ илчлэл яагаад чухал вэ? Бидэнд Есүсийн дэлхий дээрх амьдрал, үйлсийг бичээд өгсөн өөр номууд байдаг биз дээ?

Миний бодлоор, Илчлэл нь Есүс маань ялгуусан Аврагчийнхаа хувьд хэн болохыг хальт харуулсан ном байх. Есүс биднийг тайлж, Өөртэйгээ адилхан болгохын тулд Өөрийгөө тайлаад, бидэн шиг болсон. Есүс хүчирхэг, ариун, сүр жавхлантай... тиймээс *өөдөө хар*.

Дараа нь, *эргэн тойрноо хар*. Бид тэнгэрийн үзэл санааг зэрвэс харсан болохоороо, өөрийгөө ч, орчин тойрноо ч, дэлхийн хүмүүсийг ч арай өөр, гэгээрсэн харцаар харна. Исаиа 6-аар бүлэг дээр зөнч Исаиа Бурханы илчлэлээр “шинэчлэгдэхдээ” үүнийг биеэр үзсэн. Эхлээд түүний үгс нь бохир байхыг үзсэн. Дараа нь хамт амьдарч байгаа хүмүүс нь ч бохир гэж бодсон. Түүний ял, нүглийг цогоор цэвэршүүлэх үед Исаиа “Намайг илгээгээч” гэж хариу хэлсэн. Исаиа цэвэрлэгдэж, сунгагдаж, цаг нь болохоос нааш сонсох чихгүй байх хүмүүс рүү илгээгдэхэд бэлэн болжээ.

Бид зүрхнийхээ цохилтыг, дэлхийн зүрхний цохилттой давхцуулж үзэх үед ариун, зөвт Бурханы дүр төрх, эргэн тойрон дахь бодит байдлын ялгаа бидний өрийг өмлөх ёстой. Эргэн тойрноо хар. Мэдээ юмуу олон ангит кино тавиад үз. Юу гарч байна? Шударга бус явдал, нүгэл гарч байна. Гэхдээ бас гэрлийн хүүхдүүд өөрсдийг нь нуувчинд байх хойгуур ноёрхлоо тогтоосон аймшигт харанхуйтай нүүрэлдэхээр, нуувчаасаа гарч ирж байна.

Дараа нь *сайтар хар*. Энэ нь сайн сайхныг бүтээж, эрүүл бус, эмгэг өвчтэйд эрүүл саруул байдлыг авчрах арга замыг хайх ёстой гэсэн үг гэж би итгэж байна. Энэ нь харанхуйг илчилж, хол, ойрын цөхрөгсдөд найдвар авчирч, буруугаасаа эргэж, зөвийг үйлдэх гэсэн үг гэж би итгэж

байна. Бууж өгсөн, эрүүл бус нэгний эрүүлийг, хүчийг сэргээ. Энэ нь эдийн засгаас авахуулаад, боловсролын шийдэл, харилцааны тал дээр ч хамаатай.

Бидний эргэн тойронд өвчилсөн гэрлэлт, гэр бүл дүүрэн байна. Эм эмчилгээ, цэвэр ус, хүнсний хомсдолтой хүмүүс дүүрэн байна. Гэр бүлээр гачигдсан, ганцаардсан хүмүүс, үрчлэгдэх ёстой өнчин үрс, аврагдах ёстой хоригдлууд байна. Өргүүлэх ёстой дарлагдагсад, боогдсон эрчүүд, эмэгтэйчүүд байна. *Сайтар хар.*

Дараа нь *урагшаа харахын* тулд бид одоо хийж байгаа сонголт маань мөнхийн үр дагавартай учраас, сайн байхаас гадна хэтийг харсан сонголт байх ёстойг мэдээрэй. Амьдралын зөрлөг бүр дээр зориуд алсаа бодож амьдрах хэрэгтэй.

Надад Нинжа гэдэг мотоцикл бий. Энэ маань миний хамгийн ухаалаг ч биш, аюулгүй ч биш хэрэглээ учраас, нөхөр маань миний аюултай уналгыг аюулгүй болгохын тулд надтай хамт мотоциклын курет суусан юм. (Би тэр курсын цорын ганц эмэгтэй сурагч байв) Тэнд дийлэнх осол зөрлөг дээр гардаг бөгөөд ослын гол шалтгаан нь мотоциклчид аюултай давхидагтаа биш, харин машины жолооч нар тэднийг харахгүй учраас, гардгийг заасан юм. Тиймээс ослоос сэргийлэхийн тулд: хайгуул хийх, дүгнэлт хийх, гүйцэтгэх гэсэн утга бүхий “Х-Д-Г” ажиллагааг өөртөө сануулж байхыг зааж өгөв.

Би Нинжатайгаа зөрлөг дээр ирэхдээ, жолооч нар намайг мэдэхээсээ илүү би жолооч нар байгаа гэдгийг мэднэ. Миний өндөр анхаарал, тэдний харьцангуй анхааралгүй байдлын улмаас, би хайгуулын горимоо ажиллуулна. Би эргэн тойрныхоо тээврийн хэрэгслийг нягтлаад, хэн нь утсаар ярьж байгааг, хэн нь эргэж байгааг, хэн нь намайг харсныг, хэн нь хараагүйг, дээрээс нь бас замын нөхцөл байдлыг тэмдэглэж харна. Хайрга, элс хоёр миний нөхөд биш. Зөрлөг бүр дээр үүсч болзошгүй асуудал, нөгөө талын замын нөхцлийг ч нягтлан хайгуул хийнэ.

Хайгуул дуусаа бол, явал хамгийн сайн болохыг шийдэхийн тулд нөхцлөө дүгнэнэ. Жонтой хамт давхиж явахад, Жон түрүүлж явна. Яагаад гэвэл түүний дугуй хавьгүй чанга дуутай учраас, жолооч нар түүнийг анзаарч харна. Харин гэрлэн дохио өнгөрсөн хойно Жон намайг урдаа гаргаж, араас минь хамгаална.

Тэгээд төлөвлөгөөгөө гаргаа бол, гүйцэтгэлдээ орно. Машинд ойлгомжгүй мессеж өгч болохгүй. Зүүн эргэх дохио өгчихөөд, шулуун явж болохгүй. Санаагаа тодорхой бөгөөд ойлгомжтой дамжуулна.

Нэгэнт хөдөлгөөнд орсон бол, Нинжа дээрээ сурсан өөр нэгэн хичээлээ хэрэгжүүлнэ: доошоо хараад байх юм бол, доошоогоо л яваад байх эрсдэлтэй. Мотоцикл дээр - яг л амьдрал дээр байдаг шиг дээшээ харах, эргэлтийг нэвт харах хэрэгтэй. Явсан газраа юмуу явж байгаа газраа

харахаасаа илүүтэй явах чигээ харах (урагшаа харах) юм бол, эргэлтээ зөв гүйцэтгэнэ. Хүрэх газраа хар.

Бидний одоо байгаа газар - бидний зорьсон газар биш. Өмнө маань илүү их баяр хөөр, илүү их аюул, илүү их Бурхан, илүү их ёрын муу, илүү их зөвт ёс, илүү их эрх чөлөө, илүү их хүч, илүү их гэрэл, илүү их найдвар байна.

Бид байгаа юмс эсвэл байх ёстой юмс, байх ёстой арга замын голд зогсож байна. Энэ нь биднийг хөдөлгөөнд оролцож явааг ч мэдэхгүй жолооч нар зам дээр зөндөө байгаа гэсэн үг. Тэд биднийг хайх ёстой бус, харин бид тэднийг харж, болгоомжлох ёстой юм.

Эцэст нь *үнэнийг хэл*. Исаиа урагшаа хараад, үнэнийг хэлснийг Паул хэлсэн. Исаиаг амьд ахуй цагт түүний үгийг юмын чинээ тоогоогүй. Зарим түүхчдийн хэлснээс үзбэл, Исаиа үнэнийг хэлснийхээ төлөө хөрөөдүүлсэн гэдэг. Исаиа үнэнийг хэлснийхээ төлөө алдаршаагүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй, аятай тухтай байгаагүй ч, тэрбээр үнэнийг ярихаар барахгүй, ирээдүй рүү илгээсэн тэр л үнэнээрээ амьдарчээ.

Харин үнэн мөргөгчид нь сүнсээрээ, үнэнээр Эцэгт минь мөргөх цаг ирж байгаа бөгөөд одоо ирчихээд байна. Эцэг Өөрт нь ийнхүү мөргөгчдийг эрж байна. (Иохан 4:23)

Үнэнээр тэднийг ариусгаач. Таны үг үнэн мөн. Та Намайг ертөнцөд илгээсний адилаар Би мөн тэднийг ертөнцөд илгээв. Тэд бас үнэнээр ариусгагдахын тулд Би Өөрийгөө тэдний төлөө ариусгана. (Иохан 17:17-19)

Бид үнэнийг мэдэхгүй бол, Бурханы үг үнэн - Есүсийг ухаарах замыг маань гэрэлтүүлж өгнө.

Өөдөө харсан боловч, эргэн тойрноо хараагүй учраас, бүтэлгүйтсэндээ, нуугдчихсан хүмүүс байна. Эргэн тойрноо харсан боловч, өөдөө хараагүй учраас, айсандаа юу ч хийж чадаагүй хүмүүс байна. Урагшаа харсан боловч, үнэнийг яриагүй учраас, худлаар амьдарсан хүмүүс байна. Үнэнийг ярьдаг боловч, эргэн тойрноо хараагүй учраас, ярьсан үнэнээрээ хэнд ч тус болж чадаагүй хүмүүс ч байна.

Тиймээс, дараагийнхаа бүлгээр жишгийн хэмжүүрээ өргөхөөсөө өмнө алдагдсан хүчийг дахин тодосгох чадалтай, зэрлэг гайхамшгийн талаар бичмээр байна. Үүнийгээ пал хийтэл цугтах маягаар биш, харин дүрслэн харуулах маягаар хийе.

Энэ хуудсан дээр миний та нартай хуваалцах зүйлсийг хачин, сонин юм гэж бодуузай. Тийм биш шүү. Энэ зүйл надад гайхамшгийн илчлэл болж ирсэн юм. Энэ илчлэл бол миний хязгаартай үгийн бүтээлээс хавьгүй том

зүйл гэдгийг хуваалцах гэсэн хүн - миний оролдлого болой.

Мунхаглалаар харанхуйлсан дэлхийд гэгээрсэн ойлголт чухал. Хүн зууралдсан зүйлтэйгээ адилхан болдог гэж юутай үнэн. Бид дотоод хараа ба гэрлийн төсөөллөөрөө эргэн тойрноо жолоодуулах хэрэгтэй. Өнөөдөр бидний хувьд, нүдэнд харагдах юмсаас давж харж, цөхрөл дунд Бурханы үйлдэж буй ажлыг харах цаг.

Бид харанхуйд байгаа ч, гэрлийг тунхаглах ёстой.

Ойлголтын нүдээр бид Бурханаа ямар том болохыг дахин бишрэх бишрэлээ сэргээнэ. Бурхан бидэнд харах нүд өгдөг.

Бурханы гэрэл нэмэгдэхүйтэй хамт тэнгэрийн эш үзүүлэл сэрнэ гэдэгт би итгэдэг. Бурхан бидэнд үйлсийг нь харах нүдийг, үгийг нь сонсох чихийг, Үгийг нь эрх мэдэлтэй хэлэх эр зоригийг өгнө. Энэ сэрэлт өрнөхийн цагт хүний зүрхэн дэхь бартаа үйрнэ.

Дотор чинь гайхамшгаа айлдахыг Бурханд зөвшөөр. Бурханы хараа, алсын харааг халт үзэх эш үзүүллийн чадвар нь Түүний гайхамшгаа зуурч, ухаарал олох явдал юм. Энэ хараа үгүй бол, амьдрал нь харанхуй доторх алхаа л болно.

Алсын хараа байхгүй аваас Ард түмэн журамгүй, Харин хуулийг сахигч нь жаргалтай. (Сургаалт үгс 29:18)

Есүс хэзээ ч хачин байгаагүй, харин явсан газар бүрийдээ Бурханы гайхамшгийг авчирдаг байсан. Есүс Аавынхаа хийж буй үйлсийг л үйлддэг байсан. Есүс өвчилсөн хүн төрөлхтнийг ч үзсэн, үүнд Аав нь хэрхэн хариу үйлдэж буйг ч үзсэн. Есүс Бурханы хүүхдүүдийн нүдийг бүрхэж, амьд Бурханаас нь хагацаасан харанхуйг, шашны худлыг үргээхийн тулд гэрлийг айлтгасан.

Эш үзүүлэгчийг өөрөөр бас *харагч* гэж хэлж болно. Есүс бусдын харахгүй байгааг харсан. Тэрбээр гологдсон, шоовдор хүмүүсийг олж хараад, бохирт нь хүрсэн. Есүс хурсан олныг бөөнд нь харахаас гадна олон доторх хүн нэг бүрийг харсан. Есүс эрчүүд, эмэгтэйчүүдээс гадна хувь хүн, зүрхнүүдийг харсан. Есүс харанхуйн дунд гэрлийг харж, гэрлийн дүртэй харанхуйг илчилсэн. Есүс дэлхийн гэрэл байсан бөгөөд эдүгээ ч и тэр гэрлийг тээгч болоод байна.

Ингэснээр та нар ертөнцийн гэрэл мэт гялалзан, гажууд үеийнхний дотор Бурханы өөгүй, буруугүй хүүхдүүд байх юм.
(Филиппой 2:15)

Бурханы хайртай охин минь, харанхуйд ан хийх зааварчилгаа маань энд байна. Бид Бурханы гэрлийг харанхуйд амьдруулна. Бид өөрчлөгдсөн амьдралаа төөрсөн бөгөөд шархадсан дэлхийд харуулдаг. Бид харанхуйгаас нуугдах бус, харин зайлуулна. Харанхуй нь бидний оршихуйгаас зугтдаг. Гэрэл харанхуй руу ойртох үед харанхуй ардаа юу үлдээснийг бид үзнэ. Харанхуй газарт гэрлийг хүлээж байгаа хүмүүс байна.

Энэ бол анд гарч, найдварын мессежээр цангаж, олзонд байгаа хүмүүсийг аврах цаг.

ХАРАНХУЙД АН ХИЙХ

Саяхан надад ан хийх боломж олдож, би Энэтхэгийн ядуусын хорооллоор явж үзсэн юм.

Харанхуйгаас олж харсан зүйл маань намайг гайхшруулдаг. Би Лайф Аутрийчийн шугамаар Мумбай орлоо. Бид ядуусын хороолол дахь эмсийн хүрээлэнгийн хоригдол болсон хүүхэд, эмэгтэйчүүдийг аврахын тулд нутгийн нэгэн байгууллагатай хамтран ажиллав.

Энэтхэг хүмүүс маш үзэсгэлэнтэйгээс гадна туйлын энэрэнгүй, өгөөмөр соёлтой боловч, ядуусын хорооллын аж байдал нь үгээр илэрхийлэшгүй, аймшигтай. Тэр нөхцөл байдлаас би *Ядуусын хорооллын саятан* гэдэг киноны үйл явдлыг бодитоор үзэж билээ. Жижиг муур шиг л том хархнууд гудмаар нэг өмхийрөх хүн, малын ялгадсаас ялгадас руу дамжин гүйлдэнэ.

Би ч Мумбайн түгжрээ дундуур намайг аюулгүй авч ирсэн хөргүүртэй машинаасаа буумагцаа, тэс өөр ертөнцөд хөл тавьчихав. Ер бусын газар учраас бус, харин тусгаар, хүнлэг бус, дагуул соёл байсан учраас л тэс өөр ертөнц гэлээ.

Борооны улирал байсан учраас, чийг, халууны нийллэг нь битүү агаарыг улам л бүгчим болгоно. Би ч тэр даруй тэр орчны үнэрт цохиулав. Өтгөн, шингэний эхүүн үнэр ялзарсан хоол хүнс, заваан нөхцөл, бохир хүмүүсийн үнэр танартай хутгалдана. Агаар нь ч харанхуй сүнсэнд дарлуулсан, жигтэйхэн хүнд.

Тэр дунд хоёр бүтэц тоглож байхыг мэдрэв - үзэсгэлэнтэй Энэтхэг хүмүүс, тэднийг олзолсон харгис хар сүнс. Ядуусын хороолол үр нөлөө, шинж чанараасаа ичэх ч үгүй. Ядуурал, завхрал, хоосролын чанга гар эрчүүд, эмэгтэйчүүдийг хага атгажээ.

Манай багийнхан уг нь хүн амьтанд анзаарагдахгүй гэж Энэтхэг дээл хувцас өмссөн ч, өнгөрсөн бүхэн биднийг л харж байсан болохоор, өнгөлөн далдалгаа маань бүтсэнгүй болтой.

Манай пастор, илгээлтийн эзэн - хөтөч маань биднийг бушуухан

шиг л эмнэлэг рүү дагуулан оров. Энэ маань хүмүүсийг хайрлаж, санаа тавьдгаараа алдартай, хүмүүсийн итгэлийг олсон эмнэлэг байлаа. Би өвчтөнүүд эмчид үзүүлэхээр хүлээж байгаа, даруухаан хүлээлгийн өрөөнд явж орлоо. Хуучин эмсийн хүрээлэнгийн эзэгтэй явсан хатагтай нараас бүрдсэн үйлчлэлийн багийнхан биднийг хүлээж байжээ. Бушуухан шиг хажуугийн өрөөнд явж ортол, эмсийн хүрээлэнгийн эмэгтэйчүүдийг зүгээр л “ерөөгөөрэй” гэсэн заавар хүлээж авлаа.

Тэгэхэд л би үүргэвчинд минь байгаа номлол ямар ч хэрэгцээгүй болохыг ойлгов. Зохиолч, номлогч Лиза энд хэрэггүй болохыг ойлгохын дээдээр ойлгож байлаа. Бид нууцаар шахуу яваа учраас, Библиэ хэрэглэж болохгүй. Орчуулагч маань Англиар тааруухан ярина, би Хиндугээр бүр таг. Тэр хүмүүстэй холбох холбоос маань гагцхүү Бурханы Сүнс л байлаа.

Тэдний түүхээс авч үлдэхийн тулд даашинзныхаа дор микрофон зүүгээд, утсыг нь бүсэлхийгээрээ ороогоод, микрофоноо өмднөөс маань зүүсэн хураагуурт залгалаа. Өөр нэг эмэгтэй хүзүүндээ зүүсэн хар ороолтондоо нууц камер залгав. Бид гар гараа барин залбираад, түм түчигнэсэн гудманд гарлаа.

Би ч шууд л хүний хараанд өртсөнөө мэдрэв. Гэхдээ дайсагнасан гэхээсээ илүү цоо ширтсэн харц. Би замын эсрэг талын байшин өөд хараад, хоёр давхрын цонхон дээрээс маш хөөрхөн Ази охины царайг олж үзэв. Арван таваас хэтрэхгүй л болов уу. Шарх, цөхрөлөөр хашхирсан царай. Тэр үед л би түүнийг эмсийн хүрээлэнгийн хоригдол болохыг нь ойлгов.

Ийм харцанд би хэрхэн хариулах юм бэ?

Өөдөөс нь инээмсэглэх үү? Толгой сэгсрээд, үүгээрээ охиныг шүүж, цээрлэж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэх үү? Би охиныг өөр тийшээ хартал нь өөдөөс нь ширтлээ. Би доошоо харахдаа, орц байхыг олж харав. Үүдэнд нь хөмсгөө зангидсан хэдэн харцуул сууна. Тэд миний ширтэхийг “Чи юу вэ? Эндээс зайл. Чиний байх газар биш!” гэх шиг л ил тод дургүйцлээр хаав.

Тийм ээ. Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн ямар ч хүн тийм газарт байх ёсгүй. Тэр бол байх биш, зугтах газар.

Хамт явсан бүсгүйчүүдийн маань нэг нь миний уурыг мэдрээд, бүсэлхийгээр минь гэврээд, “Явъя. зам гаръя!” гэж хэлэв. Тэрбээр намайг шавартай гудмаар ямар ч дүрэм журамгүй, замбараагүй зөрөлдөх хүн, дугуй, машин дундуур замчлан гаргаж өглөө.

Ядуусын хороололд өдрийг өнгөрөөснийхөө дараа би зам гарахдаа, зогсож болохгүй гэдэг ганц дүрэмтэй болж авч билээ. Чамайг зүглэн хичнээн олон дугуй, мотоцикл, машин ирж байсан ч, айлгүй яваад л байх хэрэгтэй. Нэг удаа айгаад замын дунд зогсчихтол, хоёр хатагтай араас

ёворч түлхэнгээ, толгойгоо бөнжигнүүлэн “Зогсож болохгүй! Бид чамайг хамгаална” гэж билээ. Үнэхээр ч хамгаалсан даа.

Бидний очсон эхний хүрээлэн 40м2 томгүй хүлээлгийн өрөөтэй байлаа. Тэнд үйлчлүүлэгч нар өөрсдөд нь үйлчлэх охидоо хүлээнэ. Мөн эмэгтэйчүүд хоол хийж, нөхөрлөж, хүүхдүүдээ асардаг, нийтийн хэсэг ажээ. Тэр сүүдэртэй өрөөнөөс шууд хаалганы гаднах навсгар гудамж харагдана. Тэр умгар өрөөнд Бурханы хайрыг сонсохоор эмтэрсэн эмэгтэйчүүд цугларчээ.

Би ормогцоо, тэнд байгаа өөр нэгэн хаалгыг өөрийн эрхгүй хараад байлаа. Таар унжуулсан тэр хаалганы цаана ариун цэврийн өрөөнүүд шиг эгнэсэн хаалгуудтай нарийн корридор байв. Тэнд охид унтдаг, үйлчлүүлэгч нартаа үйлчилдэг болохыг нь хожим мэдэв. Тийшээ хартал, зарим хаалга нь хаалттай байсан нь охид амарч байгаа юмуу эсвэл”ажилтай” байгааг нь илтгэнэ.

Би өмнөх бүсгүйчүүд рүүгээ харлаа. Тэд шалан дээр юм дэвсэж, өрөөний хоёр талаар бандан сандал тавьжээ. Биднийг төвхнөх үеэр гивлүүртэй бүсгүйчүүд, гайхсан янзтай, нэг нэгнээ хань татан, шахцалдаж байлаа.

Орчуулагч маань тэдэнтэй Хинду хэлээр мэндлэв. Тэд ч анхааралтай сонсон, хүндэтгэлтэй нь аргагүй, олноос онцгой Энэтхэг маягаараа толгойгоо хоёр тийш нь бөнжигнүүлнэ.

Төдөлгүй үл мэдэгдэх Хинду хэл дундаас би өөрийнхөө нэрийг олж танилаа. Бүх толгой над дээр тусав. Би ч тэр даруй пастор руугаа цөхөрсөн харцаа тусгалаа. Пастор ч миний өөдөөс гараа өргөөд, өмнөх шигээ л “Тэднийг ерөө... тэд чамайг хоёр цаг хүлээж байна!” гэж хэллээ.

Би өөрийгөө танилцуулаад, хаанаас ирснээ хэллээ. Дөрвөн хүүтэй, удахгүй ач хүүтэй болох гэж байгаагаа ч хэллээ. Хэлсэн үг маань өөрийн маань чихэнд ч нэг л хөндий хоосон цуурайтна. Энэ бүхэн энэ бүсгүйчүүлд ямар нэгэн утга илэрхийлэх үү? Миний мэддэг Америк “нормын” нүүрэн дээр тэдний мэддэг юмс сарнижээ. Гэвч тэд эелдэг тулдаа зөөлнөөр толгой дохиж байлаа.

Би тэднийг ганцаараа биш гэдгийг мэдүүлэх гэсэндээ урт замыг туулсаар ирснээ ч хэллээ. Дэлхийн эмэгтэйчүүд бүгдээрээ тэднийг зүрхэндээ тээж, тэдний төлөө уйлдгийг ч хэллээ.

Ямар утгатай үг вэ? Тэд ганцаараа биш? Тэдний цөхрөлийн үг ядуусын хорооллоос нь жигүүрлэн ниссэн? Тэдний алдаа эндлийн төлөө бусад эмэгтэйчүүд уйлдаг? Хэний ч мэдэхгүй, тэр Энэтхэг охидын төлөө маш олон эмэгтэйчүүд Бурханы сэнтийн өмнө залбирлаа өргөдөг тухай хэлтэл, тэдний нүүр царай чимээгүй нулимсаар гийгээд л явчихав.

Холбоо хамаарлаа ухаарахын хүчийг тэд үнэхээр ойлгосон болов уу хэмээн би заримдаа гайхдаг юм. Бид ганцаархнаа зөрчилдөөгүй. Бид ганцаархнаа найдаагүй. Есүс биднийг хэзээ ч орхихгүй гэж амласан.

Би өөрийнхөө харууслыг ч хуваалцлаа. Тэд цэвэр ариун бие, нэр төрөө хүчээр алдсан бол, харин би залуу насныхаа тэнэглэлээр сайн дураараа үрэн таран хийсэн. Би тийм завхарсан амьдралыг өөрөө сонгосон боловч, хожим Бурханд үүдээ нээхэд, Бурханы хайр амьдралд маань үерлэн орж ирээд, намайг нэг мөр сүйрэхээс хамгаалсан. Тэд над руу бөхийлөө.

Ариун Сүнс бүсгүй нэг бүрийг гийгүүлж байгааг би мэдрэв. Тэд баахан эмэгтэйчүүд биш, харин тус тусдаа Бурханы охин байлаа. Би бүсгүй болгоны нүүрийг илэхдээ, мутраа сунгаад хүн миний үгийг Сүнсээрээ тодруулж өгөх ажлыг нь Бурхандаа даатгав. Би тэдэнд хүрч байхдаа “Бурхан чамд төлөвлөгөө зэхсэн” гэж хэлж байлаа.

Харанхуйд хоригдсон тэднийг хайсаар, ирж айлчилсан Бурхан гэдэг үгийг хэлэхтэй хамт хацраар нь нулимс урсана. Дарлал дор, хүний гарт амьдарна гэдгийг тэдэн шиг мэдэх хүмүүс үгүй. Тэнд байгаа охин бүр хүнээр амьдралаа төлөвлүүлэхийн аймшиг дор амьдарч байв. Миний ярилцсан эмэгтэй бүр бэлгийн боолчлолд хүчлэгдэж юмуу мэхлэгдэж оржээ. Тэд яг одоо миний санал болгож байгаа тэр л найдвартай хөөцөлдөж яваад, энэ нүхэнд оржээ.

Бүгдээрээ л сайхан ажил, боловсрол, зүгээр л хайр хүссэн. Зарим нь тосгоны аймшигт ядуурлаас зугтахыг хүссэн. Итгэж явсан эрчүүд, эмэгтэйчүүддээ хууртагдсан. Садангийн ах, нөхөр, төрсөн ах дүүс, хамаатан садан, эгч, тэр бүү хэл найздаа ч хууртагдсан түүх сонсож байлаа. Сайн сайхан амьдралын мөрөөдлөөр л урхидан урважээ. Харин би тэднээс дахин найдахыг, хэзээ ч худлаа ярьж чаддаггүй Бурханы Хүү Есүст итгэхийг хүслээ.

Мэдээж олон л юм ярьсан. Одоо мартчихаж. Энэ хуудсан дээр ахин дахин давтах хэллэг, үгс минь манай барууны нийгэмд утгагүй санагдаж болох. Гэхдээ тухайн үед тэнгэрийн амьсгал тээж байсан юм шүү.

Дуу хөгжим хангинаагүй ч, тэр умгар өрөөг тэнгэрийн амьсгал эзлэв. Бүсгүй бүр найдвар хайрласан, амьд Бурханд хариулахад нь Бурхан - тэдний хооронд нэгэн холбоо тогтжээ.

Энэ шилжилтийг мэдэрсэн бас хэлэх үг маань ч дууссан болохоор, би пастор руу эргэж харлаа. Пастор эмэгтэйчүүдтэй хамт бас тэдний төлөө залбирлаа. Пастор тэнгэрийг дуудахад, хамт үйлчилж байсан эмэгтэйчүүд маань нөгөө нандин охид дээр очоод, нэг нэгээр нь тэврэн, залбирлаараа хүрээлэв. Тэрхэн эгшинд харанхуй хана ухарсан юм шиг л санагдаж байлаа.

Гэтэл нэгэн үйлчлүүлэгч өмдөө товчлон гарч явахдаа, мөрөн дээгүүрээ жигшсэн харц чулуудах нь тэр. Бид их л хачин зочид байсан болтой.

ТӨВЛӨРСӨН БӨГӨӨД ДОШГИН

Дараах эшлэлийг бодолцоно уу:

Харин Та харсан билээ.
Учир нь мутраараа хариулахын тулд
Та зовлон зүдүүр, уур унтууцлыг ажигласан билээ.
Ядуу нэгэн Танд даатгадаг.
Та өнчин хүмүүсийн туслагч байсаар ирсэн билээ.
Буруутан хийгээд ёр мууг үйлдэгчийн гарыг хугалж,
Юу ч олохгүй болтлоо
Гэм бурууг нь хайн илрүүлээч.
ЭЗЭН үүрд мөнхөд Хаан юм
Газар нутгаас нь үндэстнүүд устгагдсан билээ.
ЭЗЭН, Та даруу хүний
хүсэлтийг сонссон билээ.
Зүрхийг нь батжуулж, чихээ тавин сонсооч.
Ингэснээр дэлхий дээрх хүмүүсээс
Дахин давтан сүрдэхгүй болгож
Өнчин хийгээд хэлмэгдсэн хүнийг зөвтгөөч. (Дуулал 10:14-18)

Жинхэнээсээ сонсов уу? Харанхуйд ан хийхэд хэрэгтэй бүх бүтэц энд байна: итгэл, шударга ёс, ялгуусан байдал, эдгэрэл, найдвар, үрчлэл, сэргэлт, зөвт байдал тэгээд эцэст нь шинэ эхлэл! Тэгэхээр, одоо эдгээр үгийг залбирах цаг бөгөөд Бурханы Үгийг илгээхэд, биеллийг нь Бурхан Өөрөө хариуцна.

Энэ маань нилээд эрс тэс, мафи маягийн залбирал шүү. Үнэндээ, би л хувьдаа аюулгүй, аятайхан залбирлаас залхаад байна. “Буруутан хийгээд ёр мууг үйлдэгчийн гарыг хугал” гэдэг ч аюултай залбирал. Хурц гуйлт. Ийм залбирлыг дөлгөөхнөөр залбирна ч гэж байхгүй байх. Дуулал 10 нь үнэндээ миний саяхан Зүүн Өмнөд Ази руу явахдаа сэлэм болгон авч явсан, Бурханы амлалт болой. Шударга бус явдлыг үзэх тоолондоо би энэ сэлмээрээ цавчсан.

Залбирахдаа, төвлөрөлтэй бөгөөд дошгин залбир. Харагдах зүйлээс даван, шударга ёс, сэргэлтийг олж хар. Бурхан үүнийг л газар дээр авчрахыг хүснэ. Залбирахдаа нүдээ аниад, “Намайг олж хараач!” хэмээн хашхирч буй хүмүүсийг олж хар. Амнаас чинь гарахдаа чамайг ч хүртэл айлгамаар, тэнгэрт хүрдэг залбирал хэл.

Идэвхигүй чуулган нэг их удахгүй. Энхийн Ханхүүг ирж, энэ бүх аймшгийг эцэслэх хүртэл харанхуйд ан хийж чаддаг чуулган л байх хэрэгтэй. Үүний тулд хувиараа ч, хувьсгалаараа ч эрэлд гарч, нуугдсаныг илрүүл.

Харанхуйд хоригдсон, цөхөрсөн хүмүүсийг олох гэж заавал Энэтхэг рүү аялах хэрэггүй шүү. Эргэн тойронд чинь хоригдол болсон эрчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүд зөндөө байна. Тэд биднийг хүрч ирэхийг харуулдсаар байна. Тэднийг чөлөөлөх үүдийг нээхийн тулд өөрөө харанхуйгаас гар. Тэр цагт бид тэднийг гэрэлд гаргаж чадна.

Бид Бурханы гэрлээр гийхдээ, төөрөгсдийг харанхуйгаас гаргаж чадна. Энэ бол доктрины төлөө юмуу мега үйлчлэл, чуулганы статусын төлөө тэмцэлдэх цаг биш. Бид эрх суурийн төлөө, өөр хоорондоо өрсөлдөхийн оронд үйлчлэх ёстой.

Сэр! Цаана чинь үрчлэгдэж, бүх талаараа хайр халамж хүсч байгаа өнчин хүүхдүүд байна. Мянга мянган ганцаардсан, тусгаарлагдсан хүмүүс ямар байгаагаасаа үл хамааран, ганцаараа биш хэмээн найдан дотроо залбирч явна.

Би “Харанхуйд ангуучлах” гэдэг ойлголтыг олон улсын төвшинд гаргахын тулд л Энэтхэг дэхь хүний наймааны гаслант түүхийг хуваалцсан юм шүү. Түүнээс биш утгыг нь алдагдуулж болохгүй. Энэ түүхийг уншаад, өөрийнхөө болоод эргэн тойрныхоо хүмүүсийн зовиурыг юу ч биш юм байна гэж бүү бодоорой. Бурхан элэг эмтэрсэн хүн бүрт ойрхон байдаг. Хоригдох, тусгаарлагдах, урвалт, зөрчил, хүчирхийлэл, цөхрөлийн зовлон бүх улсын бүх хүнд ирдэг. Хаа газрын хүн бүрт ижилхэн хэрэгцээ байдаг ч, хүн бүрт ижилхэн туслалцаа олддоггүй.

Итгэмжтэй нярав байж, хөгжил цэцэглэлээ үржүүлье. Чи бусдыг ерөөхийн тулд ерөөгдсөн. Чиний ерөөл үй олон газарт хэрэгтэй. Өгөх гэж хаа хол явах шаардлагагүй. Ажлын газарт чинь, ордог дэлгүүрт чинь цөхрөл байж л байгаа. Найз чинь гэр бүлдээ хүчирхийлүүлж байж ч мэдэх. Хамт Бурханыг хүндэтгэдэг хүмүүс чинь ганцаардаж байж ч болох. Хүүхдүүд чинь сургуульдаа урвалт шарвалт үзэж байж ч болох.

Бусдын амьдралд найдвар тарих үйлдэл маань бидэнд өөрт маань ч эдгэрэл авчрах нь олонтаа. Хүний сэтгэлд нэмдэг Есүс Христийн хайр, үнэ цэнэ дэлхийн хүмүүст хэрэгтэй. Тэд үгээгүй ядуурлын буланд сууна уу, асуудлаасаа зугтаж явна уу эсвэл түр хорогдох байранд байгаа юу - хилийн зурвас татагдаж, хил хязгаар тогтоогджээ. Амь ч бий, үхэл, сүйрэл ч бий. Найдвар ч бий, цөхрөл ч бий. Гэрэл ч бий, таг харанхуй ч бий. Талбар үүн шиг тодорхой байсангүй, бооцоо ч үүн шиг өндөр байсангүй.

Эрслэнгүүд гэрэлд амьдарч, харанхуйд ан хийдэг. Тиймээс, зоригт оо,

бид үүн шиг л амьдрах ёстой. Чи амлалтын охин учраас л, энэ номыг барьж байгаа. Чи хаалгаа дэлгэжээ. Эдүгээ Түүний сүр жавхланта гэрэлд амьдарч сур. Түүнчлэн халамжинд юмуу зовнилд авталгүй, хамтдаа амьдар.

Нүдээ том нээгээд, харанхуйд харж сур - давж хараад, нуугдсан юмс, зүрхийг нь хар. Хамтдаа харанхуйд ангуучилж, бусдыгаа Бурханы гэрэлд гарга. Эрслэнтэй адил амарсан, нээлттэй, хурц, дошгины тэнцвэрийг хадгалъя. Бурханы дотор амарч, бие биетэйгээ тухалж, харанхуйн зүрхийг үхүүлье.

АРСЛАНТАЙ ХАМТ АЛХАХ

Бүү уйл. Харагтун, хуйлмал номыг болон долоон лацыг нь нээхийн тулд Иудагийн овгийн Арслан буюу Давидын Үндэс ялсан юм.

Илчлэл 5:5

Хүнд хэцүү нөхцлөөр туулж явахад зөндөө л уйлна. Гэхдээ үнэндээ ямарваа нэгэн нууцгай атлаа хүчирхэг зүйл чиний өмнө чамаас түрүүлэн алхалж байна. Цаашаа уншихдаа, чи өөрөө ч мэдэхгүйгээр, Арслан Есүс Христтэй алхаж явснаа мэдэх болно.

Заримдаа, дагах нь аймшигтай байна. Бэрхшээл нь Бурханы үгийг ойлгохдоо биш, харин хэрхэн хийхдээ оршино. Дийлэнх хүмүүс Бурхантай зэрэгцэж явахыг үнэн голоосоо хүсдэг ч, хэрхэн хийхээ огт мэддэггүй.

Есүс гаднаасаа аймаар энгийн гэмээр чиглүүлэг өгчээ. Матай 16:24-ийг дараах хоёр өөр хувилбараас үзнэ үү:

Намайг дагах хүсэлтэй хүн, өөрийгөө няцаагаад, загалмайгаа аваад, Намайг дагаг. (ЭнКэйЖэйВи)

Арай тодорхой хэлбэл...

Надтай хамт явахыг хүсч буй хүн Намайг түрүүндээ гаргах ёстой. Жолоочийн суудалд чи биш, Би сууж байна. Зовлонгоос зугталгүй, хүлээж ав. Намайг дага, хэрхэн хийхийг Би чамд харуулна. (Мессеж Библи)

Удирдамж тодорхой байна - өөрийгөө няцаах, загалмайгаа авах, дагах.
Гэхдээ асуудал нь хэрхэн хийх вэ гэдэгт л байна.
Өөрийгөө хэрхэн няцаах вэ?
Загалмайгаа авах гэж юу гэсэн үг вэ?
Харж чадахгүй хүнээ яаж дагах юм бэ?
Хариулт нь энгийн: Есүс хөтөлнө... бид дагана.

ИТГЭЛЭЭР АЛХАХ

Би залуу охидын асуулт - хариултын форумд их оролцдог. Тэнд “Гэхдээ хэрхэн хийх юм бэ?” гэдэг асуулт маш их ирдэгт ч гайхдаг.

Бурханы ярихыг хэрхэн мэдэх юм бэ?
Аавыгаа хэрхэн уучлах юм бэ?
Буруу хооллохоос хэрхэн эдгэрэх юм бэ?
Зөв, буруу залуу гэдгийг нь хэрхэн мэдэх юм бэ?
Айдас, ичгүүр, ялыг хэрхэн ялах юм бэ?

Охидод тулгарсан эдгээр асуулттай тулгарах бүрийдээ би зүгээр л Бурханы Үг үнэн гэдэгт итгээд, намайг дагуулах зүг рүү нь л дагадаг. Есүс бол хүн биеэр ирсэн Үг. Бид Бурханы Үгийг уншихдаа, Есүсийг хэрхэн амьдарч, хаашаа хөтөлдгийг нь хардаг. Хүнд курст суралцаж байгаа хүмүүс эхэндээ өөрийгөө сурч чадна гэдгээ мэддэггүй. Тэд урмаа нөөцөлж байгаад л Есүсийг итгэлээр дагадаг.

Тэд итгэлээр, хаанчлалуудыг эзэлж, зөвийг үйлдэн, амлалтуудад хүрч, арслангуудын амыг хааж (Еврей 11:33).

Хүмүүс итгэл дотор үйлдэхэд, завхарсан хаанчлалууд нурж, үнэн зөв нь буруутай нүүрэлдэж, Бурханы амлалт бодитой болдог. Бид итгэлээр амьдрахдаа, Бурханы төлөвлөгөө, амлалт руу нэвтэрнэ. Тэргүүн Арсланг дагахад итгэл хэрэгтэй.

Итгэл эргэлзээг залгина. Бид Бурханаас “Та байна уу? Би мэдрэхгүй байна” гэж асуудаг. Арслан маань “Би чамайг хэзээ ч орхихгүй” (Еврей 13:5) гэж хариулахыг бид итгэлээр сонсдог.

Биднийг залбирахад, итгэл хүсэн хүлээлт үүсгэдэг. Итгэлээр хэлсэн залбирал нь өвчтэйг эдгээдэг бөгөөд Эзэн чамайг эдгээнэ. Чи нүгэл үйлдсэн бол, уучлагдана (Иаков 5:14-ийг үзнэ үү).

Итгэлийн үйлдэл гэж юу вэ?

Энэ нь тухайлбал, итгэлийн өвөг Абрахамын хувьд, хаана хүрэхээ мэдэхгүй ч, Бурханыг цөлөөр дагах явдал байв. Абрахам, Сара хоёрын

аяллын талаар уншихдаа, Бурхан тэдэнд дамжиж өнгөрсөн газрыг нь ч, итгэлээр харсан газрыг нь ч өгснийг анзаарч билээ.

Итгэлээр Абрахам, өв болгон авах гэж байсан нутаг уруу явахаар дуудагдахдаа дуулгавартай байв. Тэр хаашаа явж байгаагаа ч мэдэлгүй гарч явав. (Еврей 11:8)

Абрахам, Сара хоёр дасал болсон, ая тухтай Ур нутагтаа үлдсэн бол, Бурханы амлалтыг өвлөхгүй байх байж.

Итгэлээр амьдрах хичнээн амаргүй. Бидэнд газрын зураг хэрэгтэй ч, Бурхан нууцаараа биднийг далладаг.

Итгэлийн энэ аялал нь бидний дотор урмыг хөгжүүлдэг. Хүн нэг бүрийн өмнө аугаа адал явдлаар дүүрэн, бартаат гүйлтийн зам өрөөтэй бөгөөд Арслан биднийг Өөрийн биеэр бэлдээгүй замаараа яасан ч явуулахгүй. Бурхан биднийг хараагүй, хийгээгүй, цоо шинэ зүйлд дуудах нь хэзээд аймшигтай байдаг. Заримдаа Бурхан биднийг өмнө хэний ч зүүдлээгүй юмуу яваагүй өсгүүр газар, зүг чиг рүү хөтөлнө. Бидэнд Түүний “Охин минь, чи айсан ч гэсэн, Намайг дагах уу?” гэсэн урилга, уриалга л байна.

Саяхан нэг найз маань надад аймаар ч гэх үү, стратегитай ч гэх үү мэдээ дуулгав. Тэрбээр өндөр нэр нөлөө бүхий удирдагч эрчүүдийн том цугларалт дээр үг хэлэх эрэгтэй номлогч нартай эгнэх урилга хүлээн авчээ. Эр нөхөр нь ч яагаад гэргийг нь урих болсонд гайхаж, эргэлзэж орхижээ.

Найз маань конференцийн танилцуулгаа хүлээж авангуутаа, өөрийгөө цорын ганц эмэгтэй илтгэгч байгааг бодитоор үзээд, балмагдаж, буруу зөрүү юм хийчихэв үү хэмээн айсандаа над руу ярьж.

Би ч юу гэж хэлэхээ мэдэхгүй байж байснаа гэнэт л “Чи үүний төлөө л насаараа бэлтгэгдсэн. Чи үүнийг хийж чадна, сайн ч хийнэ. Чи үүнийгээ дур булаамаар, бурханлаг, цэц ухаантай аргаар хийнэ” гээд л хэлчихэв.

Би найзыгаа уртаар санаа алдахыг сонсоод, толгой дохихыг нь мэдрэв. Түүнийг ганцаараа биш гэдгийг нь би мэдэж байлаа. Дэргэд нь Арслан Есүс маань зогсоно. Найз маань ч чичирж байсан ч хамаагүй, Арсланг дагаж, хийх ёстой юмаа хийх л болно. Тэр ганцаараа биш гэдгээ мэдэх л болно.

Есүсийг дагадаг хүмүүс Арслантай хамт байдаг. Есүс - бидний нядлагдсан Хурга бөгөөд Иудагийн Арслан болж амиуулагдсан Нэгэн болой.

Ахлагчдын нэг нь надад —Бүү уйл. Харагтун, хуйлмал номыг болон долоон лацыг нь нээхийн тулд Иудагийн овгийн Арслан буюу Давидын Үндэс ялсан юм гэлээ. (Илчлэл 5:5)

БҮҮ ТЭЭНЭГЭЛЗ

Айдас, чичрэлээ Христийн мэдэл дор оруулахын тулд өөрийгөө дэргэдээ арслантай алхаж байна гээд төсөөл. Бурхан чамаас айдас төрүүлмээр зүйл хийхийг асуух ч юм билүү, хэн мэдлээ.

Галил далай дээгүүр гаталж буй, уулан дээр номнож буй Есүсийн дүрслэл нь Түүний эдүгээх сүр хүчийг төгс дүрслэн бүтээж чадахгүй. Бурханы Хүү Өөрийнхөө эрх ямбыг бүрэн тайлаад, энэ дэлхий дээр хүний дүрээр айлчилсан. Гэвч одоо охид, хөвгүүдийнхээ дүрээр явааг нь эс тооцбол, Есүс Өөрөө хүний дүрээс гарсан. Тэрбээр Өөрөө хүч чадал, сүр жавхлангийн дүр төрх болсон зэрлэг, тансаг, тэнгэрлэг, өндөр оршихуйдаа залран буй.

Хараагаа өргөөд, сүр жавхлант, яруу алдарт Иудагийн Арсланг хар. Тэр чамайг дүрэм журам, үүрэг хариуцлагын ноёрхол дор биш, ер бусын, гайхамшиг дундаа амьдруулахыг хүснэ. Түүний дуу хоолойгоор номхроогүй, дошгин дотоод чанараа сэрээлгэ! Залуу Иеремиад өгсөн Бурханы амлалт Бурханы айдасгүй, эш үзүүлэгч охин - чамд ч хамаатай.

«Эхийн хэвлийд чамайг бүрэлдүүлэхээсээ өмнө

Би чамайг мэдэж байсан.

Төрөхөөс чинь өмнө Би чамайг ариусгаж,

Үндэстнүүдэд эш үзүүлэгч болгон чамайг томилсон»

гэж хэлэхэд Би

—Аяа, Эзэн БУРХАН!

Харагтун, би бага залуу тул

Хэрхэн ярихыг мэдэхгүй гэв.

Харин ЭЗЭН, надад

—«Би бага залуу» гэж бүү хэл.

Учир нь чамайг илгээх газар бүрд минь чи явах болно.

Чамд тушаах бүхнийг минь чи ярих болно.

Тэднээс бүү ай.

Чамайг чөлөөлөхөөр Би

Чамтай хамт байна

гэж ЭЗЭН тунхаглаж байна.

Тэгээд ЭЗЭН, мутраа сунган миний аманд хүргээд, ЭЗЭН надад

—Үзэгтүн, Би үгсээ аманд чинь хийв. (Иеремиа 1:5-9)

Чи ч бас Иеремиатай адил үр нөлөөтэй байхын тулд Бурхан чамтай хамт байна гэдэг бодит байдал дээр тогтох ёстой. Энэ бэлтгэл байдал чинь чамайг хүмүүсийн эсэн бусын үгээс айхгүй байхад бэлтгэнэ.

Амьдралын аян замд үй олон дуу хоолой, нөлөө дагалдах л болно. Зарим нь чиний зүг чигийг хүчжүүлж, батжуулах бол, зарим нь чамайг замаас чинь гаргаж, ганхуулна. Зарим дуу хоолой нь чамайг чиний мэдэхгүй газар руу уриалан дуудах бол, зарим нь хойш чангаана. Зарим нь “Эргэ, буц! Уналаа. Гэмтлээ” хэмээн өнгөрснөөс зогсоо зайгүй хашхирч, шивэгнэх дуу хоолой байна - гэр бүлийн чинь дуу хоолой, гутралын дуу хоолой, айдсын дуу хоолой. Эдгээр дуу хоолой нь биеэ бөөцийлөхийг л ятгана.

Эдгээр сөрөг, амьдрал сорогч дуу хоолой дунд амь хайрлагч, хүчирхэг дуу хоолой байна. Ямагт байж л байдаг энэ дуу хоолойг чихээ тавихаас нааш сонсож чадахгүй. Биднээс түрүүлж очсон, тэнгэрийн эзний дуу хоолой Бичээсээр дамжин дуулдаж, “Эргэн тойрон дахь аймшиг, айдсыг бүү сонс. Яллагч, тамлагч дайсны худлыг бүү сонс. Бүү сатаар. Чи бидэнд хэрэгтэй! Зам дээрээ байж, уралдаанаа гүйцээ!” хэмээн чамайг урагш уухайлан дэмжинэ.

Арслангийн дэргэд ямар ч араатан айдас төрүүлэхгүй. Сатаныг идшээ шиншлэн хайх арслантай адилтгасан боловч (1Перт 5:8), тэр арслан биш. Тэр зүгээр л дүр эсгэгч. Сатан жинхэнэ Арслантай эгнэхгүй. Харанхуйн эзэн бөгөөд хамсаатнууд нь тэнгэрлэг архираатай мэт царайлдаг ч, тэд Бурханы бүтээлийн суу, гэрлийг зээлдэгч сүүдэр, хар тусгалууд юм.

АРСЛАНТАЙ УУЛЗСАНДАА ИТГЭ

Би жаахан байхдаа Нарниагийн домгийг бүрэн эхээр нь бэлгэнд авч билээ. Бүлэг болгон нь нууц эрдэнэс шиг л. Тэгээд бүгдийг нь уншиж дуусаад асгаргал үйлсан сан. Түүх дууссанд бус, харин тэр нэгэн нууцлаг, ер бусын ертөнцтэй холбоо тасарсандаа. Аслан ану Есүсийг төлөөлж байгааг ойлгож байсан ч, Есүсийг Нарниагийн домог дээр миний дурласан, хүрэшгүй, номхрошгүй, зэрлэг арслангаар төлөөлсөнтэй нь нэг л эвлэрч чадахгүй байлаа.

Аслан хүүхдүүдтэй хамт явсан. Би шашны, дуу хоолойгүй шүтээн, хүйтэн ариун аршаан ус руу буцахыг хүссэнгүй. Би жинхэнэ, амьд арслангаа буцааж авахыг хүсч байлаа. Би Бурхангай үгүйсгэхийн аргагүй бодитой оршихуйтай, халуун дулаан, амьд, жинхэнэ учрааг хүсч байлаа. Би айдас төрүүлмээр, хүчирхэг хайрыг хүсч байлаа. Би уушги зүрх амаар гаргам, шударга ёсыг хүсч байлаа.

Би амьтад, модод нь ярьдаг, тийм нэгэн ертөнц дэхь Люси байхыг хүсч байлаа. Би үнэнийг бөгөөд чанарыг шагнадаг, тэр газарт байхыг хүсч байлаа. Би алдааг ялладаггүй, уучилдаг, тийм газрыг хүсч байлаа.

Бурхан биднийг бүлтэгнэсэн, хүүхэд мэт сэтгэлээр өмнө нь хүрч очоод, Түүний хайр, авралыг хүлээж аваасай гэж хүсдэг. Гэвч шашны дүрэм журам, цагийн үе тогтол нь олон хүнийг замаасаа гажихад хүргэх. Тэгээд бид залуу насныхаа Арслангаас хараа тасардаг.

Үүнийг санангаа, Нарниагийн цувралын дөрөвдүгээр ном болох Каспийн ханхүү дээрх Люси дээр очицгооё. Хүүхдүүд туйлдаж, төөрч хариугүй бас нэгэн буруу алхам хийх дээрээ тулаад байтал, Люси арслан Аслангаа олж харна.

“Хараач, хараач!” хэмээн Люси хашхирав.

“Хаана? Юу?” хэмээн бүгд ч асууцгаав.

“Арслан. Харахгүй байна уу? Аслан байна” хэмээн Люси хэллээ. Люсигийн царай дугуйлан гийж, нүд нь гэрэлтэв.

“Нээрэн үү?” хэмээн Петр түрүүлж асуулаа.

“Чи Түүнийг хаана харах шиг болов?” хэмээн Сюзан ч асуулаа.

“Битгий томчууд шиг яриад бай. Би харах шиг болоогүй. Би харсан” хэмээн Люси хөлөө дэвслэн хэлэв.

“Хаана тэр вэ, Лү?” хэмээн Петр асуулаа.

“Яг тэр үнсэн уулын завсраар. Үгүй ээ, хавцлын энэ талд. Доор нь биш, дээр нь. Та нарын явах гээд байгаа замын чинь яг эсрэг талд. Тэр биднийг өөрийнхөө байсан газар руу - дээшээ явахыг хүслээ.”

“Чи түүний юу хүссэнийг яаж мэдэж байгаа юм?” хэмээн Эдмунд асуув.

“Тэр... би... би зүгээр л мэдэж байна. ...Царайгаар нь...” хэмээн Люси хариуллаа.

Хүүхдүүд мэл гайхан, өөд өөдөөсөө харав.¹

Арсланг гарч ирэхэд, царай чинь тусган харуулдаг. Алсын хараатай хамт мэдлэг ирнэ.

Аддисон Жулианаг ирээдүйнхээ эхнэрийг гэдэгт итгэж байгаагаа хэлэх үед энэ мэдлэг түүний царайнаас илт харагдаж байсныг би санаж байна. Би Киевт болсон эмэгтэйчүүдийн конференцээс дөнгөж эргэж ирээд байсан бөгөөд намайг эзгүй байсан зургаан хоногийн дотор хүү маань амьдралынхаа ханьтай учирчээ. Хүү минь тэр өдрөө л биднийг өдрийн хоолонд урьж билээ. Хүлээлгийн хэсэгт сууж байхад, хүү минь “заяаныхаа ханьтай” учирснаа хэлж билээ.

Хүүгээсээ яаж мэдэж байгааг нь асуутал, хүү минь миний харцыг хүлээж аваад, “Зүгээр л мэдэж байна” гэж хэлж билээ. Тэр эгшинд би ч мэдсэн юм. Тэр залуухан бүсгүйг үзээд, хүү минь өөрийнхөө ухаанаар

тайлбарлаж үл чадах чиглүүлгийг дагах хүч хайрласан, ямар нэгэн том зүйлийг олж харжээ. Ээжийнх нь хувьд, би түүний аян замыг дэмжсэн. Би учрыг нь мэдэхгүй ч, Жулианатай уулзахаасаа ч өмнө түүнийг миний хүүгийн хань гэдгийг нь мэдсэн юм.

Хүмүүс бидний харсныг харахгүй байсан ч, бид Арслантай уулзсандаа итгэх ёстой. Люси бусдынхаа эргэлзээг үл тоон, харсан үнэндээ итгэсэн.

Люси Аслангийн заасан зүг чигийг бусаддаа хэлэхэд, бусад нь түүнд эргэлзсэн. Тэд Люсиг Арсланг харсан эсэхэд нь эргэлзээд зогсохгүй, яагаад Люсид харагдах болов гэдэгт ч гайхсан. Тэгээд тэд Люси, түүний харсан гээд байгаа Арсланг дагах уу, илүү шулуун замаар явах уу гэдэг дээрээ санал хураахаар шийддэг. Люси ялагдаж, хүүхдүүд өөр замаар явав. Люси буруу замаар яваа бусдыгаа уйлан, уйлан дагав.

Түүнд ямар байсныг бид мэдэж л байгаа байх.

Бид бусдынхаа харахгүй байгаа Арсланг юмуу Бурханы тэмдгийг үзэхэд, бөөн асуулт ургана. Хүмүүс чамайг яахаараа өөрсдийнх нь үзээгүй юмыг үзчихсэнийг мэдэхийг хүснэ. Ийм асуултад гагцхүү Бурхан л хариулдгийг би сурсан. Бурхан тааллаараа л үйлдэнэ. Бурхан Өөрийгөө хүмүүст өөр, өөр арга замаар илчилдэг. Энэ динамик Христийн бие дотор асуулт ургуулах бус, харин харилцан хамаарлыг бий болгох ёстой юм. Хүн бүр өөр, өөрийн гэсэн хувьтай бөгөөд удирдагч нар бие биеэ хүчжүүлж, уриална. Буруугаар ойлгогдож, буруу чиг рүү хөтлүүлэх аймшигтай. Бурханаас хүлээж авсан ойлголтыг чинь хүмүүс үнэлэхгүй байх аймшигтай. Гэхдээ ийм тохиолдол дээр ч Бурхан илүү том зорилгын төлөө ажиллаж байдгийг санаарай. Эсэргүүцэл, үл ойлголцол сэтгэлд чинь шүүх юмуу хорсол авчрахыг бүү зөвшөөр. Боловсруул.

Каспийн ханхүү ном руугаа эргэж орё. Баахан буруу эргэлттэй, аминд халтай явдлын эцэст хүүхдүүд маань эхэлсэн газартаа эргэж бууж таарчээ. Хамаг бие нь хөндүүрлэж, тамирдсан хүүхдүүд газар дээрээ л унаад өгөв. Люсид хэцүү байгааг Аслан мэдэх бөгөөд улам дордохоос нь сэргийлэн, түүнтэй уулзав.

Буудалласан газрынх нь гадаах сүүдрээс Аслан хүнд хүчир өдрийн дараа ч гайхмаар сэргэг байгаа Люсиг дуудав. Люси Аслангийн дууг сонсоод, баярлан гүйж очно. Люси өдрийнхөө үйл явдлыг тоочингоо, өөрийнх нь зөвлөгөөг сонсоогүй ах, эгч нараа шүүмжлэв. Арслан аман дотроо архирсан нь үг хэлэх гэснийх байв. Люси цочоод, өөрийгөө буруу юм хийсэн эсэхийг асуулаа.

“Гэхдээ би буруугүй байсан биз дээ, тийм биз дээ?”

Арслан Люсигийн нүд рүү цоо харав.

“Өө Аслан минь,” хэмээн Люси хэлээд, “Би бусдыгаа орхиод, яаж Тан руу ганцаараа очих билээ, тийм биз дээ...” гэлээ. Аслан юм хэлсэнгүй.²

Аслан Люсигийн нүд рүү цоо ширтсээр байлаа. Бурханы оршихуй юугаараа хүн бидний сарнимал харааг тийм тодорхой болгож өгдөг юм бол? Би олон удаа Бурханы оршихуйд өөрийгөө буруугаар ойлгогдсон, хор хохирол үзсэн хохирогч мэт явж ороод, зарим нэг сонголт маань цэвэр минийх л байсныг ойлгосон сон. Гэвч Арслангийн оршихуйд би ичгүүр мэдэрдэггүй. Харин ч хүч орж, урагшаа явахад бэлэн, бэлтгэл байдалтай болдог.

Хүн бүр амьдралдаа ийм хүнд байдалд ордог. Бурхан чамайг нэг зүг рүү яв гээд байхад, найз нөхөд, гэр бүл чинь нөгөө зүг рүү яв гэж дарамтална. Магадгүй чи олон нийтээ дагах юмуу эсвэл дуугаа хурааснаараа итгэл үнэмшил, ёс суртахуунаа хөсөрдүүлэх өдөөлтөнд орж байсан байх. Дарамтаас үл хамааран, Арслан дээр очиход, шалтаг хүчингүй болно. Тэдгээрийг чимээгүй хүлээж авна. Бурхан чимээгүй байвал, хамгийн сүүлд хэлсэн үгийг нь дахин санах ёстой байдаг гэж би олонтаа сонссон. Чи хэлсэн үгийг нь хүлээж авсан уу, хийсэн үү, хэлсэн үү, өгсөн үү? Үгүй бол, Арслан чиний хариултыг хүлээсээр байна.

“ЧИ ЭРСЛЭН...”

Хүн санал хураах юмуу санал зөрснөөс болж Бурхан чиглүүлгээ өөрчлөхгүй. Тэр бас яллах тоглоом тоглодоггүй. Бурхан чамайг ялаас үнэн зөв рүү хөдлөх хүртэл чинь хүлээсээр, сонссоор байна. Энэ даруу зангийн бэлтгэл байдал биднийг босож, Бурхантай хамт онгон зэрлэг байгаль руу алхах хүчтэй болгоно.

Си. Эс. Люис гуай энэ хөдлөшгүй үнэнийг Люси, Аслан хоёрын яриагаар маш тодорхой харуулжээ. Люси бусад нь дагалдахгүй байсан ч, өөрөө Асланг дагах ёстой байснаа ухаарсан. Энэ илчлэлтэй хамт шинэ хариуцлага ирнэ. Аслан түүнд дахин боломж олгож, ах, эгч нараа сэрээгээд, Аслантай дахиж уулзсан, одоо түүнийг дагах цаг ирлээ гэж хэлэхийг хүсдэг.

“Гэхдээ тэд надад итгэхгүй!” хэмээн Люси хэллээ.

“Тэр хамаагүй” хэмээн Аслан хэлэв.

“Ээ, одоо яадаг билээ. Тантай дахин уулзсандаа жигтэйхэн баярласан юмсан. ...Би Таныг өнгөрсөн удаагийнх шигээ л ирээд,

архираад л бүх дайсныг үргээнэ гэж бодсон юмсан. Гэтэл одоо бүх юм аймшигтайгаар эргэх нь байна” хэмээн Люси хэллээ.

“Бяцхан минь, чамд хэцүү байгаа. Гэхдээ юмс хэзээ ч хоёр давтагддаггүй юм” хэмээн Аслан хэлэв.

Байзаарай. Бурханы чиглүүлэгт хүний хариулж байгаа энэ зураглалд би дуртай. Хүн адал явдалд зэхэхдээ, бүхнийг “аймшигтайгаар” эргэнэ л гэж төсөөлдөг. Люси найдаж байснаа одоо нуугдаж эхэлж байна.

Цаашаа явъя:

Люси Аслангаас нуугдах гэсэндээ түүний зогдорт нүүрээ шигтгэв. Гэтэл Аслангийн зогдор ид шидтэй юмсанж. Арслангийн хүч өөрт нь нэвчиж байгааг Люси мэдрэв. Тэгснээ гэнэт суучихав.

Люси “Аслан минь, намайг уучил. Би одоо бэлэн” гэж хэлэв. Аслан түүнд “Чи одоо эрслэн. Эдүгээ Нарниа шинэчлэгдэх болно”³ хэмээн айлдлаа.

Би Аслангийн энэ мэдэгдлийг уншаад зог тусч билээ. “Чи одоо эрслэн.” Бурхан суугаад, уйлахаа болиод, бэлэн болсон охин бүртээ энэ үгээ мэдэгдэхийг хүсдэг гэж би итгэдэг. Тэгээд Бурхан “Чи зоригтой. Эдүгээ чи Миний үзэл санаатай. Чи хүчээ мэддэг. Чи тулаанд бэлэн” гэж тунхаглаж чадна. Чи даян дэлхийг хамарсан том дайнд орсон их цэргийн нэг болохоо санаарай.

УРАМ ӨӨРЧЛӨЛТИЙГ АВЧИРДАГ

Энэ дайн ямар үр дүнтэй гэж? Харанхуй улам тэлсээр, гэрэл улам бүүдийсээр л байх шиг.

Эдүгээ дундаа арсланг дуудах цаг болжээ. Бид чухал бус юмстай хөөцөлдөөд, арслангаа мартсан байж болох. Харанхуйн хүч бидний хариуцаж байгаа газар дээр эмх замбараагүй байдал учруулахад, бид цолоороо хуваагдсаар, төвлөрөл маань сарнисаар. Эргэн тойронд маань ид тулаан өрнөж байхад, бид хуаран дотроо байлдаад завгүй.

Эрин үеүдийн Хаан, мөхөшгүй, үл үзэгдэх цор ганц Бурханд хүндлэл ба алдар нь үеийн үед байх болтугай. Амен. Тимот хүү минь, чиний тухай урьд нь хийгдсэн эш үзүүлэгчүүдийн “чи сайн тэмцлээр тэмцэгтүн” гэсэн тушаалыг би чамд даалгаж байна.

Ингэхдээ итгэл, сайн мөс чанараа сахь. Зарим нь үүнийг үл ойшоосноос итгэл нь, сүйрсэн хөлөг онгоц мэт болжээ. (1Тимот 1:17-19)

Ирээдүй рүү маань амлалт шиджээ. Бид дайнд гэрэл, найдварын зэвсгээр байлдана. Бурхан үхлийг дахиж ялахгүй. Бурхан үхлийг хэдийнээ ялсан. Гэвч энэ бол бидний хувьд Бурханы ялалтыг биелэл болгож, бусдыгаа урамшуулан дагуулах цаг.

Манай улс одоо ч ёс суртахууны, эдийн засгийн, сүнсний сүйрлийн ирмэг дээр байна. Бид дэлхий даяар ч, улс орондоо ч дайсан, алан хядагч нарт бүслэгдээд байна. Галын шугам бүр дээр айдас, хорлол ажлаа хийж, зарим нөхөд маань биднийг сэтгэх толгойгүй гэж үзэж байна.

Миний бодлоор, манай одоогийн уур амьсгал хэдэн зуун жилийн өмнөх Английнхтай адилхан байх шиг. Бутарч, сэглэгдсэн газраас эх гүрэн бий болж, залуу бүсгүй эрслэнг сэрээх үед Их Британий хүмүүс шинэчлэгдсэн байдаг.

Хорин таван настай Елизабет санхүүгээр ч, ёс суртахуунаар ч бүрэн дампуураад байсан улсын хаанд ширээнд суув. Англи гаднаасаа тал бүрээсээ Католицизмээр бэхэжсэн, хавьгүй хүчирхэг улсуудын араа шүдэнд оржээ. Харин дотроо дотоодын шашны дажнаасаа болоод хэд хуваагдаад байв. VIII Хенри хааны болоод хатан хаан Мэригийн самуурсан захиргаа Их Британийг сөхрүүлжээ.

Тийм боловч, хатан хаан Елизабет хаан ширээнд өргөмжлөгдөх ёслол дээрээ юу гэж хэлснийг үзнэ үү: “Над дээр буусан дарамт намайг бишрүүлэв.”⁴ Тэр эмэгтэйн энэ үг хэдэн зууны хойно амьдарч буй надад цагаа олсон, өдөөн хатгасан үг шиг санагдах. Ямар гээчийн бүсгүй хүн тэр үлэмж дарамтыг биширдэг билээ.

Тэр хатан хаан өөрийгөө хэт залуу, эмзэг, буруу хүйсийн хэмээн шалтаглаагүй нь юутай сайхан. Тэрбээр үй түмэн бэрхшээлийг туулж байж, хаан ширээнд суусан. Тэрбээр VIII Хенри хааны зулбасгаараа дуудуулсан ч, няцсангүй. Харин ч бишрэхийг сонгож. Бишрэл нь түүнийг Бурханд найдах, ер бусын, гайхамшгийн ертөнц рүү хөдөлгөжээ.

Елизабет эхнээсээ л үгээ болгоомжтой сонгоход суралцжээ. Тэгээгүй байсан бол, тэрбээр хорин тав ч наслахгүй байж. Төрөхөөсөө үхэх хүртлээ Елизабет хортон дайснуудынхаа дунд л цэцэглэжээ. Ордонд нь ч, улсад нь ч Елизабетиийг хэлсэн үгээр нь ороох санаатай урвагч, шарвагч нар дүүрэн байж. Елизабетиийн өмнө хатан хаан байсан, эцэг нэгт эгч Мэри нь хаанчлалынхаа хугацаанд цаазалсан хүнийхээ тооноос болж “цуст Мэри” хочийг авчээ. Мэри Елизабетиийг хөнөөх бүх арга чаргыг хайж, Елизабетын эх Anne Болийнгийн толгойг авах хүртлээ хорьж байсан

Лондонгийн цамхагт хүртэл хорьжээ. Елизабетийг чиглэсэн хатан хаан Мэригийн довтолгоо, хуйвалдаан өөрийнх нь үхлээр төгсөв.

Елизабетийг хатан хаан болоод удаагүй байтал, түүний төрөл садны хүн болох, Католик сүмээр араа даалгасан, Шотландын хатан Мэри Их Британид эргэж ирээд, Английн хаан ширээг булааж авах гэж удаа дараалан оролджээ. Эцэст нь эрээ цээргүй хуйвалдаан нь ил болж, Елизабет түүнийг ч цаазаар авсан. Елизабет урвалт, гадуурхал, үл итгэлцэл - бүгдийг нь үзсэн ч, тэр бүх бэрхшээлийг ашиглан, Английн түүхэн дэхь хамгийн аугаа захирч гэдэг нэрээр гоёж чадсан юм.

I Елизабет хатан хаан гэрлэж, өв залгамжлагч төрүүлэхийн оронд хаанчлалынхаа сүйт бүсгүй ч, эх ч байх тангараг өргөжээ. Энэ ер бусын үнэн зориулалт нь түүнд хаанчлалаа хүчитгэн бэхжүүлэх стратеги дээр төвлөрөх эрх чөлөө олгосон байна. Дээрээс нь өөрийгөө тасралтгүй боловсруулж, сайжруулахын тулд тэрбээр цэцэн зөвлөхүүдээр хүрээлүүлж, ард түмнийхээ сайн сайхны төлөө л хандав.

Елизабетын хаанчлал дор:

- Шашны бүлэглэлүүд Английн Сүм дор нэгдсэн.
- Английн эдийн засаг төвлөрсөн төлөвлөгөөт хэлбэрээс бие даасан, төрөлжсөн хэлбэртэй болсон.
- Шинжлэх ухаан, урлаг цэцэглэсэн.
- Англи усан цэрэгтэй болсон.
- Америк тивийн судалгаа, суурьшил оргилдоо хүрсэн.

Елизабет хатан хаан улсаа Алтан үе рүү оруулж, жижигхэн хаанчлалыг эх гүрэн болгожээ.

Түүнийг эрслэн гэдэгт ч гайхалтгүй. Энэ олон ололтыг үл харгалзан, тэрбээр хатан хаан байхыг хэзээ ч ачаа зовлонд үзээгүй байна. Тэрбээр:

“Хаан байхуй, титэм зүүхүй нь зүүсэндээ таашаалтай байхаасаа илүү үзэгч нарт л сүр жавхлантай.”⁵ гэж хэлжээ.

Елизабет титмээрээ зүгээр нэг гангараагүйг түүх хэлдэг. Тэрбээр шинэ санаачилга, худалдаа, судалгааг манлайлжээ. Тэрбээр нэгдмэл эвслийн хүчийг ойлгож, Франц тэргүүтэй улсууд хувьсгалын хөлд үрэгдээд байсан ч, үндэсний хувьслыг тордон бойжуулжээ.

Елизабет тулаанд ч аймшиггүй байв. Түүний цэргүүдээ манлайлан тулаанд орохоосоо өмнө хэлсэн үгээс нь хэсэглэн хүргэе.

“Бурханыхаа өлмийд тэргүүн хүчээ, албатуудынхаа үнэнч зүрх, сайн санаанд аюулгүй байдлаа даатгахыг хэзээд мэддэг сахилгаас

минь дарангуйлагч нар аюугтун. Тиймээс эдүгээ би зугаа гаргах юмуу цусанд улайрсандаа бус, харин шийдэлд хүрэх гэсэндээ та бүхний дунд үхэх, сэхэхээ үзэлцэх халуун тулааны голомтонд зогсож байна. Бурханыхаа, хаанчлалынхаа, хүмүүсийнхээ төлөө нэр төр, цус юугаа тоосонд өргөө.

Бие маань бүсгүй хүний мөхөс, дорой боловчиг, Хааны дайтай зүрхтэй, Хааны дайтай дотортой билээ би. Парма, Испани, Европын аль нэг Захирагч атгаг санаа, бузар нүдээ Хаанчлалын маань хилээр давуулах аваас, би нэр төрөө алдсанд орбол, зэвсэг барина... Тийнхүү удахгүй миний Бурхан, Хаанчлал, Хүмүүсийн маань дайснуудын дээр дархан ялалтаа мандуулах болно.”⁶

Тэгээд тэд ялсан.

Ганц л эмэгтэй айхыг биш, бишрэхийг сонгох үед юу болдгийг харж байна уу? Елизабет хувь тавиландаа хямгатай байж, Бурханыг аймшиггүй дагасан. Тэрбээр Бурханы зөвлөгөөг алдаг оног дагадаг байгаагүй, харин гурван хэл дээр тэмдэглэл хөтөлдөг байжээ. Үр дүн нь ч биширмээр гэхэд багадмаар. Магадгүй, Бурхан чамайг ямар нэгэн ер бусын юмуу бүр аймшигтай зүйлд дуудаад байгааг чи мэдэрч байгаа байх. Тийм бол, Люсигийн ч, I Елизабет хатан хааны ч үлгэр жишээгээр урамшин давшихыг уриалж байна.


Хүмүүс чиний өмнөөс юу гэж харах нь хамаагүй. Бурхан хэлсэн бол, Түүнд итгэ. Яв гэсэн газар руу нь явж, хэлсэн үгийг нь сонс. Өмнө чинь яваа Арсланг дагаж, хүмүүс ойлгохгүй байсан ч, “мэдээд байгаа” зүйлдээ найд.

Бишрэхэд бэлэн үү?

ШИВНЭЭГЭЭС АРХИРАА

Би арслан байгаагүй ч,
арслан шиг архирах ёстой санагдсан.

УИНСТОН ЧЕРЧИЛЛ



Арслан архирдаг.

Чи үүнийг мэднэ. Гэхдээ эрслэн ч архирдгийг мэдэх үү?

Арслан, эрслэн хоёр архирсан шиг архирахын тулд тусгай бэлтгэл байдал авдаг байна. Хүч чадлын ийм ориг тунхаглал нь сөгдөх бэлтгэл байдлыг шаарддаг ажээ. Зантгар толгойгоо бөхийлгөж, уушги дүүрэн агаар авахын тулд цээжээ сунгадаг байх нь. Тэд шөнийн аниргүй агаар мандалд 8 км газар аялж, хүн адгуусын зүрхийг үхүүлэх хүчтэй, чанга мэдэгдлээ хийхдээ, бараг тэсрэх шахдаг байх гэж би боддог юм. Арслангийн гайхамшигт архираа нь чамайг байгаа газар дээр чинь хөшөөнө.

Үүнтэй адил, Бурханы эрслэн ийм хүчин чадалтай дуу гаргахын тулд одоогийн бэлтгэл байдлаа өөрчлөх л хэрэгтэй болно. Архирах чадвартай байхын тулд бид өнгийсөн толгойгоо бөхийж, сөгдөх ёстой. Ийм даруу байдлын байршил, залбирал нь биднийг Ариун Сүнсний шинэ амьсгалаар дүүргэх бэлтгэл байдалд оруулна. Бид Бурханы дүүрэн амьдралыг тээх хүчин чадлаа давах үедээ архирдаг гэж би итгэдэг. Бид Бурханы үнэн, хайр, сайн сайхныг харамлаж татганахаа болихдоо, хамаг тэнхээгээрээ Бурханыг хашхиран тунхагладаг.

Гэхдээ бидний архираа зүгээр нэг дуу чимээ гаргадгүйгээрээ эрслэнгийн архираанаас ялгаатай. Бидний мэдэгдэл ину үг, үйл хэрэг,

итгэлийн үйлсийн тэнгэрлэг нэгдэл байх болно. Итгэл, найдвар, хайрын нүдэнд үл үзэгдэх юмс нь хувь хүн дотор биетэй болж, дэлхийн хэрэгцээнд нэгдмэл хариу болон илэрхийлэгдэх үед Бурханы хайр, бидний архираа сонсогдох болно. Бид Арслангаа үлгэрлэн дагах үед Түүний архирааг дэлхий сонсоно. Ингэмэгц энэ дуу хоолойг доод төвшний эзэд сонсоод, “Ганцхан Бурханыг хүндэтгэ!” хэмээн хашхирцгаана, тэд.

Дэлхий дүүрэн архираа байна. Би архираа гэдэг ойлголтыг судлаж байхдаа, маш олон зүйл архирах чадалтай байдгийг сурсан билээ. Тэнгис далай архирна. Талын салхи ч архирна. Өндөрлөгөөс унаж байгаа хүрхээ ч архирна. Тэмцээн үзэж байгаа хөөрсөн хөгжөөн дэмжигч нар ч архирна.

Тэнгэрийн сэнтийн өмнөх дөрвөн амьд бүтээл ч “Ариун, ариун, ариун” хэмээн архирахад, “дуудагчийн дуунаар босгоны суурь чичирсэн ба тэгэхэд сүм утаагаар дүүрч байлаа” (Исаиа 6:4). Бид тэдний үгийг газар дээр дуун хэлбэрээр давтдаг боловч, Ариун Бурханы энэ мэдэгдэл нь архираанаас л эхтэй.

Тиймээс чи тэдний эсрэг эдгээр бүх үгийг эш үзүүлж, чи тэдэнд хэлэхдээ «ЭЗЭН өндөр дээрээс архиран Ариун оршихуйгаасаа дуугаа гаргана. Тэрээр сүргийнхээ эсрэг хүчтэйгээр архирна. Тэрээр дэлхийн бүх оршин суугчийн эсрэг Усан үзмийг гишгэлдэг хүмүүсийн адил хашхирна. (Иеремиа 25:30).

Мөн:

Би догшин уураа гүйцэлдүүлэхгүй. Би дахин Ефраимыг сүйтгэхгүй. Учир нь Би хүн бус, Харин Бурхан юм. Би та нарын дунд буй Ариун Нэгэн бөгөөд Би хилэгнэл дотор ирэхгүй. Тэд ЭЗЭНий араас алхах бөгөөд Тэр арслан мэт архирах болно. Үнэхээр Тэр архирч, Хөвгүүд нь баруунтаагаас дагжсаар ирнэ. (Хосеа 11:9-10)

Шивэгнээг юу шивнээ, хүржигнээ, уйлаан, хашхираанаас том болтол өсгөдөг вэ? Архираа нь дан дууныхаа чадлаар хүчирхэг болдог уу?

ШИВНЭЭГЭЭС ЭХЭЛНЭ

Үүнийг судлахын тулд эхлээд шивнээний эрч хүчийг мэдье.

Магтаалч:

Тэрээр Египет нутаг даяар явахдаа Иосефын дотор гэрчлэлийг тогтоосон. Тэгэхэд би мэдэхгүй хэлээ сонсов. (Дуулал 81:5) гэж бичжээ.

Магтаалч Бурханы магтаалын гайхамшигийг тайлбарлажээ. Магтаалч Бурхантай тогтоосон эвслээ магтан, дуулсан бус уу? Магадгүй Бурхантай тогтоосон харилцаа нь эхэлж байсан гайхамшиг руу магтаалаараа дахин зочлоод ирсэн байх. Бид өмнө сонсоогүй зүйлээ таньдаггүй. Давид хоньчин хүү байхдаа Бурханы шивнээг анх сонссон бол, хожим Бурханы дуу хоолойг хаа ч явсан сонсдог болсон. Бурханы дуу хоолойг “хамгийн зөөлхөн шивнээ” хэмээн дүрсэлжээ. Гайхамшигт Бурхан маань хүний амьдралын хатуу бодит байдлыг онцлохдоо, хамгийн эвлэгхэн, зөөлөн өнгөөр өгүүлдэг.

Тийнхүү биднийг ч чимээгүй байхыг уриалдаг: “Тэмцэлдэхээ больж Бурхан гэдгийг минь мэд” (Дуулал 46:10).

Өндөр Бурхан, Бүтээгч маань хүүхдүүдээ Өөрийнх нь шивнээг сонсож, тайтгарна гэдгийг мэдсэн гэдэгт би итгэнэ.

“Хашхирдаг Бурханаас” илүү “шивнэдэг Бурхан” гэдэг санаа намайг илүү гайхшруулдаг. Тийм том Бурханаас том л дуу хүлээмээр байтал, гэнэтийн шивнээ. Энэ зөөлөн долгионоор л Бурхан бидний анхаарлыг төвлөрүүлж чаддаг. Гүн нь гүнээ дууддагтай адил, Бурханы шивнээ нь мутрынх нь бүтээл болох хүүхдүүдэд нь хүрдэг Бүтээгчийнх нь цуурай ажээ.

Елиа Бурханы дуу хоолойг салхи, газар хөдлөлт, галаас хайсан ч, шивнээн дундаас л олсон (1 Хаад 19:12-ыг үзнэ үү). Елиа намуухан, зөөлөн дууг сонсоод, агуйгаас гараад Бурханы үгийг сонссон.

Дуугаа аядаж, чихээ тавьсан хүнд “шшш” гэсэн шивэгнээ нь гүн гүнзгий, дотно зарлал болдог. Бурханы анир чимээгүй дуу хоолой дор сүнс маань Аавын маань дотно шивнээг сонсоно. Хүн бүр Бурханы шивэгнээг сонсохыг хүсдэг. Чи Бүтээгчээ сонсдог байхаар бүтээгдсэн. Сэтгэлийн чинь цөмд хандан үгээ хэлж, зүрхний чинь санаашралыг биелүүлэхийг Түүнд зөвшөөр.

Бурхан ярихдаа шивнээгээр эхэлдэг гэж би итгэдэг. Ямар ч чанга зүйл шивнээгээр л эхлэх. Би бие давхар байхдаа дотроо бяцхан түлхэлт мэдэрсэн бөгөөд энэ нь ирээдүйд мэндлэх үрийн минь шивэгнээ байсан юм. Уйлаан дотоод шивэгнээгээр л эхэлнэ. Магадгүй, чиний дотоод сэтгэлийн уйлаанд Бурхан шивнээгээрээ хариулахыг чи үзсэн байх. “Бурхан минь, би өлсөж байна, айж байна, ганцаардаж байна!”

Гэтэл Бурхан “Битгий ай, хүү минь, Би энд байна” гэж хариулсан.

Заримдаа би эмэгтэй хүнийг шивэгнээ гэж төсөөлдөг. Айсан үрээ

бүүвэйлж байгаа эх хүн хашхиралгүй, шивэглэдэг. Бурханы охид дотоод шуургаа бие биедээ шивэглэж байхыг би олон жил сонссон. Бараг гучин жил би нөхөртэйгээ орондоо шивнэлдэж байна. Шөнийн дээвэр дор, дулаан хөнжил дор хашхирч ярих нь ямар ч зохицолдоогүй мэт. Ор бол шивнээ, амралт, дотнослын газар.

Цуглаанд гэр бүлээрээ сууж байхдаа, би шивэглэж ярьдаг. Би хатуу юмуу худлаа зүйл сонсохоороо дуугаа намсгаж ярьдаг. “Энэ буруу” гэж шивнэдэг. Жон ч, хөвгүүд маань ч надад: “Таны зовнилыг ойлгож байна. Чанга ярих хэрэггүй. Бид сонсож байна” гэдгээ илэрхийлэхдээ, толгой дохин, гарыг маань илбэдэг.

Заримдаа шаардлагатай учраас, шивнэнэ. Хэт жижиг, хэт туйлширсан, гажсан эсвэл тас буруу зүйлтэй нүүрэлдэлгүй, дуугүй өнгөрөх нь буруу мэт. Магадгүй, би үүрч яваа дүрийнхээ улмаас, иймэрхүү юмсыг үндэслэж амжихаас нь өмнө аврахын тулд үнэнийг бувтнах ёстой байдаг байх л даа. Шивнээ маань чангаар хэлэгдсэн зүйлийг няцаадаг.

Би Бурханы надад шивэглэнэгүй, амьдралд маань цохогдоогүй мэдэгдлийг сонсохоороо шивэглэнэх ёстой болдог. Чи ч бас ингэж үзсэн л байх. Чи Бурханы шивэглэнэ сонссон бол, тэр эрхэм үгийг анхаарах ёстойгоо мэднэ. Бид номлох юмуу заахдаа, ихэвчлэн бусдаас сурсан зүйлээ давтаад байдаг. Гэтэл Бурхан бидэнд айлдах нь тэс өөр байдаг буюу. Бурханы шивнээ нь хөнгөн зүйл биш бөгөөд хүндэтгэлийг минь хүртэх ёстой.

Бурхан хөвгүүд, охиддоо шивэглэдэг. Энэ бол Бурханы шивнээг сонсож, шивэглэнэх цаг гэдгийг чи мэдэрч байна уу? Магадгүй чи яг одоо ч сонсож байж болох. Шивнээ нь нууцын бөгөөд зөгнөлийн аялга болой.

Хүмүүс мянга мянган жилийн турш Бурханы шивнээг хайсаар ирсэн бөгөөд эрэл хайгуул нь ихэвчлэн л аниргүй хариу мөргөсөөр иржээ.

Би та нарт хэлье. Та нарын харж байгааг чинь олон эш үзүүлэгч ба хаад харахыг хүссэн авч хараагүй мөн сонсож байгааг чинь сонсохыг хүссэн авч сонсоогүй юм. (Лук 10:24)

Эртний эш үзүүлэгч, хаад сонсох гэж чихээ дэлдийлгэж байсан ч, Бурхан чимээ сураг өгөөгүй аж. Тэд ирээдүй рүү нүдээ ширгэтэл ширтсэн ч, мандал дээр юу ч үзэгдсэнгүй. Анир ч үгүй, хараа ч үгүй, дүр дүрс ч үгүй, “Сонсоу уу?” гээд дэргэдхээсээ асуучихмаар, ямар ч чимээ ажиг гарсангүй.

Тэгтэл цаг нь болж, мэдээ ирсэн бөгөөд ирэх ирэхдээ шивнээгээр биш, харин хүний дүрээр морилов. Шивнэгдсэн Үг нь махан бие болж ирээд,

хүмүүсийн дунд хүрч, зааж, эдгээж, үхлээс амилуулахдаа чангаар өгүүлэв. Харамсалтай нь, нөгөө чихээ дэлдийгээд байсан хүмүүс нь сонсох чихгүй болцгоожээ. Бурхан тэдний хүссэнээс өөр арга замаар дуугарсан учраас, тэд үл хэрэгсэв. Есүс татвар хураагч, загасчдад шивэглэж, Фарисайчууд руу хашхирсан юм.

Есүс Өөрийгөө хэн болохыг, хаанаас ирснийг амаараа тайлбарлахын оронд зүгээр л амьдарлаараа илчилсэн. Үйлдлээрээ, ямар ч үгээр илэрхийлэшгүйгээр чанга айлдсан буюу.

ШИВНЭЭГЭЭС ХАШХИРАА

Миний найз Бобби Хьюстон бидэнтэй л адил тэнгэрийн дуу хоолойг сонсож, Өндөр Бурханы Сүнс Бурханы охидод ямар хил хязгаар, хэлбэр дүрсийг хариуцуулж байгааг ажигладаг. Тэрбээр бидний харж байгаа зүйлийг:

“Бурханы шивнээ хашхираа болохуй” хэмээн яруухнаар найраглажээ.

Даян дэлхийн эмэгтэйчүүд ч энэ үгийг цуурайтуулж байна. Бурханы шивнээ гэж юу вэ? Яагаад энэ шивнээ чангараад байна? Бид найдварынхаа тунхаглал болгон үнэн ёсны төлөө нэгэн дуугаар хашхирч байна. Есүсийн ээж Мариа хүмүүсээ аврах Бурханы амлалтыг хүлээж авахдаа, дотроо тээж, зүрхэндээ нандигнасан байдаг. Өнөөдөр зүрхэнд нь суулгаж буй Бурханы амь, эрх чөлөөг тунхаглаж буй Бурханы охидын тоо өссөөр байна. Үүний үр дүнд хүн тус бүрийн зүрхэнд шивнээгээр эхэлсэн зүйл олны дуу хоолой болж байна. Удаан тогтсон аниргүй байдал эдүгээ дуу хоолой болон өргөгдөж байна.

Харанхуйд та нарт юу хэлснийг минь гэрэлд ярь, чихэнд чинь шивнэснийг минь дээвэр дээр тунхагла. (Матай 10:27)

Есүс эхлээд Өөрөө шивэглээд, дараа нь дагалдагч нартаа хашхир гэжээ. Тэрбээр ухаарал, гэгээрлээ ойрын хүрээндээ дамжуулаад, дараа нь энэ нууцыг нээлттэй тунхаглахыг дагалдагч нартаа тушаасан.

Бид өчигдрийн “Бурханы шивнээч” нар маргаашийн зарлан тунхаглагч нар болох цаг дор амьдарч байгаа гэдэгт би итгэнэ. Бид үүний хүчийг бүрэн ойлгох ямар ч боломжгүй ч, та нарын дундаас олон хүн хэдийнээ бөхийгөөд, сонсож байгаа гэдгийг мэдэрч байна. Ойртох тусам, бүдэг шаржигнаа - дотоод эргүүлгийг сонсоно.

Бурханы шивнээ заримдаа айдас төрүүлмээр хүнд.

Барьц алдмаар зэвүүн хүчтэй.

Нэгэнт ажиллаад эхэлсэн бол, зогсоох боломжгүй, хүчирхэг.

Түүнийг зэмлэхэд тэнгэрийн багананууд ганхаж, гайхацгаадаг.

Тэр хүчээрээ далай тэнгисийг номхруулж,

Өөрийн ойлголтоор тэрээр Рахабыг бут цохисон.

Түүний амьсгалаар тэнгэр цэлмэдэг.

Зугтагч могойг тэрээр мутраараа цоо хатгав.

Харагтун, Түүний замуудын өчүүхэн нь энэ юм.

Түүний талаар бидний сонсдог үг ямар амархан бэ!

Гэвч Түүний хүчит нүргээнийг хэн ойлгож чадах вэ? гэв.

(Иов 26:11-14)

Бид... яг яах бол? Мэдээж чичирнэ. Гэхдээ шивнээг мэддэг, үүнд итгэдэг нь Бурханы хашхирааг эсэргүүцэхгүй. Бидний дотоод гүн Түүний өндөр дуу хоолойг бишрэн, анхааран сонсох л болно. Тэгээд Бурханыг дөнгөж шивэгнэхийн төдийд л өдий дайны хүч, эрх мэдэл гарах аж. Бурхан амьсгалаа гаргахын төдийд л тэнгэр цэлмэх!

Бурхан миний амьдралд анх амь, эрх чөлөө, найдвар, тамир, зэрлэг чанар, үнэ цэнэ тэгээд гоо үзэсгэлэн шивэгнэхэд, энэ бүхэн намайг сунгасан юм. Миний хувьд өргөжих юмуу өсөх ямар ч орон зай байхгүй гэмээр байхад л Бурхан надад томрохыг санал болгосон.

Миний түгшүүрийг ингэж дүрсэлж болох юм: Чи амьдралдаа хэзээ ч төсөөлж яваагүй, ач холбогдолтой шивнээ дуулжээ. Тухайлах юм бол, чиний амьдралдаа хүлээж авсан бүхэн чинь үнэн биш гэсэн шивэгнээ. Энэ шивнээ чиний ил тодоор мэдэгдсэн зүйлтэй чинь тас зөрөлдөх.

Тийм боловч, шивнээ нь аль нэгэн нууц, гүн газар руу даллах бөгөөд санаж бодоо ч үгүй санаашралыг чинь сэрээх. Энэ нь чиний зурагтаар үзэж, ном, сэтгүүлээс уншсан зүйлээс чинь үнэн сонсогдоно. Илчлэлийн энэ шивнээгээр чи тэс өөр хүн болно. Гэнэт чиний хэдхэн өдрийн өмнө мэддэг байсан газар, харилцаа, чаддаг байсан харилцан яриа чинь бүгд хачин эвгүй санагдаж эхэлнэ.

Би анх Бурханы шивнээг сонсоход, ийм л явдал болсон. Би их бага хэмжээгээр буруу нөхөдтэй найзлаад байгаагаа мэдэж байсан ч, буруу итгэлээр яваад байснаа ёстой мэдээгүй. Яг л юманд туугдаад одсон мэт боловч, дараагийн боомтоо яаж олохоо мэдэхгүй. Өмнө мэддэг чаддаг байсан юмс маань эдүгээ баталгаагүй, тодорхойгүй, таагүй болов. Амьдралдаа дассан сурсан зүйл маань өөрчлөгдөөд, урьдынхаараа байх аргагүй болов.

Тийм ээ, шивнээ нь биднийг ямар нэгэн аргаар мэддэг чаддаг юмнаас маань хурдан салгах хүчтэй. Зарим нь үүнийг төсөөлөл л гэх байх, зарим нь та зүгээр л амьдралынхаа хэв маягийг өөрчилж л гэх байх.

Харин би Бурханыг хайх бүрий, Тэрбээр надад шивэглэж хариулдаг.

Намайг анхаараач, надад хариулаач. (Ойртож ирээд, хариугаа шивнээч. Би Танаар дутаж байна) (Дуулал 55:2)

Түүний хариулт биднийг тодорхой хэмжээгээр тусгаарлах бөгөөд тодорхой хугацаанд тавгүй санагдаж болох. Тиймээс Бурханы шивнээг сонсохдоо дуугаа аядаж, сонсож, дотоод шивнээгээ олзолж авах нь чухал.

Людвиг Ван Бетховен “Цаасан дээр буулгах хүртэл эргэн тойронд минь өнгө дуу аялгуулж, архирч, шуургална.”¹ гэсэн байдаг. Тэрбээр дотроо сонссон ноотыг үзэглээгүй бол, яанам? Хөгжим нь бидэнд хүрэхгүйгээс гадна хөгжмийн зохиолч маань өөрийн олзолсон, өнгө дууны найрал хөгжмөөр нь сэрсэн бодол, хайр, мөрөөдөл, онгодоо гээх байж.

Бурханы шивнээ дотор минь бодлын шуурга, архирааг сэрээх үед би үүнийг нь тэмдэглэж авах хүртлээ бачуурдаг. Тэнгэрээс амьсгалтай шивнээг олзолж авах олон арга бий. Зарим маань үүний өнгө дууг үзэглэж авдаг бол, зарим нь хөгжим болгож бичнэ. Зарим нь мессеж, кино, түүхээр дамжуулан агуулгыг нь чанга цуурайтуулна. Харин зарим нь дүрслэх урлаг, уран барилгаар дамжуулан тэрхүү бүтээлч шивнээнд хэлбэр, үйл ажиллагаа хайрлана.

Арга барил нь хамаагүй, амьдруулах нь л чухал.

ШИВНЭЭГЭЭ ЧАНГААР АМЬДРУУЛ

Бид бүгдээрээ л “Чанга амьдар” гэж ярихыг сонссон ч, би үүн дээр ганц үг нэмчихмээр байна. Дотор байгаа зүйлээ чангаар амьдруул.

Ральф Уальдо Эмерсон “Өөрөө дотроо олж сонссон шивнээндээ чих тавихаас нааш ямар нэг онцсайн, итгэл үнэмшилтэй зүйл бүтээдэг хүн үгүй юм.”² гэж хэлсэн байдаг.

Өөрөө өөрийгөө сонсож сур. Өөрөө ганцаараа л сонсож чадах зүйлээ бусдаас бүү асуу. Ингэх юм бол, чи хүнийг Бурханы зүрхэнд чинь тусгасан шивнээнээс дээгүүр тавина. Бурханы шивнээг хүндэтгэж, Түүний онцсайнаар зүрхэнд чинь дамжуулж байгаа зүйлийг сонсох цаг гарга.

Бид голдуу ганцаараа байхдаа л шивнээ сонсдог. Гэхдээ ганцаархнаа олж сонсдог нь биш. Бурхан дуугаа аядаж, сонсдог хүнтэй ярих дуртай. Ариун Сүнсийг тодорхой сонсохын тулд хангалттай хугацаанд дуугаа

хураагаад, дараа нь үгийг нь хүчтэйхэн сорох хэрэгтэй. Өөрийнхөө илэрхийллийн хувийг олзолж авсан бол, бусдын шивнээг ялгаж салгах чадалтай болно. Чимээгүй сонсох улирал нь тав тухгүй хэдий ч, аюулгүй боомтод хүрэх гэж байгаа л бол, хийх л ёстой.

Миний хувьд, ганцаараа байж, сонсох улирал маань 2006 оны адгаар Хелен, Бобби, Лиза, Дебора тэргүүтэй хүчирхэг эмэгтэйчүүдийн багтай Филиппин руу аялахад дуусч билээ. Бид даян дэлхийн эмэгтэйчүүдэд үнэ цэнэ, хүч хайрласан сургалтыг эхлүүлэх ажлаар дөрвөн улсаар аялав.

Биеэ авч явж байгаа байдал маань конференцийг тэгтэл эрс тэс өөрчлөх юм чинээ санаагүй байлаа, би. Конференц миний хэлсэн үгийг ч, хэлсэн маягийг ч өөрчилсөнгүй. 2006 оны адаг гэхэд миний асуулт тавих, уучлалт гуйх хоёр маань л цөөрөөд байсан байх.

Конференцийн дараа би Бурханы шивнээнд илүү дотно, илүү үнэнч болов. Түүнээс өмнө би зөрчилтэй, тусгаарлагдмал тэгээд маш их ганцаарддаг байлаа.

Хуваарийн дагуу, би түрүүлж номлов. Дуусгаад, бусад эмэгтэйчүүдийнхээ үгийг залгилж эхлэв. Балга бүр миний тамирдсан, төөрсөн сэтгэлд амь юүлж байлаа. Яг л номлогч эмэгтэй болгон тод байдал, хүч, тосолгоо, эелдэг чанарыг ярихдаа, миний доторх шивнээ, нууцыг уудлаад байх шиг л. Нулимс хоёр хацраар минь тогтоож барихын аргагүй урсаж, ангамал сэтгэлийг минь дэвтээв. Санаашрал, асуулт минь хариулт авав.

Сүүлийн хичээлийн дараа би зарим хүүхнүүдтэйгээ хамт зочид буудал руугаа зөөлгөв. Дотор минь болж байгаа юмсыг үгээр хэлбэршүүлэх гэж ядан, түгдчиж байлаа.

“Гэхдээ энэ чинь чиний л бичдэг, ярьдаг зүйл шүү дээ” хэмээн Бобби хэлэв.

Түүний зөв. Гэхдээ би үүнийг чангаар цуурайтахыг нь сонсож байсангүй.

Олон жил би битүү орон зай дотор өөртэйгээ л яриад байх шиг санагдаж байлаа. Хараад байгаа хэрнээ, өөр нэгэн хүн түгжээтэй хаалгыг ярж, гэрэл, инээдээр бялхсан, цэлийсэн том орон зай руу урих хүртэл гарч чадахгүй явжээ.

Бобби гараа сунгаад, “Чи ганцаараа биш” хэмээн хөлийг минь илбэв.

Би толгой дохиод, хүүхэд шиг л айж ичэлгүй уйллаа. Тэр орой бүх юм өөрчлөгдөв. Би бусадтайгаа нийлэх хүртлээ ганцаардаж байснаа мэдээгүй болтой. Бид ахан дүүстэйгээ мөр зэрэгцээд, дэлхийг өөрчлөхийн төлөө ажиллах эгч дүүсийн нэг байв. Адилхан шивнээ сонссон бусадтайгаа холбоо харилцаатай байх нь хүчтэй, гайхмаар, эрх чөлөөтэй зүйл.

Чи ч бас үүнийг үзсэн л байх. Чи өөрийгөө дандаа л гадна талаас дотогшоо өнгийдөг хүн гэж санатал, гэнэт чамайг дотогш урина. Охид, эгч дүүс, ээж, найз нөхөд чинь чамайг өөрсдийнхөө гэнэ. Чи ганцаараа биш. Хэзээ ч ганцаараа байгаагүй. Бурханы шивнээг тээдэг бусад чинь чамайг нүд салгалгүй харж, урина.

Тэд чамайг өрөвдсөндөө юмуу эелдэг байхгүй бол болохгүй учраас, албадлагаар урьсан юм биш шүү. Чи дэлхийг эргүүлэхийн тулд газар дээр хүчээ авч буй эрчүүд, эмэгтэйчүүдийн нэг учраас, уригджээ.

Харин та нар Ариун Нэгэнээр тослогдсон бөгөөд бүхнийг мэднэ.

Та нар үнэнийг мэдэхгүй тул би бичсэн биш, харин түүнийг мэддэг бөгөөд ямар ч худал нь үнэнээс гардаггүй учир би та нарт бичсэн.

(1Иохан 2:20-21)

Хамт олонтой гэдгийг мэдэх нь надад амин чухал байв. Хэдийгээр би долоо хоног бүр аялж, зуу зуун эмэгтэйд номлодог ч, дотроо бол дандаа л гадны хүн шиг санагддаг байлаа. Зүгээр л зочин болохоос биш, тэдэнд хамааралгүй. Ийм мэдрэмж маш их ганцаардуулна. Тиймээс Бурханы хайрт охин минь, чи гийчин биш, гэр бүлийн гишүүн. Олон хүн нэгдэхэд үг цуурайтаж, харилцаа бий болж, дуу чангарна. Ийм төрлийн шивнээ нь биднийг харилцаа холбоонд уриалан дууддаг.

Тэгээд юу гэж хашхирах уу?

Намайг “Уухайлан хашхир” гэж хэлэх тэр өдрийг хүртэл та нар хашхирч ч, дуугаа сонсгож ч мөн амнаасаа үг гаргаж ч болохгүй.

Харин намайг хэлэх үед уухайлан хашхирагтун. (Иошуа 6:10)

Шивнэх бодол хашхираа болоход цаг хугацаа хамааралтай. Бид аюултай бөгөөд стратегийн ач холбогдолтой цаг үед амьдарч байна. Иериход үйлдсэн шигээ Бурхан зарим юмсыг нууцаар бүсэлсээр, цаг нь болмогц нэгдмэл хашхираан дор буулгаж авах гэж байна.

Учир нь, Эзэн Өөрөө тушаалын уухай, тэргүүн тэнгэрэлчийн дуу ба Бурханы бүрэнээр тэнгэрээс бууж ирнэ. Тэгээд Христ дотор үхэгсэд эхлээд амилна. (1Тесалоник 4:16)

Түүний дуун дор үхлийн хаанчлал ч, сүйрэл ч дуусна.

Израильчууд хамаг хүчээрээ хашхирах цаг нь болтол Иерихог долоон удаа бүслүүрдэн тойрсон байдаг. Үүнтэй адил ухаант эрслэн цаг нь

болсныг мэдэх хүртлээ хоосон бархирахгүй. Хамаг учир нь том дуутай юмуу хашхичихдаа бус, харин стратегитай байхад оршино. Хийсэн шиг хийх байр суурьгүй байж, том, том мэдэгдэл хийх эрх хэнд ч байхгүй.

Бүх шивнээг хашхирч болдоггүй юм.

Жирэмсэн эмэгтэй төрөхдөө зовон, Өвдөх шаналлаасаа болж орилдог шиг ЭЗЭН минь бид чинь Таны өмнө ийм л байсан.
(Исаиа 26:17)

Бид хувиараа ч, нийтээрээ ч олон жил зовлонгоо хашхирсан ч, энэ маань хариулт болохгүй. Амаржихын зовиураас хүн төрөх нь л хариулт юм. Хүчтэй, эрчтэй охидын үеийг төрүүлэхийн төлөө амаржсан ч, буруугаар ойлгогдсон ч, өвдсөн ч гомдолгүй.

ХАШХИРАА АРХИРАА БОЛОХЫН ЦАГТ

Хашхирахыг хэн ч чадна. Гэхдээ дуртай нь архираад байж чадахгүй - ядаж л цагаасаа өмнө.

Тэгвэл архираа гэж юу вэ? Зүгээр нэг супер чанга хашхираа биш шүү. Хамгийн түрүүнд айдасгүйн тунхаглал. Архираа нь үндсэн, хүршгүй тэгээд яльгүй ойлгомжгүй зүйлийг чөлөөлөх үйлдэл юм. Хүн бүрт архирах хүчин чадал байдаг ч, ганц ганцаараа хийх нь үр дүн муутай болов уу. Би л хувьдаа, хүний архираа нь дуу хоолойгоос том зүйлийн нэгдмэл илэрхийлэл гэж итгэдэг. Энэ нь итгэл үнэмшлээ чангаар харуулахдаа, найдвар түгээж, Бурханы хайрыг илэрхийлж байгаа хүмүүсийн дуу гэж би итгэдэг.

Хелен Реддигийн 1970 онд гаргасан “Бүсгүй хүн - миний архирахыг сонс!” гэдэг дууг санаж байгаа байх аа. Эмэгтэй хүн л архирдаг гэж хэлэх гээгүйг минь ойлгоорой. Түүнчлэн эмэгтэйчүүдийг эрчүүд рүү, эрчүүдийг эмэгтэйчүүд рүү архирахыг ч би дэмжихгүй. Харин бид хоолойгоо нэгтгээд, хамтдаа архирах цаг нь болж!

Одоо ч сүнс дотор минь “Охид минь, өөрсдийгөө бэлтгэ. Учир нь та нарын нэгдмэл хашхираа газраас архираа болон хуйларч, тэнгэрийн хангамжийг буулгана” гэдэг үг дуулдаж байна. Уинстон Черчилл гуайн: “Би арслан байгаагүй ч, арслан шиг архирах ёстой санагдсан” гэдэг үг шиг л.

Үүнтэй адил, бид арслан биш боловч, Арслангийнхаа архираанд дуу хоолойгоо зээлдүүлэх ёстой. Есүс л Иудагийн Арслан мөн. Бид болбоос Түүний архирааг цуурайтуулдаг, дагагч нар нь. Эзэнийг маань юу архирахад хүргэх бол? Онгон байгаль дахь арслан, эрслэнг юу архирахад

хүргэдгийг судлахад л хариулт нь ил болно гэдэгт би итгэж байна.

Хоёр том муурын аль, аль нь архирдаг ч, өөр, өөр шалтгаантай ажээ. Арслан нутаг дэвсгэрээ мэдэгдэж, хамгаалахын тулд архирдаг байна. Харанхуй болоход, тэргүүн арслан (арслангууд) хөл дээрээ босоод, толгойгоо бөхийлгөөд, цээжээ сунгаад, шөнийн агаарыг сорно. Тэгээд архирна. Архираа нь “Би сонор соргог бөгөөд хүчирхэг байна. Нутаг ус, гэр бүлд минь халдаар ирэх хэнийг ч тасчина. Эрслэнг минь эсвэл үр төлийг минь хулгайлах гэсэн хэнийг ч зүгээр өнгөрөөхгүй. Гадны дээрэмчин тонуулчид хоол хүнсэнд маань хүрэхгүй” гэдэг мэдэгдлийг талаар нэг тараана.

Арслангийн архираа хиена чоныг сүрдүүлнэ. Архирааны хүч нь дотор, гадаргүй чичрээж, ямар ч халдлагыг тэвчихгүйг сүүдэрт сүүмэгнэх бүхэнд анхааруулна. Архираа гадныхныг айлгаж, хил хязгаарыг байр байранд нь тогтооно.

Түүнчлэн арслан сүргийнхээ гишүүдийн байр байршлыг тогтоох гэж архирдаг. Архираа нь “Би энд байна. Чи хаана байна?” гэдэг. Бүлийнх нь эрслэн, арслангууд өөрийнхөндөө хариу архирна.

Архирааных нь цар хүч, өнгө дуу нь арслангийн зан чанарын талаар ихийг өгүүлнэ. Архираа нь арслангийн хэмжээ, нас, эрүүл мэндийг ч илтгэнэ. Үндсэндээ “Чи намайг харахгүй ч, үүнийг сонсож, мэдэрч байна уу? Аятайхан л байгаарай!” гэдэг. Эцэст нь арслан өвдөхөөрөө архирна.

Үүнийг бичиж байхдаа, Бурханы өргөөний төлөө Есүс яаж тарчилсныг өөрийн эрхгүй дурсах. Бид толгойгоо бөхийлгөөд, амьдралаа дүүргээд, холбоо тогтоосон нэгнээ мэдэгдэж чадах уу?

Тэгвэл эрслэнг юу архирахад хүргэдэг юм бол?

Арслантай л адил эрслэн ч газар нутгаа мэдэгдэн, хамгаалж, сүрэгтэйгээ нийлэхдээ архирна. Мөн тусламж дуудаж, бусад эрслэнтэйгээ харилцаж, дайснаас хамгаалахдаа архирна. Эрслэн төөрсөн үр төлөө дуудахдаа архирна. Гэхдээ эрслэн хамгийн гол нь үр төлөө хамгаалах гэж л архирдаг ажээ.

Үүнийг дүрслэхийн тулд эрслэнгийн архирааны талаар бүтэн хоёр жил хийсэн судалгаанаасаа эш татмаар байна:

Эрслэнгүүд бүлэглэхдээ, зулзагыг нь хөнөөгч арслангаас үр төлөө хамгаалах хүчээ зузаатгаад зогсохгүй мөн нийлж архирснаараа ийм тулаанаас бүр мөсөн сэргийлэх боломжтой байдаг ажээ.³

Эрслэнгүүд голдуу сүргээрээ архирна. Яагаад гэвэл ганц эрслэнгийн архираа нь тэнэмэл арсланд хээлтэх санал мэт андуурагдах талтай. Эрслэн

үр төлийг нь хөнөөж, сүргийг нь өмчлөх тэнүүлч арсланг дуудахыг яв ч хүсэхгүй. Тэнэмэл арслан эрслэнтэй бушуухан хээлтэхийн тулд ихэвчлэн эрслэнгийн үр төлийг хөнөөдөг байна. (Үр төлтэй эрслэн хээлтдэггүй.) Ингэснээрээ арслан аль болох түргэн өөрийнхөө ургийг байгуулна.

Зан авирын судлаач нар эрслэнгийн сүргийн нягт холбоо харилцааг нь анчлах хүчээ зузаатгахтай нь холбож тайлбарласан түүх байдаг. Гэтэл одоо тэд энэ судалгааныхаа дүгнэлтэд эргэлзэж, эрслэнгийн бүлгээрээ амьдардаг гол шалтгаан нь нэгдүгээрт - үр төлөө хамгаалах, хоёрдугаарт нь илүү үр дүнтэй ан хийх гэдэг болжээ.

Эрслэнгийн сүргээрээ архирдаг гол шалтгаан нь үр төлөө үхэл, аюулаас хамгаалах гэдгийг уншаад би золтой л уйлчихаагүй. Тэд судалгаандаа “гурван эрслэн нийлж архирахад л зулзагынхаа алуурчдаас сэргийлэх хүчтэй байдаг” гэжээ.⁴

Энэ нь бидэнд юу өгүүлнэ вэ?

Ганц хүнийг хэн нэг нь дайран дийлж чадах бол хоёр нь нэгийг няцаана. Гурамсалж гөрсөн сур тийм ч амар тасардаггүй.
(Номлогчийн үгс 4:12)

Эхээсээ холдсон үр төлд нь аюул учрахыг эрслэн мэдээд байхад, бид яахаараа бие даах гэж яарна вэ? Хамтдаа байж л үр хүүхдээ аюул, сүйрлээс хамгаална. Тус тусдаа байвал, боломж байхгүй.

Ийм байтал, яагаад бид бие биедээ хэрэгтэй гэдгээ хүлээн зөвшөөрөхөөс айна вэ? Олон нийтийг хөдөлгөх шаардлагагүй. Зүгээр л сэтгэлтэй, халамжтай цөөхөн хүн байхад л олон нийтийг өөрчилнө.

ЗАЛБИРЛЫН АРХИРАА

Бие биеэ мэддэг эрслэнгүүд л эмээлгүй архирдаг. Эрслэнгүүд өөрийнхөө дуу хоолойд ч, ар тал болдог эгч дүүсдээ ч итгэл төгс байна.

Ийм байхад, Бурханы эрслэн - охид бид архирахгүй гэж үү?

Бид Бурханы хүчирхэг ноёрхол, өөрсдийнхөө нэгдлийг мэдэгдэхийн тулд дуу хоолойгоо өргөнө. Бид төөрөгсдийг дуудахын төлөө архирна. Дуу хоолой маань үр төлийг маань аюулгүй руу чиглүүлэн, хөтөлнө.

Сэтгэлтэй хэдхэн хүн дэлхийг өөрчилж чадахгүй гэдэгт бүү итгэ. Учир нь үнэндээ, эд л өөрчилдөг юм.
— Маргарет Муйг

Түүнчлэн бид халдагч, дайсан, хулгайчийн хөдөлгөөнийг шалгах гэж агаарыг чичрүүлнэ. Бид хамтдаа архирахдаа, үр хүүхдээ үхэл, сүйрлээс хамгаална. Бид харанхуйн өмнө дуугүй зогсохгүй.

Миний хувьд дээрхээс илүү сайн шалтгаан олохгүй байна. Би одоо ч өчнөөн удаан дуугүй байсандаа уур хүрч байна. Дуугарч чадахгүй байгаа хүмүүсийн өмнөөс дуугарах үүрэгтэй байтлаа бид яаж дуугүй байх билээ. Цаг оройтож байна. Нойрмоглож байх хойгуур харанхуй газар авчээ. Эдүгээ сэрсэн болохоороо, Бурханы гэрлийг тусгаад, Бурхан хүчин чадлыг маань үржүүлэхийн төлөө залбирах ёстой. Залбирал нь биднийг цуглуулдаг хамгийн том шалтгаан болой. Бидэнд энэ тулаанд дайтахад тэнгэрийн хамгаалалт, цэц ухаан, стратеги хэрэгтэй.

Есүс “Чи Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа хайрла” (Матай 22:37) гэж хэлсэн.

Сэтгэл, залбирал, оюун нь дуу хоолойгоо архираа болгож чадах, гурван зэмсэг болой. Энэ гурван талбарыг амьдралдаа боловсруулах үед эдгээр нь биднийг Бурханыг халуун сэтгэлээр, оюунлаг залбирлаар хайрлах хүртэл нэгдэнэ.

Бид жижгээр эхлээд, том итгэнэ. Бурхан Өөрийнх нь нэрээр цугласан хоёр, гурван хүний дунд ч байхаа амласан. Залбирал нь хангамж, зорилго, стратегид зам засдаг. Эрслэн эгч дүүс минь, чамтай ядахнаа утсаар ч хамтарч залбирах хоёр эмэгтэй лавтай олдono.

Биднийг босоод, цуглаад, дуу хоолойгоо өргөхөд, Бурхан гурван хүнийг шууд л гучин хүнтэй бүлэг болгоно. Дараа нь гучин эгч дүүс маань арав үржээд, гурван зуу болно. Гурван зуу нь гурван мянга, дараа нь гучин мянга гэх маягаар газраас залбирлаар архирсан их цэрэг болно. Энэ бол Арслангийн архирааг цуурайтуулах оргил цаг.

Унтаад боссон арслан мэт бай
Ялагдашгүй олон.
Унтаж байхад дээр чинь буусан
Гинжээ газарт шүүдэр мэт гөвж унага.
Бид олуулаа - тэд цөөхүүлээ.⁵
— Перси Бушши Шелли

Дуугаа өргө, эрслэн минь.

ЯРИЛЦАХ АСУУЛТ

1. Эрслэнгийн дүрслэлээс юу сурав? (1-ээр бүлэг)
2. Бие хөшиж, чилж, таталдаад ирэхээрээ эрхгүй “суниадаг”. Суниах чадвар нь уян хатан байдлыг нэмэгдүүлж, гэмтлээс сэргийлнэ. Чиний амьдралд суниах хэрэгтэй ямар тал байна? Эсвэл хэдийнээ сайн суниасан ямар тал байна? Эрслэнгийн дүрслэл чиний өөрийн чинь талаарх үзэл бодлыг хэрхэн өөрчлөв? (2-аар бүлэг)
3. “Хүчтэй учраас амгалан, чадалтай учраас тайван” гэдгийг чи юу гэж ойлгов? (2-аар бүлэг)
4. “Эрслэн “Би аймшигтай бөгөөд гайхамшигтай бүтээгдсэн” хэмээн өөртөө төгс итгэлтэй байдаг. Тэгвэл чи ингэж хэлж чадах уу? Тийм бол, яагаад? Үгүй бол, яагаад? (4-ээр бүлэг)
5. Хүчтэй бөгөөд чадалтай итгэлтэй нь зөвхөн өөртөө эв аятайг хийгээд байх биш, харин урагш гараад, ухарсан нэгэндээ гараа сунгах ёстой. Хүч нь байр суурь биш бөгөөд үйлчлэлийн төлөө оршдог. Хүн бүр эргэн тойрныхоо хүмүүсийн сайныг харж, өөрөөсөө “Би яаж туслах вэ?” (Ром 15:1-2) гэж асуух ёстой. Бусдад тус болж чадах, хүчтэй тал чинь юу вэ? (5-аар бүлэг)
6. “Эрчүүд дан ганц хүйсийнхээ улмаас л удирдлагад тэнцдэг юм биш, эмэгтэйчүүд дан ганц хүйсийнхээ улмаас л удирдлагад тэнцдэггүй юм биш. Хэн хэн нь чанарынхаа улмаас л тэнцдэг.” Чи энэ үгийг юу гэж бодож байна? Яагаад тэгж бодож байна? (6-аар бүлэг)
7. “Харин та нар доторхыг нь өглөг мэтээр өг, тэгвэл харагтун, бүх юмс та нарын хувьд цэвэр байх болно” (Лук 11:41). Тусыг чинь хариулж чадахгүй хүнд туслах нь жинхэнэ дотоод цэвэршилт юм. Ийм цэвэрлэгээг хүлээж авахын тулд цаг, мөнгө, үйлчлэлээ хэнд өгч болохоор байна? (7-аар бүлэг)
8. Домогт гэдэг нь: ер бусын чадвар, ур, хүч; онцгой эр зориг, хатан зүрхийг илэрхийлнэ. Домогт чанартай хүн “Би бүгдийг мэддэг, чаддаг

биш. Гэхдээ мэддэг зүйлээ онцсайн хийнэ” гэдэг байх. Чи ямар чадвар, ур, хүчээ онцгой болгох гэж байна? (8-аар бүлэг)

9. Бурханы хүүхэд бүр амьдрах тэгш эрхтэй гэдэгт чи итгэдэг үү? Тийм бол, чи үүнийгээ хэрхэн харуулах вэ? Тухайлах юм бол, хөршийнхөө юмуу өрөөлийн хүүхдэд хэрхэн хандах вэ? (8-аар бүлэг)
10. “Чи ядарч байна уу? Туйлдаж байна уу? Шашнаас залхаж байна уу? Тэгвэл над дээр ир. Надтай хамт яв, Би чамайг сэргээе. Хэрхэн амрахыг чинь харуулъя. Надтай хамт явж, хамт ажилла - хэрхэн хийдгийг минь хар. Нигүүлслийн, албадлагагүй хэмнэлд суралц. Чам дээр би хүнд хүчир, муу юм тавихгүй. Надтай нөхөрлөбөл, эрх чөлөөтэй бөгөөд хөнгөн амьдарч сурна (Матай 11:28-30). Яг одоо дарамттай тал амьдралд чинь байна уу? Тэр талаа чи Есүст өгөөгүй байна уу? (9-ээр бүлэг)
11. Бид одоо хийх сонголт маань үр дагавартай гэдгийг мэдэн, урагшаа харах ёстой. Хожмын үеийнхнээ сайн сайхан амьдруулахын төлөө өнөөдөр чи ямар сонголт хийж байна? (9-ээр бүлэг)
12. Есүс дагалдагч нартаа “Хэн нэг нь Миний араас дагахыг хүсвэл тэр өөрийгөө үгүйсгэн, загалмайгаа авч Намайг дага. Хэн амиа аврахыг хүснэ, тэр түүнийгээ алдана. Харин хэн Миний төлөө амиа алдана, тэр түүнийгээ олно” (Матай 16:24-25) гэж хэлсэн. Чамд Бурханы дагуулж буй боловч, дагахаас айж байгаа газар байна уу? (10-аар бүлэг)
13. Чиний хувьд домогт эрслэн мэт хүн байна уу? Тэр хүн байхгүй болсон ч, түүний ямар зан чанар чамд үлдэх вэ? Тэгвэл чи өөрөө юугаараа дурсагдахыг хүсч байна? (10-аар бүлэг)
14. Бурхан амь, эрх чөлөө, зэрлэг чанар, гоо үзэсгэлэн, үнэ цэнэ шивнэсэн учраас, чамд эвгүй байгаа талбар амьдралд чинь бий юу? (11-ээр бүлэг)
15. Цаг - бүх зүйл. Бид стратегийн онц чухал цагт аж төрж байна. Бурхан нууцаар юмсыг бүслүүрдэн ороосоор, зөв цаг нь болмогц ганц хашхираагаар л буулгана! Бурхан чамайг ямар талбараа залбирлаар бүсэл гэж байна? (11-ээр бүлэг)

ЗҮҮВЭР

Бүлэг 2: Үл үзэгдэх хүч

1. Nicholas D. Kristof and Sheryl WuDunn, *Half the Sky: Turning Oppression into Opportunity for Women Worldwide* (New York: Knopf, 2009), xx.
2. Kristof and WuDunn, *Half the Sky*, xx.
3. Kristof and WuDunn, *Half the Sky*, xxi.
4. Kristof and WuDunn, *Half the Sky*, 250.

Бүлэг 3: Аюултай сэргэг

1. Nicholas D. Kristof and Sheryl WuDunn, *Half the Sky: Turning Oppression into Opportunity for Women Worldwide* (New York: Knopf, 2009), xviii.

Бүлэг 6: Нэгэн даалгавар дор

1. Lisa Bevere, *Fight Like a Girl: The Power of Being a Woman* (New York: Warner Faith, 2006), 42.
2. Sue Monk Kidd, *The Dance of the Dissident Daughter: A Woman's Journey from Christian Tradition to the Sacred Feminine* (New York: HarperCollins, 1996), 27.
3. Marianne Williamson, *A Woman's Worth* (New York: Random House, 1993), 20.
4. Williamson, *A Woman's Worth*. 21.
5. Williamson, *A Woman's Worth*. 21.
6. "What's Your Quotation Quotient?" *Monterey County Herald*, May 4, 2010, www.montereyherald.com/entertainment/ci_14961372.

Бүлэг 8: Эрслэн стратегитай

1. *Random House Webster's College Dictionary*, s.v. "prowess"
2. Margaret Mead, ThinkExist.com, http://thinkexist.com/quotation/sister_is_probably_the_most_competitive/12512.html.

3. Lisa Bevere, *Nurture: Give and Get What You Need to Flourish* (New York: Hachette, 2008), 57.

Бүлэг 10: Арслантай хамт алхах

1. C. S. Lewis, *Prince Caspian: The Return to Narnia* (New York: HarperCollins, 1979), 131-32.
2. Lewis, *Prince Caspian*, 149.
3. Lewis, *Prince Caspian*, 150.
4. Alan Axelrod, *Elizabeth I, CEO: Strategic Lessons from the Leader Who Built an Empire* (Paramus, NJ: Prentice Hall, 2000), 6.
5. Axelrod, *Elizabeth I, CEO*, 250.
6. Axelrod, *Elizabeth I, CEO*, 83-85.

Бүлэг 11: Шивнээгээс архираа

1. Ludwig van Beethoven, ThinkExist.com, http://thinkexist.com/quotes/ludwig_van_beethoven/2.html.
2. Ralph Waldo Emerson, ThinkExist.com, http://thinkexist.com/quotation/none_of_us_will_ever_accomplish_anything/223531.html.
3. Jon Grinnell, "The Lion's Roar: More Than Just Hot Air," *Zoogoer*, May-June 1997, <http://nationalzoo.si.edu/Publications/ZooGoer/1997/3/lion-sroar.cfm>.
4. Grinnell, "The Lion's Roar."
5. Percy Bysshe Shelly, *The Mask of Anarchy*, Art of Europe, www.artofeurope.com/shelley/she5.htm.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Эргэлзээ, харьцуулалтын энэ эрин цагт
өөрийгөө болон зорилгоо олж мэдэх



Бид бусдыг ямагт өрсөлдөгчөө хэмээн үзэж, өрсөлдөөн харьцуулалтаар өөрийгөө боомилдог нь цаанаа шалтгаантай юм. Үүний цаана биднийг өөр хоорондоо хэвэнд цутгагдчихсан мэт ялгарашгүй байлгахаар оюун санаа, хүсэл, сэтгэл мэдрэмж рүү маань байнга халдан довтолж байдаг дайсан бий. Бид энэ тойрогт орохдоо дотно харилцаа холбооноосоо тасарч, өөрийгөө хэн болоход эргэлзээж, зорилгоо гээдэг.

Өрсөлдөөнийг өөртөө ашигтайгаар эргүүлж, өөрийнхөө шилдгийг гарга. Өөрийнхөө тухай ярианаас бүү зугт. Эмэгтэйчүүд таарахгүй, тэнцэхгүй, гэнэдүү, гэнэн гэдэг маргаанд хариу барь. Хүйсийн өрсөлдөөнийг шийдвэрлэж, эрчүүдтэй мөр зэрэгцэн ажиллахыг сур. Өрсөлдөгчгүй амьдрах цаг иржээ!

Татаж аваарай:  [MessengerX.com](https://messengerx.com)

СЭЛЭМТЭЙ ОХИД

Загалмайгаа жинхэнэ баатар шиг үүрье



Бурханы Үг болох илдний тухай судлах нь илдийг сугалж хэрэглэхээс амархан бөгөөд таатай байдаг. Охидууд бид тэнгэрийг газартай холбох цаг болжээ. Дэлхий даяар эмэгтэйчүүд алив гадуурхал, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлийн бай болсоор байна.

Лиза Бивэр энэ номдоо эмэгтэйчүүдийн өнгөрсөнийг биш, харин ирээдүйг өгүүлжээ.

Тиймд Бурханы дайчин охид оо, эр зоригтойгоор босоод, ялгах чадвараа ашиглан, уучилж, мэргэн байж сэлмээ эргүүлэн баатарлаг үйлсийг бүтээгээрэй.


Татаж аваарай:



MessengerX.com

АДАМАНТ

Олон санаат ертөнцөд үнэнийг олох



Үнэн, хайрын тал дээр хад чулуу мэт хөдлөшгүй байх ёстой цаг гэж байдаг бол тэр цаг иржээ. Бурхан бол хайр. Бурхан бол үнэн. Хайр ч, үнэн ч цаг хугацаагүй бөгөөд үе үеийн чиг хандлага, санаа бодлыг давдаг. Заримдаа үнэнийг ярих нь бидний хийж чадах жинхэнэ хайрын үйлс болдог. Гэхдээ үнэнийг ярих нь үнэнээр амьдрахаас эхлэнэ.

Шилдэг борлуулалтай номын зохиолч Лиза Бивэр Бичээс, түүхийг хослуулан байж, таныг Бурханы ганхашгүй үнэн, хайр дотор амьдруулахаар барахгүй, харин “адамант” буюу хөдлөшгүй, шийдэмгий, ганхашгүй хүмүүс болгох газрыг зорих аян замд гаргана.

Бурханы дотор амьдрах үед Түүний төлөвлөгөө илчлэгддэг. Тэнд л бид хэлбэршин бүрэлддэг. Бид Булангийн чулуу болох Христ дотор амьдрахдаа, адамантын буюу хөдлөшгүй нэгний дүрд хувирдаг

Татаж аваарай:



MessengerX.com

УЙЛУУЛАХ УЧИРГҮЙ ҮНСЭЛТ

Эмэгтэй хүн буулт хийхдээ ялагддаг




Нүгэл, ичгүүр хоёр нь биднийг Бурханы хайрыг харах нүдгүй болгож, эрх чөлөөнөөс хорьдог ахан дүүс, ихрүүд юм. Үнэн л биднийг эрх чөлөөтэй болгоно. “Иймээс Хүү та нарыг чөлөөлвөл та нар үнэхээр эрх чөлөөтэй болно” гэж Есүс амласан (Иохан 8:36). Эмэгтэйчүүд өөрсдийг нь нэр төрийг хаяад, ял дор булшлахыг санаархагч дайсныхаа саварт тарчилж байна.

“Уйлуулах учиргүй үнсэлт” ном нь хайртай охин чамдаа зориулсан Бурханы зүрхний үгс юм. Бурхан чамд дотносол, хайр, дур хүслийг эдлүүлэхээр чамайг бүтээсэн. Чи хэн нэгний бэлгийн гарч юмуу дур хүслийг тайлагч байхаар бүтээгдээгүй. Бурханы Үгийн хүч нь чиний цагаас нь өмнө сэрээсэн зүйлсийг чинь тайвшруулан, буцааж нойрсуулахаар айлчилж байна. Бурхан миний нэр төр, хүч чадал, эрх хүчийг сэргээсэн шигээ чинийхийг ч сэргээнэ.

X MessengerX

Газар газрын хүн бүрт зориулсан дагалдагчийн аян




- 110 гаруй хэл дээр үнэ төлбөргүй үзэх боломжтой.
- Апп хэлбэрээр ч, онлайн хэлбэрээр ч хэрэглэх боломжтой.
- Таны өсөлт төлөвшилд зориулагдсан материал.
- Өөрийн түүх, дагалдагчийн аяныг хянах боломжтой.



Бүх төрлийн төхөөрөмж дээр үзэх, унших, сонсох боломжтой цахим ном, сонсдог ном, богино хэмжээний кино, видео сургаал, Библи зэрэг дагалдагч бэлтгэхэд нэн шаардлагатай бүх материалыг Messenger сангаас хүлээн авна уу.

MessengerX.com



Дэлхий даяар App Store болоод Google Play дээр үзэх боломжтой.

Сэрсэн.

Эрслэн нойрноосоо сэрэх нь л өөрөө ер бусын хүч, гал, гоо үзэсгэлэнгийн дүр зураг болой. Эрслэнгийн оршихуй нь хээр талыг номонд нь оруулж, үр төлд нь хамгаалалт болж, арсланг нь хүчжүүлдэг. Эрслэнгийн сүрэг багаараа ажиллахдаа ер бусын бүтээлч, стратегитай хүч болж, эргэн тойрноо өөрчилдөг байна.

Чи бол эрслэн.

Эрслэн сэрэв ном дээрээ зохиолч, номлогч Лиза Бивэр эрслэнг эмэгтэйчүүдийн хувьд үлгэр жишээ аван дууриах ёстой зэрлэг бөгөөд ер зөөлөн дүр болохыг дүрслэн харуулжээ. Энэ гайхамшигт амьтны гайхаж биширмээр олон зан чанарыг илчлэхдээ, зохиолч маань эмэгтэйчүүдийг гал, домогт чанар, зорилгоо дахин шинээр олж авахыг уриалжээ.

Дараах зүйлсийг сураарай:

- Хүч чадлыг биширтэл төлөөлөн харуул.
- Үр төлөө аймшиггүй хамгаал.
- Дуугарч чадахгүй хүмүүсийн өмнөөс дуугар.
- Гэрэлд амьдарч, харанхуйд анчил.
- Бүхнийг өөрчлөхийн тулд нийтээрээ архир.

Байгаль дээрх эрслэнгийн амьдрал, библи дээрх эрслэнгийн тухай эшлэлээр баян энэхүү ном нь эмэгтэйчүүдийг тоогоор ч, хүчээр ч нэгдэн босоод, дэлхийг өөрчлөх дуудлага болой.

Бид бол сэргж буй Бурханы эрслэнгүүд.



Лиза Бивэр - олон улсад нэртэй илтгэгч, бестселлер зохиолч, дэлхийн 216 гаруй улсад цацагддаг "The Messenger" телевизийн нэвтрүүлгийн хамтран хөтөлгөч.

Лиза Бивэр Бурханы Үгийг ил тод заасаар, хүмүүсийн амьдралыг өөрчилж, хүчжүүлж, чөлөөлсөөр байна. Тэрбээр нийгэм дээрх шударга бус явдалд эмзэглэж, өөрчлөхийн төлөө ажилладаг учраас, бусдыг ч бас хол ойрын, амьдралын амин чухал асуудалд шийд олох энэ үйлсдээ уриалан дууддаг билээ.



Үнэ төлбөргүй материалыг татаж авах хаяг: [MessengerX.com](https://messengerx.com)



MESSENGER
INTERNATIONAL

Энэхүү ном нь зохиолчийн бэлэг бөгөөд ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОНО.

